



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
ДАРГА НЯМ-ОСОРЫН УЧРАЛ
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.mongolia.gov.mn

2026.03.18 № 3Г-1/17
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх тухай

Төрийн нууцын тухай хууль (Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэсний дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлэхийг хүсье.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД



Г.ЗАНДАНШАТАР

000264006992



**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР**

Төрийн ордон, Жанжин Д.Сүхбаатарын талбай,
6 дугаар хороо, Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14201
Утас: (976-51) 26 08 17, Факс: (976-51) 26 24 08,
Цахим шуудан: info@cabinet.gov.mn,
Цахим хуудас: www.cabinet.gov.mn

2026.03.13 № ХХТ/839

танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Төрийн нууцын тухай хууль (Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр шийдвэрлэсний дагуу холбогдох материалын хамт хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлохыг хүсье.

Хавсралт ²⁶⁴... хуудастай.

Хүндэтгэсэн,

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

С.БЯМБАЦОГТ

000265003682

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭС

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн 8 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“6.ХЭЛЭЛЦСЭН нь: Төрийн нууцын тухай хууль (Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Төрийн нууцын тухай хууль (Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулга)-ийн төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон эдгээр хуулийн төслийг дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслийг хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: <http://www.mof.gov.mn>

2026. 03. 10 № 01/1633

танай _____-ны № _____-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000280



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

Засгийн газрын II байр, С.Данзангийн гудамж 5/1,
4-р хороо, Чингэлтэй дүүрэг, 15160 Улаанбаатар хот,
Утас/факс: (976-51) 26 74 68, Цахим шуудан: info@mof.gov.mn,
Цахим хуудас: http://www.mof.gov.mn

2026. 03. 10 № 01/1634

танай _____-ны № _____-т

ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД Б.ЭНХБАЯР ТАНАА

Төрийн нууцын жагсаалт батлах тухай
хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн
20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг
үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх
зөвшөөрөл олгож байна.

Хүндэтгэсэн,

Б.ЖАВХЛАН

9761000278



**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

Засгийн газрын V байр, Б.Ширэндэвийн гудамж 8/4,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас/Факс: (976-51) 26 75 33,

Цахим шуудан: info@mojha.gov.mn,

Цахим хуудас: www.mojha.gov.mn

2026.03.12 № 4/1256

танай _____-ны № _____-т

**МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БЯМБАЦОГТ ТАНАА**

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон дагалдуулан боловсруулсан бусад хуулийн төслүүдийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.

Б.ЭНХБАЯР

ХЗДХЯ-ны А5

152640485

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД

Б.ЭНХБАЯР

2025.11.28

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаалуулах” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4-т “иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, 7.5-д “төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно” гэсэн зорилтыг тусгасан ба тус бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.6.3-т “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 5.6.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030 он)”-ийн 10.1.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийг шинэчлэх хууль зүйн, үндэслэл шаардлага болно.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (2004 онд шинэчлэн найруулсан)-ийг тус тус баталснаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан.

Үүнээс хойш Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 1995 оны Төрийн нууцын тухай хуульд байгаагүй “албаны нууц” хэмээх шинэ нэр томъёо тодорхойлогдон, практикт одоо хэрэглэгдэж байна.

1/Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд “...Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.2-т “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно” гэж тодорхойлсон боловч “байгууллагын ашиг сонирхол” болон “салбарын ашиг сонирхол” зэрэг нэр томъёо, ойлголтын тодорхойгүй байдлаас үүдэн төрийн байгууллагын удирдлагаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэт өргөнөөр албаны нууцад хамааруулах явдал нийтлэг байна. Учир нь “албаны нууц”-ыг тодорхойлох шалгуурыг хуульчлаагүйгээс төрийн байгууллага, агентлагийн дарга нар албаны нууц хэмээх ангилалд хэт өргөн хүрээний мэдээллийг хамруулж, иргэний мэдэх эрхийг зөрчих явдал их байна. Өнөөгийн байдлаар “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрийн зоргоор мэдээлэл нууцлах тохиолдол цөөнгүй байна” гэж дурджээ.¹

Тодруулбал, хуульд “салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах” мэдээллийг албаны нууцад хамааруулахаар томъёолсон нь төрийн байгууллагаас нууцлах мэдээллийн төрөл, хэмжээ, агуулгыг хэт өргөжүүлж, мэдээллийг явцуу ашиг сонирхлоор албаны нууцад авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

2/Тагнуулын ерөнхий газраас 2025 онд хуульд заасан чиг үүргийнхээ дагуу төрийн 59 байгууллагын албаны нууцад хамааруулсан нийт 882 мэдээллийг албаны нууцад авсан үндэслэл, шаардлага, түүний хүрээнд үүсэж хөтлөгдөж байгаа баримт

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2023 он. 20-21 дэх хvvдас.

бичгүүд хуульд заасан шалгуурыг хангаж байгаа эсэхэд хяналт шалгалт хийхэд, тэдгээрийн 69 хувь буюу 608 мэдээлэл нь хуульд заасан шалгуурыг хангаж, харин 31 хувь буюу 274 мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан зөрчил илэрчээ.

Мөн дээрх мэдээллийн 6.1 хувь буюу 54 мэдээлэл нь Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулиар зохицуулсан хувь хүний мэдээлэлд хамаарах мэдээлэл байсан байна.

Түүнчлэн, дээрх хяналт шалгалтын тайланд Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт “хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй” гэж, 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэгт “төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ болон хуулиар хаалттай, хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана” гэж тус тус заасныг зөрчиж, хуульд нээлттэй, ил тод байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулсан тохиолдлын талаар дурдсан байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй байх” гэсэн зарчмыг тусгасан боловч төрийн байгууллага, албан тушаалтны зүгээс мэдээллийг хууль зөрчиж, үндэслэлгүйгээр албаны нууцад хамааруулах нь төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд сөргөөр нөлөөлөх, иргэдийн мэдэх эрх хангагдахгүй байх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Төрийн болон албаны нууцын тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойш Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлд заасны дагуу тус хуулийг зөрчсөн үндэслэлээр нийт 23 зөрчилд хэрэг бүртгэлтийн ажиллагаа явуулж, 14 иргэн, албан тушаалтанд зөрчлийн шийтгэл оногдуулсан байна. Мөн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.2 дахь хэсэгт заасны дагуу нийт 42 албан тушаалтанд сахилгын хариуцлага хүлээлгэжээ.

3/“Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” олон улсын зарчим (2013)²-д зааснаар мэдээлэл авах эрх нь төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих боломжийг олгох төдийгүй төрийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог дэмжиж, ардчилал, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын салшгүй хэсэг болдог. Мөн тус зарчимд улс орнууд үндэсний аюулгүй байдлыг хангах зэрэг тодорхой үндэслэлээр мэдээллийг нууцлах хууль ёсны ашиг сонирхолтой байж болох ч мэдээллийг ил болгох, нууцлан хадгалах тэнцвэрийг зөв тогтоох нь ардчилсан нийгмийн амин чухал зүйл бөгөөд түүний аюулгүй байдал, хөгжил дэвшил, сайн сайхан байдал болон хүний эрх, эрх чөлөөг хамгаалахад чухал ач холбогдолтой болохыг хүлээн зөвшөөрсөн.

Түүнчлэн, мэдээллийг хэт өргөн хүрээгээр нууцлан хязгаарлах нь засаглалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг талаар судлаачид тэмдэглэсэн байна. Тодруулбал, энэ нь олон нийтийн төрд итгэх итгэлд сөргөөр нөлөөлж, мэдээлэлгүй, эсхүл дутуу, буруу мэдээлэл авснаас үүдэн төрийн үйл ажиллагаанд итгэхээ болих үр дагавар үүсгэдэг. Иймд төрийн байгууллага, албан хаагч өөрийн шийдвэр, үйл

² The Global Principles on National Security and the Right to Information (The Tshwane Principles). 2013

ажиллагааны талаарх үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг олон нийттэй тогтмол хуваалцах нь төрд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх чухал ач холбогдолтой.³

“Транспаренси Интернэшнл” олон улсын байгууллагаас жил бүр гаргадаг Авлигын төсөөллийн индексийн оноогоор 180 орноос Монгол Улс 2017 онд 36 оноо авч 103, 2018 онд 37 оноо авч 93, 2019 онд 35 оноо авч 106, 2020 онд 35 оноо авч 111, 2021 онд 35 оноо авч 110, 2022 онд 33 оноо авч 116, 2023, 2024 онуудад мөн 33 оноогоор 121, 116 дугаар байрт тус тус эрэмбэлэгдсэн байна.

Тус олон улсын байгууллагаас өгсөн зөвлөмжид Монгол Улсын авлигын төсөөллийн индексийн оноо, эрэмбэ сүүлийн жилүүдэд тогтмол буурахад нөлөөлж буй гол хүчин зүйлсэд “төрийн анхан шатны мэдээлэл хомс, нээлттэй, ил тод биш, шийдвэр гаргах үйл явцад иргэдийн оролцоо хангалтгүй, иргэдийн мэдэх эрхийг хангах асуудал доголдолтой” гэж тодорхойлжээ.

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан албаны нууцтай холбоотой зохицуулалтыг эргэн харж, төрийн байгууллагын нууцлах мэдээллийн хүрээг хумих, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдлыг хангах, төрийн нууцын жагсаалтыг зөвхөн хуулиар тогтоох, төрийн байгууллагаас үндэслэлгүйгээр мэдээллийг нууцлах явдлыг таслан зогсоох практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгана:

1.Хууль тогтоомжийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.12 дахь хэсэгт заасны дагуу Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нэрийг “Төрийн нууцын тухай хууль” болгон өөрчилж, тус хуулиар зөвхөн төрийн нууцтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлнэ;

2.албаны нууцтай холбоотой зохицуулалтыг бүхэлд нь хуулиас хасна;

3.төрийн нууцад хамаарахаас бусад төрийн байгууллагын бүх мэдээлэл ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлнэ;

4.хуульд заасан хүрээнд нийцүүлэн төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоох буюу төрийн нууцын жагсаалт батлах эрхийг Улсын Их Хуралд бүрэн төвлөрүүлж, иргэд, олон нийтийн хяналтыг тогтооно.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Хуулийн төсөл батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрх хангагдах суурь нөхцөл бүрдэнэ.

³ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ. 2023 он. 20-21 хvндас

Шийдвэр гаргалт хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, авлига, албан тушаалын гэмт хэрэг буурахад эерэг нөлөө үзүүлнэ.

Төрийн байгууллага, албан тушаалтан үндэслэлгүйгээр мэдээллийг нууцад хамааруулахаас урьдчилан сэргийлэх, төрийн нууцлах мэдээллийн хүрээг хумих, төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Засгийн газрын шийдвэрээр төрийн нууцын жагсаалтыг салбар, байгууллагын хэмжээнд хэт өргөжүүлэн батлах зохицуулалтыг хүчингүй болгосноор төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох Үндсэн хуулийн үзэл санаа баталгаажна.

Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн байх бөгөөд хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хэлбэр, мөн хуулийн 28-30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулна.

Мөн Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

Хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Байгууллагын нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай, Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт

оруулах тухай, Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

Түүнчлэн, Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбар, байгууллагын хэмжээнд албаны нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалт бүхий Төрийн нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг боловсруулна.

---o0o---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон албаны нууцын тухай
хуулийн шинэчилсэн найруулгын
төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (2004 онд шинэчлэн найруулсан)-ийг тус тус баталснаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан.

Үүнээс хойш Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 1995 оны Төрийн нууцын тухай хуульд байгаагүй “албаны нууц” хэмээх шинэ нэр томъёо тодорхойлогдон, практикт одоо хэрэглэгдэж байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд “...Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5.1.2-т “албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно” гэж тодорхойлсон боловч “байгууллагын ашиг сонирхол” болон “салбарын ашиг сонирхол” зэрэг нэр томъёо, ойлголтын тодорхойгүй байдлаас үүдэн төрийн байгууллагын удирдлагаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэт өргөнөөр албаны нууцад хамааруулах явдал нийтлэг байна. Учир нь “албаны нууц”-ыг тодорхойлох шалгуурыг хуульчлаагүйгээс төрийн байгууллага, агентлагийн дарга нар албаны нууц хэмээх ангилалд хэт өргөн хүрээний мэдээллийг хамруулж, иргэний мэдэх эрхийг зөрчих явдал их байна. Өнөөгийн байдлаар “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрийн зоргоор мэдээлэл нууцлах тохиолдол цөөнгүй байна” гэж дурджээ.¹

Тодруулбал, хуульд “салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах” мэдээллийг албаны нууцад хамааруулахаар томъёолсон нь төрийн байгууллагаас нууцлах мэдээллийн төрөл, хэмжээ, агуулгыг хэт өргөжүүлж, мэдээллийг явцуу ашиг сонирхлоор албаны нууцад авах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2023 он, 20-21 дэх хуудас.

газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.4.1-д "Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно" гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030 он)"-ийн 10.1.1-д "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ" гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авилга, хүнд суртлыг бууруулах, төрийн байгууллагын албаны нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлд заасан хэлбэр, мөн хуулийн 28-30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 39 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа:

-Төрийн болон албаны нууцын тухай хуулийн нэрийг "Төрийн нууцын тухай хууль" болгон өөрчилж, тус хуулиар зөвхөн төрийн нууцтай холбогдсон харилцааг зохицуулах эрх зүйн үндсийг бүрдүүлсэн;

-төрийн байгууллагын албаны нууцтай холбоотой зохицуулалтыг бүхэлд нь хуулиас хассан;

-төрийн нууцад хамаарахаас бусад төрийн байгууллагын бүх мэдээлэл ил тод, нээлттэй байх нөхцөлийг бүрдүүлсэн;

-төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлж, парламентын хяналтыг бүрэн тогтоосон.

Хууль батлагдсанаар Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажуулсан төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах иргэний эрх хангагдах суурь нөхцөл бүрдэнэ.

Мөн шийдвэр гаргалт хариуцлагатай, ил тод, нээлттэй байх, төрийн үйлчилгээ түргэн шуурхай, хүнд суртлаас ангид байх зарчмын хэрэгжилт хангагдаж, авилга, албан тушаалын гэмт хэрэг буурахад эерэг нөлөө үзүүлнэ.

Түүнчлэн, төрийн байгууллага, албан тушаалтан үндэслэлгүйгээр мэдээллийг нууцад хамааруулах явдлыг таслан зогсоож, үйлдэл гаргахаас сэргийлэх, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэх боломж бүрдэнэ.

Засгийн газрын шийдвэрээр төрийн нууцын жагсаалтыг салбар, байгууллагын хэмжээнд хэт өргөжүүлэн батлах зохицуулалтыг хүчингүй болгосноор төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох Үндсэн хуулийн үзэл санаа баталгаажна.

Хуулийн төслийг дагалдуулан:

-Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

-хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор нийт 43 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

-Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбар, байгууллагын хэмжээнд албаны нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалт бүхий Төрийн нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан болно.

Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар хамтран Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэгт яамд, Засгийн газрын агентлагийн асуудал хариуцсан нийт 50 гаруй албан хаагчид оролцсон.

Түүнчлэн, хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (cabinet.gov.mn), Хууль зүй, дотоод хэргийн яамны (mojha.gov.mn) цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д тус тус байршуулсан бөгөөд хуулийн төсөлтэй холбоотой санал бичгээр болон цахимаар ирээгүй болно.

---o0o---

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн болон албаны нууцын тухай
хуулийн шинэчилсэн найруулгын
төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж тус тус заасан.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоон хамгаалах, төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авилга, хүнд суртлыг бууруулах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсрууллаа.

Хуулийн төсөл нь 7 бүлэг, 39 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын өөрчлөлтийг тусгасан:

1/Төрийн байгууллагын албаны нууцтай холбоотой зохицуулалтыг бүхэлд нь хассан:

Одоо хүчин төгөлдөр мөрдөж байгаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд “салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах” мэдээллийг албаны нууцад хамааруулахаар хуульчилсан нь төрийн байгууллагын нууцлах мэдээллийн төрөл, хэмжээ, агуулгыг хэт өргөжүүлсэн байна.

Мөн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт “Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй байх” гэсэн зарчмыг тусгасан боловч хууль зөрчиж, мэдээллийг явцуу ашиг сонирхлын хүрээнд нууцад хамааруулах нь төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдалд сөргөөр нөлөөлж, иргэдийн мэдэх эрх хангагдахгүй байх, авлига, албан тушаалын гэмт хэрэг үйлдэгдэх суурь нөхцөлийг бүрдүүлж байна.

Тухайлбал, 2025 онд Тагнуулын ерөнхий газраас хуульд заасан чиг үүргийн хүрээнд 59 төрийн байгууллагын нийт 882 албаны нууцад хяналт шалгалт хийснээс 31 хувь буюу 274 мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан зөрчил илэрсэн байна.

2/Төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоох эрх зүйн үндсийг бүрдүүлсэн:

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт заасны дагуу Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах 574 мэдээллийн жагсаалтыг баталсан. Уг жагсаалтад 2019-2024 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд мэдээллийн жагсаалтаас хассан-2, өөрчлөлт оруулсан-3, нэмсэн-14 тохиолдол байна.

Иймд төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын шийдвэрээр баталснаар ард түмнээс сонгон байгуулсан төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлын хяналт суларч, уг жагсаалтыг үндэслэлгүйгээр өргөжүүлэх нөхцөл бүрдэж байгаа тул “төрийн нууцыг хуулиар тогтоон хамгаалах” олон улсын нийтлэг зарчимд нийцүүлэн төрийн нууцын жагсаалтыг хуулиар тусгайлан батлахаар тусгасан.

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэгт хуулийн зорилт, хууль тогтоомж, хуулийн үйлчлэх хүрээ, мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлах зарчим, нэр томъёоны тодорхойлолт, төрийн байгууллага, албан тушаалтны төрийн нууцыг хамгаалах нийтлэг үүрэг, төрийн нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх зохицуулалтыг тусгасан.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх заалтад төрийн нууцад хамааруулсан мэдээлэлтэй танилцах, эсхүл тараахад хязгаарлалт тогтоох арга хэмжээг “мэдээллийг нууцлах” гэдэгт хамааруулж ойлгохоор хуульчилсныг өргөжүүлж, мэдээллийг эзэмших, ашиглах, дамжуулах үйл ажиллагааг хамааруулахаар нэмж тусгасан.

Хоёрдугаар бүлэгт төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх буюу төрийн нууцыг хамаалах талаар Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, тагнуулын байгууллага болон бусад байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийг хуульчилсан.

Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батлахаар тусгасантай холбогдуулан мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох бүрэн эрхийг Улсын Их Хурал хэрэгжүүлнэ.

Харин мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх бүрэн эрхийг тагнуулын байгууллага хэрэгжүүлж, эдгээр асуудлыг хэлэлцэн Улсын Их Хуралд оруулах бүрэн эрхийг Засгийн газар хэрэгжүүлэхээр зохицууллаа.

Байгууллага, албан тушаалтны хувьд эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах бөгөөд тухайн байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг Засгийн газраас баталсан нийтлэг журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх боломжтой байхаар тусгасан.

Гуравдугаар бүлэгт төрийн бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил, мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд хамаарах төрийн нууцад хамаарах 62 мэдээллийн хүрээг хуульчлан тогтоосон.

Дээрх хүрээнд хамаарах төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтоохоор зааж, уг жагсаалтад салбарын болон байгууллагын хэмжээнд мэдээллийг нууцлах хугацаа, нууцын зэрэглэлийг тусгасан байхаар зохицуулсан.

Дөрөвдүгээр бүлэгт төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцлах арга хэмжээ, мэдээллийн нууцын зэрэглэл, түүний шалгуур, мэдээллийг нууцлах хугацаа, нууцыг ил болгох үндэслэл, журмын талаар тусгасан.

Төрийн нууц нь “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц”-ын зэрэглэлтэй байх бөгөөд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд:

-Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээлэл-“онц чухал нууц” зэрэглэлд;

-Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах чадавхыг сулруулах мэдээлэл-“маш нууц” зэрэглэлд;

-үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, маш нууц, онц чухал нууц зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэглэлд тус тус хамааруулахаар шалгуурыг тодорхойлсон.

“Онц чухал нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийг 30 жил, “маш нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийг 20 жил, “нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийг 10 жилийн хугацаагаар нууцлах бөгөөд хугацаа тогтоох боломжгүй, тодорхой үйлдэл хийснээр, эсхүл үйл явдал болсноор ил болох бол тухайн нөхцөлийн дагуу нууцлах хугацааг тооцохоор заасан.

Төрийн нууцыг ил болгох үндэслэлийг дараах байдлаар хуульчилсан:

1/төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон;

2/нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон (энэ тохиолдолд тагнуулын байгууллага тухайн нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа холбогдох санал, дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлэх ба уг санал, дүгнэлтийг үндэслэн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ);

3/нууцлах хугацаа дуусгавар болсон (энэ тохиолдолд төрийн байгууллага, албан тушаалтан тухайн мэдээллийг нууцлах хугацаа дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө ажлын хэсэг байгуулан шинжилгээ хийлгэж, үндэслэл бүхий дүгнэлт гаргуулах ба мэдээллийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах талаар тагнуулын байгууллагын саналыг авсны үндсэн дээр шийдвэрлэнэ).

Мөн хуулийн төслийн 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэгт “Гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох

мэдээлэлтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүд танилцах бөгөөд бусад хүн танилцахыг хориглоно” гэж заасантай уялдуулан уг хэсэгт заасан төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгохыг хориглох хязгаарлалтыг тогтоосон.

Тавдугаар бүлэгт төрийн нууцтай танилцах нөхцөл, тусгай нөхцөл, төрийн нууцтай танилцах эрх, түүнийг олгох, татгалзах үндэслэл, уг эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэний нийтлэг үүрэг, төрийн нууц хамгаалах ажилтны үүрэг, түүний хууль зүй, эдийн засгийн баталгаатай холбоотой зохицуулалтыг тусгасан.

Төрийн нууцтай танилцах эрх нь тухайн танилцах нууцын зэрэглэлээс хамааран түвшинтэй байх бөгөөд түүнийг олгохтой холбоотой харилцааг төрийн нууцыг хамгаалах нийтлэг журмаар зохицуулна.

Мөн төрийн нууцтай танилцах эрх олгохдоо тухайн албан тушаалтан, иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн болон шалгагдаж байгаа гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг заавал харгалзан үздэг байхаар тодотгож оруулсан.

Түүнчлэн, төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалтыг тагнуулын байгууллага явуулах ба уг шалгалт явуулах журмыг тагнуулын байгууллагын дарга батлахаар заасан.

Зургаадугаар бүлэгт төрийн нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт, төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах, төрийн нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх, төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагаа, түүнд тавих хяналтын зохицуулалтыг тусгасан.

Монгол Улсын төрийн нууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газар чиглүүлэн удирдах бөгөөд тагнуулын байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.

Энэ хүрээнд тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулах ба байгууллага, албан тушаалтан тагнуулын байгууллагын албан шаардлагыг заавал биелүүлэх үүрэгтэй гэж хуульчилсан.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан тохиолдлыг ил болгох үндэслэлд хамааруулж байсныг агуулгын хувьд хяналт шалгалттай уялдуулж энэ нь тагнуулын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол тухайн зөрчил бүхий мэдээллийг ил болгох журмыг баримтлан шийдвэрлэхээр зохицуулсан.

Мөн тагнуулын байгууллага төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг жил бүр Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд хүргүүлдэг байхаар тусгалаа.

Хуулийн төслийг дагалдуулан:

-Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасны дагуу 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төсөл;

-хуульд заасан нэр томъёог жигдлэх, зохицуулалт хоорондын уялдааг хангах зорилгоор нийт 43 хуульд холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл;

-Хууль тогтоомжийн тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу хууль хэрэгжүүлэхтэй холбогдуулан салбар, байгууллагын хэмжээнд албаны нууцад хамааруулсан мэдээллийг ил болгох арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх эрх бүхий этгээд, хугацааг тогтоосон шилжилтийн үеийн зохицуулалт бүхий Төрийн нууцын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг тус тус боловсруулсан.

Шилжилтийн үеийн зохицуулалтын хүрээнд төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу албаны нууцад хамааруулсан баримт бичиг, бусад зүйлийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн ил болгох арга хэмжээг зохион байгуулахаар тусгав.

Мөн Засгийн газар Төрийн нууцын тухай хуулийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дүрэм, журмыг боловсруулж, батлах, хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, зохион байгуулалтын арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэхээр зохицууллаа.

---oOo---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

2 дугаар зүйл.Төрийн нууцын тухай хууль тогтоомж

2.1.Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль, Үндэсний аюулгүй байдлын тухай хууль, энэ хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль болон эдгээр хуульд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.

3 дугаар зүйл.Хуулийн үйлчлэх хүрээ

3.1.Энэ хуулийг Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө.

3.2.Монгол Улсын төрийн нууцтай танилцсан гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн энэ хуулийг биелүүлэх үүрэг хүлээнэ.

3.3.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс, олон улсын байгууллагаас шилжүүлэн өгсөн төрийн нууцад хамаарах мэдээллийг хамгаалахад энэ хуульд заасан журам нэгэн адил үйлчилнэ.

4 дүгээр зүйл.Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлах зарчим

4.1.Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг удирдлага болгоно.

5 дугаар зүйл.Хуулийн нэр томьёоны тодорхойлолт

5.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:

5.1.1.“төрийн нууц” гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй

байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;

5.1.2.“төрийн нууц тээгч” гэж төрийн нууцыг бичвэр, тэмдэг, дүрс, дохио, техникийн шийдэл, үйл ажиллагааны хэлбэрээр агуулж байгаа материаллаг зүйлийг;

5.1.3.“мэдээллийг нууцлах” гэж төрийн нууцад хамааруулсан мэдээлэлтэй танилцах, мэдээллийг эзэмших, ашиглах, тараах, дамжуулахад хязгаарлалт тогтоох арга хэмжээг;

5.1.4.“нууцын зэрэглэл” гэж төрийн нууц мэдээллийн нууцлалын түвшинг илэрхийлэх, нууц тээгч, эсхүл түүний дагалдах баримт бичигт тавьсан тэмдэглэгээг;

5.1.5.“төрийн нууцтай танилцах эрх” гэж энэ хуульд заасны дагуу албан тушаалтан, иргэн төрийн нууцад хандах, хуулийн этгээд төрийн нууцыг ашиглахтай холбоотой үйл ажиллагаа явуулах эрхийг;

5.1.6.“төрийн нууцыг хамгаалах ажилтан /цаашид “нууц хамгаалах ажилтан” гэх/” гэж төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн нууцын хамгаалалтыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн ажилтан, эсхүл энэ чиг үүргийг хэрэгжүүлэх ажилтныг;

5.1.7.“төрийн нууцыг хамгаалах хэрэгсэл” гэж төрийн нууцыг хамгаалах зориулалтаар ашиглах техникийн, программ хангамжийн, криптографийн болон бусад хэрэгслийг;

5.1.8.“төрийн нууцыг хамгаалах” гэж төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэхэд чиглэсэн хууль зүй, зохион байгуулалт, техник, криптографийн болон бусад арга хэмжээний цогцыг;

5.1.9.“төрийн нууцыг ил болгох” гэж энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу төрийн нууцын хамгаалалт, нууцлах хугацаа, зэрэглэлийг хүчингүй болгохыг;

5.1.10.“төрийн нууцыг задруулах” гэж мэдээлэх, дамжуулах, үзүүлэх, хэвлэн нийтлэх болон бусад арга замаар төрийн нууцтай танилцах эрхгүй этгээдэд хүрсэн байхыг;

5.1.11.“төрийн нууцыг үрэгдүүлэх” гэж тогтоосон дэглэм, журмыг зөрчсөний улмаас байгууллага, албан тушаалтан, иргэний эзэмшил, ашиглалтаас төрийн нууц түр, эсхүл бүрмөсөн гарсныг.

6 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах нийтлэг үүрэг

6.1.Төрийн байгууллага, албан тушаалтан нь төрийн нууцыг хамгаалах үүрэгтэй.

6.2.Төрийн нууцтай танилцсан Монгол Улсын төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад хуулийн этгээд /цаашид “төрийн байгууллага, бусад хуулийн этгээд” гэх/, улс төрийн нам, эвсэл, төрийн бус

байгууллага, албан тушаалтан, албан хаагч, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн, харьяалалгүй хүн тэдгээрийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.

6.3.Төрийн байгууллага нь тухайн жилд хэрэгжүүлсэн төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын ажлын талаарх мэдээллийг дараа жилийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

6.4.Төрийн нууц задарсан, үрэгдсэн байж болзошгүй тухай мэдсэн, түүнчлэн гээгдсэн, алдагдсан нууц тээгчийг олсон аливаа албан тушаалтан, иргэн энэ талаар тагнуулын байгууллагад нэн даруй мэдэгдэх үүрэгтэй.

6.5.Төрийн нууцыг задрах, үрэгдэхээс урьдчилан сэргийлсэн, нууц хамгаалалтад бодитой хувь нэмэр оруулсан, хууль бус үйл ажиллагааны талаар мэдээлэл өгсөн буюу бусад хэлбэрээр тагнуул, хууль сахиулах байгууллагад туслалцаа, дэмжлэг үзүүлсэн хуулийн этгээд, иргэнийг урамшуулах журмыг Засгийн газар тогтооно.

7 дугаар зүйл.Төрийн нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх

7.1.Гадаад улс, олон улсын байгууллагаас шилжүүлэн өгснөөс бусад төрийн нууц нь Монгол Улсын төрийн өмч байна.

7.2.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд, албан тушаалтан, иргэн хариуцсан, эсхүл өөрт байгаа төрийн нууцыг хууль тогтоомжийн дагуу эзэмшиж, ашиглаж, хамгаална.

7.3.Иргэн, хуулийн этгээдийн өмчлөлд байгаа, үндэсний ашиг сонирхол, үндэсний аюулгүй байдлыг хангахад чухал ач холбогдолтой, эсхүл хохирол учруулах мэдээлэл, түүний тээгчийг нууцлах шаардлагатай гэж үзвэл өмчлөгчтэй зөвшилцөн түүнтэй байгуулсан гэрээний үндсэн дээр нөхөн төлбөртэй болон төлбөргүйгээр төрийн өмчид авч болно.

7.4.Энэ хуулийн 7.3-т заасан өмчлөгчид олгох нөхөн төлбөрийн хэмжээний талаар харилцан тохиролцож чадаагүй бол Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн 7.2-т заасан журам, аргалчлалын дагуу үнэлгээ хийлгэж, баталгаажуулсан үнээр нөхөн төлбөрийг тооцно.

7.5.Энэ хуулийн 7.3-т заасан иргэн, хуулийн этгээдийн мэдээлэл, түүний тээгчийг төрийн өмчид авах эсэхийг эрх бүхий байгууллагын санал, тагнуулын байгууллагын дүгнэлтийг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ.

7.6.“Онц чухал нууц” зэрэглэлээс бусад зэрэглэлийн төрийн нууцыг гадаад улс, олон улсын байгууллагатай байгуулсан нууц мэдээллийг харилцан хамгаалах гэрээ, хэлэлцээр, тагнуулын байгууллагын саналыг үндэслэн шилжүүлэн өгч болно.

ХОЁРДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ ТАЛААРХ ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХ

8 дугаар зүйл.Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1.Улсын Их Хурал төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.1.төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих;

8.1.2.төрийн нууцыг хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах;

8.1.3.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох.

9 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх

9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавьж, энэ талаар холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх

10.1.Засгийн газар төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

10.1.1.төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх;

10.1.2.төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, төсөл, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг хэрэгжүүлэх;

10.1.3.төрийн нууцтай холбоотой журам, зааврыг батлах;

10.1.4.төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах;

10.1.5.төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах;

10.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудлыг Улсын Их Хуралд оруулах.

11 дүгээр зүйл.Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх

11.1.Байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

11.1.1.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг нийтлэг журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх;

11.1.2.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих;

11.1.3.төрийн нууцыг хамгаалах арга, хэрэгслийг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх саналаа эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх;

11.1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн нууцыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлах, тухайн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах.

11.2.Энэ хуулийн 11.1.1-д заасан байгууллагын төрийн нууцын хамгаалах журамд энэ хуульд зааснаас өөрөөр мэдээллийг нууцлах, ил болгох, нууцтай танилцах, ашиглах нөхцөлийг тусгахыг хориглоно.

12 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын бүрэн эрх

12.1.Тагнуулын байгууллага төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

12.1.1.төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

12.1.2.төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан нууцыг ашиглаж, хамгаалж байгаа байдалд хяналт тавих, шалгах;

12.1.3.төрийн нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгсэлд туршилт, шинжилгээ хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах;

12.1.4.байгууллага, албан тушаалтан төрийн нууцаа хамгаалах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

12.1.5.төрийн нууцын тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг боловсронгуй болгох саналыг Засгийн газарт хүргүүлэх;

12.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт хүргүүлэх;

12.1.7.төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ашиглах;

12.1.8.төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг судалж, шалгах;

12.1.9.төрийн нууцыг дамжуулах, илгээх мэдээлэл, шуудан, харилцаа холбооны сүлжээ, шифр харилцааг улсын хэмжээнд болон хилийн чанадад зохион байгуулж, хяналт тавих;

12.1.10.төрийн нууцыг хамгаалах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах;

12.1.11.төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөлд санал, дүгнэлт өгөх.

12.2.Энэ хуулийн 12.1.7-д заасан мэдээллийн санг байгуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.

ГУРАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦАД ХАМААРУУЛАХ МЭДЭЭЛЭЛ

13 дугаар зүйл.Төрийн нууцад хамааруулах мэдээллийн хүрээ

13.1.Төрийн нууцад дараах мэдээллийг хамааруулна:

13.1.1.төрийн бодлогын хүрээнд:

13.1.1.а.Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг;

13.1.1.б.Улсын Их Хурлын чуулган, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл;

13.1.1.в.гадаад улстай харилцах Монгол Улсын чиг бодлого, байр суурийг нарийвчлан илэрхийлсэн мэдээлэл, гадаад улсын төрийн байгууллага, иргэдээс итгэмжлэгдсэн байдлаар авсан мэдээлэл;

13.1.1.г.Засгийн газар, Төв банкнаас гадаад улс, олон улсын байгууллагатай санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ, хэлэлцээр, тэдгээрт хамаарах мэдээлэл;

13.1.1.д.дээд, өндөр түвшний харилцан айлчлал, хоёр болон олон талын яриа, хэлэлцээрийн тухай дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.е.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл;

13.1.1.ё.хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын онцгой нөхцөл байдал үүссэн үед авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ, түүнтэй холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг;

13.1.1.ж.олон улсын хурал зөвлөгөөн, чуулганд оролцох дээд, өндөр түвшний болон Засгийн газрын төлөөлөгчдийн ажлын чиглэл, түүнтэй холбоотой мэдээлэл;

13.1.1.з.улсын батлан хамгаалах, эдийн засагт чухал ач холбогдол бүхий үйлдвэр, онц чухал объектод гарсан гэмт халдлага, осол, сүйрэл, онцгой нөхцөл байдлын үед эрх бүхий байгууллагаас авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүнтэй холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг;

13.1.1.и.Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан болон Зөвлөлийн ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн нууцалбал зохих хэсэг.

13.1.2.эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд:

13.1.2.а.эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаатай холбоотой мэдээллийн нууцалбал зохих хэсэг;

13.1.2.б.мөнгөн тэмдэгтийн нөөц, нөөцийн сангийн байршил, хамгаалалтын тухай мэдээлэл;

13.1.2.в.үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн тухай мэдээлэл;

13.1.2.г.мөнгөн тэмдэгтийн эх загвар бүтээх, үйлдвэрлэх, устгах, мөнгөн тэмдэгтийн нийлүүлэлт, солилцоо, гүйлгээнээс гаргах тухай мэдээлэл.

13.1.3.батлан хамгаалах хүрээнд:

13.1.3.а.батлан хамгаалах бодлого, төрийн цэргийн номлолын нууцалбал зохих мэдээлэл;

13.1.3.б.зэвсэгт хүчний тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч, төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн байлдааны цагийн орон тоо, жинхэнэ нэр, зохион байгуулалт, бүтэц, тэдгээрийн байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл;

13.1.3.в.төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо, зэвсэгт хүчнийг бэхжүүлэх, хэрэглэх болон стратегийн төлөвлөлтийн баримт бичиг, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэн байрлуулах төлөвлөгөө, зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл;

13.1.3.г.байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны газар, орныг төхөөрөмжлөхтэй холбогдсон мэдээлэл;

13.1.3.д.батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай, төрийн нууцад хамааруулсан мэдээлэл агуулсан байр зүйн зураг, батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газрын холбогдох мэдээлэл;

13.1.3.е.улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөө, нөөц, нөхөн хангах тооцоо, төрийн цэргийн байгууллагын байлдааны техник зэвсэглэл, материал, галт хэрэглэлийн хангалт, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл;

13.1.3.ё.төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн

мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо /улсын болон аймаг, нийслэлийн хэмжээнд/;

13.1.3.ж.төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур /удирдлага холбооны/ удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалт, хангалтын тухай мэдээлэл;

13.1.3.з.төрийн цэргийн байгууллагын удирдлагын байрны байршил, мэдээлэл, холбооны сүлжээ, радио долгионы давтамжийн хуваарилалтын тухай мэдээлэл;

13.1.3.и.улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл;

13.1.3.й.улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, хангалтыг зохион байгуулахтай холбоотой мэдээлэл;

13.1.3.к.улсын болон батлан хамгаалах нөөцийн бодит хэмжээ, байршил, тайлан, санхүүжилтийн тухай мэдээлэл;

13.1.3.л.улсын болон батлан хамгаалах нөөцийн жилийн болон дунд, урт хугацааны үндсэн чиглэлийн төслийн тооцоо, үндэслэл, түүнийг хэрэгжүүлэх талаар төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан баримт бичиг;

13.1.3.м.улс орныг дайны байдалд шилжүүлэх төлөвлөгөө, дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл;

13.1.3.н.онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, энэ зорилгоор дэд бүтцийг ашиглах тухай мэдээлэл;

13.1.3.о.зэвсэгт хүчний улсын төсвийн санхүүжилт болон хөгжлийн сангийн орлого, зарлагатай холбоотой нууцалбал зохих мэдээлэл.

13.1.4.тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд:

13.1.4.а.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхавчлахтай холбоотой мэдээлэл;

13.1.4.б.гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн болон тусгай сангийн мэдээлэл;

13.1.4.в.гүйцэтгэх ажлын мэдээллийн болон тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл;

13.1.4.г.бие бүрэлдэхүүнийг нь нууцалбал зохих тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын салбар нэгж, тэдгээрийн

барилга байгууламж, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн тухай мэдээлэл;

13.1.4.д.гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл;

13.1.4.е.эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, бусад баримт бичиг;

13.1.4.ё.гүйцэтгэх ажилтны үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, тайлан, албан тушаалын тодорхойлолтын мэдээлэл;

13.1.4.ж.тагнуул, сөрөх тагнуул, эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажил эрхлэх нэгжийн зохион байгуулалтын бүтэц, орон тооны тухай мэдээлэл;

13.1.4.з.тагнуулын байгууллагын төсөв, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий бусад байгууллагын гүйцэтгэх ажлын зардал, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлангийн мэдээлэл;

13.1.4.и.гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтны хувийн хэргийн болон тэдний албан ажилтай холбоотой мэдээлэл;

13.1.4.й.тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл;

13.1.4.к.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тусгай архивын данс, бүртгэл, эд зүйл;

13.1.4.л.гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, террор, хорлон сүйтгэх ажиллагаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио;

13.1.4.м.Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тагнуулын байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа;

13.1.4.н.тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл;

13.1.4.о.тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажлын зориулалттай техник хэрэгсэл, зэвсэг, тусгай хэрэгсэл, материал техникийн хангалт, нөөцийн мэдээлэл;

13.1.4.ө.тагнуулын байгууллагаас гадаад улсын тусгай албатай тогтоосон хамтын ажиллагааны тухай мэдээлэл;

13.1.4.п.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл.

13.1.5.мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд:

13.1.5.а.төрийн тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, радио долгионы давтамжийн хуваарилалтын мэдээлэл;

13.1.5.б.төрийн мэдээллийн сүлжээний удирдлагын төвийн тусгай зориулалтын техник, программ хангамж;

13.1.5.в.төрийн шифр харилцааны бодлого, криптографийн боловсруулалт, шифрийн арга ажиллагаа, аргачлал, алгоритм, схем, эх код, кодын ном, түлхүүр, сан, нөөц, тусгай техник, хэрэгсэл, тэдгээрийг ашиглах заавар, хангалт, түүнд холбогдох мэдээлэл;

13.1.5.г.төрийн шифр мэдээ, шифр харилцааны дүрэм, журам, заавар, бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааны бүртгэл, шифрийн материал, хэрэгслийн бүртгэл;

13.1.5.д.төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл;

13.1.5.е.төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан, илтгэл, мэдээлэл, дүгнэлт, хурал, зөвлөгөөн, лекц, гүйцэтгэх ажлын сургалтын хөтөлбөр, хичээлийн тэмдэглэл;

13.1.5.ё.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудлыг шалгасан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл;

13.1.5.ж.хуулиар төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа албан тушаалтны эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл;

13.1.5.з.улсын онц чухал болон тусгай объектын байршил, олгосон газрын нэр, зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл;

13.1.5.и.цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга байгууламжийн байршлын зураг;

13.1.5.й.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээ, баримт бичиг, эд зүйлийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэл үйл ажиллагаа;

13.1.5.к.энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг;

13.1.5.л.хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн

болон төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн тухай мэдээлэл;

13.1.5.м.улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах журам.

13.2.Энэ хуулийн 13.1-д заасан хүрээнд хамаарах төрийн нууцын жагсаалтыг хуулиар тогтооно.

13.3.Төрийн нууцын жагсаалтад тухайн мэдээллийг нууцлах хугацаа, нууцын зэрэглэлийг тусгасан байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ МЭДЭЭЛЛИЙГ НУУЦЛАХ БОЛОН ИЛ БОЛГОХ

14 дүгээр зүйл.Мэдээллийг нууцлах

14.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ.

14.2.Мэдээллийг энэ хуульд заасан нууцын зэрэглэл болон бусад тэмдэглэгээг тавьж бэхжүүлэх замаар нууцална.

14.3.Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Засгийн газрын баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.

14.4.Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл энэ хуулийн 13.2-т заасан жагсаалтад ороогүй боловч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шалгуурт нийцэж байгаа тохиолдолд төрийн нууцад хамааруулах саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

14.5.Тагнуулын байгууллага энэ хуулийн 14.4-т заасан саналыг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор тухайн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, үндэслэлтэй гэж үзвэл түр хамгаалалтад авч, төрийн нууцад хамааруулах саналаа Засгийн газарт хүргүүлнэ.

14.6.Энэ хуулийн 14.5-д заасан мэдээллийг төрийн нууцад хамааруулах тагнуулын байгууллагын саналыг ажлын 5 өдөрт багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэж, асуудлыг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд оруулна.

15 дугаар зүйл.Төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түүний шалгуур

15.1.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхол, байгууллага, иргэнд учруулах аюул, занал, хохирлын хэмжээнээс хамаарч төрийн нууцад хамаарах мэдээлэл дараах зэрэглэлтэй байна:

15.1.1.онц чухал нууц;

15.1.2.маш нууц;

15.1.3.нууц.

15.2.Төрийн нууцад хамаарах мэдээлэлд энэ хуульд зааснаас өөр нууцын зэрэглэл хэрэглэхийг хориглоно.

15.3.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээллийг “онц чухал нууц” зэрэглэлд хамааруулна.

15.4.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах чадавхыг сулруулах мэдээллийг “маш нууц” зэрэглэлд хамааруулна.

15.5.Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл энэ хуулийн 15.3, 15.4-т заасан мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэглэлд хамааруулна.

16 дугаар зүйл.Мэдээллийг нууцлах хугацаа

16.1.Энэ хуулийн 16.4, 16.5-д зааснаас бусад төрийн нууцыг дараах хугацаагаар нууцална:

16.1.1.“онц чухал нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл-30 жил;

16.1.2.“маш нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл-20 жил;

16.1.3.“нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл-10 жил.

16.2.Мэдээллийг нууцлах хугацаа нь түүнд нууцын зэрэглэлийн дардас, бусад тэмдэглэгээ тавьж бэхжүүлсэн өдрөөс эхлэн тооцогдоно.

16.3.Төрийн нууцын зэрэглэлийг өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчилсөн зэрэглэлийн хугацаагаар тооцно.

16.4.Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын нууц гүйцэтгэх ажилтан, эдгээр байгууллагатай нууцаар хамтран ажиллаж байсан болон нууцаар хамтран ажиллаж байгаа хүн, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална.

16.5.Төрийн нууцад хамаарах мэдээлэлд хугацаа тогтоох боломжгүй бөгөөд тодорхой үйлдэл хийснээр, эсхүл үйл явдал болсноор ил болох бол тухайн нөхцөлийн дагуу нууцлах хугацааг тооцно.

16.6.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс, олон улсын байгууллагын нууц мэдээлэлд энэ хуульд заасан хугацааг мөрдөнө.

17 дугаар зүйл.Төрийн нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ

17.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг зохих баримт бичиг, бусад нууц тээгчид дараах тэмдэглэгээ тавьж бэхжүүлэх замаар хэрэгжүүлнэ:

17.1.1.нууцын зэрэглэл;

17.1.2.бүртгэлийн дугаар;

17.1.3.мэдээллийг нууцалсан огноо, нууцлах хугацаа;

17.1.4.мэдээллийг нууцалсан албан тушаалтны албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, нэр, гарын үсэг.

17.2.Нууцын зэрэглэлийн дардсыг баримт бичигт хуудас бүрийн баруун дээд өнцөгт дарж тэмдэглэх ба хуудас бүр дугаарлагдсан байна. Хэрэв баримт бичиг хэд хэдэн хувиас бүрдсэн бол хувь тус бүрийн эхний хуудсанд өөрийн дугаарыг баримт бичгийн нийт хуудасны тооны хамт заасан байна.

17.3.Энэ хуулийн 15.1-д заасан өөр өөр нууцын зэрэглэлтэй мэдээллийг агуулсан баримт бичиг, бусад зүйлд хамгийн өндөр нууцын зэрэглэлээр нийтэд нь тэмдэглэгээ хийнэ.

17.4.Төрийн нууц тээгчид нууцын зэрэглэлийн дардсыг тавих боломжгүй тохиолдолд түүний дагалдах баримт бичигт, биет зүйлд түүний гадна талд нууцын зэрэглэлийн дардсыг тавьж бэхжүүлнэ.

17.5.Нууцын зэрэглэлийн дардсыг төрийн нууцад хамаарахгүй мэдээлэл тээгчид хэрэглэхийг хориглоно.

18 дугаар зүйл.Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам

18.1.Төрийн нууцыг дараах үндэслэлээр ил болгоно:

18.1.1.төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон;

18.1.2.нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон;

18.1.3.нууцлах хугацаа дуусгавар болсон.

18.2.Энэ хуулийн 18.1.2-т заасан үндэслэлээр тагнуулын байгууллага төрийн нууцад хамаарах нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа тухайн мэдээлэлд хийсэн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

18.3.Энэ хуулийн 18.2-т заасан тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тухайн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

18.4.Энэ хуулийн 18.1.3-т заасан үндэслэлээр төрийн байгууллага, албан тушаалтан мөн хуулийн 16.5-д зааснаас бусад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах эсэхийг дараах журмын дагуу зохион байгуулна:

18.4.1.тухайн мэдээллийг нууцлах хугацаа дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө ажлын хэсэг байгуулан шинжилгээ хийлгэж, үндэслэл бүхий дүгнэлт гаргуулан тагнуулын байгууллагын саналыг авна;

18.4.2.мэдээллийг ил болгох талаар тагнуулын байгууллагын саналыг авсны дараа ажлын хэсэг төрийн нууцыг ил болгосон тухай нотолгоо бичиж, тухайн байгууллагын даргаар батлуулснаар төрийн хамгаалалтаас гарсанд тооцно;

18.4.3.төрийн хамгаалалтаас гаргасан нууц баримт бичиг, бусад тээгчид “ил болсон” гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ. Тухайн баримт бичгийг цаашид шилжүүлэх, хадгалах, нийтэд ашиглуулах асуудлыг албан хэрэг хөтлөлт болон архивын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ;

18.4.4.ажлын хэсэг мэдээллийг үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлын үүднээс цаашид үргэлжлүүлэн нууцлах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд тагнуулын байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 16.1-д заасан хугацаагаар нууцална;

18.4.5.нууц баримт бичиг, бусад тээгчийн нууцлах хугацааг сунгасан тохиолдолд “хугацааг сунгав” гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ.

18.5.Төрийн архивын хаалттай сан хөмрөгт хадгалагдаж байгаа нууц баримт бичиг, бусад нууц тээгчийг боловсруулсан буюу бүтээсэн байгууллагын эрх олгосноор, тухайн байгууллага, түүний эрх залгамжлагч байхгүй тохиолдолд төрийн архивын байгууллага нууцыг ил болгох, хугацааг сунгах асуудлыг энэ хуулийн 18.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

18.6.Энэ хуулийн 20.4-т заасан төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгохыг хориглоно.

ТАВДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦТАЙ ТАНИЛЦАХ

19 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах нөхцөл

19.1.Энэ хуулийн 20 дугаар зүйлд зааснаас бусад төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулна.

19.2.Хяналт шалгалт, аудитын болон тодорхой ажил, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн нууцтай танилцах иргэн, албан тушаалтанд энэ хуулийн 19.1-д заасан шаардлага нэгэн адил хамаарна.

19.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага тухайн байгууллагын хариуцсан төрийн нууцтай танилцах албан тушаалтны жагсаалтыг тагнуулын байгууллагын саналыг авч батална.

20 дугаар зүйл.Төрийн нууцтай танилцах тусгай нөхцөл

20.1.Хуулиар хориглоогүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

20.2.Хуулиар хориглоогүй бол Улсын Их Хурлын болон Засгийн газрын гишүүн хуралдаанаар хэлэлцэж шийдвэрлэх асуудлын хүрээнд төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

20.3.Төрийн нууцад хамаарах асуудлыг хянан шалгах зорилгоор Улсын Их Хурлаас байгуулсан ажлын хэсгийн гишүүн, эсхүл энэ зорилгоор тусгайлан эрх олгогдсон хүн тухайн шалгах асуудлын хүрээнд хуулиар хориглоогүй бол төрийн нууцтай зэрэглэл харгалзахгүйгээр танилцана.

20.4.Гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж болон гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлд холбогдох мэдээлэлтэй зөвхөн шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их Хурлын зөвшөөрснөөр Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хорооны дарга, гишүүд танилцах бөгөөд бусад хүн танилцахыг хориглоно.

20.5.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, мөрдөгч зөвхөн шалгаж шийдвэрлэх тодорхой хэрэг, маргаанд хамаарах төрийн нууцтай хуулиар тогтоосон журмын дагуу танилцана.

20.6.Энэ хуулийн 20.1-20.5-д заасан албан тушаалтан, Монголбанкны Ерөнхийлөгч, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, агентлагийн дарга, бүх шатны Засаг дарга аюулгүй байдлын шалгалтад хамрагдахгүй бөгөөд төрийн нууцыг задруулахгүй байх баталгаа гаргана.

21 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах эрх олгох

21.1.Төрийн нууцтай танилцах эрхийг дараах шаардлагыг хангасан иргэнд олгоно:

21.1.1.төрийн нууцтай танилцах эрх олгохтой холбоотойгоор аюулгүй байдлын шалгалт явуулахыг өөрөө бичгээр зөвшөөрсөн;

21.1.2.аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж, тэнцсэн;

21.1.3.төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргасан.

22 дугаар зүйл.Төрийн нууцтай танилцах эрх

22.1.Төрийн нууцтай танилцах эрх нь тухайн танилцах нууцын зэрэглэлээс хамааран түвшинтэй байх бөгөөд түүнийг олгохтой холбоотой харилцааг төрийн нууцыг хамгаалах нийтлэг журмаар зохицуулна.

23 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэл

23.1.Албан тушаалтан, иргэнд дараах үндэслэлээр төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзана:

23.1.1.төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангаагүй;

23.1.2.аюулгүй байдлын шалгалтад хамрагдах, төрийн нууцыг хамгаалах баталгааг бичгээр гаргаж өгөхөөс татгалзсан;

23.1.3.аюулгүй байдлын шалгалтад өөрийн тухай болон холбогдох бусад мэдээллийг танилцуулаагүй, эсхүл худал мэдээлсэн;

23.1.4.төрийн нууцыг хамгаалах журмыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчиж байсан;

23.1.5.Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтээ гаргасан;

23.1.6.сэтгэцийн өвчин, эмгэгтэй нь тогтоогдсон;

23.1.7.согтуурах, мансуурах донтой болох нь тогтоогдсон.

23.2.Төрийн нууцтай танилцах эрх олгохдоо тухайн албан тушаалтан, иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн болон шалгагдаж байгаа гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг харгалзан үзнэ.

24 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох

24.1.Гэмт хэрэгт сэжигтэн, яллагдагчаар татагдсан, эсхүл төрийн нууцыг хамгаалах журам зөрчсөн үйлдэлд шалгагдаж байгаа бол шүүхийн шийдвэр гарч хүчин төгөлдөр болох, эсхүл албаны шалгалтын дүн гарах хүртэл албан тушаалтан, иргэний төрийн нууцтай танилцах эрхийг тагнуулын байгууллага түдгэлзүүлж болно.

24.2.Албан тушаалтан, иргэний төрийн нууцтай танилцах эрхийг ажил, албан тушаалаас чөлөөлөгдсөн, халагдсан, энэ хуулийн 23 дугаар зүйлд заасан нөхцөл байдал илэрсэн, ажил гүйцэтгэх гэрээ дуусгавар болсон, төрийн нууцыг хамгаалах талаар тогтоосон журам, үүргээ удаа дараа болон ноцтой зөрчсөн тохиолдолд тагнуулын байгууллага хүчингүй болгоно.

25 дугаар зүйл.Аюулгүй байдлын шалгалт явуулах

25.1.Энэ хуулийн 20.6-д зааснаас бусад төрийн байгууллага, хуулийн этгээдийн төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалтыг тагнуулын байгууллага явуулна.

25.2.Энэ хуулийн 25.1-д заасан аюулгүй байдлын шалгалт явуулах журмыг тагнуулын байгууллагын дарга батална.

25.3.Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын ажилтны албан тушаалд сонгон шалгаруулах иргэнийг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу судалж, шалгана.

26 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэний үүрэг

26.1.Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, иргэн дараах нийтлэг үүрэг хүлээнэ:

26.1.1.төрийн нууцын тухай хууль тогтоомжийг сахин биелүүлэх;

26.1.2.танилцсан болон ажил, үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа задруулахгүй байх;

26.1.3.төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах;

26.1.4.нууц үрэгдэх, задрах нөхцөл байдал бий болсон, эсхүл үрэгдсэн, задарсан, нууц хамгаалах журам зөрчигдсэн бол нууц хамгаалах ажилтанд нэн даруй мэдэгдэх;

26.1.5.албаны болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон, өөр ажил, албан тушаалд шилжих тохиолдолд өөрт нь итгэмжлэн хариуцуулсан төрийн

нууц тээгчийг зохих ёсоор хүлээлгэн өгөх, албан үүргийн хувьд танилцсан төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргах;

26.1.6.хуульд өөрөөр заагаагүй бол хувийн хэргээр гадаад улсад зорчих тохиолдолд байгууллагадаа урьдчилан бичгээр мэдээлэх.

27 дугаар зүйл.Төрийн нууц хамгаалах ажилтны үүрэг

27.1.Төрийн нууц хамгаалах ажилтан энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ:

27.1.1.төрийн нууцын тухай хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх;

27.1.2.албан тушаалтан, албан хаагчид төрийн нууцыг ашиглах, хамгаалахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх;

27.1.3.салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үзлэг, тооллого зохион байгуулах;

27.1.4.төрийн нууцтай танилцах эрх олгогдсон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах;

27.1.5.гадаад улсын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай тагнуулын байгууллагад мэдэгдэх;

27.1.6.төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны шилжилт хөдөлгөөний талаар тагнуулын байгууллагад тухай бүр мэдэгдэх;

27.1.7.төрийн нууц хамгаалах журам зөрчигдсөн тохиолдолд албаны шалгалт явуулж, дүнг байгууллагын удирдлагад, шаардлагатай бол тагнуулын байгууллагад танилцуулах, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг нэн даруй авч хэрэгжүүлэх;

27.1.8.төрийн нууц задарсан, үрэгдсэн бол нэн даруй байгууллагын удирдлага болон тагнуулын байгууллагад мэдэгдэх.

28 дугаар зүйл.Нууц хамгаалах ажилтны хууль зүй, эдийн засгийн баталгаа

28.1.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь нууц хамгаалах ажилтныг чөлөөлөх, өөр ажил, албан тушаалд шилжүүлэх бол энэ тухай шийдвэр гаргахаас ажлын 5-аас доошгүй өдрийн өмнө тагнуулын байгууллагад мэдэгдэж, саналыг авсан байна.

28.2.Нууц хамгаалах болон шифр хариуцах ажилтанд Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно.

ЗУРГААДУГААР БҮЛЭГ ТӨРИЙН НУУЦЫГ ХАМГААЛАХ

29 дүгээр зүйл.Төрийн нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт

29.1.Монгол Улсын төрийн нууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газар чиглүүлэн удирдана.

29.2.Тагнуулын байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд улсын хэмжээнд нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах бүтцийн нэгжтэй байна.

29.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулах үүрэг, хариуцлагыг тэдгээрийн удирдлага хүлээнэ.

29.4.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн нууцтай холбоотой ажлын цар хүрээ, ачааллаас хамааран тэдгээрийн удирдлагад шууд захирагдах нууц хамгаалах нэгж, эсхүл ажилтантай байна.

29.5.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг энэ хуульд заасны дагуу хууль зүй, зохион байгуулалтын, техникийн болон бусад арга хэмжээний тусламжтайгаар хэрэгжүүлнэ.

30 дугаар зүйл.Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах

30.1.Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэх, илгээх, бүртгэх, устгах, бүрэн бүтэн байдлыг хангах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг энэ хууль болон Засгийн газрын баталсан төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

30.2.Төрийн нууцыг хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд илгээх, хүлээн авахад түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болно.

30.3.Хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд тусгай шуудан хүргэх, хүлээн авахтай холбогдсон харилцааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, тагнуулын байгууллагын даргын хамтарсан тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулна.

31 дүгээр зүйл.Төрийн нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх

31.1.Төрийн нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх бүхий удирдлагын шийдвэрээр төрийн нууцыг өөр төрийн байгууллага, хуулийн этгээдэд зохих журмын дагуу шилжүүлнэ.

31.2.Энэ хуулийн 31.1-д заасны дагуу төрийн нууцыг шилжүүлэн авах, эсхүл ашиглах төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хуульд заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлагыг хангасан байна.

32 дугаар зүйл.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцыг шилжүүлэх

32.1.Тагнуулын байгууллагын зөвшөөрлийг үндэслэн байгууллагын удирдлагын шийдвэрээр зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн нууцыг иргэн, хуулийн этгээдэд шилжүүлж болно.

32.2.Энэ хуулийн 32.1-д заасны дагуу нууцыг шилжүүлэн авах хуулийн этгээд нь энэ хуульд заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлага хангасан, иргэн нь төрийн нууцтай танилцах эрх авсан байна.

32.3.Ажил гүйцэтгэгч төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна.

32.4.Төрийн нууцад хамаарах мэдээлэл шинээр боловсруулах, шилжүүлэн авч, тодорхой ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна.

32.5.Энэ хуулийн 32.4-т заасан хуулийн этгээдийг судалж, шалгах, аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална.

33 дугаар зүйл.Төрийн нууцын техник, криптографийн хамгаалалт

33.1.Төрийн нууцыг хамгаалах техник, криптографийн арга хэмжээг төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ.

33.2.Төрийн нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгсэл нь мэдээллийг хамгаалах зохих шаардлага хангасныг баталгаажуулсан байна.

33.3.Төрийн нууцыг хамгаалах криптографийн хэрэгслийг ашиглах асуудлыг Засгийн газрын баталсан төрийн шифр харилцааны дүрмээр зохицуулна.

34 дүгээр зүйл.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн тохиолдолд төрийн нууцыг хамгаалах

34.1.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эсхүл төрийн нууцыг ашиглахтай холбоотой ажил дуусгавар болсон бол тухайн байгууллага, хуулийн этгээд өөрт байгаа төрийн нууц тээгчийг хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй.

34.2.Энэ хуулийн 34.1-д заасан тохиолдолд тухайн байгууллага, хуулийн этгээд төрийн нууц тээгчийг тогтоосон журмын дагуу дараах байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна:

34.2.1.тухайн төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх залгамжлагч, эсхүл харьяалах дээд шатны байгууллагад шилжүүлэх;

34.2.2.тухайн нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх;

34.2.3.энэ хуулийн 34.2.1, 34.2.2-т заасан байгууллага байхгүй тохиолдолд Үндэсний төв архивт шилжүүлэх.

34.3.Энэ хуулийн 34.2-т заасан төрийн нууц тээгчийг устгах, шилжүүлэх арга хэмжээг авахад тагнуулын байгууллага хяналт тавина.

35 дугаар зүйл.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах

35.1.Иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах асуудлыг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.

36 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт

36.1.Улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг зохих төсвийн хөрөнгөөс, бусад байгууллага, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

37 дугаар зүйл.Төрийн нууцын хамгаалалтад тавих хяналт

37.1.Тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулна.

37.2.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.

37.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тагнуулын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол энэ хуулийн 18.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.

37.4.Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална.

37.5.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага, тэдгээрийн нууц хамгаалах нэгж, ажилтан харьяа салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавина.

37.6.Ажил гүйцэтгэх гэрээний захиалагч нь тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор ажил гүйцэтгэгчид шилжүүлсэн төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих үүрэгтэй.

ДОЛДУГААР БҮЛЭГ БУСАД ЗҮЙЛ

38 дугаар зүйл.Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

38.1.Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хуульд заасны дагуу эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ.

38.2.Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараах хариуцлага хүлээлгэх саналыг харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ:

38.2.1.энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй бол албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;

38.2.2.энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, эсхүл мөн хуулийн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй бол албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах.

38.3.Харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан нь холбогдох албан тушаалтанд энэ хуулийн 38.2-т заасан хариуцлага хүлээлгэж, энэ талаар ажлын 10 өдрийн дотор тагнуулын байгууллагад хариу мэдэгдэнэ.

38.4.Энэ хуулийн 38.2-т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол тагнуулын байгууллагаас тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ.

38.5.Тагнуулын байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шаардлага, шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, иргэн холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй.

38.6.Энэ хуулийн 38.5-д заасныг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

38.7.Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

39 дүгээр зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

39.1.Энэ хуулийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/-ИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬ

1 дүгээр зүйл.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэгт заасны дагуу албаны нууцад хамааруулсан баримт бичиг, бусад зүйлийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн ил болгох арга хэмжээг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

2 дугаар зүйл.Монгол Улсын Засгийн газар нь Төрийн нууцын тухай /Шинэчилсэн найруулга/-ийн хэрэгжилтийг хангахад шаардлагатай дүрэм, журмыг батлах, хууль тогтоомжийн сургалт, сурталчилгаа, зохион байгуулалтын болон техник хэрэгсэл, санхүү, эдийн засгийн холбогдох арга хэмжээг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн дотор зохион байгуулна.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АРХИВ, АЛБАН ХЭРЭГ ХӨТЛӨЛТИЙН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.3 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 31.1, 31.2, 31.6 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.1 дэх заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Ашигт малтмалын тухай хуулийн 57 дугаар зүйлийн 57.3 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**БАЙГУУЛЛАГЫН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Байгууллагын нууцын тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГАМШГААС ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гамшгаас хамгаалах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.5 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ГЭРЧ, ХОХИРОГЧИЙГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.4 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ГҮЙЦЭТГЭХ АЖЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Гүйцэтгэх ажлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1.3 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2, 21.7 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ДИПЛОМАТ АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Дипломат албаны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАСГИЙН ГАЗАР ДАХЬ ХЯНАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Засгийн газар дахь хяналтын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3 дахь заалтын “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ЕРӨНХИЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Захиргааны ерөнхий хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.3 дахь заалт, 10 дугаар зүйлийн 10.4.3 дахь заалт, 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэг, 28 дугаар зүйлийн 28.1.6 дахь заалт, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗАХИРГААНЫ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэг, 75 дугаар зүйлийн 75.2.6 дахь заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зэвсэгт хүчний тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.20 дахь заалт, 18¹ дугаар зүйлийн 18^{1.6} дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 3.3 дугаар зүйлийн 4.9 дэх хэсэг, 3.4 дүгээр зүйлийн 4.4 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Зөрчлийн тухай хуулийг 2017 онд батлахдаа Төрийн болон албаны нууцын тухай хуульд нийцүүлэн “Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих” зөрчлийг хуульчилж, уг зөрчлийг Зөрчлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэгт заасны дагуу тагнуулын байгууллагын эрх бүхий албан тушаалтан харьяалан шийдвэрлэхээр заасан.

Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлд төрийн болон албаны нууцтай холбоотой дараах зөрчилд хуулийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан:

- төрийн болон албаны нууцад хамааруулах;
- төрийн болон албаны нууцтай танилцах;
- төрийн болон албаны нууцыг нууцлах, эсхүл ил болгох;
- төрийн болон албаны нууцыг шилжүүлэх, эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаархи тогтоосон журам зөрчсөн;
- төрийн болон албаны нууцад үл хамаарах мэдээлэл нууцалсан, эсхүл хувийн зорилгоор ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох.

Хуулийн хэрэгжилтийн хугацаанд 23 удаагийн зөрчлийн шинжтэй үйлдэлд зөрчлийн хэрэг бүртгэлт явуулж, үүнээс 14 иргэн, албан тушаалтанд зөрчлийн шийтгэл оногдуулжээ. Үүнээс 10 иргэнд Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт заасан “төрийн болон албаны нууцыг шилжүүлэх, эсхүл хамгаалах дэглэмийг хангах талаархи тогтоосон журам зөрчсөн” үндэслэлээр шийтгэл оногдуулсан байна.

Төрийн нууцын тухай хуулийн төслийн 3.1-д “Монгол Улсын иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллага, албан тушаалтан дагаж мөрдөнө” гэж, 32.4-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл шинээр боловсруулах, шилжүүлэн авч тодорхой ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна” гэж тус тус заасан бөгөөд хуулийн этгээд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр хуульд заасан эрх, үүргийн хүрээнд төрийн нууцын харилцаанд оролцох боломжтой юм.

Гэтэл зөрчлийн хариуцлагыг зөвхөн хувь хүнд оногдуулахаар хуульчилсан нь төрийн нууцын хууль тогтоомж зөрчсөн хуулийн этгээдэд хариуцлага хүлээлгэх боломжийг хязгаарлаж, эрх зүйн зохицуулалтын хийдэл үүсгэж байна. Энэ нь зөрчлөөс урьдчилан сэргийлэх, тэмцэх бодит үр нөлөөг бууруулахын зэрэгцээ шийтгэл, албадлагын арга хэмжээний төрөл, хэмжээ нь зөрчил үйлдэгдсэн нөхцөл байдал, зөрчлийн шинж, хохирлын хэр хэмжээнд тохирсон байх хуулийн зарчмыг алдагдуулах, төрийн нууцын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хязгаарлах эрсдэлтэй. Иймд хуулийн этгээдэд зөрчлийн шийтгэл оногдуулах зохицуулалтыг бий болгох нь байгууллагын бүтэц, бодлого, удирдлагын шийдвэр зэрэг байгууллагын түвшний хүчин зүйлсээс үүдэн гардаг зөрчлийн бодит шалтгаан, нөхцөлийг харгалзан үзэх, хариуцлагыг зөвхөн хувь хүнээр хязгаарлах зохицуулалтыг сул талыг арилгах чухал ач холбогдолтой гэж үзэж байна.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлийн 1.4 дэх заалт, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр” гэсний дараа “, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр” гэж тус тус нэмсүгэй.

2 дугаар зүйл.Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1.1-1.4 дэх заалт, 2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг, 15.34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Албаны нууцаас бусад” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИННОВАЦИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Инновацийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.4.4 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.6 дахь хэсэг, 46 дугаар зүйлийн 46.3 дахь хэсэг, 86 дугаар зүйлийн 86.2.6 дахь заалт, 110 дугаар зүйлийн 110.2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**КИБЕР АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Кибер аюулгүй байдлын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ
ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 24 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**МОНГОЛ УЛСЫН ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИССЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Монгол Улсын хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.7 дахь заалт, 26 дугаар зүйлийн 26.2 дахь хэсэг, 41 дүгээр зүйлийн 41.1.3 дахь заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

НИЙТИЙН МЭДЭЭЛЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.6.Хаалттай мэдээлэлд хамаарах төрийн нууцтай холбогдох Төрийн нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсгийн “албаны нууц болон” гэснийг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 12.10.1 дэх заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл.Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ӨМГӨӨЛЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Өмгөөллийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт, 20 дугаар зүйлийн 20.3 дахь хэсэг, 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ПАТЕНТЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Патентын тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1.6 дахь заалтын “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Тагнуулын байгууллагын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.11 дэх заалт, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэг, 17¹ дугаар зүйлийн 17¹.1.6 дахь заалт, 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТҮГЭЭМЭЛ ТАРХАЦТАЙ АШИГТ МАЛТМАЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.3 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.9 дэх заалтын “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төрийн нууцын тухай хуулийн төслийн 19 дүгээр зүйлд төрийн нууцтай танилцах ажил, албан тушаалд аюулгүй байдлын шалгалтын дүнг үндэслэн тодорхой зэрэглэлийн нууцтай танилцах эрх олгосон иргэнийг ажиллуулах бөгөөд хяналт шалгалт, аудитын болон тодорхой ажил, үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор төрийн нууцтай танилцах иргэн, албан тушаалтанд энэхүү шаардлага нэгэн адил хамаарахаар тусгасан.

Төрийн аудитын тухай хуулийн 6.4-т “Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргаас итгэмжилсэн аудитор аудит хийх бөгөөд уг аудитыг гүйцэтгэх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор батална” гэж заасан боловч Улсын Их Хурлын даргаас итгэмжлэл олгохоос өмнө тухайн аудитор нь төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангасан эсэх, түүнд тавих шаардлага зэргийг хуульчлаагүй байна.

Иймд Төрийн нууцын тухай хуулийн төсөлтэй уялдуулан Төрийн аудитын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулж, уг хуулийн төсөлд гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийх итгэмжилсэн аудитор нь төрийн нууцтай танилцах эрх олгогдсон байхаас гадна дараах шаардлагыг хангасан байхаар тусгалаа. Үүнд:

- 1.төрийн аудитын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;
- 2.мэргэшсэн нягтлан бодогч байх;
- 3.ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;
- 4.тухайн байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй байх.

Мөн Улсын Их Хурлын даргаас тухайн аудиторт итгэмжлэл олгохдоо хуульд заасан эрхлэх асуудал, хариуцсан чир үүргийн хүрээнд Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороонд урьдчилан танилцуулдаг байхаар, мөн гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад аудит хийх журмыг Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо баталдаг байхаар тус тус нарийвчлан зохицууллаа.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН АУДИТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.9, 6.10 дахь хэсэг нэмсүгэй:

“6.9.Энэ хуулийн 6.4-т заасан аудит хийх журмыг Монгол Улсын Ерөнхий аудитор боловсруулж, Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороо батална.

6.10.Энэ хуулийн 6.4-т заасан аудиторт итгэмжлэл олгохдоо Улсын Их Хурлын Тусгай хяналтын дэд хороонд танилцуулна.”

2 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“6.4.Гүйцэтгэх ажил эрхэлдэг байгууллагын гүйцэтгэх ажилд зориулсан улсын төсвийн хөрөнгийн зарцуулалтад Монгол Улсын Ерөнхий Аудиторын санал болгосноор Улсын Их Хурлын даргаас итгэмжилсэн аудитор аудит хийх бөгөөд аудитор нь дараах шаардлагыг хангасан байна:

6.4.1.төрийн аудитын байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан байх;

6.4.2.мэргэшсэн нягтлан бодогч байх;

6.4.3.ёс зүйн зөрчил гаргаж байгаагүй байх;

6.4.4.тухайн байгууллагатай ашиг сонирхлын зөрчилгүй байх;

6.4.5.төрийн нууцтай танилцах эрх олгогдсон байх.

3 дугаар зүйл.Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 15.3 дахь хэсэг, 37 дугаар зүйлийн 37.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн бус байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ТӨРИЙН ТУСГАЙ ХАМГААЛАЛТЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Төрийн тусгай хамгаалалтын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1.14 дэх заалт, 38 дугаар зүйлийн 38.1.6 дахь заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалт, 18 дугаар зүйлийн 18.7.3 дахь заалт, 19 дүгээр зүйлийн 19.4.12 дахь заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮЙ ОЛНООР ХӨНӨӨХ ЗЭВСЭГ ДЭЛГЭРҮҮЛЭХ БОЛОН
ТЕРРОРИЗМТОЙ ТЭМЦЭХ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтэй тэмцэх тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэг, 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХУВИРГАСАН АМЬД ОРГАНИЗМЫН ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хувиргасан амьд организмын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.5 дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.2.7 дахь заалтын “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цагдаагийн албаны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 69 дүгээр зүйлийн 69.1.4 дэх заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦЭРГИЙН АЛБА ХААГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.9 дэх заалтын “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЦӨМИЙН ЭНЕРГИЙН ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Цөмийн энергийн тухай хуулийн 11² дугаар зүйлийн 11^{2.3} дахь хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХ ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Шүүх шинжилгээний тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2 дахь хэсэг, 48 дугаар зүйлийн 48.2.4 дэх заалт, 49 дүгээр зүйлийн 49.2.3, 49.4.8 дахь заалт, 53 дугаар зүйлийн 53.2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 260 дугаар зүйлийн 260.2 дахь хэсэг, 273 дугаар зүйлийн 273.2.4 дэх заалтын “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

**ЭД ХӨРӨНГИЙН ЭРХИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсэг, 10 дугаар зүйлийн 10.9 дэх хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэх үйдлийг гэмт хэрэгт тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх талаар 1986 оны болон 2002 оны Эрүүгийн хуульд тусган төрийн нууцыг задруулах гэмт хэрэгт 8 жил хүртэл, төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэрэгт 2-3 жил хүртэл хорих ял оногдуулж байсан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэгт хамаарах төрийн нууцыг задруулах гэмт хэрэг нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд бусад этгээдэд мэдээллийг санаатайгаар дамжуулснаар төгсдөг. Харин төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэрэг нь төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг хадгалах, хамгаалах журам зөрчсөн (санаатай, эсхүл болгоомжгүйгээр) үйлдлийн улмаас нууц мэдээлэл бусдын мэдэлд орох нөхцөл бүрдэж, хор уршиг учирснаар төгсдөг онцлогтой.

2015 оны Эрүүгийн хуулиар төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэх гэмт хэрэгт оногдуулах ялын бодлого илүү уян хатан (эрх хасах, торгох, зорчих эрх хязгаарлах, хорих) болж, эрүүгийн хариуцлага гэмт этгээдийн үйлдсэн гэмт хэргийн нийгмийн аюулын шинж чанар, хэр хэмжээ, гэм буруугийн хэлбэрт тохирсон байх шударга ёсны зарчмыг хангах нөхцөлийг бүрдүүлсэн.

Төрийн нууцын тухай хуулийн төсөлд төрийн нууцын зэрэглэлийг “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц” гэж тогтоосоно бөгөөд эдгээр зэрэглэлд хамаарах мэдээллийг үндэсний аюулгүй байдалд учруулах хор хохирлоос хамааруулан ялган зүйлчлэх, түүнд тохирсон ялын бодлогыг тодорхойлох шаардлагын хүрээнд Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Эрүүгийн хуулийн 19 дүгээр зүйлийн 19.12 дугаар зүйл (Төрийн нууцыг задруулах), 19.13 дугаар зүйл (Төрийн нууцыг үрэгдүүлэх) гэмт хэргийн үндсэн объектод “маш нууц”, “онц чухал нууц” зэрэглэлийн мэдээлэл хамаардаг. Төрийн нууцын тухай хуулийн төсөлд “нууц” зэрэглэлийн мэдээллийг төрийн нууцад хамааруулахаар тусгасан тул уг мэдээллийн аюулгүй байдлыг Эрүүгийн хуулиар хамгаалах шаардлага бий болж байна.

Энэ хүрээнд “нууц” зэрэглэлд хамаарах төрийн нууц мэдээллийг задруулах, үрэгдүүлэх тохиолдолд хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээг тодорхойлж ялын бодлогын хувьд хамгийн бага, сонгох боломжтой байдлаар томъёолон тусгасан.

Өөрөөр хэлбэл, эрүүгийн эрх зүйн шударга ёсны зарчимд нийцүүлэн “Төрийн нууцыг задруулах”, “Төрийн нууцыг үрэгдүүлэх” гэмт хэргийн үндсэн болон хүндрүүлэх бүрэлдэхүүн нь төрийн нууц мэдээллийн нууцын зэрэглэлээс шууд хамаарах буюу оногдуулах ял шийтгэлийн хэмжээг харилцан адилгүй байхаар хуульчилсан болно.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуулийн дараах зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“1/19.12 дугаар зүйл. Төрийн нууцыг задруулах

1.Төрийн нууц зэрэглэлд хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, гадаадын тагнуулын алба, байгууллага, иргэнтэй хууль бусаар хамтран ажиллах гэмт хэргийн шинжгүй бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн маш нууцыг задруулсан бол гурван жил хүртэл хугацаагаар эрх хасаж нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

3.Энэ гэмт хэргийг үйлдэж төрийн онц чухал нууцыг задруулсан бол таван жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2/19.13 дугаар зүйл.Төрийн нууцыг үрэгдүүлэх

1.Төрийн нууц зэрэглэлд хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг итгэмжлэгдэн хариуцсан, албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд, тэдгээртэй харьцах талаар тогтоосон журам зөрчсөний улмаас үрэгдүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс хоёр мянга долоон зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийн улмаас төрийн маш нууцыг үрэгдүүлсэн бол хоёр мянга долоон зуун нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийн улмаас төрийн онц чухал нууцыг үрэгдүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох асуудлыг зохицуулсан бөгөөд уг зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох...”, 5 дахь хэсэгт “Хавтаст хэрэгт тусгагдаагүй...мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, бусад баримт болон гүйцэтгэх ажилтай холбоотой ямар ч баримт мэдээллийг шүүхийн хэлэлцүүлэг, урьдчилсан хэлэлцүүлэг явуулах, хэрэг хянан шийдвэрлэх шүүхэд танилцуулахыг хориглоно” гэж тус тус хуульчилсан.

Мөн хуулийн 32.1 дүгээр зүйлд хэргийн оролцогч нарт хавтаст хэргийн материал танилцуулах ажиллагааг тусгаж, мөн зүйлийн 5 дахь хэсэгт “Оролцогч хүсэлт гаргавал хавтаст хэргийн материалаас шүүхээр хэлэлцүүлэх төрийн нууцад хамаарахаас бусад нотлох баримтыг өөрийн зардлаар хуулбарлаж, хувилж авах боломжоор хангана. Талууд хуулбарлан авсан нотлох баримтыг шүүхэд шинжлэн судлахаас өөр зорилгоор ашигласан бол хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ” гэж заасан.

Албаны нууцад хамаарч байсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүн, холбогдох баримт сэлт ил болох тохиолдолд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан “...нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж” задрах эрсдэлийг дагуулахын зэрэгцээ хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад оролцогч нарт төрийн нууцаас бусад нотлох баримтыг хуулбарлан олгох нь мөрдөн шалгах нууц ажиллагааны нууцлал, аюулгүй байдал алдагдах эрсдэлийг бүрдүүлэхээр байна.

Иймд эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцогч талууд тэгш эрхтэй мэтгэлцэх, хавтаст хэргийн материалыг хуулбарлан авах эрхийг хангахын зэрэгцээ мөрдөн шалгах нууц ажиллагааны аюулгүй байдлыг хангах зайлшгүй шаардлага үүсэж байна.

Энэ хүрээнд мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн баримтаас холбогдох хэсгийг нууцалж гардуулах зохицуулалтыг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлтээр тусгах нь зүйтэй байна. Ингэснээр мөрдөн шалгах нууц ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалжийг хамгаалах, оролцогч талуудын амь нас, аюулгүй байдлыг хангах, цаашлаад эрүүгийн процессын шударга, найдвартай байдлыг баталгаажуулах чухал ач холбогдолтой.

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 32.1 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 13 дахь хэсэг нэмсүгэй:

“13.Мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг бэхжүүлсэн магадлагааг энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хуулбарлан өгөхдөө прокурор, мөрдөгч, оролцогч, бусад оролцогчийн аюулгүй байдалд эрсдэл учруулж болох, эсхүл мөрдөн шалгах нууц ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж ил болох үндэслэл бүхий сэжиг байгаа бол холбогдох хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж гардуулан өгнө.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 2.10 дахь заалт, 8.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 9.4 дүгээр зүйлийн 3.4 дэх заалт, 23.3 дугаар зүйлийн 3.11 дэх заалт, 29.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсгийн “болон албаны” гэснийг тус тус хассугай.

3 дугаар зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 34.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

БАТЛАВ.
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА

С.БЯМБАЦОГТ

БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН
САЙД

Б.ЭНХБАЯР

2025.11.19

ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ **ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно” гэж, Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4-т “иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ”, 7.5-д “төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно” гэсэн зорилтыг тусгасан ба тус бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.6.3-т “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно” гэж, 5.6.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна” гэж тус тус заасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 4.1.4.1-д “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно” гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023–2030 он)”-ийн 10.1.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар

төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь Төрийн нууцын жагсаалтыг хуулиар батлах хууль зүйн үндэслэл, шаардлагыг илэрхийлж байна.

1.2.Практик хэрэгцээ, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу төрийн нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох зорилгоор 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (2004 онд шинэчлэн найруулсан)-ийг тус тус баталснаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьсан.

Тодруулбал, Улсын Их Хурлаас 1995 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр баталсан Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээг тогтоосон бөгөөд үүнтэй нийцүүлэн төрийн нууцад хамааруулах зүйлсийн жагсаалтыг салбар тус бүрээр 1995 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (нийт-73), 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (нийт-60)-иар тус тус баталсан байна.

Одоогийн зохицуулалтын уялдаагүй байдал: 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон албаны нууцын тухай хуулиар төрийн нууцад хамааруулах мэдээллийн хүрээ, салбарыг нэгтгэн хуульчилж, тэдгээртэй нийцүүлэн мэдээллийн жагсаалтыг байгууллага тус бүрээр батлах эрхийг Засгийн газарт олгосон бөгөөд энэ нь төрийн нууцыг хуулиар тогтоох олон улсын нийтлэг зарчимд нийцэхгүй байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд “...салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй мэдээллүүд багтсан”, “...Засгийн газраас аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулахад төвлөрч, нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна” гэж дурдсан байна.¹

“Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төрийн нууцын жагсаалтад нийт 33 байгууллагын 574 мэдээлэл байна.

Уг жагсаалтад 2019-2024 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд мэдээллийн жагсаалтаас хассан-2, өөрчлөлт оруулсан-3, нэмсэн-14 тохиолдол байна.

Хяналт, хариуцлага: Төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын шийдвэрээр баталснаар Улсын Их Хурлын хяналт суларч, төрийн нууцын

¹ Хууль зүйн үндэсний хүрээлэн, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2023 он, 14-15, 29 дэх хуудас.

жагсаалтыг үндэслэлгүй өргөжүүлэх, үүнтэй холбоотойгоор хүн хүч, техник технологи, зохион байгуулалтын хувьд үр ашиггүй байдлыг үүсгэж байна.

Төрийн нууцын жагсаалтыг ард түмнээс сонгон байгуулсан төрийн эрх барих дээд байгууллага Улсын Их Хурлаар хэлэлцүүлэн батлуулах замаар хууль тогтоох байгууллагын хяналтыг сайжруулж, ардчиллын зарчмыг хэрэгжүүлнэ.

Үндэсний аюулгүй байдлыг хангах: Шүүхийн ерөнхий зөвлөлөөс ирүүлсэн судалгаанаас үзэхэд, 2013-2024 оны байдлаар Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан төрийн нууцыг хууль бусаар олж авсан-3, задруулсан-8, үрэгдүүлсэн-3 гэмт хэрэгт нийт 14 хүн ял шийтгэгдсэн байна.

Иймд төрийн нууцын жагсаалтыг үндэсний аюулгүй байдлын шинэ болон бодит аюул занал (кибер аюулгүй байдал, өндөр технологи, эдийн засгийн аюулгүй байдал) зэрэгт нийцүүлэн шинэчилнэ.

Хоёр.Хуулийн төслийн бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл нь мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг Монгол Улсын төрийн нууцад хамааруулах, хууль хүчин төгөлдөр болох гэсэн хоёр зүйлтэй байна.

Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, гадаад харилцаа, батлан хамгаалах, хууль зүй, дотоод хэрэг, эдийн засаг, байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, уул уурхай, зам, тээвэр, хүнс, хөдөө аж ахуй, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Авлигатай тэмцэх газар, төрийн аудит, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний статистикийн хороо, Цөмийн энергийн комисс, Төрийн албаны зөвлөл, харилцаа холбоо, мэдээллийн технологи, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар, тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын байгууллага, онцгой байдал, стандарт, хэмжил зүй, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурор, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг гаргаж, нууцын зэрэглэл, нууцлах хугацааг тодорхойлно.

Төрийн нууц нь “онц чухал нууц”, “маш нууц”, “нууц” гэсэн зэрэглэлтэй, нууцлах хугацаа нь мэдээллийн ач холбогдлоос хамааран байнга болон 10-30 жил хүртэл хугацаатай байхаар тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, хүрэх үр дүн, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний тухай санал

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн байгууллага, албан тушаалтан мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлаас урьдчилан сэргийлж, улмаар төрд итгэх олон нийтийн итгэлийг нэмэгдүүлэн, салбар, байгууллагын хэмжээнд мэдээллийг төрийн нууцад хэт өргөжүүлэн хамааруулах эрсдэл хумигдаж, төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох Үндсэн хуулийн үзэл санаа баталгаажна.

Түүнчлэн, төрийн нууцын жагсаалт нь цаг үеийн шаардлагад нийцэж, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах эрх бүхий байгууллагаас хууль хэрэгжүүлэхэд харьцангуй тодорхой, ойлгомжтой болно.

Дөрөв.Хуулийн төслийн Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай уялдсан байдал, шинээр боловсруулах болон нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хуулийн талаарх санал

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг хуульд заасан шаардлагын дагуу Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцүүлэн боловсруулна.

---o0o---

ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Үндсэн хуульд заасны дагуу 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (2004 онд шинэчлэн найруулсан)-ийг тус тус батлан төрийн нууцыг хамгаалах харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан.

Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, уг хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан.

Уг жагсаалтад 33 салбар, байгууллагын нийт 565 мэдээллийг төрийн нууцад хамааруулсан бөгөөд 2019-2024 онд нийт 12 мэдээллийг нэмж, 2 мэдээллийг хасаж, 3 мэдээллийг өөрчилсөн байна.

Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдаас Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарт даалгасан.

Үүний дагуу Ажлын хэсэг төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтнууд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлаас урьдчилан сэргийлэх, салбар, байгууллагын хэмжээнд нууцад хамаарах мэдээллийн хүрээг үндэслэлгүйгээр хэт өргөжүүлэхээс зайлсхийх зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа. Мөн кибер аюулгүй байдлын эрсдэл, өндөр технологийн хурдацтай хөгжлийг харгалзан үзэж, орчин үеийн шаардлагад нийцсэн зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийг “Төрийн бодлого”, “Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи”, “Батлан хамгаалах”, “Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил”, “Мэдээллийн аюулгүй байдал болон бусад” гэсэн хүрээнд ангилан тусгаж, хоёрдугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тодорхой зааж оруулсан.

Мэдээллийн жагсаалтыг боловсруулахдаа Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тусгагдсан 33 салбарын 575 мэдээлэлд үндэслэсэн бөгөөд төрийн 44 байгууллагаас санал авсан. Эдгээрээс 16 байгууллага хуулийн төсөлд “тусгайлан өгөх саналгүй” гэсэн бол үлдэх 28 байгууллагаас 265 мэдээлэлд нэмэлт,

өөрчлөлт оруулах болон төрийн нууцаас хасах санал ирүүлсний 196 саналыг хуулийн төсөлд тусгаж (шалгуур хангаж шууд тусгасан-93, өөрчлөн найруулж тусгасан-55, агуулгаар нэгтгэж тусгасан-43), 69 саналыг төрийн нууцад хамааруулах мэдээллийн шалгуур хангаагүй үндэслэлээр тусгаагүй болно.

Хуулийн төслийг боловсруулах ажлын хүрээнд Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар, Улсын Их Хурлын Тамгын газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, Гадаад харилцааны яам, Батлан хамгаалах яам, Зэвсэгт хүчин жанжин штаб, Цагдаагийн ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Онцгой байдлын ерөнхий газар, Хил хамгаалах ерөнхий газар, Төрийн тусгай хамгаалалтын газар зэрэг нийт 16 байгууллагатай уулзалт зохион байгуулж хамтран ажилласан.

Төрийн нууцад хамаарах мэдээллийг цаг үеэ олсон, үндэслэлтэй байх зарчим, Төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан шалгуурыг үндэслэн дүн шинжилгээ хийж, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд 200 мэдээллийг тусгав.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн бүтцийн тухайд:

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт Төрийн бодлогын хүрээнд: нийт **20 мэдээлэл**;
2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд: нийт **5 мэдээлэл**;
3. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт Батлан хамгаалах хүрээнд: нийт **70 мэдээлэл**;
4. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд: нийт **62 мэдээлэл**;
5. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд: нийт **43 мэдээллийг** тусгасан.

Төрийн нууцад хамаарах нийт мэдээллийн нууцын зэрэглэл:

- i. онц чухал нууц **39** мэдээлэл (онц чухал нууцад-10, онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-7, нууцалсан зэрэглэлээр-16, байнга нууцлах хугацаагаар-6);
- ii. маш нууц **138** мэдээлэл (үүнээс онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-7, маш нууц зэрэглэлд хамаарах-100, маш нууц/нууц зэрэглэлд-10, нууцалсан зэрэглэлээр-16, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-4, байнга нууцлах-1);
- iii. нууц **70** мэдээлэл (үүнээс нууц зэрэглэлд-43, маш нууц/нууц зэрэглэлд-10, нууцалсан зэрэглэлээр-16, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-1).

Төрийн нууцын тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо илүү боловсронгуй болж, төрийн байгууллага болон албан тушаалтан хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Мөн мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлаас урьдчилан сэргийлэх, төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох Үндсэн хуулийн үзэл санааг бататган хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

Хуулийн төсөл нь улсын төсөвт хүндрэл учруулахгүй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.18 дахь заалтад заасны дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх болон хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д “төр түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасан.

Үндсэн хуульд заасны дагуу 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (2004 онд шинэчлэн найруулсан)-ийг тус тус батлан төрийн нууцыг хамгаалах харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцооны эрх зүйн үндсийг тавьсан.

Улсын Их Хурлаас 1995 оны 04 дүгээр сарын 18-ны өдөр Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцад хамааруулах зүйлийн хүрээг тогтоож, түүнд нийцүүлэн төрийн нууцад хамааруулах зүйлсийн жагсаалтыг салбар тус бүрээр 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль (нийт-60)-иар баталж байсан.

Төрийн болон албаны нууцын тухай хууль 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 2004 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль хүчингүй болсон.

Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг 33 салбар, байгууллагын 565 мэдээлэлтэйгээр баталсан.

Уг жагсаалтад 2019-2024 онд Засгийн газрын тогтоолоор нийт 12 мэдээллийг нэмж, 2 мэдээллийг хасаж, 3 мэдээллийг өөрчилсөн байна.

Засгийн газрын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн хуралдаанаар Монгол Улсын Ерөнхий сайдаас Төрийн нууцын тухай, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга, Хууль зүй, дотоод хэргийн сайд, Тагнуулын ерөнхий газрын дарга нарт даалгасан.

Үүний дагуу Ажлын хэсэг төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх, төрийн байгууллага, албан тушаалтнууд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлаас урьдчилан сэргийлэх, салбар, байгууллагын хэмжээнд нууцад хамаарах мэдээллийн хүрээг үндэслэлгүйгээр хэт өргөжүүлэхээс зайлсхийх зорилгоор хуулийн төслийг боловсрууллаа. Мөн кибер аюулгүй байдлын эрсдэл, өндөр технологийн хурдацтай хөгжлийг харгалзан үзэж, орчин үеийн шаардлагад нийцсэн зохицуулалтыг тусгалаа.

Хуулийн төслийн нэгдүгээр зүйлд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийг “Төрийн бодлого”, “Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологи”, “Батлан хамгаалах”, “Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажил”, “Мэдээллийн

аюулгүй байдал болон бусад” гэсэн хүрээнд ангилан тусгаж, хоёрдугаар зүйлд хууль хүчин төгөлдөр болох хугацааг тодорхой зааж оруулсан.

Мэдээллийн жагсаалтыг боловсруулахдаа Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тусгагдсан 33 салбарын 575 мэдээлэлд үндэслэсэн бөгөөд төрийн 44 байгууллагаас санал авсан. Эдгээрээс 16 байгууллага хуулийн төсөлд “тусгайлан өгөх саналгүй” гэсэн бол үлдэх 28 байгууллагаас 265 мэдээлэлд нэмэлт, өөрчлөлт оруулах болон төрийн нууцаас хасах санал ирүүлсний 196 саналыг хуулийн төсөлд тусгаж (шалгуур хангаж шууд тусгасан-93, өөрчлөн найруулж тусгасан-55, агуулгаар нэгтгэж тусгасан-43), 69 саналыг төрийн нууцад хамааруулах мэдээллийн шалгуур хангаагүй үндэслэлээр тусгаагүй болно.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан бөгөөд хэлэлцүүлэгт төрийн нууц хариуцсан байгууллагуудын 50 гаруй төлөөлөл оролцож, санал, дүгнэлт өгснийг нэгтгэн хуулийн төсөлд тусгасан.

Төрийн нууцад хамаарах мэдээллийг цаг үеэ олсон, үндэслэлтэй байх зарчим, Төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан шалгуурыг үндэслэн дүн шинжилгээ хийж, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд 200 мэдээллийг тусгав.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн бүтцийн тухайд:

1. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх хэсэгт Төрийн бодлогын хүрээнд: нийт **20 мэдээлэл**

Нууцын зэрэглэлийн хувьд:

- “**онц чухал нууц**” зэрэглэлийн **8** (үүнээс онц чухал нууцад-2, онц чухал нууц/маш нууцад-2, нууцалсан зэрэглэлээр-4);
- “**маш нууц**” зэрэглэлийн **16** (үүнээс онц чухал нууц/маш нууцын зэрэглэлд-2, маш нууцын зэрэглэлд-5, маш нууц/нууцын зэрэглэлд-2, нууцалсан зэрэглэлээр-4, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-3);
- “**нууц**” зэрэглэлийн **9** мэдээлэл (үүнээс маш нууц/нууц зэрэглэлд-2, нууц зэрэглэлд-1, нууцалсан зэрэглэлээр-4, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-2).

2. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт Эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд: нийт **5 мэдээлэл**

Нууцын зэрэглэлийн хувьд:

- “**маш нууц**” зэрэглэлийн **5** (үүнээс маш нууц зэрэглэлд-3, маш нууц/нууц зэрэглэлд-1, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-1);
- “**нууц**” зэрэглэлийн **1** мэдээлэл (маш нууц/нууц зэрэглэлд-1).

3. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.3 дахь хэсэгт Батлан хамгаалах хүрээнд: нийт **70 мэдээлэл**

Нууцын зэрэглэлийн хувьд:

- “онц чухал нууц” зэрэглэлийн 6 (үүнээс онц чухал нууцын зэрэглэлд-5, нууцалсан зэрэглэлээр-1);
 - “маш нууц” зэрэглэлийн 46 (үүнээс маш нууц зэрэглэлд-45, нууцалсан зэрэглэлээр-1);
 - “нууц” зэрэглэлийн 17 мэдээлэл (нууц зэрэглэлд-16, нууцалсан зэрэглэлээр-1).
4. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.4 дэх хэсэгт Тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд: нийт **62 мэдээлэл**

Нууцын зэрэглэлийн хувьд:

- “онц чухал нууц” зэрэглэлийн 14 (үүнээс онц чухал нууцын зэрэглэлд хамаарах-1, онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-4, нууцалсан зэрэглэлээр-3, байнга нууцлах хугацаагаар-6);
 - “маш нууц” зэрэглэлийн 46 (үүнээс онц чухал нууц/маш нууцын зэрэглэлд-4, маш нууцын зэрэглэлд-31, маш нууц/нууцын зэрэглэлд-7, нууцалсан зэрэглэлээр-3, байнга нууцлах хугацаатай-1);
 - “нууц” зэрэглэлийн 19 мэдээлэл (үүнээс нууц зэрэглэлд-9, маш нууц/нууц зэрэглэлд-7, нууцалсан зэрэглэлээр-3).
5. Хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1.5 дахь хэсэгт Мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд: нийт **43 мэдээлэл**

Нууцын зэрэглэлийн хувьд:

- “онц чухал нууц” зэрэглэлийн 11 (үүнээс онц чухал нууцын зэрэглэлд-2, онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-1, нууцалсан зэрэглэлээр-8);
- “маш нууц” зэрэглэлийн 25 (үүнээс онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-1, маш нууц зэрэглэлд-16, нууцалсан зэрэглэлээр-8);
- “нууц” зэрэглэлийн 24 мэдээлэл (үүнээс нууц зэрэглэлд-16, нууцалсан зэрэглэлээр-8).

Төрийн нууцад хамаарах нийт мэдээллийн нууцын зэрэглэл:

- онц чухал нууц 39 мэдээлэл (онц чухал нууцад-10, онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-7, нууцалсан зэрэглэлээр-16, байнга нууцлах хугацаагаар-6);
- маш нууц 138 мэдээлэл (үүнээс онц чухал нууц/маш нууц зэрэглэлд-7, маш нууц зэрэглэлд хамаарах-100, маш нууц/нууц зэрэглэлд-10, нууцалсан зэрэглэлээр-16, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-4, байнга нууцлах-1);
- нууц 70 мэдээлэл (үүнээс нууц зэрэглэлд-43, маш нууц/нууц зэрэглэлд-10, нууцалсан зэрэглэлээр-16, тодорхой үйл явдал дуусгавар болох хүртэлх хугацаанд-1).

Албаны нууцын “нууц” зэрэглэлээс төрийн нууцын “нууц” зэрэглэлийн шалгуурыг хангасан 21 мэдээлэл байна:

1. Төрийн нууцад хамаарах баримт бичгийн бүртгэлийн дэвтэр;
2. Төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын талаар төрийн байгууллагуудын тайлан, мэдээлэл;
3. Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн нууцыг хамгаалах төлөвлөгөө;
4. Төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл агуулж буй мэдээллийн систем, сүлжээнд хийсэн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж;

5. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуяглан хүргэх ажлын болон оргосон хоригдогчийг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагааны заавар”;
6. Батлан хамгаалах салбарын цэргийн тоглолт, команд-штабын тактик, тусгай тактикийн сургуулийн сэдэв бодлого, төлөвлөгөө, тоглолт, дайны болон дайн бүхий байдлын үеийн хүн хүчний мэдээ, түүнд холбогдох бүртгэл, судалгаа, цэргийн шинжлэх ухаан, техник технологийн нээлт, инноваци, судалгаа-боловсруулалт, туршилт, сургалт, үйлдвэрийн мэдээ, баримт бичиг цэргийн тусгай шуудан, тусгай цахим шуудангийн зохион байгуулалт, хүч хэрэгсэл, маршрут зэрэг мэдээлэл багтсан.

Төрийн нууцын тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо илүү боловсронгуй болж, төрийн байгууллага болон албан тушаалтан хуулийг нэг мөр ойлгон хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ. Мөн мэдээллийг үндэслэлгүйгээр нууцад хамааруулах явдлаас урьдчилан сэргийлэх, төрийн нууцыг зөвхөн хуулиар тогтоох Үндсэн хуулийн үзэл санааг бататган хэрэгжүүлэхэд чухал ач холбогдолтой.

---o0o---

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2026 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн нууцад хамаарах мэдээлэл

1.1.Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1-д заасан төрийн бодлогын хүрээнд дараах мэдээлэл төрийн нууцад хамаарна:

Д/д	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц	
1.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, гадаад бодлогын үзэл баримтлал, номлолын нууцалбал зохих хэсэг	+			30
2.	Монгол Улсын Үндэсний аюулгүй байдал, гадаад бодлого, тусгаар тогтнол, бүрэн эрхт байдалтай холбоотой төрийн нууцад хамаарах асуудлаар гарсан нууцалбал зохих мэдээлэл (зөвлөмж, шийдвэр, тэдгээрийн хэрэгжилтийн тайлан)	+	+		30, 20
3.	Онц болон дайны байдал зарлах, цуцлах асуудал хэлэлцсэн Улсын Их Хурлын онцгой чуулганы хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл, холбогдох мэдээлэл, баримт бичиг, бусад тээгч	+			30
4.	Улсын Их Хурал, Байнгын хороо, дэд хороо, түр хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба, тэдгээрийн байгуулсан ажлын хэсгийн төрийн нууцад хамаарах мэдээлэл (тайлан, илтгэх хуудас, танилцуулга, хурлын тэмдэглэл, санал, дүгнэлт, холбогдох бусад баримт бичиг)	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
5.	Олон улсын парламентын холбоо, Ази, Номхон далайн орнуудын парламентын ээлжит чуулга уулзалтын хуралдаанаас нууцлан ирүүлсэн шийдвэр, мэдээлэл (факс, ноот бичиг, албан бичиг)		+		20
6.	Монгол Улсын Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын төрийн нууцад хамаарах шийдвэр, холбогдох мэдээлэл (зарлиг,	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр

	тогтоол, захирамж, тушаал, зөвлөмж, албан даалгавар, мэдээ, тайлан, илгээлт, уулзалт ярианы тэмдэглэл, тавьсан илтгэл, танилцуулга, үүрэг, чиглэл, хэлсэн үг)				
7.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанд холбогдох баримт бичиг (хэлэлцэх асуудлын жагсаалт, хуралдааны дэг, хөтөлбөр, санал, хуралдааны тэмдэглэл, шийдвэр, зөвлөмж, илтгэх хуудас, баримтлах үндсэн чиглэл, шинжээчийн дүгнэлт, тэдгээрийн төсөл, бусад нууц тээгч)	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
8.	Нэгдсэн үндэстний байгууллага, түүний төрөлжсөн байгууллага, олон улсын бусад байгууллагын тогтоол, шийдвэрийг батлахад болон сонгуульд Монгол Улсын баримтлах байр суурьтай холбогдох мэдээлэл (санал, чиглэл, үндэслэл, судалгааны баримт бичиг)		+		20, сонгууль, санал өгөх ажиллагаа дуустал
9.	Гадаад бодлого, хоёр болон олон талт хамтын ажиллагааны хүрээнд Монгол Улсын баримтлах байр суурийг нарийвчлан илэрхийлсэн мэдээлэл, гадаад улсын төрийн байгууллага, иргэдээс итгэмжилсэн байдлаар авсан мэдээлэл	+	+		30, 20
10.	Засгийн газар, Төв банкнаас гадаад улс, олон улсын байгууллагатай санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ, хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээлэл		+		Хуульд өөрөөр заагаагүй бол гэрээ, хэлэлцээр байгуулах хүртэл
11.	Дээд, өндөр түвшний харилцан айлчлалын үеэр яригдах төрийн нууцад хамаарах яриа, хэлэлцээний нууцалбал зохих хэсэг (сэдэв, санал, ярианы тэмдэглэл, баримт бичиг, илтгэх хуудас)		+		20
12.	Дээд, өндөр түвшний харилцан айлчлалыг хэрэгжүүлэх огноо, дэлгэрэнгүй хөтөлбөр			+	Айлчлалын талууд албан ёсоор зарлах, айлчлалыг хэрэгжүүлэх хүртэлх хугацаанд
13.	Төрийн нууцад хамаарах асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын		+	+	20, 10

	гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл				
14.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс дотоодын болон гадаад улсын төрийн байгууллагатай явуулж байгаа харилцаа, хамтын ажиллагааны төрийн нууцад хамаарах холбогдох мэдээлэл (ажлын чиглэл, удирдамж, гэрээ, хэлэлцээр, санамж бичиг, хурал, уулзалт, ярианы тэмдэглэл, хөтөлбөр, төлөвлөгөө, тайлан, танилцуулга, илтгэх хуудас, бусад холбогдох баримт бичиг)		+	+	20, 10
15.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед хилийн чанадад ажиллаж байгаа дипломат төлөөлөгчийн газрын ажиллах ерөнхий төлөвлөгөө, ажлын удирдамж		+		20
16.	Олон улсын хурал зөвлөгөөн, чуулганд оролцох дээд, өндөр түвшний болон Засгийн газрын төлөөлөгчийн яриа, хэлэлцээний сэдэв, санал, үндсэн чиглэл, ажлын удирдамж, ярианы тэмдэглэл, баримт бичиг, илтгэх хуудасны нууцалбал зохих хэсэг		+	+	Хуульд өөрөөр заагаагүй бол хурал, чуулган дуустал
17.	Улсын батлан хамгаалах, эдийн засагт чухал ач холбогдол бүхий үйлдвэр, онц чухал объектод гарсан гэмт халдлага, осол, сүйрэл, онцгой нөхцөл байдлын үед эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр, түүний хэрэгжилтийн талаарх мэдээлэл		+		20
18.	Үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай холбоотой Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тусгай төсөл, арга хэмжээний төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох бусад баримт бичиг	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
19.	Үндэсний аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, эрсдэлийг тооцох аргачлал, холбогдох бусад баримт бичиг		+		20
20.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, түүний харьяа байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны мэдээлэл, албан тушаалын тодорхойлолт			+	10

1.2.Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2-т заасан эдийн засаг, шинжлэх ухаан, техник технологийн хүрээнд дараах мэдээлэл төрийн нууцад хамаарна:

Д/д	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц	
1.	Эдийн засгийн аюулгүй байдлыг хангах бодлого, үйл ажиллагаатай холбоотой эрх бүхий байгууллагаас гаргасан төрийн нууцад хамаарах шийдвэр		+		20
2.	Улсын эрдэнэсийн нөөцийн сангийн байршил, хамгаалалтын зохион байгуулалтын тухай мэдээлэл		+		20
3.	Мөнгөн тэмдэгтийн нөөцийн талаарх мэдээлэл, тэдгээрийн байршил, тээвэрлэлт, хамгаалалтын зохион байгуулалтын тухай мэдээлэл		+		20
4.	Үндэсний аюулгүй байдал болон батлан хамгаалах чадавхад ач холбогдолтой шинжлэх ухаан, технологийн тухай мэдээлэл (технологийн ололт, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, туршилт, төсөл, тэдгээрийн үр дүн, холбогдох бусад баримт бичиг)		+	+	20, 10
5.	Мөнгөн тэмдэгтийн эх загварыг бүтээх төслийн үйл явц, мөнгөн тэмдэгт үйлдвэрлэх, устгах үйл ажиллагаа, мөнгөн тэмдэгтийн нийлүүлэлт, солилцоо, гүйлгээнээс гаргахтай холбоотой мэдээлэл		+		Хуульд өөрөөр заагаагүй бол үйл ажиллагаа дуустал

1.3.Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.3-т заасан батлан хамгаалах хүрээнд дараах мэдээлэл төрийн нууцад хамаарна:

Д/д	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц	
1.	Зэвсэгт хүчний стратегийн дэлгэн байгуулалт, дайнд ашиглах ерөнхий төлөвлөгөө, тайван цагийн болон дайны байдлын үеийн зохион байгуулалтын бүдүүвч	+			30
2.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд баталсан зэвсэгт хүчний хэрэглэх ерөнхий төлөвлөгөө		+		20
3.	Төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, ангийн дайны үеийн бүтэц, зохион байгуулалт, орон тоо, дугаар, холбогдох баримт бичиг		+		20
4.	Төрийн цэргийн байгууллагын бүх шатны удирдлагын байгууллага,		+		20

	нэгтгэл, анги, салбар, зангилгааны байлдааны цагийн нэр				
5.	Төрийн цэргийн байгууллагын байлдах чадвар, байлдааны бэлэн байдлыг тодорхойлсон нэгдсэн үзүүлэлт, мэдээлэл		+		20
6.	Цэргийн зэвсэглэл, байлдах чадварыг тодорхойлсон үнэлэлт бүхий сургалт бэлтгэлийн нэгдсэн дүн, шалгалтын акт, тайлан, илтгэл		+		20
7.	Зэвсэгт хүчний бэлэн байдал, байлдах чадварыг хангах зорилгоор хэрэгжүүлж байгаа төрийн цэргийн байгууллага, төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, салбарын стратегийн команд-штабын сургууль болон тусгай тактикийн сургуулийн нэгдсэн болон хэсэгчилсэн дадлагын сэдэв, бодлого, төлөвлөгөө, дүрслэл, холбогдох мэдээлэл			+	10
8.	Зэвсэгт хүчнийг байлдааны бэлэн байдлын дээд зэрэгт шилжүүлэх, байлдаанд бэлтгэх, шилжүүлэх төлөвлөгөө болон хавсралт төлөвлөгөө	+			30
9.	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн нэгтгэл, анги, салбар, байгууллагын байлдааны бэлэн байдлыг хангах, байлдааны бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх удирдамж, захирамж, төлөвлөгөө, мэдээ		+		20
10.	Төрийн цэргийн байгууллагын стратегийн удирдамж, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо	+			30
11.	Зэвсэгт хүчний нэгтгэл, ангийн стратеги, оперативын удирдамж, бэлэн байдлын зэрэгт шилжүүлэх төлөвлөгөө, тэдгээрийн биелэлт, тооцоо		+		20
12.	Орон нутгийн хамгаалалтын төлөвлөгөө, томилгоот хүч хэрэгслийн тооцоо, судалгаа, арга ажиллагааны тактикийн тухай мэдээлэл (улсын болон аймаг, нийслэлийн хэмжээнд)		+		20
13.	Улсыг агаарын довтолгооноос халхлах, хамгаалах үзэл баримтлал		+		20
14.	Зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалах цэргийн ажиллагааны төрөл, явуулах арга хэлбэрийг агуулсан мэдээлэл		+		20
15.	Төрийн цэргийн байгууллагын нэгтгэл, анги, байгууллагыг байгуулах,		+		20

	шилжүүлэн байрлуулах, татан буулгахтай холбогдох баримт бичиг				
16.	Төрөл мэргэжлийн цэргийн тагнуулын төлөвлөлт, удирдамж, захирамж, байлдааны даалгавар, тайлан, тагнуулын мэдээ, мэдээлэл солилцох журам, арга тактик, үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг		+		20
17.	Цэрэг-улс төр, цэрэг-стратегийн, цэрэг-эдийн засгийн орчин, гадаад орнуудын зэвсэгт хүчинд өгсөн үнэлгээ, түүнд холбогдох мэдээлэл		+		20
18.	Төрийн цэргийн байгууллагын байлдааны жижүүрлэлтийн зохион байгуулалт, ажиллагаатай холбогдсон удирдамж, захирамж, баримт бичиг, мэдээ, мэдээлэл		+		20
19.	Улсын онц чухал объектуудыг агаараас халхлах төлөвлөгөө, хүч хэрэгслийг ашиглах журам		+		20
20.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Зэвсэгт хүчний Жанжин штабын дайчилгааны төлөвлөгөө баталсан зарлиг, Зэвсэгт хүчний дайчилгааны нөөцийн бүрдүүлэлтийн талаар Засгийн газарт өгсөн чиглэл		+		20
21.	“Түгшүүр” дохиогоор ажилласан дүнгийн тухай нэгдсэн мэдээ, баримт бичиг		+		20
22.	“Цугларалт” дохиогоор ажилласан дүнгийн тухай нэгдсэн мэдээ, баримт бичиг			+	10
23.	Байлдааны нисэх онгоц, нисдэг тэрэгний байлдааны бэлэн байдал, аэродромын үзүүлэлт, зангилгааны бүдүүвч, байлдаанд ашиглах бодлого, төлөвлөгөө			+	10
24.	Цэргийн зэвсэглэлийг агаарын хилийн хамгаалалтад ашиглах дүрэм, журам, арга ажиллагаатай холбогдсон баримт бичиг мэдээ, агаарын довтолгооноос хамгаалах, торын түлхүүр, солих хугацаа			+	10
25.	Агаарын цэргийн бүх шатны удирдах байрны ажиллагааны зарчим, галт байрны байрлал, тэдгээрт хөтлөгдөх баримт бичиг			+	10
26.	Радиотехникийн салбарын байрлал, байлдааны үйл ажиллагаатай холбогдох баримт бичиг			+	10

27.	Байлдааны болон хил хамгаалалтын бэлэн байдлын мэдээ, байлдааны тушаал, захирамж, байлдааны ажиллагааны бүс, чиглэл, зааг, районы өгөгдөхүүн, газар орныг төхөөрөмжлөхтэй холбогдох мэдээлэл		+		20
28.	Батлан хамгаалах болон улсын хил хамгаалах зориулалттай, төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан нутаг дэвсгэрийн гравиметрийн зураглалын төрөл бүрийн хэмжээст зураглал, геодези, байрзүй, агаарын зураг	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
29.	Батлан хамгаалах болон үндэсний аюулгүй байдлыг хангах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан болон авахаар төлөвлөж буй газар, 1:500, 1:1000-ны газрын зураглал, тогтоол, шийдвэр, цахим өгөгдлийн сан, холбогдох мэдээлэл		+		20
30.	Батлан хамгаалах зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авсан газарт байрлах цэргийн мэргэжлийн дээд удирдлагын байгууллага, төрлийн цэргийн командлалын барилгын зураг төсөл			+	10
31.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд батлан хамгаалахад зайлшгүй шаардагдах нөөцийг бүрдүүлэх, зэвсэг, техникийг шинэчлэх төсвийг шийдвэрлэх талаар Засгийн газарт өгсөн чиглэл		+		20
32.	Улсын болон цэргийн дайчилгааны даалгавар, нөөц, нөхөн хангах тооцоо, тодотгол		+		20
33.	Дайчилгаатай сургууль явуулах баримт бичиг, дайчлах хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+		20
34.	Дайны үеийн орон тооны зэвсэглэл, цэргийн техник, тусгай зориулалтын багаж, галт хэрэглэлийн хангалт, хэрэгцээ, хөдөлгөөнийг тодорхойлсон мэдээ, данс бүртгэл, тайлан, захиалга		+		20
35.	Төрийн цэргийн байгууллагын байлдааны зэвсэг, цэргийн техник, материал, галт хэрэглэлийн хангалт, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл		+		20
36.	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн хүнс, шатахуун, тосолгооны материалын нэгдсэн захиалга, мэдээ, тайлан, төлөвлөгөө, тооллогын акт		+		20
37.	Зэвсэгт хүчний бүх шатны тагнуулын нэгжийн бүтэц, орон тоо, зохион		+		20

	байгуулалт, зэвсэг, техник хэрэгслийн тухай баримт бичиг, мэдээ, мэдээлэл				
38.	Цэргийн тусгай ачаа тээвэрлэж байгаа тухай нэгдсэн мэдээ, маршрут, харуул, хамгаалалтыг зохион байгуулах төлөвлөгөө			+	10
39.	Зэвсэг, галт хэрэглэлийн зарцуулалтын тайлан, мэдээ, устгалын акт			+	10
40.	Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл		+		20
41.	Цэргийн бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэрэгт бүртгэлтэй мэргэжлийн ангилал, дугаар		+		20
42.	Зэвсэгт хүчин, хилийн цэргийн нэгтгэл, анги, салбарын тайван цагийн орон тоо, бүртгэл, судалгаа			+	10
43.	Зэвсэгт хүчинд оногдуулан бүртгэгдсэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникийн нэгдсэн мэдээ, тооцоо (улсын хэмжээнд)		+		20
44.	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарт оногдуулан бүртгэгдсэн дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникийн нэгдсэн дүн, тооцоо (аймаг, нийслэлийн хэмжээнд)			+	10
45.	Төрийн цэргийн байгууллагын автоматжуулсан болон далдуур (удирдлага холбооны) удирдлагын системийн бүтэц, зохион байгуулалттай холбогдох баримт бичиг, хангалтын тухай мэдээлэл, ном материал, дүрэм, заавар		+		20
46.	Цэргийн далдуур удирдлага, үйл ажиллагаа, харилцаа, арга хэрэгсэл, материал, түүнтэй холбоотой мэдээлэл, техник хэрэгсэл, түлхүүрийн хангалт		+		20
47.	Төрийн цэргийн байгууллагын холбооны системийг байлдааны цагт дэлгэн байгуулах төлөвлөгөө, байлдааны дохио дамжуулах түлхүүрийн техник хэрэгсэл, нууцлалын баримт бичиг		+		20
48.	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, салбарын цэргийн далдуур удирдлагын ярианы таблиц, дотоод зохион байгуулалттай холбогдох баримт бичиг			+	10
49.	Зэвсэгт хүчний нууцалсан холбооны техникийн зохион байгуулалтын бүдүүвч, зориулалт, тоо хэмжээ, ашиглалтын заавар			+	10

50.	Төрийн цэргийн байгууллагын дайны болон дайн бүхий байдлын үеийн удирдлагын байрны бүтэц, зохион байгуулалт, байршил, хамгаалалтын зохион байгуулалт		+		20
51.	Дайчилгааны төлөвлөгөөг боловсруулж, тодотгох удирдамж, заавар	+			30
52.	Улсын дайчилгааны нэгдсэн төлөвлөгөө, зэвсэгт хүчнийг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах төлөвлөгөө, журам, удирдамж	+			30
53.	Зэвсэгт хүчний нэгтгэл, анги, байгууллага, салбарыг дайчилгаагаар өргөтгөн зохион байгуулах, дайчилгааны бэлтгэл нөөцийн бүрэлдэхүүн, техникээр нөхөн хангах төлөвлөгөө, журам, удирдамж, шийдвэр, тодотгол, холбогдох баримт бичиг		+		20
54.	Улсын болон цэргийн дайчилгааны зорилго, цар хүрээ, хэрэгжүүлэх арга хэмжээний төрөл, багтаамж, арга хэлбэр, зарлан мэдээллийн дохио, захирамж, явуулах төлөвлөгөө, заавар		+		20
55.	Төрийн захиргааны төв байгууллага болон аймаг, нийслэлийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл		+		20
56.	Төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллагын харьяа байгууллага, аж ахуйн нэгж, сум, дүүргийн дайчилгааны даалгавар, төлөвлөгөөний тухай мэдээлэл			+	10
57.	Улсын хил хамгаалалтыг зохион байгуулж, удирдах тухай удирдамж тушаал, шийдвэр, захирамж, төлөвлөгөө, холбогдох баримт бичиг		+		20
58.	Монгол Улс, Оросын Холбооны Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хилийг шалгах үед үйлдсэн протокол, холбогдох мэдээлэл		+		20
59.	Улсын хил хамгаалалтыг зохион байгуулах стратеги, оператив-тактикийн дүрэм (I, II анги), улсын хил хамгаалалт, шалган нэвтрүүлэх албаны арга ажиллагаа, холбогдох мэдээлэл		+		20
60.	Улсын хил хамгаалалтын үр дүнгийн танилцуулах мэдээ			+	10
61.	Улсын хил хамгаалалтын зориулалттай инженер, техникийн байгууламжийн			+	10

	үзүүлэлт, тэдгээрийн хамгаалалтын зохион байгуулалт				
62.	Монгол Улсын хилийн зурвас газрын заагийн эргэлтийн цэгийн солбилцол, талбайн хэмжээг илэрхийлсэн мэдээлэл		+		20
63.	Улсын стратегийн болон гамшгийн, батлан хамгаалах материаллаг нөөцийн бодит хэмжээ, байршил, агуулахын тоо, багтаамж, ажиллагаатай холбогдсон баримт бичиг, мэдээлэл		+		20
64.	Цэргийн зориулалттай цацраг идэвхт болон химийн хорт бодис, тэсэрч дэлбэрэх зүйлийн нөөцийн тоо, хэмжээ, хадгалж байгаа газар, тээвэрлэлт, харуул хамгаалалтын тухай мэдээ, тэдгээрийг бэлтгэх журам, арга ажиллагаатай холбогдох баримт бичиг		+		20
65.	Зэвсэг, цэргийн техник, галт хэрэглэлийн нөөц агуулахын хүчин чадал, өнгөлөн далдлалт, байрлалт, хамгаалалт, түүнд хүрэх замын тухай мэдээ		+		20
66.	Улсын стратегийн болон гамшгийн, батлан хамгаалах материаллаг нөөцийн талаарх тооцоо, судалгаа, холбогдох баримт бичиг		+		20
67.	Улс орныг дайны байдалд шилжүүлэх ерөнхий төлөвлөгөө	+			30
68.	Дайны болон дайн бүхий байдлын үед төрийн байгууллагын ажиллах төлөвлөгөө, түүнд холбогдох мэдээлэл		+		20
69.	Онцгой нөхцөл байдлын үеийн арга хэмжээний болон үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудын харилцан ажиллах журам, төлөвлөгөө, холбоо, зарлан мэдээллийн үйл ажиллагааны зохион байгуулалт, дэд бүтэц, удирдлагын байр, төсөв, байршил, хүчин чадлын тухай мэдээлэл, хэрэгжилтийн тайлан, холбогдох баримт бичиг		+		20
70.	Зэвсэгт хүчин, төрлийн цэргийн командлал болон хилийн цэргийн нэгтгэл, анги, байгууллага, салбарын санхүүжилт, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох мэдээлэл			+	10

1.4.Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.4-т заасан тагнуул, сөрөх тагнуул, хууль сахиулах ажлын хүрээнд дараах мэдээлэл төрийн нууцад хамаарна:

Д/д	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц	
а/ТАГНУУЛ, СӨРӨХ ТАГНУУЛ					
1.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхавчлахтай холбоотой мэдээлэл	+	+		Байнга
2.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх салбар, нэгжийн үйл ажиллагааг халхавчлахтай холбоотой мэдээлэл		+		20
3.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын нэгдсэн тоо бүртгэлийн болон тусгай сангийн мэдээлэл	+			Байнга
4.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын мэдээллийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл	+			30
5.	Гүйцэтгэх ажлын тусгай техник хэрэгслийн нэгдсэн тоо бүртгэл, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл		+		20
6.	Тагнуулын байгууллагын нууцалбал зохих салбар, нэгжийн бие бүрэлдэхүүн, барилга байгууламж, тэдгээрийн байршил, үйл ажиллагааг халхавчлахтай холбоотой мэдээлэл	+			30
7.	Тагнуулын төв байгууллагын гүйцэтгэх ажлын зориулалтаар ашиглах автотээврийн болон ердийн техник хэрэгсэл, тэдгээрт холбогдох баримт бичиг, бусад нууц тээгч		+	+	20, 10
8.	Тагнуулын байгууллагын мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах төлөвлөгөө, тайлан, мөрдөгчийн магадлагаа, нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл	+	+		30, 20
9.	Тагнуулын байгууллагаас гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл		+		20
10.	Тагнуулын байгууллагаас гүйцэтгэх ажлын шугамаар авагдсан мэдээ, мэдээллийг шалгах үйл ажиллагаа, холбогдох баримт бичиг		+		20
11.	Тагнуулын байгууллагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон		+		20

	асуудлаар гаргасан шийдвэр, журам, заавар, бусад баримт бичиг				
12.	Тагнуулын ерөнхий газрын даргын бүрэн эрхийн хүрээнд баталсан тагнуулын байгууллагын дотоод үйл ажиллагаанд холбогдох дүрэм, журам, зааврын нууцалбал зохих хэсэг			+	10
13.	Тагнуулын байгууллагын салбар, нэгжийн хэтийн төлөвлөгөө, стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөртэй холбогдох баримт бичиг (биелэлт, бодлогын судалгаа, түүний дүгнэлт, санал)	+	+		20, 10
14.	Тагнуулын байгууллага, түүний төв, орон нутаг дахь салбар, нэгж болон тагнан турших, түүнтэй адилтгах албан тушаалтны гүйцэтгэлийн төлөвлөгөө, тайлан	+	+		20, 10
15.	Тагнуулын байгууллагын тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлж буй ажилтны хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт, холбогдох баримт бичиг	+			20
16.	Тагнуулын байгууллагын тагнан турших болон түүнтэй адилтгах ажил эрхэлж буй ажилтнаас бусад албан хаагчийн хувийн хэрэг, албан тушаалын тодорхойлолт, холбогдох баримт бичиг			+	10
17.	Тагнуулын төв байгууллагын төв, орон нутаг дахь салбар, нэгжийн удирдах ажилтны зөвлөгөөнд холбогдох баримт бичиг (төлөвлөгөө, хөтөлбөр, хэлэлцэх асуудал, сэдэв, агуулга, илтгэл, шийдвэр, биелэлт)			+	10
18.	Тагнуулын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны нэгдсэн мэдээлэл, холбогдох баримт бичиг	+			20
19.	Тагнуулын байгууллагын төв, орон нутаг дахь салбар, нэгжийн бүтэц, орон тооны мэдээлэл, холбогдох баримт бичиг	+	+		20, 10
20.	Тагнуулын байгууллагын төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох мэдээлэл	+			20
21.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажлын зардал, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох мэдээлэл	+			20
22.	Төр засгийн эрх бүхий байгууллагаас тагнуулын байгууллагын үйл ажиллагааг шалгасан тухай баримт бичиг, тэдгээрийн хэрэгжилтийн талаарх мэдээлэл	+			20

23.	Тагнуулын байгууллагын нууц гүйцэтгэх ажилтны хувийн хэргийн болон тэдний албан ажилтай холбоотой мэдээлэл	+	+		30, 20
24.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд тагнуулын байгууллагын гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтныг одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасах тухай зарлиг	+	+		30, 20
25.	Тагнуулын байгууллагаас үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
26.	Тагнуулын байгууллагын тусгай архивын данс, бүртгэл		+		20
27.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд баталсан террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааны дүрэм, заавар, төлөвлөгөө		+		20
28.	Тагнуулын байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, террор, хорлон сүйтгэх ажиллагаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио, холбогдох баримт бичиг		+		20
29.	Тагнуулын байгууллагын гүйцэтгэх салбар, нэгжийн боловсруулсан нөхцөл байдлын мэдээ, гадаад дотоод орчны үнэлгээ, мэдээллийн даалгавар, танилцуулга, шуурхай мэдээ, танилцуулах мэдээ, тойм мэдээ, лавлагаа, гүйцэтгэх ажилтны илтгэх хуудас, мэдээ		+		20
30.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор тагнуулын байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа, тэдгээрт холбогдох баримт бичиг	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
31.	Тагнуулын байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, мэдээллийн сан, техник технологи, тоног төхөөрөмж, холбогдох мэдээлэл		+		20
32.	Тагнуулын төв байгууллагын тоон шинжилгээний лабораторийн цахим нотлох баримтын аюулгүй байдлыг хангах мэдээллийн систем, сүлжээний бүтэц зохион байгуулалт, эх код, техник, программ хангамжийн тохиргоо,			+	10

	тэдгээрийн ажиллагааны зарчим, холбогдох баримт бичиг				
33.	Тагнуулын байгууллагын кибер халдлага, зөрчилтэй тэмцэх нэгжид ашиглагдаж буй мэдээллийн систем, сүлжээний бүтэц зохион байгуулалт, техник, программ хангамжийн тохиргоо, тэдгээрт холбогдох баримт бичиг			+	10
34.	Тагнуулын төв байгууллага түүний төв, орон нутаг дахь салбар, нэгжийн барилга байгууламжийн зураг төсөл, холбогдох баримт бичиг			+	10
35.	Тагнуулын ажилтны мэргэжил олгох, мэргэшүүлэх сургалтын хөтөлбөр, түүнд холбогдох мэдээлэл			+	10
36.	Тагнуулын байгууллагын зэвсэг, тусгай хэрэгсэл, материал техникийн хангалт, нөөцийн мэдээлэл, тоо бүртгэл, холбогдох баримт бичиг		+	+	20, 10
37.	Тагнуулын байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа мэдээллийн систем, дэд бүтэц, зохион байгуулалт, программ хангамжийн эх код, нууцалбал зохих хэсэг		+		20
38.	Тагнуулын байгууллагаас гадаад улсын тусгай албатай тогтоосон хамтын ажиллагаа, холбогдох мэдээлэл		+		20
Б/ХУУЛЬ САХИУЛАХ АЖИЛ					
1.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын гүйцэтгэх ажлын мэдээллийн эх сурвалж, тэдгээрийг халхавчлахтай холбоотой мэдээлэл	+			Байнга
2.	Гүйцэтгэх ажлын тоо бүртгэлийн болон тусгай сангийн мэдээлэл	+			Байнга
3.	Гүйцэтгэх ажлын мэдээллийн болон тусгай техник хэрэгслийн тоо бүртгэлийн сан, түүнд ашиглагдаж байгаа тусгай зориулалтын техник, технологи, программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл		+		20
4.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын бие бүрэлдэхүүнийг нууцалбал зохих салбар нэгж, тэдгээрийн барилга байгууламж, нууц байр, уулзалтын байр, халхавчийн байгууллага, байршил, тээврийн хэрэгслийн улсын дугаар, тэдгээрийг халхавчлах болон гүйцэтгэх ажлын		+		20

	тусгай техник хэрэгсэл, түүнийг ашиглах үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл				
5.	Гүйцэтгэх ажлын шугамаар шалгасан болон шалгаж байгаа хэргийн материал, баримт сэлт, мэдээлэл		+		20
6.	Прокурорын зөвшөөрлөөр явагдах гүйцэтгэх ажлын арга хэмжээний төлөвлөгөө, үр дүнгийн талаарх танилцуулга		+		20
7.	Үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтанд илгээсэн мэдээлэл		+	+	20, 10
8.	Монгол Улсын үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгоор төрийн эрх бүхий байгууллагаас хэрэгжүүлж байгаа үйл ажиллагаа		+	+	20, 10
9.	Гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, журам, заавар, бусад баримт бичиг		+		20
10.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын хуяглан хүргэх ажлын болон оргосон хоригдогчийг эрэн сурвалжлах, баривчлах ажиллагааны заавар			+	10
11.	Гүйцэтгэх ажилтны хувийн хэрэг, үйл ажиллагааны үндсэн төлөвлөгөө, тайлан, албан тушаалын тодорхойлолт		+		20
12.	Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, хэрэг, маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны нууцалбал зохих баримт бичиг, мэдээлэл	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
13.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын гүйцэтгэх салбар нэгжийн бүтэц, зохион байгуулалт, орон тооны талаарх мэдээлэл		+		20
14.	Гүйцэтгэх ажлын зардал, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлангийн мэдээлэл		+		20
15.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагуудын гүйцэтгэх ажлын санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын, төсвийн гүйцэтгэлийн тайлан, түүнд холбогдох мэдээлэл		+		20
16.	Террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагаа явуулах үйл ажиллагаанд холбогдох баримт бичиг		+		20
17.	Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэх ажилтан, нууц гүйцэтгэх ажилтныг одон, медалиар шагнах, хүртээсэн цол, шагнасан одон, медалийг хасах тухай зарлиг		+		20

18.	Нууц гүйцэтгэх ажилтны хувийн хэргийн болон тэдний албан ажилтай холбоотой мэдээлэл		+		20
19.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын тусгай архивын данс, бүртгэл		+		20
20.	2010 оноос өмнө цаазаар авах ял гүйцэтгэсэн тухай баримт бичиг, мэдээлэл	+			Байнга
21.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагыг өндөржүүлсэн бэлэн байдалд шилжүүлэх төлөвлөгөө, террор, хорлон сүйтгэх ажиллагаа, зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх ажиллагааны төлөвлөгөө, удирдамж, хэрэглэх дохио, холбогдох баримт бичиг		+		20
22.	Гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын өөрийн аюулгүй байдлыг хангах ажлын зохион байгуулалт, арга, тактик, хүч, хэрэгсэл, төлөвлөгөөний мэдээлэл		+		20
23.	Хууль сахиулах байгууллагын галт зэвсэг, галт хэрэглэлийн тоо, бүртгэл, захиалга, нөөцийн талаарх мэдээлэл			+	10
24.	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан нүүлгэн шилжүүлэх, баримт бичгийг солих, гадаад төрхийг өөрчлөх арга хэмжээний явц, уг арга хэмжээгээр хамгаалагдсан этгээдийн нууцалбал зохих мэдээлэл	+			Байнга

1.5.Төрийн нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.5-д заасан мэдээллийн аюулгүй байдлын болон бусад хүрээнд дараах мэдээлэл төрийн нууцад хамаарна:

Д/д	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц	
1.	Тусгай хэрэглээний мэдээлэл, холбооны сүлжээ болон Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээний тусгай хэрэглээний сүлжээний бүтэц, зохион байгуулалт, түүнд ашиглагдаж буй мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, программ хангамж, радио давтамж, станцын байршил, тэдгээрийн ажиллагааны зарчим, холбогдох баримт бичиг		+		20
2.	Үндэсний хэмжээний кибер халдлага, зөрчлийн үед эрх бүхий байгууллагаас		+		20

	авч хэрэгжүүлж байгаа ажил, арга хэмжээ, түүнтэй холбоотой баримт бичгийн нууцалбал зохих хэсэг				
3.	Төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл агуулж буй мэдээллийн систем, сүлжээнд үйлдэгдсэн кибер халдлага, зөрчилд хариу арга хэмжээ авахтай холбоотой арга ажиллагаа, баримт бичгийн нууцалбал зохих хэсэг			+	10
4.	Улсын Их Хурал, Засгийн газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, эх код, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл болон холбогдох баримт бичиг		+		20
5.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан		+		20
6.	Төрийн нууцад хамаарах мэдээ, мэдээлэл агуулж буй мэдээллийн систем, сүлжээнд хийсэн кибер аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, мэдээллийн аюулгүй байдлын аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмж			+	10
7.	Зэвсэгт хүчний кибер аюулгүй байдлыг хангах байгууллагын кибер халдлага, зөрчилтэй тэмцэх чиглэлээр ашиглаж буй мэдээллийн систем, сүлжээний бүтэц зохион байгуулалт, техник, программ хангамжийн тохиргоо, тэдгээрт холбогдох баримт бичиг		+		20
8.	Замын хөдөлгөөний удирдлагын техник хэрэгслийг зохицуулахад ашиглагдах мэдээллийн систем, сүлжээний бүтэц, зохион байгуулалт, эх код, программ хангамж, тэдгээрийн ажиллагааны зарчим, холбогдох баримт бичиг			+	10
9.	Төрийн шифр харилцааны бодлого, криптографын боловсруулалт, шифрийн арга ажиллагаа, аргачлал, алгоритм, схем, эх код, кодын ном, түлхүүр, сан, нөөц, тэдгээрийг ашиглах заавар, хангалт, түүнд холбогдох мэдээлэл	+			30
10.	Шифрийн тусгай техник хэрэгсэл	+			30
11.	Төрийн шифр харилцааны бүтэц, зохион байгуулалт, түүнд холбогдох мэдээлэл		+		20
12.	Төрийн шифр харилцааны дүрэм, журам, үйл ажиллагааны заавар, шифрийн материал, хэрэгслийн бүртгэл		+		20
13.	Төрийн шифр мэдээ	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр

14.	Төрийн шифр харилцаанд шифрийн ажил хариуцах ажилтны зөвшөөрөл, баталгаа, шифрийн үйл ажиллагааны бүртгэл			+	10
15.	Төрийн нууцад хамаарах мэдээлэл тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, устгасан тухай мэдээлэл			+	10
16.	Төрийн нууцад хамаарах мэдээлэл тээгчийг шалгасан тухай мэдээлэл	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
17.	Төрийн нууцад хамаарах баримт бичгийн бүртгэлийн дэвтэр			+	10
18.	Төрийн нууцын хадгалалт хамгаалалтын талаар төрийн байгууллагуудын тайлан, мэдээлэл			+	10
19.	Онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн нууцыг хамгаалах төлөвлөгөө			+	10
20.	Төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг ашиглан бэлтгэсэн ном, сурах бичиг, бүтээл, эрдэм шинжилгээ, судалгааны ажил, тайлан илтгэл, мэдээлэл, дүгнэлт, санал, зөвлөмж, хурал, зөвлөгөөн, лекц, сургалтын хөтөлбөр	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
21.	Төрийн тусгай хамгаалалтын нэгдүгээр зэрэглэлээр хамгаалуулж байгаа хамгаалуулагчийн эрүүл мэндийн байдлын тухай мэдээлэл		+		20
22.	Улсын онц чухал болон тусгай объектын зураг, хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+		20
23.	Ерөнхийлөгчийн ордон, өргөө, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдын зориулалтын орон сууц байрлах төрийн тусгай хамгаалалт бүхий газрын газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичиг, барилга байгууламжийн зураг төсөл		+		20
24.	Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөл, бүтээн байгуулалтын ажил, зохион байгуулалттай холбоотой мэдээлэл		+		20
25.	Аймаг, нийслэлийн цэвэр ус хангамжийн эх үүсвэрийн барилга, байгууламжийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч хэрэгслийн тухай мэдээлэл		+		20
26.	Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бусад нууц тээгчийг битүүмжлэн хүргэх төрийн тусгай болон дипломат		+		20


	шуудан, битүүмжлэхээс хэрэглэгчид хүртэлх үйл ажиллагаа				
27.	Төрийн нууцад хамаарах асуудлаар эрх бүхий албан тушаалтнаас гарсан тогтоол, зөвлөмж, тушаал, төлөвлөгөө, тайлан	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
28.	Төрийн нууцад хамаарах бараа, ажил, үйлчилгээ худалдан авахтай холбоотой мэдээлэл	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
29.	Төрийн нууцад хамаарах асуудлаар Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газарт танилцуулсан мэдээлэл, холбогдох баримт бичиг	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
30.	Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
31.	Төрийн нууцад хамаарах асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, бусад нууц тээгч	+	+	+	Нууцалсан зэрэглэлээр
32.	Хуулиар төрийн тусгай хамгаалалтад байх албан тушаалтан, иргэн болон хурал, чуулган, арга хэмжээ, тээврийн хэрэгсэл, бусад зүйлийн байнгын болон цаг үеийн хамгаалалтын зохион байгуулалт, хүч, хэрэгслийн тухай мэдээлэл		+		20
33.	Төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулахтай холбоотой журам, заавар		+		20
34.	Төрийн тусгай хамгаалалтын аюулгүй байдлын эрсдэлийн үнэлгээ, түүнд холбогдох мэдээлэл			+	10
35.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын зохион байгуулалтын бүтэц, орон тооны нэгдсэн мэдээлэл, холбогдох баримт бичиг			+	10
36.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын төсөв, тэдгээрийн гүйцэтгэлийн тайлан, холбогдох мэдээлэл			+	10
37.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын хэтийн төлөв, стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр, тэдгээрийн биелэлт, холбогдох баримт бичиг			+	10
38.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас гадаад улсын төрийн байгууллагатай байгуулсан харилцаа, хамтын ажиллагааны холбогдох мэдээлэл (уулзалт ярианы тэмдэглэл, хөтөлбөр, төлөвлөгөө тайлан, баримт бичиг)			+	10

39.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллагын галт зэвсэг, сумны нэгдсэн болон тооллогын мэдээлэл, агуулахын байршил			+	10
40.	Төрийн тусгай хамгаалалтын байгууллага, түүний салбар, нэгжийн үйл ажиллагааны төлөвлөгөө, тайлан			+	10
41.	Улсын онц чухал болон тусгай объект, үйл ажиллагааг халхлах, хамгаалах журам, заавар	+	+		30, 20
42.	Төрийн тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын хөрөнгийн мэдээлэл, тэдгээрт холбогдох тогтоол, шийдвэр, бусад нууц тээгч		+		20
43.	Төрийн нууцын архивын данс, бүртгэл, жагсаалт			+	10

2 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох

2.1.Энэ хуулийг 2026 оны 11 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ



**ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН**

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫНТУХАЙ ХУУЛИЙН
ХЭРЭГЖИЛТИЙН ҮР ДАГАВРЫН
ҮНЭЛГЭЭ**

2023

**Улаанбаатар хот
2023 оны 5 дугаар сар**

Судалгааг удирдсан:

Г.Давааням

Эрдэмтэн нарийн бичгийн дарга
Хууль зүйн ухааны доктор (LLD.)

Судалгааг гүйцэтгэсэн:

Б.Энх-Амгалан

Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

Э.Сэлэнгэ

Эрдэм шинжилгээний ажилтан

АГУУЛГА

ТОВЧЛОЛ	3
УДИРТГАЛ.....	4
НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ	5
1.1 Үнэлгээ хийх шалтгаан	5
1.2 Үнэлгээ хийх хүрээ.....	6
1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт	8
1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр.....	8
1.5 Шалгуур үзүүлэлтийг томьёолох	9
1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох	9
ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	11
ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ	13
3.1 Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх болон цаг үеэ олсон байх зарчим	13
3.2 "Төрийн нууц" гэх нэр томьёоны тодорхойлолт	15
3.3 "Албаны нууц" гэх нэр томьёоны тодорхойлолт	19
3.4 Засгийн газраас төрийн нууц мэдээллийн жагсаалт батлах зохицуулалт	27
3.5 ТБАНтХ-д заасан тагнуулын байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг	31
ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	34
ЭХ СУРВАЛЖ.....	38
ХАВСРАЛТ	

ТОВЧЛОЛ

ТБАНтХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
НҮБ	Нэгдсэн Үндэстний Байгууллага
ҮАБЗ	Үндэсний аюулгүй байдлын зөвлөл
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар

УДИРТГАЛ

Хууль зүй, дотоод хэргийн яамны захиалгаар Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Энэхүү ажлын зорилго нь хуулийн хэрэгжилтийн явц дахь ололтыг бататгахын зэрэгцээ хуулийг хэрэгжүүлснээр гарч буй хүндрэл, бэрхшээлтэй асуудал, нийгэмд үзүүлж буй эерэг, сөрөг байдлыг илрүүлэн, тодорхой шалгуур үзүүлэлтэд үндэслэн дүгнэлт гаргах, цаашид зохистой, үр дүнтэй хэрэгжүүлэх боломжит хувилбарыг тодорхойлж, зөвлөмж боловсруулахад оршино.

Хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх ажил нь төлөвлөх, хэрэгжүүлэх, үнэлэх гэсэн үндсэн гурван үе шатаас бүрдсэн болно.

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Төлөвлөх үе шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож, түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. Үүнд:

- ✓ Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох;
- ✓ Үнэлгээ хийх хүрээг тогтоох;
- ✓ Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох;
- ✓ Харьцуулах хэлбэрийг сонгох;
- ✓ Шалгуур үзүүлэлтийг томъёолох;
- ✓ Мэдээлэл цуглуулах аргыг сонгох.

1.1 Үнэлгээ хийх шалтгаан

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” хэмээн заажээ.

Монгол Улсад 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьсан. Төрийн нууцын тухай хуульд 2001, 2003, 2004 (2 удаа), 2014, 2015, 2017 онд буюу нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. 1995 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг 2004 онд шинэчлэн найруулсан бөгөөд нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна. Уг хууль Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдах хүртэл хэрэгжиж байв.

Төрийн болон албаны нууцын тухай хууль /цаашид “ТБАНТХ” гэх/ 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, 2020, 2021 онд тус тус нэмэлт, өөрчлөлт орж байсан боловч өнөөдрийг хүртэл уг хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийгдээгүй. Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр зааагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно” гэж заасан.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.4.3-т “Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан бүрдүүлж, Улсын Их Хурал, орон

нутгийн иргэдийн төлөөллийн байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан иргэдийг үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудаар өргөн хүрээтэй мэдээллээр хангах механизмыг бий болгоно. Төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засгийн үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ” гэж, 3.6.4.4-т “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж, 3.6.4.5-т “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх”-ээр тусгасан байна. Монгол Улсын Засгийн Газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 4.1.8 дахь хэсэгт “Төрийн байгууллагын үйл ажиллагааны мэдээллийн ил тод байдлыг нэмэгдүүлж, иргэд, олон нийтийн оролцоог хангана” гэж, 4.1.6 дахь хэсэгт “Үндэсний ашиг сонирхлыг хамгаалсан төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг хангасан мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлж, чадавхыг нэмэгдүүлнэ” гэж тусгажээ.

Мөн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр Тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал /цаашид “Аргачлал” гэх/-ын 3.2.3-т “захиргааны байгууллага эрх хэмжээнийхээ хүрээнд хууль тогтоомжийг хэрэгжүүлэх явцад хүндрэл бэрхшээл үүссэн бол” гэж, 3.2.4-т “нийгмийн бүлэг, төрийн бус байгууллага хуулийн хэрэгжилттэй холбоотой тодорхой асуудлаар түүнийг өөрчлөх, шинэчлэх, эсхүл хүчингүй болгох талаар үндэслэл бүхий санал гаргасан” бол гэж заасанд хамаарах тодорхой саналуудыг судлаачид гаргасан байна. Тухайлбал, Глоб Интернэшнл ТББ-аас “Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө” болон “Олон нийтийн хэм хэмжээнд нийцсэн хуулиар дамжуулан олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд хийсэн “Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарласан хууль тогтоомжийн үнэлгээ” зэрэг судалгаанд Засгийн газрын тогтоолоор хэт олон буюу 560 гаруй төрлийн мэдээллийг нууцад хамааруулснаас гадна төрийн байгууллага бүр байгууллагын буюу албаны нууцын тухай журам, жагсаалтаа өөр өөрөөр тогтоон, хууль тогтоомжийг харилцан адилгүй хэрэглэж байгааг дурдсан байна.

Иймд дээр дурдсан шалтгаануудын үүднээс ТБАНТХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх шаардлага тулгамдаж байгааг харгалзан энэхүү үнэлгээг хийв.

1.2 Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээний хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд чухал ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэдэг. Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.3.1-д “үнэлгээ хийх хүрээг тогтоох ажиллагаа нь хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг судлах явцад агуулгын хувьд ач холбогдолтой, нөлөөлөл үзүүлэх хамгийн гол зохицуулалтыг тодорхойлоход чиглэнэ” хэмээн

заасан байна. Иймд ТБАНТХ-ийн зорилтыг хэрэгжүүлэхэд чухал ач холбогдол бүхий заалтуудаар үнэлгээний хүрээг тогтоох шаардлагатай.

ТБАНТХ-ийн 1 дүгээр зүйлд “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заасан. Уг зорилтыг үндэслэн дараах эрх зүйн зохицуулалтын хүрээнд үнэлгээ хийх нь зүйтэй гэж үзлээ¹. Үүнд:

1. Хуулиар тогтоосон нууцын тогтолцооны зорилго, зарчим;
2. Төрийн нууцын ойлголт, хүрээ;
3. Төрийн нууцыг тогтоох зарчим, баримтлах шалгуур;
4. Албаны нууцын ойлголт, хүрээ;
5. Албаны нууцыг тогтоох зарчим, баримтлах шалгуур;
6. Төрийн болон албаны нууцад хамааруулах тухай шийдвэр гаргах процесс, оролцогчдын эрх, үүрэг.

Өөрөөр хэлбэл ТБАНТХ-ийн дараах зохицуулалт үнэлгээ хийх хүрээнд хамаарна. Үүнд:

№	Үнэлгээ хийх хуулийн зүйл, заалт	Зохицуулалтын агуулга
1	4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг	4.1.Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг удирдлага болгоно.
2	5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт	5.1.1."төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;
3	5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт	5.1.2."албаны нууц" гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг;
4	10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт	10.1.Засгийн газар улсын хэмжээнд төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.5.мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах.

¹ ХЗДХЯ-ны мэргэжилтнийг оролцуулж зохион байгуулсан уулзалтын дүнд үнэлгээ хийх асуудлын хүрээг тогтоосон болно.

5	12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт	12.1.Тагнуулын байгууллага төрийн болон албаны нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.6.мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах;
6	14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг	14.1.Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батална.

1.3 Үнэлгээ хийх шалгуур үзүүлэлт

Аргачлалын 3 дугаар зүйлийн 3.4-т Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврыг тодорхойлоход сонгох шалгуур үзүүлэлтүүдийн жагсаалтыг тусгасан. Эдгээр шалгуур үзүүлэлтээс Аргачлалын 3.4.5-д заасан “практикт нийцэж байгаа байдал” шалгуур үзүүлэлтийг сонгов. Энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд, хууль тогтоомжийн тухайн зохицуулалтын хэрэгжилт түүний эерэг, сөрөг үр дагавар болон хэрэгжүүлэхэд хүндрэл, бэрхшээл гарч байгаа эсэхийг тодорхойлно.

1.4 Үнэлгээний харьцуулах хэлбэр

Хууль тогтоомж хэрэгжсэнээр нийгмийн харилцаанд гарсан эерэг, сөрөг өөрчлөлтүүдийг олж тодорхойлоход харьцуулах хэлбэрүүдийг ашигладаг. Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлалын 3.5.3-т заасан дөрвөн төрлийн харьцуулах хэлбэрээс 3.5.3.2-д заасан “хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш”² хэлбэр болон 3.5.3.4-т заасан “тохиолдол судлах”³ хэлбэрийг тус тус сонголоо.

ТБАНТХ дахь “мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах”-тай холбоотой зохицуулалт уг хууль хүчин төгөлдөр үйлчилж эхлэхээс өмнө байгаагүй

² Хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчлэхээс өмнөх нөхцөл байдлыг хууль тогтоомж хүчин төгөлдөр хэрэгжсэний дараах нөхцөл байдал буюу хууль тогтоомжийн хэрэгжилтийн явцад гарч байгаа үр дагавартай харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ. Байвал зохих үзүүлэлтийг хууль тогтоомжид тодорхой заагаагүй бол хууль тогтоомж батлагдахаас өмнөх үеийн нөхцөл байдал, тоо баримтыг хууль тогтоомж хүчин төгөлдөр үйлчилж эхэлснээс хойш бий болсон үеийн нөхцөл байдал, тоо баримттай харьцуулж болно.

³ Хууль тогтоомж (түүний зүйл, хэсэг, заалт), эсхүл үнэлгээний хүрээгээр тогтоосон ижил төстэй эрх зүйн хэм хэмжээ өөр, өөр орчин нөхцөл (бусад улсад, өөр орон нутагт гэх мэт)-д хэрэгжиж байгаа байдлыг харьцуулан дүн шинжилгээ хийхийг хэлнэ.

буюу төрийн нууцыг гагцхүү хуулиар тогтоох зохицуулалт үйлчилж байсан. Иймд “хууль тогтоомж батлагдахаас өмнөх болон хууль тогтоомж батлагдсанаас хойш” харьцуулах хэлбэрийг сонгож дүн шинжилгээ хийсэн.

Мөн энэхүү үнэлгээний хүрээнд судлахаар сонгосон ТБАНтХ-ийн зүйл, хэсэг, заалтад тусгасан харилцааг зохицуулж буй бусад улс орны эрх зүйн хэм хэмжээний хэрэгжилтийн байдлыг судлах үүднээс “тохиолдол судлах” харьцуулах хэлбэрийг сонгож дүн шинжилгээ хийсэн. Эдгээр хэлбэрийг сонгон харьцуулж судлах нь тус хуулийг боловсронгуй болгох ажлын хэрэгцээнд зайлшгүй шаардлагатай гэж үзэв.

1.5 Шалгуур үзүүлэлтийг томъёолох

Энэхүү үнэлгээг хийхдээ Аргачлалын “практикт нийцэж байгаа байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгож авсан. Уг шалгуур үзүүлэлтийг томъёолж, дараах асуултыг боловсруулав.

- ТБАНтХ-ийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэг. Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлахад хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчмыг удирдлага болгох зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ?
- ТБАНтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт. "Төрийн нууц" гэх нэр томъёоны тодорхойлолт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?
- ТБАНтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь заалт. "Албаны нууц" гэх нэр томъёоны тодорхойлолт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?
- ТБАНтХ-ийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх хэсэг. Албаны нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг тухайн хариуцсан байгууллага боловсруулж, асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргын шийдвэрээр батлах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?
- ТБАНтХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.5 дахь заалт. Засгийн газраас мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?
- ТБАНтХ-ийн 12 дугаар зүйлийн 12.1.6 дахь заалт. Тагнуулын байгууллага мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах зохицуулалт практикт хэрхэн хэрэгжиж байна вэ? Хүндрэл, бэрхшээл үүсгэж байгаа эсэх?

1.6 Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

Энэхүү судалгааны ажлын хүрээнд үнэлгээ хийх хуулийн зүйл, заалтын зорилгод хүрсэн түвшин, практик хэрэгжилтийг илрүүлэх зорилгоор бодлогын баримт бичиг, эрдэм шинжилгээ, судалгааны ажлын тайлан уншиж судлах, харьцуулалт хийх, мэргэжилтнүүдтэй уулзаж ярилцах аргаар хэрэгцээтэй мэдээлэл олж авах зэрэг ажлыг хийж гүйцэтгэсэн. Мэдээлэл цуглуулах дараах аргыг ашигласан болно. Үүнд:

- Аргачлалын 3.7.3.1-д заасны дагуу “Бэлэн байгаа мэдээллийг цуглуулах” хүрээнд: ТБАНТХ-д холбогдох хууль тогтоомж, Монгол Улсын олон улсын гэрээ болон холбогдох бусад баримт бичиг, ном, гарын авлага, эрдэм шинжилгээ, судалгааны тайлан, өгүүлэл, статистикийн тоо баримт цуглуулж, дүн шинжилгээ хийсэн;
- Аргачлалын 3.7.3.3-т заасны дагуу Шинжээчдийн зөвлөгөөн зохион байгуулах хүрээнд: ТБАНТХ-ийн ажлын хэсгийг хариуцан ажиллаж буй ХЗДХЯ-ны мэргэжилтнийг оролцуулан, уулзалт, ярилцлага зохион байгуулж, судалгааны асуудлыг тодруулж, хэрэгцээтэй мэдээллээ олж авсан.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

ТБАНтХ-ийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийхдээ эх сурвалж судлах, холбогдох субъектээс судалгаа авах аргаар дараах материалыг цуглуулж үнэлгээ хийхэд ашигласан.

- Бэлэн мэдээллийг цуглуулах хүрээнд:

Нэг. Магистрын ажил

Б.Мэргэн. Нээлттэй төр ба төрийн нууц. УБ., 2014 (МУИС);

Б.Баярбат. Цагдаагийн байгууллагын төрийн нууцад хамаарах мэдээллийн аюулгүй байдлыг хамгаалах арга ажиллагаа.УБ., 2018 (ХСИХ).

Хоёр. Ном, гарын авлага

Ц.Ган-Оч. Нууц мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин.

Гурав. Эрдэм шинжилгээний өгүүлэл

Ч.Өнөрбаяр нар. Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь. Нээлттэй нийгэм форум. 2010;

Д.Туяа, С.Эрдэнэбаяр. Нууцыг хадгалах тухай заасныг эргэж хармаар. "Өмгөөлөгч" мэдээлэл, танин мэдэхүйн сар тутмын сэтгүүл. 2006. №2;

Ш.Үнэнтөгс. Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх буюу нууцын тухай эрх. Хууль дээдлэх ёс. 2006. №4 (15).;

Ж.Төгс-Очир. Төрийн нууц задруулах, төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2011 №4;

Ц.Насанбат. Нууцлах хэнээрхэл. Монголын төр, эрх зүй. 2015 №1;

Б.Батхишиг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаа дахь төрийн нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтын асуудал. Хууль дээдлэх ёс. 2015 №2;

Б.Батхишиг. Монгол Улсын төрийн нууцын тодорхойлолтыг боловсронгуй болгох асуудал. Хууль дээдлэх ёс. 2015 №4;

Б.Батхишиг. Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө. Хүний эрх. 2017 №2;

Б.Батхишиг. Төрийн нууцыг гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын асуудал. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ". УБ. 2015;

Б.Баясгалан. Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжил. Хууль дээдлэх ёс. 2020 №1/76/

А.Бат-Эрдэнэ. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал, хэрэгжүүлэх арга зам. Шүүх, эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулган. УБ. 2021;

Б.Пүрэвсүрэн, Л.Галбаатар, О.Төрболд. Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ. УБ. 2019;

Дөрөв. Судалгааны тайлан

Төрийн болон албаны нууцын тухай хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдийн талаарх мэдээлэл, лавлагаа. Парламент судалгааны эмхэтгэл XXXV боть. УБ. 2021;
Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө. Глоб интернэшнл. УБ. 2016.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Үнэлэх үе шатанд, Аргачлалын “практикт хэрэгжиж буй байдал” шалгуур үзүүлэлтийн томьёоллын дагуу, ТБАНтХ-ийн дараах зохицуулалтын хэрэгжилтийг үнэллээ.

3.1 Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх болон цаг үеэ олсон байх зарчим

Мэдээллийг нууцад хамааруулахад удирдлага болгох хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим болон цаг үеэ олсон байх зарчим анх 1995 оны Төрийн нууцын тухай хуульд тусгагдаж, 2017 оны Төрийн болон албаны нууцын тухай хуульд уламжлагдаж тусгагдсан байна.

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим гэж төрийн байгууллага, албан хаагчийн аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь гагцхүү хуульд заасан үндэслэлийн дагуу байх ёстойг илэрхийлэх бол, цаг үеэ олсон байх зарчмыг үндэслэж, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд уг мэдээллийг ил болгох боломжтой. Өөрөөр хэлбэл, аливаа мэдээллийн үнэ цэнэ нь нөхцөл байдал, цаг үетэйгээ холбоотойгоор тодорхойлогддог буюу хувьсах шинжтэй байдаг.

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим

Ардчилсан нийгэмд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа олон нийтэд аль болох ил тод, нээлттэй, энэ талаарх мэдээлэл хүртээмжтэй байх ёстой. Харин онцгой нөхцөл буюу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгцээ үүссэн тохиолдолд иргэний мэдэх эрхийг хуулиар хязгаарлаж болдог. Энэ нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний *нууцыг хуулиар тогтоон хамгаална*” гэж тусгасан. Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлаж болох нь харагдаж байна.

Түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан тайлбарын дагуу *төрийн нууцын жагсаалтыг зөвхөн хуулиар тогтоох шаардлагатай*.⁴ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулах”-аар тусгажээ. Эндээс үзвэл Засгийн газрын аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулах тухай шийдвэр, тогтоол нь ТБАНтХ-д заасан төрийн нууцын хүрээнд

⁴ UN Human Rights Committee's General Comment 34 on Article 19 of the International Covenant on Civil and Political Rights. Para.24.

гарсан байх ёстой. Гэвч Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”⁵-д хуульд заагаагүй буюу хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй мэдээллүүд бас багтжээ. Тухайлбал, УИХ, түүний Тамгын газрын Мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, мэдээллийг төрийн нууцад тооцохоор тусгасан байгааг дурдаж болно.

Монгол Улсад 2021 оноос Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үйлчилж эхэлсэн бөгөөд хаалттай, хязгаарлагдмал, нээлттэй мэдээллийг ангилж тодорхой тусгасан. Гэвч тус хуульд заасны дагуу нээлттэй байх ёстой мэдээллийг төрийн байгууллагын албаны нууцад хамааруулах болон хувь хүний нууц, хувийн мэдээллийг албаны нууц гэх ойлголтод хамааруулах асуудал цөөнгүй байна. Тухайлбал, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын А/112 тоот “Журам, жагсаалт батлах тухай” захирамжийн 2 дугаар хавсралтад “хувь хүний нууцын тухай мэдээллээр хамгаалагдсан хувь хүний мэдээлэл”-ийг албаны нууцад тооцож, 10 жил нууцлахаар тусгасан байна.

Түүнчлэн Засгийн газраас 2022 оны 12 дугаар сард Эрдэнэс Тавантолгой ХК-ийн “нүүрсний хэрэг”-тэй холбогдуулан түүний бусад этгээдтэй байгуулсан 9 гэрээний мэдээллийг төрийн нууцаас ил болгохоор шийдвэрлэсэн. Гэвч тухайн 9 гэрээ нь дээрх жагсаалтад тусгагдаагүй мэдээлэл байсныг анхаарах нь зүйтэй.

Дээрхээс дүгнэвэл, ТБАНТХ-д мэдээллийг нууцад хамааруулах, нууцлахад удирдлага болгоно хэмээн заасан хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим практикт алдагдсан цөөнгүй тохиолдол байна.

Цаг үеэ олсон байх зарчим

2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг өргөн барихдаа төрийн байгууллага дахь төрийн нууцын хамгаалалт сул байгааг онцолж байжээ. Тухайлбал, Тагнуулын ерөнхий газраас 2011-2013 онд Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ, яамд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг шат, шатны нийт 362 төрийн байгууллагыг хамруулсан хяналт, шалгалт явуулахад 1837 зөрчил илэрчээ. Үүний:

- 40 хувийг мэдээллийн технологи, сүлжээний орчинд төрийн нууцыг хадгалах, хамгаалахтай холбоотой; 34 хувийг төрийн нууцын албан хэрэг хөтлөлт, бүртгэлтэй холбоотой; 21 хувийг төрийн нууцтай харьцах албан тушаалтантай холбоотой;
- 5 хувийг биет хамгаалалттай холбоотой зөрчлүүд тус тус эзэлсэн нь улсын хэмжээнд төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажил хангалтгүй байгааг харуулж байна гэж хуулийн төсөл санаачлагчид үзэн, төрийн нууц хамгаалах тогтолцоог сайжруулах зорилгоор уг хуулийн төслийг өргөн барьсан байна.

⁵ Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208019&showType=1>

Өөрөөр хэлбэл Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлох, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тус хуулийн төслийг боловсруулж батлуулсан. Үүнээс үүдэлтэйгээр, Засгийн газраас аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулахад төвлөрч, нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан байх бөгөөд 2019, 2020 болон 2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн.

Эндээс үзвэл, ТБАНТХ-д заасан цаг үеэ олсон байх зарчим хэрэгжихгүй байгаа бөгөөд ач холбогдлоо алдсан мэдээллийг нууцлалаас гаргах практик тогтоогүй байна. Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой ч үүнд хамаарах хууль тогтоомжийг ил тод, нээлттэй, ардчилсан төрийн үзэл баримтлалтай уялдуулах шаардлага байсаар байна. Жишээ нь, Япон Улс нууцлалыг 5 жилээр тогтоох бөгөөд 30 жилээс хэтрэхгүй байх талаар хуульчилжээ.⁶

3.2 "Төрийн нууц" гэх нэр томъёоны тодорхойлолт

“Төрийн нууц” (англ. state secrets, state secrecy, official secrets гэх мэт) гэдэг нь төрөөс хамгаалах арга хэмжээ авч, олон нийтээс зориуд нуун дарагдуулсан, “үндэсний аюулгүй байдалд харшлах” учир задруулахаас татгалзаж буй мэдээлэл, материалыг хэлнэ.⁷ Өөрөөр хэлбэл, төрийн нууц гэх ойлголт нь иргэдийн мэдэх ёстой мэдээллийг тэдгээрийн мэдэх ёсгүй мэдээллээс ялгах арга хэрэгсэл юм.

Төрийн нууцын сонгодог хандлагаар төрийн нууцын тухай ойлголтыг улс орны тусгаар тогтнол, хилийн халдашгүй байдлыг хамгаалах, цэрэг, батлан хамгаалах болон гадаад бодлогын (hard security) хүрээнд хязгаарлан тодорхойлдог байсан бол түүн дээр мэдээллийн аюулгүй байдал (smart security), эдийн засгийн аюулгүй байдал (soft security) зэрэг асуудлыг нэмж авч үзэх хандлага байдаг.⁸

20 дугаар зууны дунд үеэс төрийн нууцын цогц үзэл баримтлал хөгжиж эхэлсэн. Өөрөөр хэлбэл төрийн нууц гэх ойлголтын хүрээнд соёлын, эдийн засгийн, мэдээллийн, хүний аюулгүй байдал зэргийг тодорхой хязгаарт багтаан авч үздэг болсон.⁹ Цогц үзэл баримтлалыг дэмжигчид анхаарлын төвд улсыг бус хүнийг тавих шаардлага, үндэслэлийг дэвшүүлэх болсон бөгөөд энэхүү хандлагыг баримтлах тохиолдолд мэдээллийн жагсаалтыг хуулиар тогтоож өгөхгүй бол либерал нийгмийн үнэт зүйл болох мэдээллийн эрх чөлөөний зарчмыг хязгаарлах сөрөг үр дагавар үүсгэнэ гэж үздэг.

⁶ Япон Улсын Тусгай зориулалтын нууцыг хамгаалах тухай хууль (Act on the Protection of Specially Designated Secrets), <https://www.japanese-lawtranslation.go.jp/en/laws/view/2543/en>

⁷ Мөн тэнд 14 дэх тал.

⁸ Ч.Өнөрбаяр нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010, 28 дахь тал.

⁹ Мөн тэнд, 29 дэх тал.

Монгол Улсын ТБАНтХ-д "төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгохоор тодорхойлжээ.¹⁰ Дээрхээс үзвэл, ТБАНтХ-д үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах мэдээллийг төрийн нууцад тооцохоор зохицуулсан байна.¹¹ Үүнээс үүдэлтэйгээр үндэсний аюулгүй байдал, зэвсэгт хүчин, батлан хамгаалах салбарт холбогдох ихэнх мэдээлэл төрийн нууцад тооцогдож байна. Тухайлбал, Засгийн газрын тогтоолоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг тодорхойлсон захирамжийг төрийн нууцад тооцохоор тусгажээ. Өөрөөр хэлбэл, өнөөгийн хууль тогтоомжийн дагуу ҮАБЗ-ийн хуралдааны хэлэлцэх асуудал ямар ч тохиолдолд төрийн нууцад хамаарч байгаа юм.

Дэлхийн улс орнуудад мэдээлэл нууцлахыг зөвтгөх хууль ёсны зорилгыг тодорхойлдог бөгөөд уг зорилгын хүрээ нь хуулийн хэрэгжилт, хувийн нууц, үндэсний аюулгүй байдал, арилжааны болон бусад нууц, нийтийн болон хувийн аюулгүй байдал, Засгийн газрын шийдвэр гаргах процессын бүрэн бүтэн, үр дүнтэй байдал зэргээр хязгаарлагддаг.¹²

Олон улс дахь ардчиллын ойлголт, дэвшлийг үл харгалзан дэлхийн улс орнууд олон улсын харилцаа, үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлаа нууцлах дөрвөн үндэслэлийг дэвшүүлсээр байна. Үүнд: 1/ Олон улсын харилцаанд нээлттэй дипломат харилцааг бүрэн хүлээн зөвшөөрөөгүй, 2/ Улс орныхоо үндэсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн төрийн үүргийг биелүүлэх. Үүнд батлан хамгаалах хүч, төлөвлөгөө, тагнуулын нууц хамаарна. 3/ Иргэнд нээлттэй мэдээллийг бусад улсын засгийн газар олж авах боломжтой бөгөөд энэ нь улсын аюулгүй байдалд аюул үүсгэж болзошгүй. 4/ Аливаа мэдээлэл улсын нууцад хамаарах эсэхийг гагцхүү засгийн газар, төрөөс шийдвэрлэнэ. Учир нь тухайн мэдээллийн талаар хангалттай туршлагатай ганцхан субъект юм.

Жишээлбэл, ХБНГУ-ын Эрүүгийн хуулийн 93 дугаар зүйлд "төрийн нууц"-ыг дараах байдлаар тодорхойлсон:

"93.1 "Улсын нууц" гэдэгт хязгаарлагдмал бүлэг хүмүүс олж авах боломжтой, Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын гадаад аюулгүй байдалд ноцтой хохирол учруулахгүйн тулд гадаад улсаас

¹⁰ ТБАНтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт.

¹¹ This standard is clearly too low and presents almost no substantive barrier. For example, the Hungarian Law on State Secrets requires that its access or use would, "without doubt damage or jeopardize the interests of the Republic of Hungary before it can be classified as a state secret. The Peruvian Law on Transparency and Access to Information requires that information can only be withheld if it would "cause a threat to the territorial integrity and/or survival of the democratic systems and the intelligence or counterintelligence activities of the [intelligence service]."

¹²The Public's Right to Know: Principles on Freedom of Information Legislation, ARTICLE 19, June 1999, Principle 4.

нууцлах ёстой баримт, эд зүйл, эсхүл мэдээллийг ойлгоно.

93.2 Зэвсэгжилтийг бууруулах асуудлаар Холбооны Бүгд Найрамдах Герман Улс болон бусад улс орнуудтай байгуулсан гэрээг зөрчсөн эсхүл эрх чөлөөт ардчиллын үндсэн дэг журмын эсрэг шинжтэй баримтууд улсын нууцад хамаарахгүй.”

Түүнчлэн Япон Улсын Тусгай зориулалтын нууцыг хамгаалах тухай хууль (Act on the Protection of Specially Designated Secrets)-д “төрийн нууц” гэж тухайн захиргааны байгууллагын чиг үүрэгт хамааралтай асуудлаар хуульд заасан хүрээнд (Appended Table) тусгайлан нууцалсан, задруулсан тохиолдолд Япон Улсын үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах мэдээллийг ойлгохоор заасан. **Эстони Улсын Төрийн нууц болон Гадаад улсын нууцалбал зохих мэдээллийн тухай хуульд** төрийн нууцыг улсын үндэсний аюулгүй байдал, эсхүл дипломат ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор гагцхүү тус хуульд заасан бөгөөд дипломат харилцааны нууцад хамаараахгүй мэдээллийг ойлгохоор зохицуулжээ.

Түүнчлэн төрийн нууцын тухай ойлголтод дипломат нууц, дипломат мэдээллийг багтаадаггүй байна. Дипломат болон бусад мэдээллийг төрийн нууцад шууд буюу автоматаар хамруулж ойлгодоггүй бөгөөд энэ мэдээлэл нь улс орны гадаад аюулгүй байдалд хохирол учруулахуйц тохиолдолд л төрийн нууцад хамааруулж болох шалгуур тавьдаг.¹³

Хэдийгээр төрийн шийдвэр, үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх ёстой гэх хандлага хүчтэй болсоор байгаа боловч дэлхийн улс орнууд бусад улс орноос үндэсний аюулгүй байдлыг хамгаалах, батлах хамгаалах, гадаад харилцааны хүрээнд нууцалбал зохих мэдээллийг хамгаалах үүргээ биелүүлэх, эсхүл террорист бүлгэмтэй тэмцэх үүднээс зарим мэдээллийг нууцалж хамгаалсаар байна. Улс бүр төрийн нууцыг ялгаатай тодорхойлж байна. Жишээ нь, зарим улсад төрийн нууцыг тодорхойлоогүй бол, зарим улс “үндэсний аюулгүй байдалд ноцтой хохирол учруулах” гэж, зарим улс “үндэсний аюулгүй байдлын улмаас нууцалбал зохих мэдээлэл” гэж тодорхойлжээ. Эндээс төрийн нууцын нэгдсэн ойлголт хараахан үүсээгүй байгааг харж болох хэдий ч төрийн шийдвэр, үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх зарчмын үүднээс тухайн нэг улсын төрийн нууцад хамааруулах мэдээлэл тодорхой хүрээгээр хязгаарлагдах ёстой бөгөөд **хэт өргөн байхаас зайлсхийх чиглэлийг баримталж байна**. Төрийн нууцын ойлголт, тодорхойлолт харилцан адилгүй байгаа тул түүнийг практикт хэрэглэхэд хялбар болгох үүднээс улс орнууд төрөл бүрийн арга, тогтолцоог ашиглаж байна.

Хууль ёсны ашиг сонирхолд хохирол учруулахгүй мэдээллийг нууцлахаас сэргийлж мэдээллийг нууцлах үндэслэлийг нарийн тогтоох шаардлагатай. Ингэхдээ баримт, мэдээллийн төрөл бус түүний агуулгад үндэслэх нь зүйтэй. Иймд нууцлах, ил болгохоос татгалзахад цаг хугацааны хязгаарлалт тавигдана. Жишээлбэл, үндэсний

¹³ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010, 22 дахь тал.

аюулгүй байдалд аюул учруулж болзошгүй хэмээн нууцалсан мэдээлэл хожим ач холбогдлоо алдах магадлалтай.

Төрийн нууц болон иргэдийн мэдэх эрхийн тэнцвэрт байдлыг хангахын тулд дараах хэд хэдэн шалгуур, арга хэрэгслийг ашиглаж байна. Үүнд:

a. Хохирол ба нийтийн ашиг сонирхлын шалгуур /Harm and Public interest/

Олон улсын эрх зүйд, төрийн албан хаагч нь дараах 3 хатуу шалгуур ("harm" and "public interest" tests) хангагдсан тохиолдолд мэдээлэл өгөхөөс татгалзаж болно. Үүнд:

- Хуульд заасан хууль ёсны зорилготой холбоотой мэдээлэл байх;
- Уг мэдээллийг ил болгох нь уг зорилгод бодит аюул учруулахаар заналхийлсэн байх;
- Дээрх аюулын хэмжээ нь тухайн мэдээллийг олон нийт мэдсэний ашиг тусаас илүү байх ёстой.¹⁴ Төрийн байгууллагаас мэдээлэл хүссэн иргэний хүсэлтэд татгалзсан хариу өгөхдөө дээр дурдсан шалгуур хангагдсаныг нотлох үүрэгтэй.

Төрийн нууцад хамаарагдах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох нийтлэг хандлагатай байх бөгөөд ингэснээр төрийн аливаа байгууллага, албан хаагч, албан тушаалтны дур зоргыг хязгаарлана гэж үздэг. 2 дахь шалгуураар тухайн мэдээллийг задруулснаар улс орны үндэсний аюулгүй байдал, гадаад аюулгүй байдалд аюул занал учрах магадлал байгаа эсэхийг тогтооно. Гэвч уг шалгуурыг ашиглах, хянах асуудал нь практик дээр хэрэгжихэд хүндрэлтэй тул иргэний мэдэх эрхийг дээрх үндэслэлээр хязгаарлахгүй байх зорилгоор нууцад хамаарахгүй мэдээлэл, цаашилбал нээлттэй мэдээллийг тусгайлан тогтоох, түүнчлэн аливаа байгууллага, албан тушаалтны мэдээлэл олгохоос татгалзсан шийдвэрт гомдол гаргах зохицуулалтыг ашигладаг байна.

Монгол Улсын ТБАНТХ-д гомдол гаргах механизм тусгагдаагүй тул хууль бусаар аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулсан тохиолдолд иргэний мэдэх эрхийг хамгаалах механизмыг хуулиар бүрдүүлэх нь зүйтэй юм.

b. Төрийн нууцад хамаарахгүй мэдээллийг тодорхойлж өгөх

Нууцад хамаарахгүй мэдээллийг хуульд тодорхой тусгах нь бий. Жишээлбэл, Америк (The US Executive Order on Classified National Security Information), Румын (Law on Protection of Information) улсын хуульд хууль зөрчсөн, үр ашиггүй, захиргааны алдаа гаргасныг нуун дарагдуулах зорилгоор мэдээлэл нууцлахыг хориглосон.¹⁵ Засгийн газрын буруутай үйл ажиллагааг далдлах, хамгаалах зорилгоор тавигдсан

¹⁴ The Public's Right to Know: Principles on Freedom of Information Legislation, ARTICLE 19, June 1999, Principle 4, p5.

¹⁵ Олон нийтийн мэдэх эрх, мэдээллийн эрх чөлөө: Хууль боловсруулагч, тогтоогчдод зориулсан гарын авлага, 2002. http://www.globeinter.org.mn/old/publications/pub_2_2_03_07.html#15.

хязгаарлалт нь зөвтгөгдөх боломжгүй. Түүнчлэн Орос Улсын Төрийн нууцын тухай хуульд нууцалж болохгүй мэдээллийг мөн тусгасан байна. Тухайлбал, онц байдал, хүн амын эрүүл мэндэд аюул учруулахуйц үйл явдал, байгалийн гамшиг, хүрээлэн буй орчин, эрүүл мэнд, эрүүл ахуй, боловсрол, соёл хөдөө аж ахуйн салбарт хамаарах мэдээлэл, хүний эрх, эрх чөлөөний зөрчлийн талаарх мэдээлэл, төрийн өндөр албан тушаалтны эрүүл мэндийн байдал, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой мэдээлэл зэргийг дурдаж болно. Үүнтэй төстэй зохицуулалт Герман, Польш, Унгар, Казакстан, Туркменистан зэрэг улсын хууль тогтоомжид бас бий.

Монгол Улсын ТБАНтХ-ийн 24 дүгээр зүйл¹⁶-д төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэлийг заасан боловч ямар төрлийн мэдээллийг огт нууцалж болохгүй талаар зохицуулалт тусгаагүй. Гэвч уг мэдээлэл нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд “нээлттэй” мэдээлэл байдлаар хуульчлагдсан гэж үзэж болно. Иймд нэгдүгээрт, төрийн байгууллага, албан тушаалтны хууль бус бөгөөд алдаатай үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг нууцалсан гэж үзсэн тохиолдолд иргэн тухайн шийдвэрт гомдол гаргах асуудлыг тодорхой тусгах, хоёрдугаарт Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд заасан нээлттэй мэдээллийг нууцалж болохгүй талаар, тодруулбал Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн зохицуулалт нь тодорхой нэр бүхий тусгай байгууллагад хэрэглэгдэхээс бусад тохиолдолд ТБАНтХ, Засгийн газрын тогтоол, жагсаалт болон байгууллагын дотоод журам, дүрмээс давуу үйлчлэхээр тусгах нь зүйтэй.

3.3 "Албаны нууц" гэх нэр томъёоны тодорхойлолт

2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулиас өмнө үйлчилж байсан 1995 оны Төрийн нууцын тухай хуульд “албаны нууц” хэмээх ойлголт тусгагдаагүй. Өөрөөр хэлбэл, “албаны нууц” хэмээх ойлголт Монгол Улсад 2017 оноос бий болжээ. “Албаны нууц” гэж задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн ашиг сонирхолд хохирол учруулах төрийн хамгаалалтад байх мэдээллийг ойлгоно.¹⁷ Энд дурдагдаж буй “Байгууллагын ашиг сонирхол” болон “салбарын ашиг сонирхол” зэрэг нэр томъёо, ойлголтын тодорхойгүй байдлаас үүдэн төрийн байгууллагын удирдлагаас байгууллагын үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг хэт өргөнөөр албаны нууцад хамааруулах

¹⁶ 24.1.Албан тушаалтан, иргэнд дараахь үндэслэлээр төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзана:

24.1.1.төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангаагүй;

24.1.2.аюулгүй байдлын шалгалтад хамрагдах, төрийн болон албаны нууцыг хамгаалах баталгааг бичгээр гаргаж өгөхөөс татгалзсан;

24.1.3.аюулгүй байдлын шалгалтад өөрийн тухай болон холбогдох бусад мэдээллийг танилцуулаагүй, эсхүл худал мэдээлсэн;

24.1.4.төрийн болон албаны нууцыг хамгаалах журмыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчиж байсан;

24.1.5.гэмт хэрэг санаатай үйлдэж эрүүгийн хариуцлага хүлээсэн, эсхүл эрүүгийн хэрэгт шалгагдаж байгаа;

24.1.6.Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтээ гаргасан;

24.1.7.сэтгэцийн өвчин, эмгэгтэй нь тогтоогдсон;

24.1.8.мансууруулах болон сэтгэцэд нөлөөлөх бодис, согтууруулах ундаанаас хамааралтай.

¹⁷ ТБАНтХ-ийн 5 дугаар зүйлийн 5.1.2 дахь хэсэг.

явдал нийтлэг байна. Учир нь “албаны нууц”-ыг тодорхойлох шалгуурыг хуульчлаагүйгээс төрийн байгууллага, агентлагийн дарга нар албаны нууц хэмээх ангилалд хэт өргөн хүрээний мэдээллийг хамруулж, иргэний мэдэх эрхийг зөрчих явдал их байна. Тухайлбал, Эрчим хүчний яам баталсан “Төрийн болон албаны нууцыг ашиглах, хадгалах, хамгаалах журам”-аа албаны нууцад хамааруулсан байв. Дүгнэвэл, ТБАНТХ дахь албаны нууцын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс үүдэн албаны нууцыг ангилахад хүндрэл, бэрхшээл үүссэн байна.

Өнөөгийн байдлаар, “албаны нууц” гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрийн дур зоргоор мэдээлэл нууцлах тохиолдол цөөнгүй байна. Мэдээллийг өргөнөөр хязгаарлаж нууцлах нь засаглалын тогтвортой байдалд сөргөөр нөлөөлдөг талаар судлаачид тэмдэглэсэн. Тодруулбал, мэдээллийг өргөнөөр нууцлах нь олон нийтийн төрд итгэх итгэлд нөлөөлж, мэдээлэлгүй, эсхүл дутуу, буруу мэдээлэл авснаас үүдэн төрийн үйл ажиллагаанд итгэхээ болих сөрөг үр дагавар үүсгэдэг. Иймд төрийн байгууллага, албан хаагч өөрийн шийдвэр, үйл ажиллагааны талаарх үнэн зөв, бүрэн гүйцэд мэдээллийг олон нийттэй тогтмол хуваалцах нь төрд итгэх олон нийтийн итгэлийг бэхжүүлэх чухал ач холбогдолтой.¹⁸ Түүнчлэн хэт өргөнөөр хязгаарлаж, нууцлах нь чухал мэдээллийн хамгаалалтыг сулруулахад хүргэдэг байна. Мөн мэдээллийг хэт олноор нууцлах, хамгаалах тогтолцоо нь төрийн үйл ажиллагааны зардлыг тодорхой хэмжээгээр ихэсгэдэг хэмээн онцолдог.

Сонгодог хандлагаар төрийн нууцыг задруулах асуудлыг албан мэдээллийг олон нийтэд тараах гэсэн ойлголтоос ялган заагладаг байна. Төрийн байгууллагын бодлого, шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой асуудлаар иргэдийн мэдэхийг хүссэн мэдээлэл, төрийн байгууллагын зүгээс иргэд, олон нийтэд тайлагнадаг мэдээлэл зэрэг нь албан мэдээллийг тараах, түгээх гэсэн ойлголтод багтана.¹⁹ Өөрөөр хэлбэл төрийн нууцын ойлголтод албаны мэдээллийг гаргаж өгөх, тараах асуудлыг хамааруулахгүй байх нь зүйтэй. Үүнээс үзвэл, төрийн нууцын тухай хууль тогтоомжоор албаны нууцтай холбоотой харилцааг зохицуулж буй өнөөгийн практикийг эргэн харах шаардлагатай юм.

“Албаны нууц” ба “төрийн нууц” гэх ойлголтын ялгааг бусад хууль тогтоомжоос тодруулж үзвэл, **2021 оны Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд** мэдээллийг дараах байдлаар ангилжээ. Үүнд:

- | |
|---|
| <p>7.1.Нийтийн мэдээллийг нээлттэй, хязгаарлалттай, хаалттай гэж ангилна.</p> <p>7.2.Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан, эсхүл хязгаарлалттай болон хаалттай мэдээлэлд хамаарахгүй мэдээллийг нээлттэй мэдээлэл гэж үзнэ.</p> <p>7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.</p> |
|---|

¹⁸ David Banisar, Comments on the Moldovan Draft Law on State and Official Secrets, 2005, <https://www.osce.org/files/f/documents/3/7/16548.pdf>

¹⁹ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010, 28 дахь тал.

7.4.Хуульд хаалттай байхаар заасан, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг хаалттай мэдээлэл гэж үзнэ.

9.1.Албаны нууцад хамаарах мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуульд заасан үндэслэл, журамд заасны дагуу ашиглана.

9.2.Энэ хуулийн 7.3-т заасан хүн, хуулийн этгээдэд хамаарах хязгаарлалттай мэдээлэлд дараах мэдээлэл хамаарна:

9.2.1.хуульд өөрөөр заагаагүй бол гэмт хэрэг, зөрчил шалган шийдвэрлэх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааны явцад цуглуулсан мэдээлэл;

9.2.2.төрийн хяналт шалгалтын явцад болон шийдвэр хүчин төгөлдөр болох хүртэлх хугацаанд цуглуулсан мэдээлэл;

9.2.3.нээлттэй байлгах нь соёлын хосгүй үнэт өвд аюул учруулж болзошгүй мэдээлэл;

9.2.4.хуульд заасан бусад.

Мөн Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7.5-д “Хуульд ил тод, нээлттэй байхаар заасан мэдээллийг албаны нууцад хамааруулж тогтоохгүй” талаар тусгасан. Эндээс үзвэл, “албаны нууц” гэж төрийн нууцад хамаарах мэдээлэл болон нээлттэй байх мэдээллээс бусад мэдээллийг ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд “албаны нууц” ба “төрийн нууц” нь хоорондоо ялгамжтай байдлаар зохицуулагдсан. Гэвч энэхүү зохицуулалт нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.2-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл “онц чухал нууц”, “маш нууц”, албаны нууцад хамаарах мэдээлэл “нууц” зэрэглэлтэй байна” гэж заасантай нийцэхгүй байна. Өөрөөр хэлбэл, одоо байгаа хуульд дээрх 2 ойлголтыг тусад нь томъёолсон ч албаны нууц мэдээлэл нь төрийн “нууц” зэрэглэлд хамаарахаар зөрчилтэй зохицуулжээ.

Мөн төрийн болон албаны нууцыг хамгаалах харилцаанд нэг журам буюу Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам²⁰ үйлчилдэг. Уг журмын зохицуулалтыг нарийвчилбал:

№	Журмын зохицуулалт	Төрийн нууцад үйлчлэх эсэх	Албаны нууцад үйлчлэх эсэх
1	Нууцад хамаарах мэдээллийг нууцлах	+	+
2	Нууцын зэрэглэлийг тогтоох	+	+
3	Нууцын зэрэглэлийг өөрчлөх	+	+
4	Нууц баримт бичиг, бусад тээгчид тэмдэглэгээ тавих	+	+
5	Нууц баримт бичиг, бусад нууц тээгчийг ил болгох, нууцлах хугацааг сунгах	+	+
6	Иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох	+	
7	Иргэнд албаны нууцтай танилцах эрх олгох		+

²⁰ <https://legalinfo.mn/mn/detail?lawId=208025&showType=1>

8	Нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалт гаргах, өөрчлөх	+	+
9	Нууцтай танилцах эрхийн түвшин	+	+
10	Нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох	+	+
11	хуулийн этгээдэд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх эрх олгох	+	+
12	Нууцын албан хэрэг хөтлөлт	+	+
13	Зургаа.Нууц мэдээлэл боловсруулах, хадгалах, дамжуулах систем, сүлжээ, техник хэрэгслийн аюулгүй байдлыг хангах	+	+
14	Хуулийн этгээд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх үед нууц мэдээллийг хамгаалах	+	+
15	Нууц баримт бичиг, бусад тээгчийг шилжүүлэх, хүлээлцэх	+	+
16	Нууц мэдээллийг гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх	+	+
17	Нууцын биет хамгаалалт	+	+
18	Хаалттай хуралдаан зохион байгуулах	+	+
19	Нууцын хамгаалалтад тавих хяналт	+	+
20	Хариуцлага тооцох	+	+

Дээрхээс үзвэл, албаны нууц болон төрийн нууц нь мэдээллийн нууцлалын зэрэглэлээс гадна **тэдгээр мэдээллийг хэрхэн олж авах процессын түвшинд** ялгагдаж байна. **Мэдээлэлтэй танилцах эрх авах процессыг дэлгэрүүлбэл:**

4.1.Иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох

4.1.1.тухайн байгууллагаас төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтад орсон албан тушаалтан нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.1.2.хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад тодорхой түвшинд төрийн нууцтай танилцах зайлшгүй шаардлагатай албан хаагч, иргэнд **байгууллагын дарга төрийн нууцтай танилцах зөвшөөрөл (энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1) олгоно.** Энэ тохиолдолд тухайн албан хаагч, иргэн нь Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 22.1-д заасан шаардлагыг хангасан байна.

4.1.3.тухайн байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан нэгж нь энэхүү журмын 4.1.1, 4.1.2-т заасан иргэн, албан хаагчтай холбоотой баримт бичиг (иргэний үнэмлэх, төрсний гэрчилгээ, боловсролын гэрчилгээ, диплом... гэх зэрэг)-ийг бүрдүүлэн биечлэн тулгаж шалгасны дараа холбогдох материалыг нууц хамгаалах ажилтанд шилжүүлэн өгнө.

4.1.4.нууц хамгаалах ажилтан материалыг хянаж, албан бичгийн хамт дугтуйнд хийж битүүмжлэн аюулгүй байдлын шалгалт хийлгэхээр тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

4.1.5.тагнуулын байгууллага аюулгүй байдлын шалгалтыг тогтоосон хугацаанд зохих журмын дагуу явуулж, тухайн иргэн, албан хаагчид тодорхой түвшинд төрийн нууцтай танилцах эрх олгох эсэх талаар хүсэлт гаргасан байгууллагад бичгээр мэдэгдэнэ.

4.1.6.энэхүү журмын 4.1.5-д заасны дагуу тагнуулын байгууллагаас зохих хариу өгөөгүй байхад тухайн иргэн, албан хаагчийг төрийн нууцтай танилцах албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгохыг хориглоно.

4.1.7.энэ журамд заасан шаардлагыг хангасан иргэнийг төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалд томилох, эсхүл төрийн нууцтай танилцах эрх олгох тухай байгууллагын даргын шийдвэр гаргахаас өмнө нууц хамгаалах ажилтан тухайн иргэнд төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийг судлуулж, нууцтай танилцахад түүний тодорхой эрх хязгаарлагдах, хууль тогтоомж зөрчсөн тохиолдолд зохих хариуцлага хүлээх, тэдгээртэй холбоотой бусад үр дагавар үүсэх тухай тайлбарлаж, энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 2-т заасан нууц задруулахгүй байх баталгааг гаргуулан авна.

4.1.8.нууц хамгаалах ажилтнаар томилох тухай шийдвэрт тогтоосон журмын дагуу олгох цалингийн нэмэгдлийг тусгасан байна.

4.2.Иргэнд албаны нууцтай танилцах эрх олгох

4.2.1.албаны нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан уг албан тушаалд томилогдохдоо нууц задруулахгүй байх баталгаа гаргана. Ийнхүү баталгаа гаргаагүй албан тушаалтанд албаны нууц танилцуулахыг хориглоно.

4.2.2.хяналт шалгалт хийх, тодорхой ажил, үүрэг гүйцэтгэх, аж ахуйн үйл ажиллагаа явуулах, эрдэм шинжилгээ, судалгааны ажил эрхлэх, суралцах явцад албаны нууцтай танилцах зайлшгүй шаардлагатай албан хаагч, **иргэнд байгууллагын дарга энэхүү журмын 2 дугаар хавсралтаар баталсан Маягт 1-д заасан албаны нууцтай танилцах зөвшөөрлийг олгоно.** Энэ тохиолдолд хүсэлт гаргасан албан хаагч, иргэн нууцын баталгаа гаргана.

Төрийн нууцтай танилцах эрх олгохдоо Тагнуулын байгууллагын саналыг үндэслэж, байгууллагын дарга зөвшөөрөл олгож байгаа бол, албаны нууцтай танилцах этгээдэд байгууллагын дарга зөвшөөрөл олгож байгаа юм.

Улс орнуудын нууцын холбогдолтой хууль тогтоомжийг судалж үзэхэд, Пост социалист орнууд, тухайлбал Казакстан²¹, Киргизстан²², Узбекстан²³ зэргээс бусад

²¹ Закон Республики Казахстан от 15 марта 1999 года № 349-І О государственных секретах https://online.zakon.kz/Document/?doc_id=1012633&pos=60;-8#pos=60;-8

²² Закон КР от 15 декабря 2017 года № 210 (15) "О защите государственных секретов Кыргызской Республики" <http://cbd.minjust.gov.kg/act/view/ru-ru/111719>

Статья 9. Степени секретности сведений, составляющих государственные секреты, и грифы секретности носителей этих сведений

1. Государственные секреты Кыргызской Республики по степени важности составляющих их сведений подразделяются на две категории: государственную тайну (сведения, составляющие государственную тайну) и служебную тайну (сведения, составляющие служебную тайну).

2. Устанавливаются три степени секретности сведений, составляющих государственные секреты, и соответствующие этим степеням грифы секретности для носителей указанных сведений: "особой важности", "совершенно секретно" и "секретно".

улс орнуудад “албаны нууц” хэмээх ойлголт байхгүй байна. Дээрх улсуудад албаны нууц буюу **служебная тайна** нь төрийн нууцад хамаарч байна. Өөрөөр хэлбэл, төрийн нууцыг онц чухал, маш нууц, нууц гэж ангилах бөгөөд албаны нууц нь төрийн нууцын “нууц” зэрэглэлд хамаардаг.

Бусад улс орнуудад дээрх төрлийн ойлголт түгээмэл биш. Жишээ нь, Эстони Улсын Төрийн болон гадаад улсын нууцын тухай хуульд төрийн нууцыг ач холбогдлоор нь хязгаартай (restricted), нууц (confidential), маш нууц (secret), онц чухал нууц (top secret) зэргээр ангилсан боловч “албаны нууц” гэсэн ойлголт байхгүй юм.²⁴ Түүнчлэн Хонг конг, Их Британи, Малайзад “Official secrets act” гэж байгаа боловч тухайн актын хүрээ нь батлан хамгаалах, тагнуул, гадаад харилцаа зэрэгт хамаарах төрийн нууцын хүрээгээр хязгаарлагддаг байна. Герман Улсад “албан тушаалын нууц” гэх ойлголтыг 2006 оноос халж, захиргааны соёл, сэтгэлгээнд өөрчлөлт оруулсан байна.²⁵

Харин зарим улсын Нийтийн мэдээллийн тухай хууль болон Мэдээллийн ил тод байдлын тухай хууль зэрэг эрх зүйн баримт бичигт “албаны мэдээлэл” гэх ойлголт тусгагджээ. Төрийн байгууллагаас боловсруулсан, эсхүл түүнд шилжүүлсэн, түүний мэдэлд байгаа аливаа мэдээллийг албан мэдээлэл гэж үздэг боловч түүнийг нууцлах ойлголт яригддаггүй. Дээрх хууль тогтоомж нь албаны мэдээллийн ил тод байдлыг хангах, түүнтэй холбоотой хүсэлтийг шийдвэрлэхэд баримтлах гол эх сурвалж болдог байна.

Монгол Улсын **2021 оны Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай** хуульд олон нийтэд ил тод, нээлттэй байх мэдээллийн төрлийг хуульчилсан бөгөөд дээрх мэдээллийг ямар ч тохиолдолд нууцад хамааруулах ёсгүй. Тухайлбал, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй байлгах, төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналтыг бий болгох зорилгоор **мэдээлэл хариуцагчийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалт, хүний нөөц, төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа, үзүүлж байгаа үйлчилгээ** болон хуулиар хаалттай,

3. Сведениям, составляющим государственную тайну, присваиваются грифы секретности "особой важности", "совершенно секретно".

4. Сведениям, составляющим служебную тайну, присваивается гриф секретности "секретно". Служебная тайна имеет характер отдельных сведений, относящихся к государственной тайне, и не раскрывает их полностью.

²³ Закон Республики Узбекистан, от 07.05.1993 г. № 848-XII

Статья 3. Категории государственных секретов

Государственные секреты Республики Узбекистан подразделяются на государственную, военную и служебную тайну.

Государственную тайну составляют сведения, разглашение которых может оказать отрицательное воздействие на качественное состояние военно-экономического потенциала республики или повлечь другие тяжкие последствия для обороноспособности, государственной безопасности, экономических и политических интересов Республики Узбекистан.

Военную тайну составляют сведения военного характера, разглашение которых может повлечь тяжкие последствия для обороноспособности, государственной безопасности и Вооруженных Сил Республики Узбекистан.

Служебную тайну составляют сведения в области науки, техники, производства и управления, разглашение которых может нанести ущерб интересам Республики Узбекистан.


²⁴ State Secrets and Classified Information of Foreign States Act, <https://www.riigiteataja.ee/en/eli/521052020005/consolide>

²⁵ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010, 38 дахь тал.

хязгаарлалттай гэж тогтоосноос бусад мэдээллийг ил тод, нээлттэй байлгана.
/Хавсралт 1-ээс дэлгэрэнгүй үзнэ үү/

Албан мэдээллийг тухайн байгууллагын дарга жагсаалтаар тодорхойлдог улс байхад нэг бүрчлэн тогтоодоггүй улс ч байна. Аль ч тохиолдолд нууцад хамааруулж үздэггүй. Гэхдээ албан мэдээлэлтэй танилцах эрхийг хязгаарлах тохиолдлууд байна. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах бололцоог үгүйсгээгүй. Ийнхүү хязгаарлах тохиолдлуудыг хуульд тухайлан заасан байгаагаас гадна хязгаарласан мэдээллийг “нууц” гэж томъёолоогүй байна.

Зураг 1. Албан мэдээлэл ба төрийн нууцын харилцан хамаарал.



Судлаачид “албаны нууц” хэмээх тусдаа ойлголт байх шаардлагагүйг тайлбарлахдаа, төрийн байгууллага нь төрийн нэрийн өмнөөс үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нэгэнт төрийн нууц гэх ойлголтыг холбогдох хууль тогтоомжоор зохицуулсан байдаг тул үүн дээр дахин төрийн байгууллагын нууцын тухай ойлголтыг давхардуулах шаардлагагүй гэж үзжээ.²⁶

Байгууллагын нууцын тухай (одоогоор “албаны нууц”) ойлголтыг гол төлөв бизнесийн үйл ажиллагаанд хамааруулан шүүхийн практикаар хамрах хүрээг нь

²⁶ Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010, 36 дахь тал.

тодорхойлох хандлага нийтлэг бөгөөд дараах шалгуур үзүүлэлтийг хангасан байхыг шаарддаг байна. Үүнд:²⁷

1. Мэдээлэл нь тодорхой нэг хуулийн этгээд, ямар нэгэн бизнесийн байгууллагатай шууд холбоотой байх;
2. Тухайн мэдээлэл нь нээлттэй биш байх, өөрөөр хэлбэл, хязгаарлагдмал тооны этгээдүүд мэдэж байх;
3. Бизнесийн байгууллагын эзэмшигч нууц болгон хадгалах хүсэлт гаргасан байх;
4. Бизнесийн байгууллага ажилтантай гэрээ байгуулан байгууллагын нууцыг задруулахгүй байх үүрэг хүлээлгэн, зохицуулалт хийх зэргийг нэрлэж болно.

Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийг шинэчлэхдээ Байгууллагын нууцын тухай хуулиас төрийн албаны буюу төрийн байгууллагын харилцааг салгаж, Төрийн болон албан нууцын тухай хуулиар төрийн нууц болон албаны нууцын харилцааг хамтад нь зохицуулж эхэлсэн. Дээрх шинэчлэл нь Байгууллагын нууцын тухай хуулийн хэрэглээнд эерэг нөлөө үзүүлсэн ч төрийн нууцын тухай хууль тогтоомжид зарчмын шинжтэй алдаа гаргахад хүргэжээ. Харин Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд томьёолсон “хязгаарлагдмал мэдээлэл²⁸” нь албаны буюу төрийн байгууллын нууцалбал зохих мэдээллийн хүрээтэй илүү нийцжээ.

Мөн **Салбарын болон байгууллагын ашиг сонирхол** гэх ойлголт нь хэт өргөн хүрээтэй бөгөөд албаны мэдээллийн мөн чанарт нийцэхгүй юм. Албан мэдээллийг нээлттэй мэдээлэхээс татгалзаж буй нь төрийн үйл ажиллагааны тасралтгүй, мэргэжлийн, үр нөлөөтэй байдлыг хангахад чиглэх ёстой. Гэвч албаны мэдээллийг нууцад тооцохоор хуульчлах, ялангуяа төрийн нууцын тухай хуулиар хамтад нь зохицуулах нь “төрийн нууц”-ыг хамгаалах замаар үндэсний аюулгүй байдлыг хамгаалах тус хуулийн зорилго, мөн чанартай нийцэхгүй байгааг эргэн харах нь зүйтэй.

Албаны нууцад хамаарах мэдээллийг төрийн нууц хэмээх ойлголтоос юун түрүүнд салгах нь зүйтэй. Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 16.2-т “Төрийн нууцад хамаарах мэдээлэл “онц чухал нууц”, “маш нууц”, албаны нууцад хамаарах мэдээлэл “нууц” зэрэглэлтэй байна” гэж заасныг өөрчлөх шаардлагатай. Мөн хуулиар нээлттэй байх ёстой мэдээлэл болон төрийн нууцаас бусад мэдээллийг “албаны мэдээлэл” гэж нэрлэх замаар нууц, түүний хамгаалалтын ойлголтоос салгах нь зүйтэй. Учир нь Монгол Улсын Үндсэн хуульд зааснаар аливаа мэдээллийг хуулиар нууцлах бөгөөд харин журмаар аливаа мэдээллийг нууцлах нь Үндсэн хуульд нийцэхгүй. Жишээ нь Молдав Улсад албаны мэдээллийг тогтоохоор хуулийн төсөл боловсруулж байсан ч тухайн хуулийн төсөл дэмжигдээгүйг анхаарах нь зүйтэй.

Төрийн байгууллагын нууцад хамаарах мэдээлэл нь бизнесийн байгууллагын ашиг сонирхлыг хамгаалахад чиглэгдсэн байдаг бол хамаарахгүй мэдээлэл нь

²⁷ Мөн тэнд, 37 дахь тал.

²⁸ НМИТБТХ-ийн 7.3.Танилцах, ашиглахад хуулиар хязгаарлалт тогтоосон албаны нууц болон хүн, хуулийн этгээдэд хамаарах мэдээллийг хязгаарлалттай мэдээлэл гэж үзнэ.

гуравдагч этгээдийн ашиг сонирхлыг хамгаалахад чиглэдэг гэжээ. ²⁹ Иймд байгууллагын нууц буюу албаны нууцад хамаарахгүй мэдээллийг тусгайлан заах нь төрийн байгууллага, албан тушаалтны дур зоргыг хязгаарлах чухал ач холбогдолтой.

Мөн практикт ихэнх төрийн байгууллага албаны нууцын жагсаалтыг байгууллагын дотоод журмын хавсралтаар зөвхөн нэг удаа баталж байгаа нь албаны нууцын мэдээллийн жагсаалтыг давтамжтай хянах, шинэчлэх асуудал орхигдоход хүргэсэн байна.

3.4 Засгийн газраас төрийн нууц мэдээллийн жагсаалт батлах зохицуулалт

Засгийн газрын тогтоолоор нийт 20 байгууллага, 10 салбарын хүрээнд хамаарах төрийн нууц мэдээллийг тогтоосон. Жишээ нь, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1-д заасан төрийн нууцад хамааруулсан мэдээллээс гадна СЗХ-ны эрх хэмжээнд дараах мэдээллийг төрийн нууцад хамааруулсан. Үүнд:

№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл		Нууцлах хугацаа (жилээр)
		Онц чухал нууц	Маш нууц	
1.	Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)		+	20
2.	Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг		+	20
3.	Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай баримт бичиг		+	20
4.	Хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг		+	20

Дээрх мэдээллүүд нь ТБАНТХ-аар хамгаалагдах боломжтой. Засгийн газрын тогтоолын зохицуулалтыг ажиглавал, аливаа нууц мэдээллийг (анхдагч мэдээлэл) солилцох, боловсруулах, хэлэлцэх явцад үүсэх хоёрдогч мэдээллийг төрийн нууцад хамаарах мэдээлэлд хамааруулсан байгаа юм. Нэгдүгээрт, анхдагч мэдээллийг нууцлах үүрэгтэй хувь хүн, албан хаагч нь түүнийг солилцох, боловсруулах, хэлэлцэх явцад үүсэх хоёрдогч мэдээллийг ч мөн хамгаалах, задруулахгүй байх үүргийг хүлээх бөгөөд хоёрдугаарт, хэдийгээр ийнхүү хариуцах байгууллагыг тогтоосон нь төрийн нууцыг цөөн тооны этгээд мэдэх зарчимд нийцүүлэхтэй холбоотой боловч төрийн нууцад хамаарах мэдээллийг байгууллагаар нь бус улсын хэмжээнд нэг мөр тогтоох нь хийдэл, давхцал үүсгэхгүй байх ач холбогдолтой.

²⁹ Мөн тэнд, 39 дэх тал.

Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 2019-2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн байна. Уг жагсаалтаар батлагдсан төрийн нууц мэдээллийн тоо:

№	Байгууллага, салбар	Төрийн нууцад хамаарах мэдээллийн тоо
1	Улсын Их хурлын тамгын газар	31
2	Ерөнхийлөгчийн тамгын газар	16
3	Засгийн газрын хэрэг эрхлэх газар	32
4	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, Стратегийн судалгааны хүрээлэн	33
5	Гадаад харилцааны салбар	19
6	Батлан хамгаалах салбар	78
7	Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар	56
8	Банк, санхүүгийн салбар	21
9	Байгаль орчин, аялал жуулчлалын салбар	10
10	Барилга, хот байгуулалтын салбар	16
11	Боловсрол, соёл шинжлэх ухаан, спортын салбар	9
12	Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар	11
13	Зам, тээврийн салбар	10
14	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар	10
15	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар	12
16	Эрүүл мэндийн салбар	10
17	Эрчим хүчний салбар	12
18	Авлигатай тэмцэх газар	20
19	Төрийн аудитын байгууллага	6
20	Сонгуулийн ерөнхий хороо	5
21	Санхүүгийн зохицуулах хороо	4
22	Үндэсний статистикийн хороо	5
23	Цөмийн энергийн комисс	6
24	Төрийн албаны зөвлөл	7
25	Харилцаа холбоо, мэдээллийн технологийн салбар	9
26	Мэргэжлийн хяналтын байгууллага	5
27	Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар	7
28	Үндэсний хөгжлийн газар	5
29	Тагнуулын байгууллага, Төрийн тусгай хамгаалалтын газар	60
30	Онцгой байдлын салбар	13
31	Стандарт, хэмжил зүйн газар	4
32	Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага	13
33	Аймаг, нийслэлийн Засаг даргын тамгын газар	17

Засгийн газрын тогтоолоор нийт 575, давхцалгүй тоогоор 404 мэдээллийг төрийн нууцад хамааруулжээ.³⁰ Уг тогтоолоор 2017 онд хүчингүй болсон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн дагуу төрийн нууцад хамааруулж байсан мэдээллийн тоог хэд дахин нэмэгдүүлсэн. Дээрх хуулийн дагуу 60 мэдээллийг төрийн нууцад хамааруулж байсан.

Мөн дээрх жагсаалтад тухай бүр мэдээлэл нэмэх боломжтой. ТБАНТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.4-т зааснаар байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулж шийдвэрлүүлэх боломжтой. Гэвч саналыг хүлээн авсан удирдлага ямар шалгуур, үндэслэлийг харгалзаж шийдвэрлэх нь тодорхой тусгагдаагүй байна.

Засгийн газраас баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт” нь давхцал ихтэйгээс гадна, логик уялдаагүйгээс үүдэн төрийн нууцын тухай ойлголт тодорхой бус болсон байна. Тухайлбал, давхцалаас гадна тус жагсаалтад орсон зарим мэдээлэл нь үндэсний аюулгүй байдалтай холбоо хамааралгүй байгааг дурдах нь зүйтэй. 2020 оны 48 дугаар тогтоолоор ҮАБЗ-ийн төсвийн бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардлыг төрийн нууцад тооцжээ. Дээрх мэдээлэл хэт ерөнхий байгааг анхаарах нь зүйтэй. Дээрх зохицуулалттай холбоотойгоор ҮАБЗ-өөс зарласан тендерийн мэдээлэл нийтэд ил тод явагдахгүй байх тохиолдол практикт гарч байна.

Мөн ҮАБЗ-ийн саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор зарим мэдээллийг нууцалсан тохиолдлууд байна. Тухайлбал, 2022 оны 12 дугаар сард “нүүрсний хэрэг”-тэй холбоотойгоор үүсээд буй нөхцөл байдалтай холбогдуулж Төрийн нууцад хамаарах мэдээллийг ил болгох тухай Засгийн газрын тогтоол баталсан. Уг тогтоолоор ҮАБЗ-ийн зөвлөмжөөр нууцад хамааруулсан байсан дараах 9 гэрээг нууцаас гаргахаар шийдвэрлэсэн байна. Үүнд:

1. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2019 оны 10 дугаар сарын 29-ний өдөр байгуулсан Тавантолгой-Гашуунсухайт чиглэлийн төмөр замын төслийн бүтээн байгуулалтын зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн ЭТТ-2019/825, ТТЗ-Н19/01-01, BI-TTGS-CONT-0002 тоот гэрээ, түүний нэмэлт өөрчлөлт;
2. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2019 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр байгуулсан Нүүрс нийлүүлэх ЭТТ-2019/784, BI-TTGS-CONT-0003 тоот гэрээ, түүний нэмэлт, өөрчлөлт;
3. “Монголын төмөр зам” ТӨХК, ЗХЖШ-ын хооронд 2019 оны 06 дугаар сарын 12-ны өдөр байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын шугамын доод бүтцийн барилгын ажил гүйцэтгэх АГТ-н/1901 н/387 тоот гэрээ;
4. “Монголын төмөр зам” ТӨХК, УБТЗ ХНН-ийн хооронд 2020 оны 02 дугаар

³⁰ Зарим мэдээлэл хэд хэдэн удаа давхацсан байгааг анхаарах нь зүйтэй.

сарын 05-ны өдөр байгуулсан Тавантолгой-Зүүнбаян чиглэлийн төмөр замын дээд бүтэц дохиолол холбоо, эрчим хүч, гүүр, хоолойн барилгын ажил, зураг төсөл гүйцэтгэх АГГ-20/21-20/06 ОГ/20/042 тоот гэрээ;

5. “Эрдэнэс Тавантолгой ХК, “Тавантолгой төмөр зам” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 28-ны өдөр байгуулсан Богдхан төмөр замын төслийн суурь, бүтцийн барилгын угсралтын бүтээн байгуулалтын ажлын санхүүжилтийн МН-ЭТТ2022/497, ТТЗ-МН22/02 тоот гэрээ;
6. “Эрдэнэс Тавантолгой” ХК, “Тавантолгой төмөрзам” ХХК, “Бодь интернэшнл” ХХК- хооронд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Богдхан төмөр зам төслийн туннел болон эстакадан гүүрний зураг төсөл, худалдан авалт, барилгын ажлын санхүүжилтийн МН-ЭТТ/487, ТТЗ-МН22/01, VI-BBR-CONT-0002 тоот гэрээ;
7. “Эрдэнэс Тавантолгой ХК, “Бодь интернэшнл” ХХК-ийн хооронд 2022 оны 06 дугаар сарын 27-ны өдөр байгуулсан Нүүрс нийлүүлэх МН-ЭТТ-2022/488, VI-BBR-CONT-0003 тоот гэрээ;
8. “Эрдэнэс Тавантолгой ХК “Набсан” ХХК, “Тэргүүн инвест” ХХК “Эс энд Эй трэйд” ХХК, “Бридж констракшн” ХХК, “ЧММ” ХХК, “Сан” ХХК-ийн хооронд 2022 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр байгуулсан Загийн усны хоолойн гүний усны ордоос “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн нүүрсний уурхай хүртэлх усны хангамжийн шугам хоолойн барилга угсралтын ажлын ЭТТ-2022/34, ЭТТ-2022/35, ЭТТ-2022/36, ЭТТ-2022/37 тоот гэрээ;
9. “Эрдэнэс Тавантолгой ХК, “Элгэн” ХХК, “Литопр” ХХК, “Инженер геодези” ХХК, “Эс Жи Эс Ай Эм Эм И Монголиа” ХХК-ийн хооронд 2022 оны 10 дугаар сарын 25-ны өдөр байгуулсан Тавантолгой ордын далд уурхайн хайгуул, судалгааны ажил гүйцэтгэх Н-ЭТТ-2022/946 тоот гэрээ зэрэг багтжээ.

Эдгээр гэрээг нууцалсан үндэслэлийг тодруулбал, ТБАНТХ-ийн 10.1.5 дахь хэсэгт “мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах” бүрэн эрх олгосны дагуу Засгийн газар мэдээллийг нууцлах тогтоол гаргасан байна. Гэвч дээрх тогтоолд уг мэдээллийг төрийн нууц, эсхүл албаны нууцад хамааруулсан эсэх нь тодорхой бус байгаагаас гадна ҮАБЗ-ийн шийдвэрээр аливаа мэдээллийг төрийн нууцад хамруулах талаарх зохицуулалт ТБАНТХ-д тусгагдаагүй.

Тендерийн хяналтыг сайжруулах

Нэг талаас төрийн байгууллага, эсхүл төрийн өмчит, төрийн оролцоотой хуулийн этгээд, нөгөө талаас иргэн, ААН харилцан тохиролцож, худалдах, худалдан авах, ажил үйлчилгээ үзүүлэх зэрэг гэрээ байгуулах тохиолдолд төрийн нууцын зарим хэсгийг гэрээний талд задруулах шаардлага үүсэх тохиолдол гардаг. ТБАНТХ-ын 33.2 дахь хэсэгт “... нууцыг шилжүүлэн авах хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлага хангасан, иргэн нь төрийн болон албаны нууцтай танилцах эрх авсан

байна”³¹ гэж заасан байдаг. Өөрөөр хэлбэл, гэрээний харилцаанд орох нь төрийн нууцыг гэрээний нөгөө талдаа задруулах шаардлагыг үүсгэж байна.

Дээр дурдсанчлан гэрээний зүйл нь төрийн нууцад холбогдох тохиолдолд сонгон шалгаруулалтын ил тод байдлыг хэрхэн хангах талаар тодруулах нь зүйтэй. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4-т “Хуулиар төрийн нууцад хамааруулсан болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой тусгай зориулалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, техник, байгууламж, ажил, үйлчилгээ болон галт зэвсэг худалдан авахтай холбоотой харилцааг энэ хуулиар зохицуулахгүй” гэж заасан. Өөрөөр хэлбэл үүнд дурдсан ажил үйлчилгээ, худалдан авалттай холбоотой тендер шалгаруулалт хуульд заасан журмаас гадуур явагдаж байна.

Хэдийгээр гэрээний зүйл нь төрийн нууцад холбогдох ч сонгон шалгаруулалт тэгш, шударга, хуульд заасан журмын дагуу явагдах учиртай. Иймд төрийн нууцыг задруулах, эсхүл задруулж болзошгүй сонгон шалгаруулалтын явцад олон нийтийн хяналт тавих чиг үүргийг хэрэгжүүлэх тусгай хяналт тавих этгээд оролцох шаардлагатай. Мөн гэрээ байгуулсны дараа гэрээг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн нууцлах, нууцлалыг хамгаалах асуудал хөндөгддөг.

3.5 ТБАНТХ-д заасан тагнуулын байгууллагын эрх хэмжээ, чиг үүрэг

ТЕГ нь төрийн нууц болон албаны нууцыг тогтоох, ил болгоход чухал үүрэгтэй оролцож байна. ТБАНТХ-д заасны дагуу тагнуулын байгууллага нь улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр нууцын хадгалалт, хамгаалалтад хянан тавьж, нууцад хамаарах мэдээлэл задарч, үрэгдэхээс урьдчилан сэргийлэх, зөрчлийг илрүүлэх, таслан зогсоох арга хэмжээг авна.

ТБАНТХ-ийн 12 дугаар зүйлд зааснаас гадна Тагнуулын байгууллагын гүйцэтгэх бусад чиг үүргийг дурдвал:

- Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь тус хуулийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулна;
- Төрийн байгууллага болон төрийн өмчийн оролцоотой бусад хуулийн этгээд албаны нууцад хамааруулах шаардлагатай мэдээллийн жагсаалтын төсөл боловсруулж, тагнуулын байгууллагаас санал авсны үндсэн дээр эрхэлсэн Засгийн газрын гишүүн, байгууллагын даргаар батлуулна;
- Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг энэ зүйлийн 19.1.2-т

³¹ “Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-ын 7 дугаар зүйлд хуулийн этгээд нууцад хамаарах мэдээлэл ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх үед нууц мэдээллийг хамгаалах талаар зохицуулсан. Журмын дагуу ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь Аюулгүй байдлын гэрчилгээ, иргэн нь тодорхой түвшний нууцтай танилцах эрхийг тагнуулын байгууллагаас тус тус авсан байх шаардлагатай.

заасан үндэслэлээр нууцлах хугацаа дуусахаас өмнө ил болгох эсэхийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ;

- Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага тухайн байгууллагын хариуцсан төрийн нууцтай танилцах албан тушаалтны жагсаалтыг тагнуулын байгууллагын саналыг авч батална;
- Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлж, эсхүл хүчингүй болгоно;
- Төрийн байгууллага нь төрийн болон албаны нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ;
- Тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн болон албаны нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулна;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараах хариуцлага хүлээлгүүлэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ;

Төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах журамд зааснаар Тагнуулын байгууллагын төрийн нууцын асуудал хариуцсан нэгж болон орон нутаг дахь салбар, нэгж дор заасан мэдээллийг тухай бүр мэдээллийн санд оруулна:

- төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн болон албаны нууцын жагсаалтад орсон мэдээлэл;
- аюулгүй байдлын шалгалтад хамрагдаж төрийн нууц хамгаалах, нууцтай танилцах зөвшөөрөл олгогдсон, зөвшөөрөл олгохоос татгалзсан албан тушаалтан, иргэний мэдээлэл;
- төрийн болон албаны нууцын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянан шалгасан тухай мэдээлэл, шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах чиглэлээр авсан арга хэмжээний талаарх мэдээлэл;
- төрийн болон албаны нууцын хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтан, иргэний мэдээлэл;
- төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээлэл;
- нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, бусад нууц тээгчийн шилжилт хөдөлгөөний талаарх мэдээлэл;
- халдлагын мэдээ (гадаад, дотоод, цахим гэх зэрэг).

Түүнчлэн дээр дурдсан мэдээллийг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн нууц хамгаалах нэгж, ажилтан нэгтгэж, жил бүрийн 1 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад цахим хэлбэрээр хүргүүлнэ гэжээ. Эндээс үзвэл төрийн болон албаны нууц мэдээллийг нэгтгэсэн нэгдсэн мэдээллийн санг төрийн байгууллага үүсгэж, хөтөлж байна. Гэвч холбогдох тоон мэдээлэл, тайлан нээлттэй бус, ил тод биш байна.

Олон улсын жишгийг үзвэл Төрийн нууцын тухай хуулиараа төрийн нууцтай холбоотой санал, дүгнэлт гаргах чиг үүргийг тагнуулын байгууллагад олгохоос гадна бие даасан, төрөлжсөн байгууллагыг үүсгэн байгуулсан тохиолдол бас цөөнгүй байна.

№	Улс	Байгууллагын нэр	Чиг үүрэг
1	Америк	Үндэсний архивын харьяа Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын алба ³²	Америк Улсад Мэдээллийн аюулгүй байдлын хяналтын алба жил бүр мэдээллийг нууцлах, нууцыг задлах статистик мэдээллийг цуглуулж, нууцалсан мэдээллийн тоо, холбогдох зардлын талаарх мэдээллийг олон нийтэд танилцуулдаг.
2	Болгар	Сайд нарын болон Үндэсний аюулгүй Зөвлөлийн удирдлага дор хамаарах шинэ төрийн байгууллага болох Мэдээллийн аюулгүй байдлын улсын комисс (SCSI) ³³	SCSI-д нууц мэдээллийг хянах эрх мэдэлтэй.
3	Унгар	Мэдээллийн аюулгүй байдал, мэдээллийн эрх чөлөөний асуудал эрхэлсэн Парламентын комиссар	Мэдээллийн нууцын зэрэглэлийг өөрчлөх эрхтэй ³⁴ .
4	Франц	Үндэсний батлан хамгаалахын нууцын асуудлаарх зөвлөлдөх комисс (CCSDN) ³⁵	Хэрэг хянан шийдвэрлэх явцад Үндэсний аюулгүй байдалд хамаарах мэдээллийг нууцын зэрэглэлээс гаргах асуудлаар санал, зөвлөмж өгдөг. Зөвлөмжийг төрийн албан ёсны сэтгүүлд нийтэлдэг.
5	Герман	Хуучин БНАГУ-ын Төрийн аюулгүй байдлын албаны бүртгэлийг хариуцсан Германы Холбооны Комисс (Гаукийн газар) ³⁶	1991 оноос хойш, тус комиссын холбогдох нэгжээс 3000 гаруй мэдээллийг нэгтгэж, олон нийтэд ил болгосон.

³² The Information Security Oversight Office (ISOO). <http://www.archives.gov/isoo/>.

³³ Law for the Protection of the Classified Information. Prom. SG. 45/30 Apr 2002, corr. SG. 5/17 Jan 2003

³⁴ Hungary, Act LXV of 1995 on State Secrets and Official Secrets.

³⁵ For a copy of decisions, see <http://www.reseauvoltaire.net/rubrique387.html>

³⁶ Web Site: <http://www.bstu.de/home.htm>

Дээрхээс дүгнэхэд ТЕГ-аас төрийн болон албаны нууцын тогтолцоонд хяналт хэрэгжүүлэх, санал, зөвлөмж өгөх, нууц мэдээлэл задрахаас урьдчилан сэргийлэх, хариуцлага тооцох зэргээр улсын хэмжээнд цогц хяналт хэрэгжүүлж байгаа нь нууц мэдээллийг хамгаалах тогтолцоонд чухал ач холбогдолтой байна. Гэсэн хэдий ч түүний чиг үүрэгт ил болгосон болон нууцалсан мэдээллийн тоо, зардалтай холбоотой тайланг нэгтгэн боловсруулах, олон нийтэд мэдээлэх чиг үүрэг тусгагдаагүй байгаа нь олон нийтийн нууц мэдээллийн тогтолцоонд итгэх итгэлийг бууруулж байж болзошгүй.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн зарим зүйл, заалтын хэрэгжилтийг судалж, Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 6 дугаар хавсралтаар

баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв. Энэхүү судалгааны хүрээнд, хуулиар тогтоосон нууцын тогтолцооны зорилго, зарчим, төрийн нууцын ойлголт, хүрээ, төрийн нууцыг тогтоох зарчим, баримтлах шалгуур, албаны нууцын ойлголт, хүрээ, албаны нууцыг тогтоох зарчим, баримтлах шалгуур, төрийн болон албаны нууцад хамааруулах тухай шийдвэр гаргах процесс, оролцогчдын эрх, үүрэг гэсэн асуудлыг хөндсөн. Үнэлэх үе шатанд томъёолсон шалгуур үзүүлэлтийн дагуу судалсан үр дүнд тулгуурлан дараах дүгнэлт, зөвлөмжийг боловсруулав. Үүнд:

1. Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх болон цаг үеэ олсон байх зарчмын тухайд

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчмын тухайд:

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчмын дагуу төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр, үйл ажиллагаа нь гагцхүү хуульд заасан үндэслэл, журмын дагуу байх ёстой бөгөөд төрийн нууцад холбогдох харилцаанд ТБАНТХ-ийг удирдлага болгох учиртай. Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д ТБАНТХ-д тодорхойлсон хүрээнээс давсан мэдээллүүд тусгагджээ. Мөн ҮАБЗ-ийн саналыг үндэслэж аливаа мэдээллийг төрийн нууцад хамруулах эрх хэмжээ ТБАНТХ-д тусгагдаагүй боловч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3.4 дэх хэсгийг үндэслэж, хуульд заагаагүй журмаар аливаа мэдээллийг нууцлах тохиолдол гарсан. Түүнээс гадна захиргааны байгууллага Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн дагуу нээлттэй байх мэдээллийг нууцлах зэргээр хуульд заасан үндэслэл, журмаас гадуур шийдвэр гаргаж байна.

Үүнээс дүгнэвэл ТБАНТХ-д заасан хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим практикт алдагдах тохиолдол байгаа бөгөөд түүнд тавих хяналт, хариуцлагын механизм сул байна.

Цаг үеэ олсон байх зарчмын тухайд:

Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 2019, 2020 болон 2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн. Тухайн жагсаалтаас мэдээлэл хассан тохиолдол байхгүй нь цаг үеэ олсон байх зарчмын хэрэгжилт хангалтгүй байгааг харуулж байна.

Иймд нууц мэдээллийн жагсаалтыг давтамжтай эргэн хянаж байх, ил болгосон мэдээллийн талаар нийтэд мэдээлэх чиг үүргийг хуульд тусгах зэргээр ТБАНТХ-д заасан цаг үеэ олсон байх зарчим хэрэгжих механизмыг бүрдүүлэх шаардлагатай.

2. "Төрийн нууц" гэх нэр томъёоны тодорхойлолтын тухайд

Хэдийгээр төрийн шийдвэр, үйл ажиллагаа нээлттэй, ил тод байх ёстой гэх хандлага хүчтэй байгаа боловч бусад орнуудад үндэсний аюулгүй байдал, батлан

хамгаалах, зэвсэг хүчин, гадаад харилцаа, эдийн засгийн болон мэдээллийн аюулгүй байдалтай холбоотой мэдээллийг нууцлах хандлага байна. Мөн олон улсад төрийн нууцыг хуулиар тогтоох хандлага байгааг анхаарах нь зүйтэй. Ингэхдээ нууц мэдээллийг нэг бүрчлэн хуульд жагсаан тусгах нь нууц мэдээллийн хамгаалалтыг сулруулахад хүргэж болзошгүй тул хуулиар төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээг агуулгаар тодорхойлох нь зохимжтой.

Монгол Улсад төрийн нууцад хамаарах мэдээллийн хүрээг хуулиар тогтоосон боловч үүнийг практикт хэрэгжүүлэхэд хүндрэл гарч байна. Тухайлбал, ямар мэдээлэл хуульд заасан төрийн нууцад хамаарах талаар дүгнэлт хийхэд хүндрэл үүсэж байна. Улс орнууд дээрх хүндрэлтэй байдлыг бууруулах үүднээс төрөл бүрийн арга, тогтолцоог ашиглаж байна. Тухайлбал, нууцад хамааруулахгүй мэдээллийн жагсаалт, нийтийн ашиг сонирхлын шалгуур зэргийг ашиглаж байна.

Монгол Улсын төрийн нууцын эрх зүйн орчинд тулгарч буй бэрхшээлтэй асуудлыг шийдвэрлэх үүднээс хуульд төрийн нууцад хамааруулахыг хориглох мэдээллийн жагсаалт болон хохирол ба нийтийн ашиг сонирхлын шалгуур /harm and public interest test/-ыг хуульд тусгах нь оновчтой.

3. "Албаны нууц" гэх нэр томъёоны тодорхойлолтын тухайд

ТБАНТХ дахь албаны нууцын тодорхойлолт нь хэт өргөн, тодорхойгүй бөгөөд ялгаа зааг, шалгуур үзүүлэлтийг тогтоогоогүйгээс үүдэн албаны нууцыг ангилахад хүндрэл учирч байна. Өнөөгийн түвшинд "албаны нууц" гэх ойлголтын хүрээнд төрийн байгууллага бүр өөрсдийн дур зоргоор аливаа мэдээллийг нууцлах байдал үүссэн. Казакстан, Киргизстан, Узбекистан зэрэг улсад "албаны нууц" (**служебная тайна**) хэмээх ойлголт байх боловч албаны нууц нь төрийн нууцын "нууц" зэрэглэлд хамаардаг. Ийнхүү хуульчилсан нь Монгол Улстай адил боловч Монгол Улсын ТБАНТХ-д заасанчлан "байгууллагын дарга жагсаалтаар тогтоодог" тусгай журамгүй. Харин бусад улс орнуудын нийтийн мэдээллийн тухай хууль, мэдээллийн ил тод байдлын тухай хууль тогтоомжид "албан мэдээлэл" гэх ойлголт цөөнгүй тусгагджээ. Төрийн байгууллагын шийдвэр, үйл ажиллагааны үр дүн, хэрэгжилтийг бууруулахгүй байх, иргэн, хуулийн этгээдийн нууц мэдээллийг задруулж тэдгээрт хохирол учруулахаас сэргийлэх зорилгоор албан мэдээлэлтэй танилцах иргэний эрхийг хязгаарлах боломжтой ч хязгаарласан мэдээллийг нууц гэж үздэггүй байна.

Иймд Төрийн нууцын хууль тогтоомж дахь "албаны нууц" гэх ойлголтыг халж, Нийтийн мэдээллийн тухай хуулиар үүнд холбогдох харилцааг зохицуулах, хязгаарлаж болох албан мэдээллийн жагсаалтыг байгууллагын дотоод журмаар нэг удаа батлаад орхих бус жил бүр, эсхүл тодорхой давтамжтайгаар шинэчилж байх зохицуулалтыг тусгаж, төрийн байгууллагын мэдээлэл хариуцсан ажилтнуудын ойлголтыг нэгдмэл болгох шаардлагатай. Байгууллагын дотоод журам, жагсаалт нь Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд нийцсэн байх, хэрэв зөрчилдвөл уг хуулийн давуу байдлыг хангах зохицуулалтыг хуульчилбал өнөөгийн практикт тулгарч буй хууль хэрэглээний хүндрэлийг даван туулахад чухал ач холбогдолтой.

Түүнчлэн төрийн байгууллага, албан хаагч нь иргэний мэдээлэл авах хүсэлтэд татгалзсан хариу өгөх тохиолдолд тухайн мэдээллийг нууцалсан үндэслэлээ тайлбарлах, улмаар татгалзсан шийдвэрт гомдол гаргах боломж

бүрдүүлэх нь иргэдийн төрийн байгууллагад итгэх итгэлийг нэмэгдүүлэх, цаашилбал иргэний мэдэх эрхийн баталгааг хангахад чухал нөлөө үзүүлнэ. Түүнчлэн иргэний хүсэлтийг бүртгэх, улмаар хяналтын чиг үүрэг бүхий байгууллагад тоон мэдээллийг тогтмол хугацаанд өгөх чиг үүргийг хуульд тусгах нь зүйтэй юм.

4. Засгийн газраас төрийн нууц мэдээллийн жагсаалт батлах зохицуулалтын тухайд

Практикт хуульд заагаагүй журмаар гэрээ, хэлэлцээрийг Засгийн газраас нууцлах явдал цөөнгүй байгааг анхаарах нь зүйтэй. ТБАНтХ-ийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулах”-аар тусгажээ. Үүнээс үзвэл, мэдээллийг төрийн нууцад хамааруулах Засгийн газрын шийдвэр, тогтоол нь ТБАНтХ-д заасан төрийн нууцын хүрээнд гарсан байх ёстой. Гэвч Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д хуульд заагаагүй, хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй олон тооны мэдээлэл багтсан байна.

Уг жагсаалтад багтсан мэдээллүүд нь ТБАНтХ-аар хамгаалагдах боломжтой. Засгийн газрын 257 дугаар тогтоолыг авч үзвэл, нууц мэдээллийг (анхдагч мэдээлэл) солилцох, боловсруулах, хэлэлцэх явцад үүсэх хоёрдогч мэдээллийг мөн төрийн нууцад хамааруулсан байгаа юм. Түүнчлэн тус жагсаалтад байгууллага бүрийн нууцлах ёстой мэдээллийг тус бүрээр жагсаасан нь төрийн нууцыг цөөн тооны этгээд мэдэх зарчимд нийцүүлэхтэй холбоотой боловч төрийн нууцад хамаарах мэдээллийг байгууллагаар нь бус, улсын хэмжээнд нэг мөр тогтоох нь эрх зүйн нэгдмэл байдлын үүднээс зохимжтой.

5. ТБАНтХ-д заасан тагнуулын байгууллагын эрх хэмжээ, чиг үүргийн тухайд

Төрийн болон албаны нууцад мэдээллийг хамруулах, ил болгох харилцаанд тагнуулын байгууллага чухал чиг үүрэг гүйцэтгэдэг. Гэсэн хэдий ч, ТЕГ-ын чиг үүргийн хүрээнд нууцалсан болон нийтэд ил болгосон мэдээллийн тоо, зардалтай холбоотой тайланг нэгтгэн боловсруулах, олон нийтэд мэдээлэх чиг үүрэг тусгагдаагүй байгаа нь нууц мэдээллийн тогтолцоонд хандах олон нийтийн итгэлийг бууруулах эрсдэлтэй байна.

Иймд нууцалсан мэдээллийн тоо, болон нийтэд ил болгосон мэдээллийн тоо, зардалтай холбоотой тайланг нэгтгэн боловсруулах, олон нийтэд мэдээлэх чиг үүргийг хуулиар тус байгууллагад хүлээлгэх нь зүйтэй.

ЭХ СУРВАЛЖ

Монгол хэл дээрх

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль, 1992.
2. Төрийн болон албаны нууцын тухай хууль, 2017.
3. Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоол.
4. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль.
5. Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

6. Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж. Баярцэцэг нар. Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, Нээлттэй нийгэм форум, 2010.
7. Б.Мэргэн. Нээлттэй төр ба төрийн нууц. УБ, 2014 (Монгол Улсын Их Сургууль).
8. Ц.Ган-Оч. Нууц мэдээллийг хамгаалах эрх зүйн орчин.
9. Д.Туяа, С.Эрдэнэбаяр. Нууцыг хадгалах тухай заасныг эргэж хармаар. "Өмгөөлөгч" мэдээлэл, танин мэдэхүйн сар тутмын сэтгүүл. 2006. №2. 8-11 дэх тал
10. Ш.Үнэнтөгс. Мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрх буюу нууцын тухай эрх. Хууль дээдлэх ёс. 2006. №4 (15). 41-44 дэх тал
11. Ж.Төгс-Очир. Төрийн нууц задруулах, төрийн нууц мэдээ, баримт бичиг, эд зүйлийг үрэгдүүлэх гэмт хэрэгт хүлээлгэх эрүүгийн хариуцлагын зарим асуудал. Гэмт явдалтай тэмцэх асуудал. 2011 №4.
12. Ц.Насанбат. Нууцлах хэнээрхэл. Монголын төр, эрх зүй. 2015 №1.
13. Б.Батхишиг. Эрүүгийн байцаан шийтгэх ажиллагаан дахь төрийн нууцтай холбоотой эрх зүйн зохицуулалтын асуудал. Хууль дээдлэх ёс. 2015 №2.
14. Б.Батхишиг. Монгол Улсын төрийн нууцын тодорхойлолтыг боловсронгуй болгох асуудал. Хууль дээдлэх ёс. 2015 №4.
15. Б.Батхишиг. Төрийн нууц ба мэдээллийн эрх чөлөө. Хүний эрх. 2017 №2.
16. Б.Батхишиг. Төрийн нууцыг гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх эрх зүйн зохицуулалтын асуудал. "Монгол Улсын үндэсний аюулгүй байдал ба олон улсын гэрээ". УБ, 2015.
17. Б.Баясгалан. Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах эрх зүйн тогтолцооны түүхэн хөгжил. Хууль дээдлэх ёс. 2020, №1(76).
18. А.Бат-Эрдэнэ. Төрийн болон албаны нууцын тухай хуулийг хэрэгжүүлэхэд тулгарч буй асуудал, хэрэгжүүлэх арга зам. Шүүх эрх мэдэл, хууль сахиулах алба хаагчдын үндэсний чуулган. УБ, 2021.
19. Б.Пүрэвсүрэн, Л.Галбаатар, О.Төрболд. Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ. УБ, 2019.

Гадаад хэл дээрх

Хууль тогтоомж

1. The Public's Right to Know: Principles on Freedom of Information Legislation, ARTICLE 19, June 1999, Principle 4.
2. Япон Улсын Тусгай зориулалтын нууцыг хамгаалах тухай хууль (Act on the Protection of Specially Designated Secrets)
3. ХБНГУ-ын Эрүүгийн хууль.
4. State Secrets and Classified Information of Foreign States Act of Estonia.
5. Bulgaria, Law for the Protection of the Classified Information. Prom. SG. 45/30 Apr 2002, corr. SG. 5/17 Jan 2003
6. Hungary, Act LXV of 1995 on State Secrets and Official Secrets.
7. Singapore, Official Secrets Act, <https://sso.agc.gov.sg/act/osa1935#pr1->
8. Moldavia, Law on State Secrets, <https://www.lawyer-moldova.com/2012/12/law-on-state-secrets.html>.
9. UK, Official Secrets Act 1989, <https://www.legislation.gov.uk/ukpga/1989/6/section/4>.
10. Malaysia, Official Secrets Act 1972, http://www.commonlii.org/my/legis/consol_act/osa1972156/.

Ном, өгүүлэл, судалгааны тайлан

11. UN Human Rights Committee's General Comment 34 on Article 19 of the International Covenant on Civil and Political Rights.
12. Robertson, K.G. (1999). The Morality of Secrecy: the Philosophy and Politics of State Secrecy. In: Secrecy and Open Government. Palgrave Macmillan, London. <https://doi.org/10.1057/97802305130202>.
13. David Banisar, Comments on the Moldovan Draft Law on State and Official Secrets, 2005, <https://www.osce.org/files/f/documents/3/7/16548.pdf>

ХАВСРАЛТ 1.

НЭЭЛТТЭЙ БАЙХ МЭДЭЭЛЛИЙН ЖАГСААЛТ

Мэдээлэл хариуцагч өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

- 8.2.1.эрхэм зорилго, үйл ажиллагааны стратегийн зорилт, зорилго, тэргүүлэх чиглэл, тэдгээрийн хүрээнд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, түүний үр дүн;
- 8.2.2.чиг үүрэг, бүтэц, зохион байгуулалт, хаяг, байршил, харилцах утасны дугаар, шуудангийн хаяг, олон нийттэй харилцах, мэдээлэл хүргэх нийгмийн сүлжээний хаяг;
- 8.2.3.эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлт, үйл ажиллагааны тайлан, мэдээлэл хариуцагчийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудит, санхүүгийн хяналт шалгалтын тайлан, акт, дүгнэлт, албан шаардлага, зөвлөмж;
- 8.2.4.хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайлан;
- 8.2.5.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн тайлан;
- 8.2.6.үйл ажиллагаандаа мөрдөж байгаа хууль тогтоомж, Засгийн газрын шийдвэр, бусад эрх зүйн акт;
- 8.2.7.албан тушаалын тодорхойлолт, албан тушаалтны эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, албаны харилцах утасны дугаар, албаны цахим шуудангийн хаяг;
- 8.2.8.өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн тайлан, мэдээ;
- 8.2.9.хуульд өөрөөр заагаагүй бол хариуцсан салбарын үйл ажиллагааны статистик мэдээлэл;
- 8.2.10.мэдээлэл хариуцагчаас зохион байгуулах олон нийтийн арга хэмжээний хөтөлбөр.

Мэдээлэл хариуцагч өөрийн хүний нөөцийн талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

- 8.3.1.ажлын байрны сул орон тооны талаарх мэдээлэл;
- 8.3.2.албан хаагч, ажилтныг сонгон шалгаруулах журам;
- 8.3.3.албан хаагч, ажилтны ёс зүйн дүрэм;
- 8.3.4.хүний нөөцийн стратеги, түүний хэрэгжилтийг хянаж үнэлэх журам;
- 8.3.5.хүний нөөцийн удирдлагын ил тод байдлыг хангах чиглэлээр авч хэрэгжүүлж байгаа арга хэмжээ;
- 8.3.6.албан хаагчийн ажлын гүйцэтгэлийг үнэлэх журам.

Мэдээлэл хариуцагч төсөв, санхүү, худалдан авах ажиллагааны талаарх дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

- 8.4.1.өмнөх оны төсвийн гүйцэтгэл, тухайн жилийн төсөв, дараа оны төсвийн төсөл;
- 8.4.2.төсвийн гүйцэтгэлийн биелэлт болон хагас, бүтэн жилийн санхүүгийн тайлан;
- 8.4.3.санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлт;
- 8.4.4.хууль тогтоомжийн дагуу төвлөрүүлэх төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ;
- 8.4.5.төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;
- 8.4.6.таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг;
- 8.4.7.цалингийн зардлаас бусад таван сая, түүнээс дээш төгрөгийн үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэрийн хамт;
- 8.4.8.бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр;
- 8.4.9.шилэн дансны хөтлөлт, хэрэгжилт, аудитын тайлан, зөвлөмжийн дагуу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний мэдээлэл;
- 8.4.10.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, тендерийн баримт бичиг, тендер шалгаруулалтыг явуулах журам, тендерийн урилга, тендерт оролцохыг сонирхогчид тавих шалгуур үзүүлэлт, тендерт шалгарсан болон шалгараагүй оролцогчийн талаарх товч мэдээлэл, шалгарсан болон шалгараагүй хуулийн үндэслэл, шалтгаан;
- 8.4.11.худалдан авах ажиллагаанд хийсэн үнэлгээ болон аудит, бусад хяналт шалгалтын тайлан, дүгнэлт;
- 8.4.12.мэдээлэл хариуцагч болон захиалагч байгууллагын хүсэлтээр холбогдох этгээдийг худалдан авах ажиллагааны мэргэжил, арга зүйн зөвлөгөө, зааварчилгаагаар хангасан тухай мэдээлэл;
- 8.4.13.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагаанд оролцох эрхийг хязгаарласан этгээдийн жагсаалт;
- 8.4.14.Засгийн газрын гадаад улс, олон улсын байгууллагаас авсан зээл, тусламжийн гэрээ, хэлэлцээрийн талаарх мэдээлэл;
- 8.4.15.улсын төсөв, Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого, зарлага,

хөрөнгө оруулалт, төсвийн нэгдсэн үзүүлэлт;
8.4.16.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн ашиглалтын мэдээлэл;
8.4.17.Засгийн газрын гадаад, дотоод өрийн мэдээлэл;
8.4.18.улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбар;
8.4.19.нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн сарын мэдээ;
8.4.20.төсвийн гүйцэтгэл болон аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан;
8.4.21.төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын дотоод үнэт цаасны мэдээлэл;
8.4.23.төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ байгуулсан тухай бүрд хувийн хэвшлийн түншлэгч, түүний байгууллагын нууцад хамаарахаас бусад мэдээлэл, түншлэлийн зүйл, гүйцэтгэх ажил, үзүүлэх үйлчилгээний талаарх мэдээлэл;
8.4.24.хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан Засгийн газрын гадаад үнэт цаасны мэдээлэл;
8.4.25.улсын төсвийн нэгдсэн үзүүлэлтийг макро эдийн засгийн үзүүлэлт, холбогдох бусад үзүүлэлттэй уялдуулсан судалгаа, тооцоо;
8.4.26.төсвийн хөрөнгөөр болон гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилт, хэрэгжилт, явц, үр дүн;
8.4.27.мэдээлэл хариуцагчийн захиалгаар хийгдсэн судалгаа, шинжилгээний ажил, түүний тайлан;
8.4.28.хууль тогтоомжид заасан бусад.

Мэдээлэл хариуцагч хуульд заасан чиг үүргийн хүрээнд үзүүлж байгаа үйлчилгээний талаар дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

8.5.1.үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл;
8.5.2.зөвшөөрөл олгох, сунгах, түдгэлзүүлэх, сэргээх, хүчингүй болгох үндэслэл, журам, олгосон, сунгасан, түдгэлзүүлсэн, сэргээсэн, хүчингүй болгосон зөвшөөрлийн талаарх мэдээлэл, зөвшөөрөл эзэмшигчийн нэр, хаяг, салбар, төлөөлөгчийн газар, зөвшөөрөл олгосон болон зөвшөөрлийн хүчинтэй хугацаа.

Мэдээлэл хариуцагч дээрхээс гадна өөрийн эрхлэх асуудлын хүрээний дараах мэдээллийг байнга ил тод, нээлттэй байлгана:

8.6.1.олон нийтээр хэлэлцүүлж, санал авч байгаа хууль тогтоомж болон

захиргааны хэм хэмжээний актын төсөл, тэдгээрийн танилцуулга, холбогдох судалгаа, бусад байгууллага, иргэнээс өгсөн санал;

8.6.2.эзэмшиж байгаа оюуны өмчийн эрхийн жагсаалт;

8.6.3.хот болон газар зохион байгуулалтын төлөвлөлт, түүнд нэмэлт, өөрчлөлт оруулах шийдвэрийн явцын талаарх мэдээлэл;

8.6.4.мэдээлэл хариуцагчийн эзэмшиж байгаа газрын мэдээлэл;

8.6.5.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн нэр, хаяг, дүрэм, үйл ажиллагааны чиглэл, эрх бүхий этгээдийн оруулсан хөрөнгийн хувь хэмжээ, ашиг, алдагдлын тайлан, нэгдсэн төсөвт төлсөн татварын хэмжээ, ногдол ашиг;

8.6.6.төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хувийн эрх зүйн хуулийн этгээдийн удирдах зөвлөл, хяналтын зөвлөлийн бүтэц, бүрэлдэхүүн, тэдгээрийн гишүүн болон гүйцэтгэх удирдлагын эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, авч байгаа цалин хөлс, урамшууллын дүн, албаны цахим шуудангийн хаяг, тухайн хуулийн этгээдийн удирдлагад тавигдах шаардлага, удирдлагыг сонгон шалгаруулах журам, сонгон шалгаруулах ажиллагааны тов, сонгон шалгаруулалтад оролцогчдын талаарх мэдээлэл;

8.6.7.стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордыг ашиглах тусгай зөвшөөрөл эзэмшигч хуулийн этгээдийн хувьд нэгдсэн төсөв болон Үндэсний баялгийн санд оруулж байгаа татвар, хөрөнгийн хэмжээ;

8.6.8.төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгийг хүн, хуулийн этгээдэд ашиглуулах, шилжүүлэх, хувьчлах, төсвийн хөрөнгийн ашиглалт болон түүнийг ашиглалтаас гаргах, ашиглалтаас гаргаснаас орсон орлогын талаарх мэдээлэл;

8.6.9.хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээний явцад байгаль орчинд учруулж болзошгүй сөрөг нөлөөлөл, үр дагавар, тэдгээрийг арилгах арга хэмжээг тогтоосон байгаль орчны нөлөөллийн үнэлгээний талаарх мэдээлэл, газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн мэдээлэл;

8.6.10.мэдээлэл хариуцагчийн явуулж байгаа үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж байгаа техник, технологийн хүн, мал, амьтны эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийн талаарх мэдээлэл;

8.6.11.барилга байгууламжийг ашиглалтад оруулахыг зөвшөөрсөн улсын комиссын дүгнэлт;

8.6.12.тусгай хамгаалалттай газар нутаг дэвсгэрт олгосон газар ашиглах гэрчилгээ, байгуулсан гэрээ, газар ашигласны төлбөр төлөлтийн байдал;

8.6.13.Ашигт малтмалын тухай хуулийн 42 дугаар зүйлд заасны дагуу байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар нутгийн захиргааны байгууллагаас тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй байгуулсан гэрээ;

8.6.14.шүүн таслах ажиллагааны дүн мэдээ;

8.6.15.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцэд гаргасан өргөдөл, гомдол, хүсэлтийн дагуу маргаан хянан шийдвэрлэсэн ажиллагааны дүн мэдээ;

8.6.16.улс төрийн намын дүрэм, гишүүнчлэл, хөрөнгө, түүнд өгсөн хандивын мэдээлэл;

8.6.17.Монгол Улсын нэгдэн орсон олон талт олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэг, хүргүүлсэн тайлан, Монгол Улсад өгсөн зөвлөмж, зөвлөмжийн хэрэгжилтийг хариуцах байгууллагын талаарх мэдээлэл;


8.6.18.зүй ёсны монополь аж ахуй эрхлэгчийн үнийн бүрдлийн мэдээлэл болон давамгайл байдалтай аж ахуй эрхлэгчийн жагсаалт;

8.6.19.хуулийн этгээдийн эцсийн эзэмшигч, эцсийн өмчлөгчийн талаарх мэдээлэл;

8.6.20.нэвтрэх, ашиглахад хязгаарлалт тогтоогоогүй мэдээллийн сан дахь нээлттэй өгөгдөл;

8.6.21.мэдээлэл хариуцагчийн зардлаар суралцагчийн эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, суралцаж байгаа улс, сургуулийн нэр, мэргэжил, суралцах хугацаа, мэдээлэл хариуцагчаас санхүүжүүлсэн сургалтын зардлын дүн, гэрээний хэрэгжилт;

8.6.22.хууль болон олон улсын гэрээгээр нээлттэй байхаар заасан бусад мэдээлэл.



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

2026.03.04

Судалгааг захиалагч:

Монгол Улсын Засгийн газрын хэрэг эрхлэх газар

Хууль зүй, дотоод хэргийн яам

Судалгааг хянасан:

Н.Жамъянхүү

Захирал

Судалгааг удирдсан:

Б.Ариунжаргал

Эрүүгийн эрх зүй, криминологийн секторын Эрхлэгч

Судалгааг гүйцэтгэсэн:

Э.Анударь

Хувийн эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ахлах ажилтан

М.Ганди

Хувийн эрх зүйн секторын
Эрдэм шинжилгээний ажилтан

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

БНтХ	Байгууллагын нууцын тухай хууль
ЗтХ	Зөрчлийн тухай хууль
НМЭИТБтХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
ТБАНтХ	Төрийн болон албаны нууцын тухай хууль
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ТНтХ	Төрийн нууцын тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
ЭХХШтХ	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт ...	8
Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	9
Хүснэгт 3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	9
Хүснэгт 4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт	9
Хүснэгт 6. Шалгах хэрэгслийг сонгосон байдал	10
Хүснэгт 6. ТБАНтХ болон ТНтХ-ийн төсөл	11
Хүснэгт 7. Төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийн тухай зохицуулалтын харьцуулалт	17
Хүснэгт 8.	23
Хүснэгт 9. Төрийн нууцыг хамгаалах тухай зохицуулалтын харьцуулалт	25
Хүснэгт 10. Мэдээллийг нууцлах болон ил болгох тухай зохицуулалтын харьцуулалт	33
Хүснэгт 11. ТБАНтХ болон хуулийн төсөлд заасан хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт	41
Хүснэгт 12. ТБАНтХ болон Төрийн нууцын тухай хуулийн төслийн нууцын зэрэглэлтэй холбоотой зохицуулалт	42
Хүснэгт 13. ТБАНтХ болон Төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан сахилгын хариуцлагатай холбоотой зохицуулалт	43
Хүснэгт 14. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ	50
Хүснэгт 15. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх	50

АГУУЛГА

ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
УДИРТГАЛ	5
НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ	7
ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ ...	8
2.1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	8
2.2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	8
2.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	9
2.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал.....	9
ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	10
3.1. "ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ" ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	11
3.2. "ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ" ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	33
3.3. "ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ" ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	50
3.4. "ХАРИЛЦАН УЯЛДАА" ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ.....	52
ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ	55
АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ.....	58

УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17 дахь хэсэгт “төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална” гэж заасны дагуу 1995 онд Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль батлагдсанаар төрийн нууцыг хамгаалахтай холбогдсон харилцааг анх удаа хуулиар зохицуулж, төрийн нууцыг хамгаалах тогтолцоо, эрх зүйн үндсийг тавьжээ.

Төрийн нууцын тухай хуульд 2001, 2003, 2004 (2 удаа), 2014, 2015, 2017 онд буюу нийт 7 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан. 1995 оны Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийг 2004 онд шинэчлэн найруулсан бөгөөд нийт 3 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү хууль нь Төрийн болон албаны нууцын тухай хууль батлагдах хүртэл хэрэгжиж байсан. Төрийн болон албаны нууцын тухай хууль /цаашид “ТБАНтХ” гэх/ 2016 оны 12 дугаар сарын 01-ний өдөр батлагдаж, өнөөдрийг хүртэл дагаж мөрдөгдөж байна.

Тус хууль нь 7 бүлэг, 40 зүйлтэй бөгөөд нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулжээ. УИХ-ын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 3.6.3.2-т “Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 3.6.4.3-т “Үндэсний аюулгүй байдлын мэдээллийн сан бүрдүүлж, Улсын Их Хурал, орон нутгийн иргэдийн төлөөллийн байгууллага, хэвлэл мэдээллээр дамжуулан иргэдийг үндэсний аюулгүй байдалтай холбоотой асуудлуудаар өргөн хүрээтэй мэдээллээр хангах механизмыг бий болгоно. Төрийн мэдээллийн нээлттэй нөөцийг бүрдүүлэх ажиллагааг эрчимжүүлж, тэдгээрийг цахим засгийн үйлчилгээнд үр нөлөөтэй ашиглах боломжийг бүрдүүлнэ” гэж, 3.6.4.4-т “Нийгэмд мэдээллийг хүртээмжтэй, түргэн, шуурхай хүргэх мэдээллийн хэрэгсэл, дэд бүтцийн хөгжлийг дэмжиж найдвартай ажиллагааг хангана” гэж, 3.6.4.5-т “Хэвлэл мэдээллийн байгууллагад хуулиар хориглоогүй мэдээллийг эрэн сурвалжилж олж авах, нийгэмд түгээхэд таатай эрх зүйн орчныг бүрдүүлэх”-ээр тусгажээ.

Мөн УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын зорилт 5.4-т “Иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг ил тод, үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ.” гэж, зорилт 7.5-д “Төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадвар бий болгоно.” гэж тус тус заасан бөгөөд тус тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.6.3-т “Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно.” гэж, 5.6.8-д “Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна.” гэж тус тус заажээ.

Харин Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн Дөрөвт “Хүний эрхийг дээдэлсэн засаглалын бодлого”-ыг тодорхойлсон бөгөөд үүнд “Төрийн үйлчилгээг цахимжуулж, үр ашиг, хүртээмж, ил тод байдлыг нэмэгдүүлэн, чадварлаг, ухаалаг төрийн албыг төлөвшүүлж, хүний эрхийг дээдэлсэн, авлигагүй төрийн бодлогыг хэрэгжүүлнэ. Монгол үндэсний үнэлэмжийг нэмэгдүүлж, эх оронч сэтгэлгээг бий болгох цогц арга хэмжээг хэрэгжүүлж, гадаад бодлогын нээлттэй, олон тулгуурт зарчмыг баримтална” гэж, 4.1.4.1-д “Төрийн үйл ажиллагаанд иргэдийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно.” гэж тус тус заажээ.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он)”-ийн 10.1.1-д “Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ” гэж заасан байна.

Дээрх бодлогын баримт бичгүүдэд тусгагдсан зорилтыг хангах үүднээс шинэчлэн найруулсан Төрийн нууцын тухай хуулийн төслийг боловсруулсан байна. Иймд тус хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуульд заасныг үндэслэн Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ыг баримтлан хуулийн төслийн үр нөлөөний үнэлгээг хийж, гүйцэтгэв.

НЭГ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Энэхүү судалгааны хүрээнд тус хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан, аргачлалд дурдсан 6 шалгуур үзүүлэлтээс дараах 4 шалгуур үзүүлэлтийг сонгосон болно. Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа.

Эдгээр шалгуур үзүүлэлтийг сонгохдоо дараах үндэслэлийг харгалзан үзсэн.

1. Тус хуулийн төсөл нь зорилгодоо хүрсэн эсэх;
2. Тус хуулийн төслийн зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх;
3. Төслийн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэхийг ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн дагуу;
4. Төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжтой нийцсэн эсэхийг тус тус үнэлнэ.

ХОЁР.ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ НЬ ТООЦОХ ХЭСГЭЭ ТОГТООСОН БАЙДАЛ

Энэхүү хэсэгт уг хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх хэсгийг тогтоож, сонгосон шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн болно.

2.1. Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Зорилгод хүрэх байдал” шалгуур үзүүлэлтээр хууль тогтоомжийн төслийн зохицуулалтыг шалгаж, үр нөлөөг нь үнэлэх бол тухайн төслөөр тавьсан зорилгод хүрэхэд чиглэгдсэн эсхүл түүнийг тодорхой илэрхийлж чадахуйц зүйл, заалтыг сонгоно. Үүний тулд тухайн төслийн үзэл баримтлалтай сайтар танилцаж, хууль тогтоомжийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлагыг хэрхэн тодорхойлсон, энэхүү үндэслэл, шаардлага нь зорилгыг хэрхэн илэрхийлж байгаа эсэхийг судалдаг.

Иймд зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар үр нөлөөг тооцно. Үүнд:

Хүснэгт 1. Зорилгод хүрэх түвшин шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Зорилгод хүрэх байдал	Сонгосон зүйл, заалт
1.	Төрийн нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх.	Төслийн 7 дугаар зүйл
2.	Төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх (УИХ мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох)-тэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх.	Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт
3.	Төрийн нууцтай танилцахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх.	Төслийн 5 дугаар бүлэг
4.	Төрийн нууцыг хамгаалахтай (ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцыг шилжүүлэх) холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх.	Төслийн 32 дугаар зүйл

2.2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлт нь хууль тогтоомжийн төслийн зүйл, заалтууд нь тэдгээрийг дагаж мөрдөх болон хэрэгжүүлэхэд боломжтойгоор боловсруулагдаж чадсан эсэх, дагаж мөрдөх боломжтой эсэх, тухайн төслийн зохицуулалтыг хэрэгжүүлэх субъект, байгууллага байгаа эсэх, тэдгээр байгууллагад тухайн зохицуулалтыг хэрэгжүүлэх боломж, бололцоо байгаа эсэхийг урьдчилан үнэлэх шалгуур үзүүлэлт юм.

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах агуулгын хүрээнд зохицуулалтуудыг сонгон “Практикт хэрэгжих боломж” гэх шалгуурын үр нөлөөг тооцсон болно.

Хүснэгт 2. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Практикт хэрэгжих боломж	Сонгосон зүйл, заалт
1.	Мэдээллийг нууцлах болон ил болгохтой холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэх.	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг Төслийн 18 дугаар зүйлийн 18.1-18.3 дахь хэсэг
2.	Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэх.	Төслийн 38 дугаар зүйл

2.3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Ойлгомжтой байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авсан тохиолдолд хууль тогтоомжийн төслөөс тодорхой заалтыг, эсхүл бүхэлд нь сонгон авч шалгах боломжтой. Хууль тогтоомжийн төсөлд хэрэглэсэн нэр томьёо, хэл зүйн найруулга, үг сонголтын хувьд ойлгомжтой байгаа эсэх, иргэд байгууллагууд тухайн зохицуулалтыг шууд ойлгож хэрэглэх, хэрэгжүүлэх боломжтой байгаа эсэхийг шалгаж үнэлнэ. Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс нэр томьёоны тодорхойлолттой холбоотой хэсгийг болон хууль зүйн техникийн алдаатай зохицуулалтыг сонгон авч үнэллээ.

Хүснэгт 3. Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Ойлгомжтой байдал	Сонгосон зүйл, заалт
1.	Хуулийн төслийн ойлгомжтой байдлыг үнэлэх	Хуулийн төсөл бүхэлдээ

2.4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслөөс үр нөлөөг нь тооцох хэсгээ тогтоосон байдал

“Харилцан уялдаа” шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн зүйл, заалт нь өөр хоорондоо болон бусад хүчин төгөлдөр хууль тогтоомжтой нийцсэн эсэх, мөн төрийн байгууллагын чиг үүрэгтэй давхардсан, зөрчилдсөн эсэхийг үнэлнэ.

Тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоог шалгах учир хуулийн төслийн тодорхой заалт, зохицуулалтыг бус тухайн төслийг бүхэлд нь сонгох нь зүйтэй гэж үзлээ. Өөрөөр хэлбэл, харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн зохицуулалт нэг бүрийн уялдаа холбоо, бусад хуультай нийцтэй байдлыг шалгадаг. Иймд тус шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийн зүйл, заалтад бүхэлд нь дүн шинжилгээ хийж, үр нөлөөг тооцно.

Хүснэгт 4. Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд сонгосон зохицуулалт

№	Харилцан уялдаа	Сонгосон зүйл, заалт
1.	Хуулийн төслийн зүйл, заалт хуулийн төслийн болон бусад хууль тогтоомжтой зөрчилдөж байгаа эсэх	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл Эрүүгийн хуулийн 19.11-19.13 дугаар зүйл.

**ГУРАВ.ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭД ТОХИРОХ ШАЛГАХ ХЭРЭГСЛИЙН ДАГУУ ХУУЛИЙН
ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ**

Өмнөх үе шатуудад хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх шалгуур үзүүлэлтийг сонгож, үр нөлөөг үнэлэх хэсгээ тогтоосон тул тэдгээрт тохирох шалгах хэрэгслийг дараах байдлаар харуулав:

Хүснэгт 5. Шалгах хэрэгслийг сонгосон байдал

№	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Тохирох шалгах хэрэгсэл
1.	Зорилгод хүрэх байдал	Төслийн 7 дугаар зүйл, Төслийн 8 дугаар зүйлийн 8.1.3 дахь заалт, Төслийн 5 дугаар бүлэг, Төслийн 32 дугаар зүйл.	Зорилгод дүн шинжилгээ хийх.
2.	Практикт хэрэгжих боломж	Төслийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, Төслийн 18 дугаар зүйлийн 18.1-18.3 дахь хэсэг, Төслийн 38 дугаар зүйл.	Төслийн зохицуулалтууд практикт хэрэгжих боломжтой эсэхийг судлах.
3.	Ойлгомжтой байдал	Төсөлд бүхэлд нь	Ойлгомжтой байдлыг судлах, ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар хуулийн төслийг шалгах.
4.	Харилцан уялдаа	Төсөлд бүхэлд нь	Хуулийн төслийн уялдаа холбоог Хууль тогтоомжийн тухай хууль болон аргачлалд заасан асуулгаар шалгах.

Дээрх урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирсон шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийн үр нөлөөг үнэллээ.

3.1. “ЗОРИЛГОД ХҮРЭХ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Хүснэгт 6. ТБАНТХ болон ТНТХ-ийн төсөл

Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016)	Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл (2026)
Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 4 дүгээр зүйл. Мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцлах зарчим 5 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 6 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг үүрэг 7 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх	Нэгдүгээр бүлэг. Нийтлэг үндэслэл 1 дүгээр зүйл. Хуулийн зорилт 2 дугаар зүйл. Төрийн нууцын тухай хууль тогтоомж 3 дугаар зүйл. Хуулийн үйлчлэх хүрээ 4 дүгээр зүйл. Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцлах зарчим 5 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт 6 дугаар зүйл. Төрийн нууцыг хамгаалах нийтлэг үүрэг 7 дугаар зүйл. Төрийн нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэх
Хоёрдугаар бүлэг. 8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 9 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 10 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 11 дүгээр зүйл. Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх 12 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын бүрэн эрх	Хоёрдугаар бүлэг. Төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх 8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 9 дүгээр зүйл. Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 10 дугаар зүйл. Засгийн газрын бүрэн эрх 11 дүгээр зүйл. Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх 12 дугаар зүйл. Тагнуулын байгууллагын бүрэн эрх
Гуравдугаар бүлэг. 13 дугаар зүйл. Төрийн нууцад хамааруулах мэдээлэл 14 дүгээр зүйл. Албаны нууцад хамаарах мэдээлэл	Гуравдугаар бүлэг. Төрийн нууцад хамааруулах мэдээлэл 13 дугаар зүйл. Төрийн нууцад хамааруулах мэдээллийн хүрээ
Дөрөвдүгээр бүлэг. 15 дугаар зүйл. Мэдээллийг нууцлах 16 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түүний шалгуур 17 дугаар зүйл. Мэдээллийг нууцлах хугацаа 18 дугаар зүйл. Төрийн болон албаны нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ 19 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцыг ил болгох үндэслэл, журам	Дөрөвдүгээр бүлэг. Мэдээллийг нууцлах болон ил болгох 14 дүгээр зүйл. Мэдээллийг нууцлах 15 дугаар зүйл. Төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, түүний шалгуур 16 дугаар зүйл. Мэдээллийг нууцлах хугацаа 17 дугаар зүйл. Төрийн нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ 18 дугаар зүйл. Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам
Тавдугаар бүлэг. 20 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцтай танилцах нөхцөл 21 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцтай	Тавдугаар бүлэг. Төрийн нууцтай танилцах 19 дүгээр зүйл. Төрийн нууцтай танилцах нөхцөл 20 дугаар зүйл. Төрийн нууцтай танилцах тусгай нөхцөл

танилцах тусгай нөхцөл 22 дугаар зүйл. Төрийн нууцтай танилцах эрх олгох 23 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцтай танилцах эрх 24 дүгээр зүйл. Албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэл 25 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох 26 дугаар зүйл. Аюулгүй байдлын шалгалт явуулах 27 дугаар зүйл. Албан тушаалтан, иргэний үүрэг 28 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтны үүрэг 29 дүгээр зүйл. Нууц хамгаалах ажилтны хууль зүй, эдийн засгийн баталгаа	21 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах эрх олгох 22 дугаар зүйл.Төрийн нууцтай танилцах эрх 23 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэл 24 дүгээр зүйл.Төрийн нууцтай танилцах эрхийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох 25 дугаар зүйл.Аюулгүй байдлын шалгалт явуулах 26 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэний үүрэг 27 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах ажилтны үүрэг 28 дугаар зүйл.Нууц хамгаалах ажилтны хууль зүй, эдийн засгийн баталгаа
Зургадугаар бүлэг. 30 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт 31 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах 32 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх 33 дугаар зүйл. Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн болон албаны нууцыг шилжүүлэх 34 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын техник, криптографын хамгаалалт 35 дугаар зүйл. Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн тохиолдолд төрийн болон албаны нууцыг хамгаалах 36 дугаар зүйл. Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн болон албаны нууцыг хамгаалах 37 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 38 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцын хамгаалалтад тавих хяналт	Зургадугаар бүлэг.Төрийн нууцыг хамгаалах 29 дүгээр зүйл.Төрийн нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт 30 дугаар зүйл.Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах 31 дүгээр зүйл.Төрийн нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх 32 дугаар зүйл.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцыг шилжүүлэх 33 дугаар зүйл.Төрийн нууцын техник, криптографын хамгаалалт 34 дүгээр зүйл.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн тохиолдолд төрийн нууцыг хамгаалах 35 дугаар зүйл.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах 36 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 37 дугаар зүйл.Төрийн нууцын хамгаалалтад тавих хяналт
Долдугаар бүлэг. Бусад зүйл 39 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 40 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох	Долдугаар бүлэг. Бусад зүйл 38 дугаар зүйл. Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 39 дүгээр зүйл. Хууль хүчин төгөлдөр болох

Төрийн болон албаны нууцын тухай хуулийг 2016 онд баталж, 2017 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс дагаж мөрдөх болсон билээ. Тус хууль нь 7 бүлэг, 40 зүйлтэй бөгөөд өнөөдрийг хүртэл нийт 6 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Одоогийн дагаж мөрдөж буй ТБАНтХ хэрэгжиж эхлэхээс өмнө 1995 онд баталсан “Төрийн нууцын тухай хууль”-ийг дагаж мөрдөж байсан бөгөөд тус хуульд “албаны нууц” гэх ойлголтыг хуульчлаагүй байна. Харин 2016 оны ТБАНтХ-д “төрийн нууц”, “албаны нууц”-ыг тус хуулиар зохицуулахаар шинэчлэн найруулж баталсан байна. Өөрөөр хэлбэл, “албаны нууц” гэх ойлголт манай улсын хувьд 2017 оноос хэрэглэгдэх болжээ.

Тус хуулийн 1.1-д “Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлж, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ. Өөрөөр хэлбэл, энэхүү хууль нь 1/ төрийн нууц, 2/ албаны нууцтай холбоотой харилцааг зохицуулсан хууль байна.

Харин тус хуулийн төслийн хүрээнд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ТБАНтХ-аас “албаны нууц” гэх ойлголтыг хасаж, төрийн нууцтай холбоотой асуудлыг зохицуулахаар шинэчлэн найруулсан хуулийн төслийг боловсруулсан байна. Одоо хүчин төгөлдөр байгаа хууль болон шинэчилсэн найруулгын төслийн бүтцийг харьцуулан харахад, албаны нууцтай холбоотой зохицуулалтыг хасаж, 7 бүлэг 39 зүйлтэйгээр боловсруулсан байна. Өөрөөр хэлбэл, бүтцийн хувьд зохицуулж байсан харилцаа, зүйл, заалтын нэр өөрчлөгдөөгүй бөгөөд “болон албаны” гэсэн үгийг хассан байна.

Хэдийгээр албаны нууцыг байхгүй болгох зохицуулалт нь төрийн мэдээллийг нээлттэй, ил тод болгоход чиглэсэн зорилготой байгаа ч мэдээллийг нууцлахтай холбоотой шалгуур, зарчим нь өөрчлөгдөөгүй байгаа юм. Тодруулбал, төслийн 4 дүгээр зүйлд заасан мэдээллийг төрийн нууцад хамруулах, нууцлах зарчим нь хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчим хэвээрээ байгаа юм. Мэдээллийг нууцлах нь өөрөө зайлшгүй байх, шаардлагатай хэмжээ, хязгаараас хэтрэхгүй байх зэрэг зарчмыг оруулаагүй нь мэдээлэл илүү ил тод байх нөхцөл бүрдэнэ гэж үнэлэхэд хангалтгүй юм.

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх болон цаг үеэ олсон байх зарчим Мэдээллийг нууцад хамааруулахад удирдлага болгох хуульд нийцсэн байх зарчим болон цаг үеэ олсон байх зарчим анх 1995 оны Төрийн нууцын тухай хуульд тусгагдаж, 2017 оны Төрийн болон албаны нууцын тухай хуульд уламжлагдаж тусгагдсан байна.¹

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим гэж төрийн байгууллага, албан хаагчийн аливаа шийдвэр, үйл ажиллагаа нь гагцхүү хуульд заасан үндэслэлийн дагуу байх ёстойг илэрхийлэх бол, цаг үеэ олсон байх зарчмыг үндэслэж, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд уг мэдээллийг ил болгох боломжтой. Өөрөөр хэлбэл,

¹ ХЗҮХ, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2023 он.

аливаа мэдээллийн үнэ цэнэ нь нөхцөл байдал, цаг үетэйгээ холбоотойгоор тодорхойлогддог буюу хувьсах шинжтэй байгааг ажиглаж болно.²

Хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим Ардчилсан нийгэмд төрийн байгууллага, албан тушаалтны шийдвэр үйл ажиллагаа олон нийтэд аль болох ил тод, нээлттэй, энэ талаарх мэдээлэл хүртээмжтэй байх ёстой. Харин онцгой нөхцөл буюу нийтийн ашиг сонирхлыг хамгаалах хэрэгцээ үүссэн тохиолдолд иргэний мэдэх эрхийг хуулиар хязгаарлаж болдог. Энэ нөхцөлийг Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 17 дахь хэсэгт "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална" гэж тусгасан. Үндсэн хуулийн дээрх заалтын дагуу нууцлах мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хязгаарлаж болох нь харагдаж байна.³

Түүнчлэн, НҮБ-ын Хүний эрхийн хорооноос гаргасан тайлбарын дагуу төрийн нууцын жагсаалтыг зөвхөн хуулиар тогтоох шаардлагатай.⁴ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт "Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ зүйлийн 13.1-д заасан жагсаалтын хүрээнд салбар, байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг боловсруулж, тагнуулын байгууллагын саналыг авч Засгийн газраар батлуулах"аар тусгажээ. Эндээс үзвэл Засгийн газрын аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулах тухай шийдвэр, тогтоол нь ТБАНТХ-д заасан төрийн нууцын хүрээнд гарсан байх ёстой.⁴

Гэвч Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д хуульд заагаагүй буюу хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй мэдээллүүд бас багтжээ. Тухайлбал, УИХ, түүний Тамгын газрын Мэдээлэл, холбооны сүлжээний бүтэц, зохион байгуулалт, программ хангамж, мэдээлэл нууцлагч техник хэрэгсэл, тэдгээрийн ажиллагааны зарчим, мэдээллийг төрийн нууцад тооцохоор тусгасан байгааг дурдаж болно.⁵

Монгол Улсад 2021 оноос Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль үйлчилж эхэлсэн бөгөөд хаалттай, хязгаарлагдмал, нээлттэй мэдээллийг ангилж тодорхой тусгасан. Гэвч тус хуульд заасны дагуу нээлттэй байх ёстой мэдээллийг төрийн байгууллагын албаны нууцад хамааруулах болон хувь хүний нууц, хувийн мэдээллийг албаны нууц гэх ойлголтод хамааруулах асуудал цөөнгүй байна. Тухайлбал, Дундговь аймгийн Говь-Угтаал сумын Засаг даргын А/112 тоот "Журам, жагсаалт батлах тухай" захирамжийн 2 дугаар хавсралтад

² Мөн тэнд.

³ Мөн тэнд.

⁴ Мөн тэнд.

⁵ Мөн тэнд.

“хувь хүний нууцын тухай мэдээллээр хамгаалагдсан хувь хүний мэдээлэл”-ийг албаны нууцад тооцож, 10 жил нууцлахаар тусгасан байна.⁶

Түүнчлэн Засгийн газраас 2022 оны 12 дугаар сард “нүүрсний хэрэг”-тэй холбогдуулан 9 гэрээний мэдээллийг төрийн нууцаас ил болгохоор шийдвэрлэсэн. Гэвч тухайн 9 гэрээ нь дээрх жагсаалтад тусгагдаагүй мэдээлэл байсныг анхаарах нь зүйтэй. Дээрхээс дүгнэвэл, ТБАНТХ-д мэдээллийг нууцад хамааруулах, нууцлахад удирдлага болгоно хэмээн заасан хуульд нийцсэн, үндэслэлтэй байх зарчим практикт алдагдсан цөөнгүй тохиолдол байна.⁷

Цаг үеэ олсон байх зарчим 2016 оны Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийг өргөн барихдаа төрийн байгууллага дахь төрийн нууцын хамгаалалт сул байгааг онцолж байжээ. Тухайлбал, Тагнуулын ерөнхий газраас 2011-2013 онд Ерөнхийлөгчийн Тамгын газар, УИХ-ын Тамгын газар, ЗГХЭГ, яамд, агентлаг, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газар зэрэг шат, шатны нийт 362 төрийн байгууллагыг хамруулсан хяналт, шалгалт явуулахад 1837 зөрчил илэрчээ. Үүний:

- 40 хувийг мэдээллийн технологи, сүлжээний орчинд төрийн нууцыг хадгалах, хамгаалахтай холбоотой;
- 34 хувийг төрийн нууцын албан хэрэг хөтлөлт, бүртгэлтэй холбоотой;
- 21 хувийг төрийн нууцтай харьцах албан тушаалтантай холбоотой;
- 5 хувийг биет хамгаалалттай холбоотой зөрчлүүд тус тус эзэлсэн нь улсын хэмжээнд төрийн нууцыг хадгалах, хамгаалах ажил хангалтгүй байгааг харуулж байна гэж хуулийн төсөл санаачлагчид үзэн, төрийн нууц хамгаалах тогтолцоог сайжруулах зорилгоор уг хуулийн төслийг өргөн барьсан байна.⁸

Өөрөөр хэлбэл, Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, эрх зүйн үндсийг тодорхойлох, мэдээллийг нууцлах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тус хуулийн төслийг боловсруулж батлуулсан. Үүнээс үүдэлтэйгээр, Засгийн газраас аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулахад төвлөрч, нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-ыг баталсан байх бөгөөд 2019, 2020 болон 2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн. Эндээс үзвэл, ТБАНТХ-д заасан цаг үеэ олсон байх зарчим хэрэгжихгүй байгаа бөгөөд ач холбогдлоо алдсан мэдээллийг нууцлалаас гаргах практик тогтоогүй байна. Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой ч үүнд хамаарах хууль тогтоомжийг ил тод, нээлттэй, ардчилсан төрийн үзэл баримтлалтай уялдуулах шаардлага байсаар байна. Жишээ нь, Япон Улс нууцлалыг 5 жилээр тогтоох бөгөөд 30 жилээс хэтрэхгүй байх талаар хуульчилжээ.⁹

⁶ Мөн тэнд.

⁷ Мөн тэнд.

⁸ Мөн тэнд.

⁹ Мөн тэнд.

Ийнхүү Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээний тайланд дурдсан асуудал хэвээр байх бөгөөд үүнийг шинэчилсэн найруулгын төслөөр сайжруулаагүй болох нь харагдаж байна.

Зорилгод хүрэх байдал"-ыг үнэлэхдээ хуулийн төсөл нь хэрэгцээ, шаардлагад нийцсэн эсэх, хуулийг батлан хэрэгжүүлснээр хүрэх үр дүн тодорхой байдлаар томъёологдож чадсан эсэхийг тухайн хуулийн төсөл, дээд эрэмбийн хуулийн үзэл баримтлал, түүний агуулгыг хуулийн төслийн үр нөлөөг үнэлж буй зохицуулалттай харьцуулан дүн шинжилгээ хийдэг. Энэ хүрээнд хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан төрийн нууцыг өмчлөх, гадаадын улс, олон улсын байгууллагад шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт, мөн тус хуулийн төслийн хоёрдугаар бүлэгт заасан төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхтэй холбоотой зохицуулалтаас 8 дугаар зүйлийн 8.1.3-т заасан мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоохтой холбоотой зохицуулалт, мөн төслийн 5 дугаар бүлэгт заасан төрийн нууцтай танилцах, 6 дугаар бүлэгт заасан төрийн нууцыг хамгаалахтай холбоотой зохицуулалтаас 32 дугаар зүйлд заасан ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцыг шилжүүлэх зохицуулалтыг тус тус сонгон дүн шинжилгээ хийнэ.

Төрийн нууцыг өмчлөх, гадаад улс, олон улсын байгууллагад шилжүүлэхтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Төрийн нууцыг өмчлөх нь түүнийг хамгаалахтай уялдаатай ойлголт бөгөөд задруулсан тохиолдолд хариуцлага хүлээлгэх чухал үндэслэл болдог. Үүнд иргэнтэй холбоотой буруу, дутуу, зөрүүтэй, ач холбогдолгүй болсон зэрэг мэдээлэл байх боломжтой бөгөөд үүнийг залруулах, иргэн өөрийн эрх, ашиг сонирхлыг зөрчиж буй мэдээлэлийг устгуулах, залруулах зэрэг эрх эдлэх боломжгүй байгаа нь учир дутагдалтай юм. Иймд хуулийн төслийн 7 дугаар зүйлд заасан зохицуулалтыг олон улсын сайн туршлага болон хүний эрхэд нийцүүлэн сайжруулах шаардлагатай байна.

Харин мэдээлэл хуваалцах гэдэгт дотоод болон гадаад тагнуулын байгууллага, партнер байгууллагуудын хооронд солилцох мэдээллийг ойлгоно. Гадаад болон дотоод тагнуулын байгууллагууд цогц аюулгүй байдлын сорилтыг даван туулахын тулд мэдээлэл хуваалцах шаардлагатай болдог. Харин хэдий хэмжээнд мэдээллээ хуваалцах нь тодорхойгүй бөгөөд тухайн хамтын ажиллагааны нөхцөл нууц байдаг.

Гадны байгууллагатай мэдээлэл солилцох ажиллагаанд тавих хяналт нь тухайн хяналтыг хэрэгжүүлж буй байгууллагын хувьд хүнд сорилт болдог. Хуваалцаж буй мэдээлэл нь найдвартай, холбоо хамааралтай, нотолгоотой, хязгаартай байгаагүйгээс болж хүний эрх зөрчигдөж байсан жишээ цөөнгүй бий.

Мэдээлэл хуваалцахын өмнө хүлээн авагч байгууллагын хүний эрх зөрчиж байсан түүх, байгууллагын үйл ажиллагааны стандарт зэргийг урьдчилан үнэлж, хуваалцах мэдээлэл нь үйл ажиллагааны зорилготой нийцэж буй эсэх, хэрэглэх нөхцөл, хүрээг тодорхой заах, хүний эрх зөрчихгүй байх баталгаа гаргах шаардлагатай. Мэдээлэл хуваалцах үед дараах шаардлагыг бичгээр баталгаажуулахдаа тусгах ёстой. Үүнд:

- Хэт өргөн эрх өгөхөөс татгалзах шаардлагатай;
- Эрүүгийн хэрэг, албадан шилжүүлэлтэд тухайн мэдээллийг ашиглахыг хориглох, шаардлагатай нөхцөлд илгээгчээс зөвшөөрөл авах;
- Нууцлал, хүний эрхийг хүндэтгэх;

Хэрэв дээрх шаардлагыг зөрчвөл хяналтын байгууллага зөрчлийг өмнө нь илрүүлж, тайлбар шаардах эрхтэй. Мөн тухайн бичгээр байгуулсан шаардлагыг өөрчлөх, зогсоох арга хэмжээ авч чаддаг байх шаардлагатай байна.

Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт төрийн нууцыг харилцан хамгаалах гэрээ, хэлэлцээр, тагнуулын байгууллагын саналыг үндэслэн шилжүүлэн өгөхөөр заажээ. Энэ нь одоо хэрэгжиж байгаа зохицуулалт бөгөөд гадны байгууллагад төрийн нууцыг Тагнуулын байгууллагын ганц саналыг үндэслэн шилжүүлэх нь хүний эрх, эрх чөлөөг зөрчих болон бусад эрсдэлийг дагуулсаар байна. Учир нь үүнийг дур зоргоор шилжүүлэх бус тодорхой зарчимд үндэслэн өөр байгууллагын, тухайлбал парламентын тусгай хяналтыг хэрэгжүүлэх дэд хороо, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл зэрэг байгууллагаар урьдчилсан хянуулсан нөхцөлд шилжүүлэх нь зохимжтой юм.

Ингэхдээ тухайн мэдээллийг шилжүүлэх, солилцохтой холбоотой гэрээ, хэлэлцээрийн төслийг хянуулж, шинжээчийн дүгнэлт гаргуулан хүний эрх, үндэсний аюулгүй байдал хохирол учирахгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байх нь чухал байна. Эс тэгвэл Тагнуулын байгууллагын удирдлагын дур зоргоор төрийн нууцыг гадагш нь гаргах эрсдэлтэй гэж үзлээ. Иймд хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг сайжруулах хэрэгцээ, шаардлагатай байна.

Төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхтэй холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

ТБАНТХ болон ТНТХ-ийн төсөлд төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрх дараах байдлаар зохицуулсан байна.

Хүснэгт 7. Төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхийн тухай зохицуулалтын харьцуулалт

Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016)	Төрийн нууцын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл (2026)
8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 8.1. Улсын Их Хурал төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.1. төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих; 8.1.2. төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд	8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх 8.1. Улсын Их Хурал төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 8.1.1. төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих; 8.1.2. төрийн нууцыг хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах; 8.1.3. мэдээллийг төрийн нууцад

зарцуулах хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах.	хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох.
9 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд төрийн <u>болон албаны</u> нууцын хамгаалалтад хяналт тавьж, энэ талаар холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.	9 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх 9.1.Монгол Улсын Ерөнхийлөгч-Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тэргүүн нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавьж, энэ талаар холбогдох төрийн байгууллагын тайлан, мэдээллийг сонсох, Засгийн газарт чиглэл өгөх бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.
10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 10.1.Засгийн газар улсын хэмжээнд төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж <u>дараахь</u> бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.төрийн <u>болон албаны</u> нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх; 10.1.2.төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах төрийн бодлого, төсөл, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх; 10.1.3.төрийн <u>болон албаны</u> нууцтай холбоотой журам, зааврыг батлах; 10.1.4.төрийн <u>болон албаны</u> нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах; 10.1.5.мэдээллийг төрийн <u>болон албаны</u> нууцад хамааруулах, <u>нууцыг шилжүүлэх</u>, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах.	10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрх 10.1.Засгийн газар улсын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж <u>дараах</u> бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх; 10.1.2.төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, төсөл, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх; 10.1.3.төрийн нууцтай холбоотой журам, зааврыг батлах; 10.1.4.төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах; 10.1.5.төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах; 10.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг Улсын Их Хуралд оруулах.

11 дүгээр зүйл.Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх 11.1.Байгууллага, албан тушаалтан төрийн болон албаны нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.1.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах; 11.1.2.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд байгаа төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих; 11.1.3.төрийн болон албаны нууцыг хамгаалах арга, хэрэгслийг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх саналаа эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх; 11.1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн болон албаны нууцыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлах, тухайн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах.	11 дүгээр зүйл.Байгууллага, албан тушаалтны бүрэн эрх 11.1.Байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.1.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг нийтлэг журамд нийцүүлэн баталж, мөрдүүлэх; 11.1.2.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд байгаа төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих; 11.1.3.төрийн нууцыг хамгаалах арга, хэрэгслийг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх саналаа эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх; 11.1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн нууцыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлах, тухайн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах.
12 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын бүрэн эрх 12.1.Тагнуулын байгууллага төрийн болон албаны нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.төрийн болон албаны нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 12.1.2.төрийн болон албаны нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан нууцыг ашиглаж, хамгаалж байгаа байдалд хяналт тавих, шалгах; 12.1.3.төрийн болон албаны нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгсэлд туршилт, шинжилгээ хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах; 12.1.4.байгууллага, албан тушаалтан төрийн болон албаны нууцаа хамгаалах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; 12.1.5.төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, төрийн болон албаны	12 дугаар зүйл.Тагнуулын байгууллагын бүрэн эрх 12.1.Тагнуулын байгууллага төрийн нууцыг хамгаалах талаар дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 12.1.1.төрийн нууц задрахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 12.1.2.төрийн нууцыг хариуцаж байгаа байгууллага, албан тушаалтан нууцыг ашиглаж, хамгаалж байгаа байдалд хяналт тавих, шалгах; 12.1.3.төрийн нууцыг хамгаалах техник, криптографийн хэрэгсэлд туршилт, шинжилгээ хийх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах; 12.1.4.байгууллага, албан тушаалтан төрийн нууцаа хамгаалах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; 12.1.5.төрийн нууцын тухай хууль тогтоомж, Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэх талаар холбогдох байгууллагатай хамтран ажиллах, төрийн нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг боловсронгуй болгох саналаа Засгийн газарт оруулах;

нууцыг хадгалах, хамгаалах, ашиглах ажлыг боловсронгуй болгох саналаа Засгийн газарт оруулах; 12.1.6.мэдээллийг төрийн болон албаны нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах; 12.1.7.төрийн болон албаны нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ашиглах; 12.1.8.төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн болон албаны нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг судалж, шалгах; 12.1.9.төрийн болон албаны нууцыг дамжуулах, илгээх мэдээлэл, шуудан харилцаа холбооны сүлжээ, шифр харилцааг улсын хэмжээнд болон хилийн чанадад зохион байгуулж, хяналт тавих; 12.1.10.төрийн болон албаны нууцыг хамгаалах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах; 12.1.11.төрийн болон албаны нууцыг харилцан солилцох, хамгаалах асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөлд санал, дүгнэлт өгөх. 12.2.Энэ зүйлийн 12.1.7-д заасан мэдээллийн санг байгуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.	12.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, нууцыг шилжүүлэх, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах, энэ хуульд заасан үндэслэлээр ил болгох асуудлаар санал боловсруулж, Засгийн газарт оруулах; 12.1.7.төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулж, ашиглах; 12.1.8.төрийн нууцтай танилцах албан тушаалтан, иргэнд аюулгүй байдлын шалгалт явуулах, төрийн нууцыг ашиглан үйл ажиллагаа явуулах, ажил гүйцэтгэх хуулийн этгээдийг судалж, шалгах; 12.1.9.төрийн нууцыг дамжуулах, илгээх мэдээлэл, шуудан харилцаа холбооны сүлжээ, шифр харилцааг улсын хэмжээнд болон хилийн чанадад зохион байгуулж, хяналт тавих; 12.1.10.төрийн нууцыг хамгаалах сургалт, эрдэм шинжилгээ, судалгааны ажлыг зохион байгуулах; 12.1.11.төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах асуудлаар байгуулах олон улсын гэрээ, хэлэлцээрийн төсөлд санал, дүгнэлт өгөх. 12.2.Энэ зүйлийн 12.1.7-д заасан мэдээллийн санг байгуулах, ашиглах журмыг Засгийн газар батална.
--	---

Дээрх хүснэгтээс харвал, Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн нууцыг хамгаалах талаарх төрийн байгууллага, албан тушаалтны бүрэн эрхэд дараах зарчмын шинжтэй өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох нь Засгийн газрын бүрэн эрхийн асуудал байсан бол шинэчилсэн найруулгаар ЗГ нь тус асуудлыг УИХ-д оруулж, УИХ-ын бүрэн эрхэд шилжүүлсэн;
- Байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хамгаалахад зөвхөн хууль тогтоомжид нийцүүлэх бус байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг нийтлэг журамд нийцүүлэн баталж, мөрдүүлэх бүрэн эрхийг нэмсэн.

Иймд дээрх шинээр нэмэгдсэн зохицуулалтын зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийг авч үзье.

- Улсын Их Хурлаас мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох зохицуулалтын тухайд

8 дугаар зүйл. Улсын Их Хурлын бүрэн эрх

8.1. Улсын Их Хурал төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:

8.1.3. мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох.

ТБАНТХ-ийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалд хуульд заасан хүрээнд нийцүүлэн төрийн нууцыг жагсаалт батлах эрхийг Улсын Их Хуралд олгож, иргэд, олон нийтийн хяналтыг тогтоох зорилго тавьсан. Өмнөх хуульд Засгийн газрын бүрэн эрхийн хүрээнд *мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудал* байсан бол шинэчилсэн найруулгаар дээрх зорилгын хүрээнд *мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудлыг* УИХ-ын бүрэн эрхэд шилжүүлжээ.

Хууль зүйн үндэсний хүрээлэнгээс 2023 онд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээнд “Засгийн газраас аливаа мэдээллийг төрийн нууцад хамааруулахад төвлөрч, нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна. Тухайлбал, Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар *Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт*-ыг баталсан байх бөгөөд 2019, 2020 болон 2021 онд нийтдээ 10 мэдээллийг нэмж, 1 мэдээллийг өөрчилсөн. Эндээс үзвэл, ТБАНТХ-д заасан цаг үеэ олсон байх зарчим хэрэгжихгүй байгаа бөгөөд ач холбогдлоо алдсан мэдээллийг нууцлалаас гаргах практик тогтоогүй байна... Түүнчлэн тус жагсаалтад хуульд заагаагүй, хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй хэд хэдэн мэдээлэл багтсан байна...Төрийн нууцын тухай хууль тогтоомж нь үндэсний аюулгүй байдалд чухал ач холбогдолтой ч үүнд хамаарах хууль тогтоомжийг ил тод, нээлттэй, ардчилсан төрийн үзэл баримтлалтай уялдуулах шаардлага байсаар байна.” гэжээ.

Хуулийн төслийн тандан судалгаанд төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын тогтоолоор баталдаг болсон нь Үндсэн хуультай зөрчилдөж байна гэж үзээд дараах сөрөг үр дагаврыг бий болгосон¹⁰ талаар дүгнэсэн. Үүнд:

- Мэдээллийг төрийн нууцад хамааруулах шалгуур суларсан;
- Улсын Их Хурлын хяналтгүйгээр Засгийн газар дур зоргоор шийдвэр гаргах боломжтой болсон;
- Иргэдийн мэдээлэл хүртэх эрх хязгаарлагдсан;
- Засгийн газар хууль бус үйлдлээ нууцлах эрх зүйн боломжтой болсон.

Түүнчлэн суурь, зарчмыг харвал Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17/-д *төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг*

¹⁰ ТБАНТХ-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судалсан тайлан.

хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална гэж заасан байдаг. Үүнээс харвал иргэн төрийн байгууллагаас мэдээлэл авах эрхтэй боловчиг нийтийн ашиг сонирхлын үүднээс тодорхой мэдээллийг зөвхөн хуулиар тогтоох замаар иргэдийн мэдээлэл хүлээн авах эрхийг хязгаарлах боломжтой байна.

Иймд Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт батлах, мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох асуудлыг Улсын Их Хурлын бүрэн эрхэд шилжүүлэх нь Үндсэн хуульд нийцэх ба Төрийн нууцын тухай хуульд заасан цаг үеэ олсон байх зарчмыг хэрэгжүүлэх, ач холбогдлоо алдсан мэдээллийг нууцлалаас гаргах, зөвхөн хуульд заасан үндэслэлийн дагуу төрийн нууцад хамаарах мэдээллийг нэгдсэн байдлаар Улсын Их Хурал батлах чухал ач холбогдолтой байна.

Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалт нь хууль ёсны зарчимтай зөрчилдөж болзошгүй байна. Учир нь байгууллага, албан тушаалтан нийтлэг журам бус хуульд нийцүүлэн журам гаргах учиртай бөгөөд уг журмыг гаргах хүрээ, гол зохицуулалтын зарчмыг тухайн хуулийн төслөөр зохицуулах нь зүйтэй.

Төрийн нууцтай танилцахтай холбоотой зохицуулалт зорилгодоо хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ
--

Төрийн нууцтай танилцахтай холбоотой зохицуулалтын агуулга хуулийн төслийн хүрээнд өөрчлөгдөөгүй байна. Төрийн нууцтай танилцах эрх нь парламентын хяналт тавих хүрээнд ач холбогдолтой байдаг ч тухайн эрх нь дүр зоргоороо бүхий л цаг үед, ерөнхий шаардлагын хүрээгээр тодорхойлогдох учиргүй.

Парламентын гишүүдийн нууц мэдээлэлд хандах эрхийг тодорхой нөхцөлтэйгээр хязгаарладаг байна. Тодруулбал:

- *Мэдэх шаардлагад үндэслэх зарчим (need to know principle)*: Олон улсын парламентад хүлээн зөвшөөрөгдсөн энэхүү зарчмын дагуу хяналт хэрэгжүүлэх явцад эрх бүхий этгээд тухайн мэдээллийг авах албан ёсны шаардлагатай тохиолдолд л нэвтрэх эрхтэй байдаг.
- *Хуулиар хязгаарлах*: Парламентын болон парламентын бус хяналтын байгууллагын нэвтрэх эрхийг Засгийн газар эсхүл агентлагийн шийдвэрээр хязгаарлах тохиолдол байдаг. Зөвхөн 5 улс (Финлянд, Унгар, Литва, Словак, Швед) парламентын авах мэдээлэлд хязгаарлалт тавих эрхийг үгүйсгэдэг байна.
- Нууц мэдээлэлд нэвтрэхийн тулд зарим улсад *нууц хадгалах гэрээ (NDA)* байгуулж, *аюулгүй байдлын шалгалт (security clearance)* хийдэг байна. Жишээ нь: Румынд парламентын гишүүд нууц мэдээлэл авахын тулд нууцлалын гэрээ байгуулсан байх ёстой байдаг. Түүнчлэн Литвад нууц

мэдээлэлд нэвтрэхийн тулд аюулгүй байдлын шалгалтыг давсан байх шаардлагатай байна.¹¹

Харин зарим гишүүд эдгээр шалгуурыг төрийн эрх мэдэл хуваарилалтад харшилж байна гэж үзэн эсэргүүцэх нь бий. Нийт парламентын гишүүдийн төрийн болон албаны нууцтай танилцах эрхийг Европын дараах 19 улсад янз бүрийн шатаар хязгаарласан байдагийг доорх хүснэгтээс харах боломжтой.

Хүснэгт 8. Гадаад улс орны төрийн болон албаны нууцтай танилцах парламентын эрхийн хүрээ¹²

Улс	Онц чухал нууц (TOP SECRET)	Маш нууц (SECRET)	Нууц (CONFIDENTIAL)	Албаны нууц (RESTRICTED)
Австри	Тодорхой хорооны гишүүд (Standing Subcommittee of the Interior Affairs Committee and Standing Subcommittee of the National Defence Committee)	Тодорхой хорооны гишүүд (Standing Subcommittee of the Interior Affairs Committee and Standing Subcommittee of the National Defence Committee)	Тодорхой хорооны гишүүд (Standing Subcommittee of the Interior Affairs Committee and Standing Subcommittee of the National Defence Committee)	Тодорхой хорооны гишүүд (Standing Subcommittee of the Interior Affairs Committee and Standing Subcommittee of the National Defence Committee)
Белги	Гишүүд эрхгүй	Гишүүд эрхгүй	Гишүүд эрхгүй	Тодорхой хорооны гишүүд (Тусгай хяналтын хороо)
Болгар	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Чех	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Дани	Гишүүд эрхгүй	Тодорхой хорооны гишүүд (The Committee on Danish Intelligence Services)	Тодорхой хорооны гишүүд (хэд хэдэн хороо)	Бүх гишүүд
Эстони	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Финлянд	Тодорхой хорооны гишүүд (хэд хэдэн хороо)	Тодорхой хорооны гишүүд (хэд хэдэн хороо)	Тодорхой хорооны гишүүд (хэд хэдэн хороо)	Тодорхой хорооны гишүүд (хэд хэдэн хороо)
Франц	Тодорхой хорооны дарга (Commission des Lois/ Commission de la Défence)	Тодорхой хорооны дарга (Commission des Lois/ Commission de la Défence)	Тодорхой хорооны дарга (Commission des Lois/ Commission de la Défence)	Тодорхой хорооны дарга (Commission des Lois/ Commission de la Défence)

¹¹ Directorate General for Internal Policies. Parliamentary oversight of security and intelligence agencies in the European Union. Policy Department C: Citizens' Rights and Constitutional Affairs, European Parliament.

¹² Ibid.

ХБНГУ	Тусгай хяналтын хорооны гишүүд	Тусгай хяналтын хорооны гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Унгар	Тодорхой хорооны гишүүд (Committee on National Security, Defence and Law Enforcement Committee)	Тодорхой хорооны гишүүд (Committee on National Security, Defence and Law Enforcement Committee)	Тодорхой хорооны гишүүд (Committee on National Security, Defence and Law Enforcement Committee)	Тодорхой хорооны гишүүд (Committee on National Security, Defence and Law Enforcement Committee)
Итали	Тодорхой хорооны гишүүд (Parliamentary committee for the security of the Republic (COPASIR))	Тодорхой хорооны гишүүд (Parliamentary committee for the security of the Republic (COPASIR))	Тодорхой хорооны гишүүд (Parliamentary committee for the security of the Republic (COPASIR))	Тодорхой хорооны гишүүд (Parliamentary committee for the security of the Republic (COPASIR))
Литва	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Нидерланд	Намын дарга	Намын дарга	Намын дарга	Бүх гишүүд
Польш (Sejm)	Тодорхой хорооны гишүүд (Special Services Oversight Committee) Парламентын дарга Парламентын асуулгын түр хороо	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Польш (Senat)	Парламентын дарга (Speaker) болон Парламентын даргын томилсон этгээд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Румын	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Словак	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Словени	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд	Бүх гишүүд
Испани	Парламентын асуулгын түр хороо	Тодорхой хорооны дарга Парламентын дарга (Speaker)	Тодорхой хорооны дарга Намын/Бүлгийн дарга Парламентын дарга (Speaker)	Намын/Бүлгийн дарга
Их Британи	Тодорхой хорооны гишүүд (Intelligence and Security Committee (ISC))	Тодорхой хорооны гишүүд (Intelligence and Security Committee (ISC))	Тодорхой хорооны гишүүд (Intelligence and Security Committee (ISC))	Тодорхой хорооны гишүүд (Intelligence and Security Committee (ISC))

Дээрхээс харвал, парламентын төрийн болон албаны нууцтай танилцах эрхийн цар хүрээ янз бүр байх бөгөөд онц чухал нууц болон маш нууц зэрэглэлийн мэдээлэлд зөвхөн парламентын дарга, тусгай хяналтын хорооны дарга хандах тохиолдол байдаг байна. Энэ нь шууд хүссэн үедээ нэвтэрч танилцах эрхтэй гэсэн агуулга биш бөгөөд мэдээлэлтэй

танилцах зорилго, шаардлага нь хууль ёсны үндэслэлтэй байх шаардлагатай. Нөгөө талаараа энэхүү шаардлагад нийцсэн тохиолдолд тагнуулын байгууллага мэдээлэлтэй танилцах эрхийг хязгаарлахгүй байх нь хэрэгтэй байдаг.

Хуулийн төслийн 20 дугаар зүйлд төрийн нууцтай танилцах эрхийн цар хүрээ, түүнийг хязгаарлах нөхцөлийг дэлгэрүүлэн зохицуулах нь мэдээлэлтэй танилцах, парламентын тусгай хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм. Иймд тус зохицуулалтыг хуулиар илүү дэлгэрэнгүй зохицуулах шаардлагатай гэж үзлээ.

Төрийн нууцыг хамгаалахтай холбоотой зохицуулалт хүрч байгаа эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Төрийн нууцын хуулийн төсөлд төрийн нууцыг хамгаалах тухай зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 9. Төрийн нууцыг хамгаалах тухай зохицуулалтын харьцуулалт

Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016)	Төрийн нууцын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл (2026)
30 дугаар зүйл.Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт 30.1.Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааг Засгийн газар уялдуулан зохицуулна. 30.2.Тагнуулын байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд тагнуулын байгууллага улсын хэмжээнд төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжил арга зүйн удирдлагаар хангах бүтцийн нэгжтэй байна. 30.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулах үүрэг, хариуцлагыг тэдгээрийн удирдлага хүлээнэ. 30.4.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн <u>болон албаны</u> нууцтай холбоотой ажлын цар хүрээ, ачааллаас хамааран тэдгээрийн удирдлагад шууд захирагдах төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах нэгж, эсхүл ажилтантай байна. <u>30.5.Төрийн болон албаны нууцыг хамгаалах нэгжийн чиг үүрэг, эрх зүйн байдлыг төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай нийтлэг журам болон өөрийн онцлогт нийцүүлэн баталсан тухайн байгууллагын дотоод журмаар тогтооно.</u> 30.6.Төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах үйл ажиллагааг энэ хууль болон түүнд	29 дүгээр зүйл.Төрийн нууцыг хамгаалах ажлын зохион байгуулалт 29.1.Монгол Улсын төрийн нууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газар чиглүүлэн удирдана. 29.2.Тагнуулын байгууллага бүрэн эрхийнхээ хүрээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг хэрэгжүүлэх бөгөөд тагнуулын байгууллага улсын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулж хэрэгжүүлэх, хяналт тавих, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах бүтцийн нэгжтэй байна. 29.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд төрийн нууцыг хамгаалах ажлыг зохион байгуулах үүрэг, хариуцлагыг тэдгээрийн удирдлага хүлээнэ. 29.4.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь төрийн нууцтай холбоотой ажлын цар хүрээ, ачааллаас хамааран тэдгээрийн удирдлагад шууд захирагдах төрийн нууцыг хамгаалах нэгж, эсхүл ажилтантай байна. 29.5.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг энэ хууль болон түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад заасны дагуу хууль зүй, зохион байгуулалтын, техникийн болон бусад арга хэмжээний тусламжтайгаар хэрэгжүүлнэ.

нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актад заасны дагуу хууль зүй, зохион байгуулалтын, техникийн болон бусад арга хэмжээний тусламжтайгаар хэрэгжүүлнэ.	
31 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах 31.1.Төрийн болон албаны нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэх, илгээх, бүртгэх, устгах, бүрэн бүтэн байдлыг хангах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг энэ хууль болон Засгийн газрын баталсан төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ. 31.2.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрийн үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор энэ зүйлийн 31.1-д заасан нийтлэг журамд нийцүүлэн дотооддоо дагаж мөрдөх төрийн болон албаны нууцыг хамгаалах журам тогтоож болно. 31.3.Төрийн нууцыг хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд илгээх, хүлээн авахад түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болно. 31.4.Хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд тусгай шуудан хүргэх, хүлээн авахтай холбогдсон харилцааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, тагнуулын байгууллагын даргын хамтарсан тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулна.	30 дугаар зүйл.Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, бүртгэх, тээвэрлэх, илгээх, устгах 30.1.Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэх, илгээх, бүртгэх, устгах, бүрэн бүтэн байдлыг хангах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг энэ хууль болон Засгийн газрын баталсан төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ. 30.2.Төрийн нууцыг хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд илгээх, хүлээн авахад түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болно. 30.3.Хилийн чанад дахь Монгол Улсын байгууллага, албан тушаалтанд тусгай шуудан хүргэх, хүлээн авахтай холбогдсон харилцааг гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Зэвсэгт хүчний Жанжин штабын дарга, тагнуулын байгууллагын даргын хамтарсан тушаалаар баталсан тусгай журмаар зохицуулна.
32 дугаар зүйл.Төрийн болон албаны нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх 32.1.Төрийн болон албаны нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх бүхий удирдлагын шийдвэрээр төрийн болон албаны нууцыг өөр төрийн байгууллага, хуулийн этгээдэд зохих журмын дагуу шилжүүлнэ. 32.2.Энэ зүйлийн 32.1-д заасны дагуу төрийн болон албаны нууцыг шилжүүлэн авах, эсхүл ашиглах төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлагыг хангасан байна.	31 дүгээр зүйл.Төрийн нууцыг төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх 31.1.Төрийн нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх бүхий удирдлагын шийдвэрээр төрийн нууцыг өөр төрийн байгууллага, хуулийн этгээдэд зохих журмын дагуу шилжүүлнэ. 31.2.Энэ зүйлийн 31.1-д заасны дагуу төрийн нууцыг шилжүүлэн авах, эсхүл ашиглах төрийн байгууллага, бусад хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлагыг хангасан байна
33 дугаар зүйл.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн болон албаны	32 дугаар зүйл.Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцыг шилжүүлэх

нууцыг шилжүүлэх 33.1.Төрийн болон албаны нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай нийтлэг журамд заасны дагуу шилжүүлж болно. 33.2.Энэ зүйлийн 33.1-д заасны дагуу нууцыг шилжүүлэн авах хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлага хангасан, иргэн нь төрийн болон албаны нууцтай танилцах эрх авсан байна. 33.3.Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн болон албаны нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн болон албаны нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн болон албаны нууцыг татан авах арга хэмжээ авна.	32.1.Тагнуулын байгууллагын зөвшөөрлийг үндэслэн төрийн нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн нууцыг хамгаалах тухай нийтлэг журамд заасны дагуу шилжүүлж болно. 32.2.Энэ зүйлийн 32.1-д заасны дагуу нууцыг шилжүүлэн авах хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлага хангасан, иргэн нь төрийн нууцтай танилцах эрх авсан байна. 32.3.Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна. 32.3.Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна. 32.4.Төрийн нууцад хамаарах мэдээлэл шинээр боловсруулах, шилжүүлэн авч тодорхой ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна. 32.5.Энэ хуулийн 32.4-т заасан хуулийн этгээдийг судалж, шалгах, аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална.
34 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууцын техник, криптографын хамгаалалт 34.1.Төрийн болон албаны нууцыг хамгаалах техник, криптографын арга хэмжээг төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ. 34.2.Төрийн болон албаны нууцыг хамгаалах техник, криптографын хэрэгсэл нь мэдээллийг хамгаалах зохих шаардлага хангасныг баталгаажуулсан байна. 34.3.Төрийн болон албаны нууцыг хамгаалах криптографын хэрэгслийг ашиглах асуудлыг Засгийн газрын баталсан төрийн шифр харилцааны дүрмээр зохицуулна.	33 дугаар зүйл.Төрийн нууцын техник, криптографын хамгаалалт 33.1.Төрийн нууцыг хамгаалах техник, криптографын арга хэмжээг төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ. 33.2.Төрийн нууцыг хамгаалах техник, криптографын хэрэгсэл нь мэдээллийг хамгаалах зохих шаардлага хангасныг баталгаажуулсан байна. 33.3.Төрийн нууцыг хамгаалах криптографын хэрэгслийг ашиглах асуудлыг Засгийн газрын баталсан төрийн шифр харилцааны дүрмээр зохицуулна.
35 дугаар зүйл.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн тохиолдолд төрийн болон	34 дүгээр зүйл.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх зүйн байдал өөрчлөгдсөн тохиолдолд төрийн нууцыг

албаны нууцыг хамгаалах 35.1.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эсхүл төрийн болон албаны нууцыг ашиглахтай холбоотой ажил дуусгавар болсон бол тухайн байгууллага, хуулийн этгээд өөрт байгаа төрийн болон албаны нууц тээгчийг хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй. 35.2.Энэ зүйлийн 35.1-д заасан тохиолдолд тухайн байгууллага, хуулийн этгээд төрийн болон албаны нууц тээгчийг тогтоосон журмын дагуу устгах, эсхүл дараахь байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна: 35.2.1.тухайн төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх залгамжлагчид шилжүүлэх; 35.2.2.тухайн нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх; 35.2.3.үндэсний төв архивт шилжүүлэх. 35.3.Энэ зүйлийн 35.2-т заасан төрийн болон албаны нууц тээгчийг устгах, шилжүүлэх арга хэмжээг авахад тагнуулын байгууллага хяналт тавина.	хамгаалах 34.1.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эсхүл төрийн нууцыг ашиглахтай холбоотой ажил дуусгавар болсон бол тухайн байгууллага, хуулийн этгээд өөрт байгаа төрийн нууц тээгчийг хамгаалах арга хэмжээг авах үүрэгтэй. 34.2.Энэ хуулийн 34.1-д заасан тохиолдолд тухайн байгууллага, хуулийн этгээд төрийн нууц тээгчийг тогтоосон журмын дагуу дараах байгууллагад шилжүүлэх арга хэмжээ авна: 34.2.1.тухайн төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн эрх залгамжлагч, эсхүл харьяалах дээд шатны байгууллагад шилжүүлэх; 34.2.2.тухайн нууцыг хариуцсан төрийн байгууллага, бусад хуулийн этгээдэд шилжүүлэх; 34.2.3.Энэ хуулийн 34.2.1, 34.2.2-т заасан байгууллага байхгүй тохиолдолд Үндэсний төв архивт шилжүүлэх. 34.3.Энэ хуулийн 34.2-т заасан төрийн нууц тээгчийг устгах, шилжүүлэх арга хэмжээг авахад тагнуулын байгууллага хяналт тавина.
36 дугаар зүйл.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн болон албаны нууцыг хамгаалах 36.1.Иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн болон албаны нууцыг хамгаалах асуудлыг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.	35 дугаар зүйл.Хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах 35.1.Иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах асуудлыг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна.
37 дугаар зүйл.Төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 37.1.Улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааг зохих төсвийн хөрөнгөөс, бусад байгууллага, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.	36 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааны санхүүжилт 36.1.Улс, орон нутгийн төсвөөс санхүүждэг байгууллагын төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг зохих төсвийн хөрөнгөөс, бусад байгууллага, хуулийн этгээд өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
38 дугаар зүйл.Төрийн болон албаны нууцын хамгаалалтад тавих хяналт 38.1.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага, тэдгээрийн нууц хамгаалах нэгж, ажилтан харьяа салбар, байгууллагын хэмжээнд төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавина. 38.2.Ажил гүйцэтгэх гэрээний захиалагч нь тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор ажил гүйцэтгэгчид шилжүүлсэн төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт тавих	37 дугаар зүйл.Төрийн нууцын хамгаалалтад тавих хяналт 37.1.Тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулна. 37.2.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал

үүрэгтэй. 38.3.Тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн болон албаны нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч биелэлтийг хангуулна. 38.4.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй. 38.5.Энэ зүйлийн 38.3-т заасан хяналт шалгалтыг зохион байгуулж явуулах журмыг Засгийн газар батална.	биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй. 37.3.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тагнуулын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол энэ хуулийн 18.4-т заасны дагуу шийдвэрлэнэ. 37.4.Энэ зүйлийн 37.1-т заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална. 37.5.Төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн удирдлага, тэдгээрийн нууц хамгаалах нэгж, ажилтан харьяа салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцын хамгаалалтад хяналт тавина. 37.6.Ажил гүйцэтгэх гэрээний захиалагч нь тухайн ажлыг гүйцэтгэхтэй холбоотойгоор ажил гүйцэтгэгчид шилжүүлсэн төрийн нууцын хамгаалалтад хяналт тавих үүрэгтэй. 37.7.Тагнуулын байгууллага төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг жил бүр Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд хүргүүлнэ.
--	--

Дээрх хүснэгтээс харвал Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд төрийн нууцыг хамгаалах тухай зохицуулалтад дараах зарчмын шинжтэй өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах үйл ажиллагааг Засгийн газар уялдуулан зохицуулдаг байсан бол одоо төрийн нууцын ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавих үйл ажиллагааг Засгийн газар чиглүүлэн удирдана.
- Төрийн болон албаны нууцыг хамгаалах нэгжийн чиг үүрэг, эрх зүйн байдлыг төрийн болон албаны нууцыг хамгаалах тухай нийтлэг журам болон өөрийн онцлогт нийцүүлэн баталсан тухайн байгууллагын дотоод журмаар тогтоодог байсныг хассан;
- Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрийн үйл ажиллагааны онцлогтой холбоотойгоор хуульд заасан нийтлэг журамд нийцүүлэн дотооддоо дагаж мөрдөх төрийн болон албаны нууцыг хамгаалах журам тогтоож болно гэсэн эрх олгосон зохицуулалтыг хассан;
- Нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд төрийн нууцыг шилжүүлэхэд тагнуулын байгууллагын зөвшөөрөлийг авна;
- Ажил гүйцэтгэхтэй холбоотойгоор төрийн нууцад хамаарах мэдээллийг боловсруулах, шилжүүлэн авч буй иргэн, хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авах ба тус гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батлах тухай зохицуулалт нэмсэн;
- Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авах зохицуулалт нэмсэн;

- Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд өөрчлөн байгуулагдсан, татан буугдсан, эсхүл төрийн нууцыг ашиглахтай холбоотой ажил дуусгавар болсон бол тухайн байгууллага, хуулийн этгээд өөрт байгаа төрийн нууц тээгчийг тогтоосон журмын дагуу Үндэсний төв архивт шилжүүлэхдээ хуулийн 34.2.1, 34.2.2-т заасан зохицуулалтыг харгалзана;
- Төрийн байгууллага, бусад хуулийн этгээд мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тагнуулын байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон бол энэ хуульд заасны дагуу шийдвэрлэх зохицуулалт нэмсэн;
- Тагнуулын байгууллага төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийн талаарх мэдээллийг жил бүр Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд хүргүүлэх зохицуулалт нэмсэн.

Иймд дээрх шинээр нэмэгдсэн зохицуулалтын зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийг авч үзье.

- **Ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр иргэн, хуулийн этгээдэд төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх зохицуулалтын тухайд**

32.1.Тагнуулын байгууллагын зөвшөөрлийг үндэслэн төрийн нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн нууцыг хамгаалах тухай нийтлэг журамд заасны дагуу шилжүүлж болно.

32.3.Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна.

32.4.Төрийн нууцад хамаарах мэдээлэл шинээр боловсруулах, шилжүүлэн авч тодорхой ажил гүйцэтгэх хуулийн этгээд нь тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авсан байна.

32.5.Энэ хуулийн 32.4-т заасан хуулийн этгээдийг судалж, шалгах, аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална.

Дээрх зохицуулалтыг харвал иргэн, хуулийн этгээд тагнуулын байгууллагаас аюулгүй байдлын гэрчилгээ авч, ажил гүйцэтгэх гэрээний үндсэн дээр төрийн нууц мэдээллийг шилжүүлэн авах ба тухайн аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална. Хэрэв ажил гүйцэтгэгч нь төрийн нууцыг хамгаалах үүргээ биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна.

Үүнээс аюулгүй байдлыг гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батлах тухай зохицуулалт нь шинэ хэм хэмжээ бөгөөд бусад зохицуулалтын тухайд Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Монгол Улсын төрийн болон албаны нууцыг хамгаалах нийтлэг журам”-д тусгалаа олсон байна. Тус журмын 4 болон 7 дугаар зүйлд аюулгүй байдлын гэрчилгээ олгох тухай зохицуулалтыг тусгасан байх бөгөөд журмыг батлах эрх бүхий субъект нь ТБАНТХ-ийн 10 дугаар зүйлийн 10.1.3-т заасны дагуу Засгийн газрын бүрэн эрхэд хамаарч байсан. Тодруулбал, одоогийн хуулиар аюулгүй байдлын гэрчилгээ олгох журам Засгийн газрын баталсан хэм хэмжээний актад тусгалаа олсон бол шинэчилсэн найруулгаар шатлалын хувьд доошилж тагнуулын

байгууллагын дарга аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг батлах зохицуулалттай болжээ.

Тагнуулын байгууллага нь аюулгүй байдлын гэрчилгээ олгох, тус гэрчилгээг олгох журмыг батлах, хяналт тавих зэрэг зохицуулах, шалгах, шийдвэр гаргах гэсэн 3 томоохон чиг үүргийг хэрэгжүүлэхээр байгаа тул эрх мэдлийн тэнцвэр хангаж буй эсэхийг анхаарах шаардлагатай. Учир нь гэрчилгээ олгох, татгалзах, түдгэлзүүлэх шийдвэрт гомдол гаргавал хэрхэх вэ гэдэг нарийн зохицуулалт байхгүй байна. Иймд тагнуулын байгууллага хэм хэмжээний акт батлах нь хэр оновчтой вэ гэдгийг бусад улсын туршлагаас судалъя.

ХБНГУ-ын туршлагаас харвал, Төрийн нууц материалын аюулгүй байдлын журам¹³-ын 25 дугаар хэсэгт гэрээний үндсэн дээр бусад этгээдэд төрийн нууц мэдээлэл өгөх зохицуулалтыг тусгасан байна. Тус журамд зааснаар төрийн нууц мэдээллийг хамгаалалтын түвшнээс нь хамааран дараах байдлаар ангилсан байна. Үүнд:

1. STRENG GEHEIM (Онц нууц мэдээлэл) - зөвшөөрөлгүйгээр задруулсан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс эсхүл түүний аль нэг муж улсын оршин тогтнол, амин чухал ашиг сонирхолд аюул учруулж болзошгүй бол;
2. GEHEIM (Нууц мэдээлэл) - зөвшөөрөлгүй этгээдэд задруулсан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс эсхүл түүний аль нэг муж улсын аюулгүй байдалд аюул учруулах, эсхүл түүний ашиг сонирхолд ноцтой хохирол учруулж болзошгүй бол;
3. VS-VERTRAULICH (хязгаарлагдмал нууц мэдээлэл) - зөвшөөрөлгүй этгээдэд задруулсан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс эсхүл түүний аль нэг муж улсын ашиг сонирхолд сөргөөр нөлөөлж болзошгүй бол;
4. VS-NUR FÜR DEN DIENSTGEBRAUCH (зөвхөн албан хэрэгцээнд зориулсан нууц мэдээлэл) - зөвшөөрөлгүйгээр задруулсан тохиолдолд Холбооны Бүгд Найрамдах Герман Улс эсхүл түүний аль нэг муж улсын ашиг сонирхолд хохирол учруулж болзошгүй бол.

Төрийн нууц материалын аюулгүй байдлын журмын 25 дугаар хэсэгт зааснаар иргэн, хуулийн этгээд нь гэрээний үндсэн дээр “хязгаарлагдмал нууц мэдээлэл” болон түүнээс дээш зэрэглэлтэй мэдээллийг авахын тулд *байгууллагад нууц мэдээлэлтэй ажиллах аюулгүй байдлын зөвшөөрөл* (Facility Security Clearance – FSC)-ийг Холбооны Эдийн засаг, Уур амьсгалын хамгааллын яамнаас авах ёстой. Харин “зөвхөн албан хэрэгцээнд зориулсан нууц мэдээлэл”-ийг авахад тус журмын Хавсралт V (VS-NfD Мэдээллийн хуудас)-ыг мөрдөнө гэжээ.

Үүнээс харвал, гэрээний үндсэн дээр төрийн нууц мэдээллийг иргэн, хуулийн этгээд шилжүүлэн авахад тодорхой зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд, зөвшөөрөл олгох чиг үүргийг мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг боловч үндсэн шалгуур, журам нь хууль эсхүл Засгийн газрын захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон байна.

¹³ ХБНГУ: Төрийн нууц материалын аюулгүй байдлын журам, Allgemeine Verwaltungsvorschrift zum materiellen Geheimenschutz (Verschlussachenanweisung - VSA), 2023,03.13, §25 Төрийн бус байгууллагад мэдээлэл өгөх, https://www.verwaltungsvorschriften-im-internet.de/bsvwvbund_13032023_SII554001405.htm

Иймд аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг гүйцэтгэх байгууллага буюу тагнуулын байгууллага батлах бус, эрх мэдлийн хувьд дээд түвшний буюу Засгийн газар батлах шаардлагатай байна. Түүнчлэн гэрчилгээ олгох, олгохоос татгалзах шийдвэрт холбогдох гомдол гаргах, хянан шийдвэрлэх механизмыг нарийвчлан тусгах нь эрх зүйн тодорхой байдал, институцийн тэнцвэр, хүний болон хуулийн этгээдийн эрхийн баталгааг хангах үүднээс илүү оновчтой зохицуулалт болно.

3.2. “ПРАКТИКТ ХЭРЭГЖИХ БОЛОМЖ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

“Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтийн хүрээнд тухайн хууль тогтоомжийн төслийн зохицуулалт нь тодорхой тохиолдолд үйлчлэх, бодит байдал дээр хэрэгжих эсэхийг үнэлнэ. Энэхүү хүрээнд хуулийн төслийн мэдээллийг нууцлах болон ил болгохтой холбоотой хуулийн төслийн 4 дүгээр бүлэгт заасан зохицуулалтаас 14 дүгээр зүйлийн 14.4 дэх хэсэг, 18 дугаар зүйл болон тус хуулийн төслийн 38 дугаар зүйлд заасан төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын талаарх зохицуулалтыг энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэллээ.

Мэдээллийг нууцлах болон ил болгохтой холбоотой зохицуулалт практикт хэрэгжих боломжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

Төрийн болон албаны нууцын тухай хууль болон Төрийн нууцын тухай хуулийн төсөлд мэдээллийг нууцлах болон ил болгохтой холбоотой зохицуулалтыг дараах байдлаар тусгажээ.

Хүснэгт 10. Мэдээллийг нууцлах болон ил болгох тухай зохицуулалтын харьцуулалт

<i>Мэдээллийг нууцлах болон ил болгох тухай зохицуулалт</i>	
Төрийн болон албаны нууцын тухай хууль (2016)	Төрийн нууцын тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөл (2026)
15 дугаар зүйл.Мэдээллийг нууцлах 15.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн <u>болон албаны</u> нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ. 15.2.Мэдээллийг энэ хуульд заасан нууцын зэрэглэл болон бусад тэмдэглэгээг тавьж бэхжүүлэх замаар нууцална. 15.3.Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Засгийн газрын баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ. 15.4.Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2, 14.1-д заасан жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулна. <u>15.5.Энэ зүйлийн 15.4-т заасан саналыг хүлээн авсан албан тушаалтан тухайн мэдээлэлд шинжилгээ хийж, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нууцлахаас татгалзах эсэхийг Засгийн</u>	14 дүгээр зүйл.Мэдээллийг нууцлах 14.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ. 14.2.Мэдээллийг энэ хуульд заасан нууцын зэрэглэл болон бусад тэмдэглэгээг тавьж бэхжүүлэх замаар нууцална. 14.3.Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Засгийн газрын баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ. 14.4.Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2-т заасан жагсаалтад ороогүй боловч энэ хуулийн 15 дугаар зүйл заасан шалгуурт нийцэж байгаа тохиолдолд төрийн нууцад хамруулах саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

17.2.Мэдээллийг нууцлах хугацаа нь түүнд нууцын зэрэглэлийн дардас, бусад тэмдэглэгээ тавьж бэхжүүлсэн өдрөөс эхлэн тооцогдоно. 17.3.Төрийн нууцын зэрэглэлийг өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчилсөн зэрэглэлийн хугацаагаар тооцно. 17.4.Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын нууц гүйцэтгэх ажилтан, эдгээр байгууллагатай нууцаар хамтран ажиллаж байсан болон нууцаар хамтран ажиллаж байгаа хүн, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална. 17.5.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээлэлд хугацаа тогтоох боломжгүй бөгөөд тодорхой үйлдэл хийснээр, эсхүл үйл явдал болсноор ил болох бол тухайн нөхцөлийн дагуу нууцлах хугацааг тооцно. 17.6.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлын үүднээс цаашид үргэлжлүүлэн нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн нууцыг хариуцсан байгууллага, албан тушаалтан нь тагнуулын байгууллагын саналыг үндэслэн энэ зүйлийн 17.1-д заасан хугацаагаар нууцална. 17.7.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийн нууцлах хугацаа дууссан боловч тухайн мэдээллийг ил болгох эсэхийг шийдвэрлэх хүртэл мэдээллийг нууцална. 17.8.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс, олон улсын байгууллагын нууц мэдээлэлд энэ хуульд заасан хугацааг мөрдөнө.	нууцын зэрэглэлийн дардас, бусад тэмдэглэгээ тавьж бэхжүүлсэн өдрөөс эхлэн тооцогдоно. 16.3.Төрийн нууцын зэрэглэлийг өөрчилсөн тохиолдолд тухайн өөрчилсөн зэрэглэлийн хугацаагаар тооцно. 16.4.Тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажил явуулах эрх бүхий байгууллагын нууц гүйцэтгэх ажилтан, эдгээр байгууллагатай нууцаар хамтран ажиллаж байсан болон нууцаар хамтран ажиллаж байгаа хүн, Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуулийн дагуу хамгаалалтад авсан хүний талаар нууцалбал зохих мэдээллийг байнга нууцална. 16.5.Төрийн нууцад хамаарах мэдээлэлд хугацаа тогтоох боломжгүй бөгөөд тодорхой үйлдэл хийснээр, эсхүл үйл явдал болсноор ил болох бол тухайн нөхцөлийн дагуу нууцлах хугацааг тооцно. 16.6.Төрийн нууцад хамаарах мэдээллийг үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхлын үүднээс цаашид үргэлжлүүлэн нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн нууцыг хариуцсан байгууллага, албан тушаалтан нь тагнуулын байгууллагын саналыг үндэслэн энэ хуулийн 16.1-д заасан хугацаагаар нууцална. 16.7.Монгол Улсын олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол гадаад улс, олон улсын байгууллагын нууц мэдээлэлд энэ хуульд заасан хугацааг мөрдөнө.
18 дугаар зүйл.Төрийн болон албаны нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ 18.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг зохих баримт бичиг, бусад нууц тээгчид дараахь тэмдэглэгээ тавьж бэхжүүлэх замаар хэрэгжүүлнэ: 18.1.1.нууцын зэрэглэл; 18.1.2.бүртгэлийн дугаар; 18.1.3.мэдээллийг нууцалсан огноо, нууцлах хугацаа; 18.1.4.мэдээллийг нууцалсан албан тушаалтны албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, нэр, гарын үсэг. 18.2.Нууцын зэрэглэлийн дардсыг баримт бичигт хуудас бүрийн баруун дээд өнцөгт дарж тэмдэглэх ба хуудас бүр дугаарлагдсан байна. Хэрэв баримт бичиг хэд хэдэн хувиас бүрдсэн бол хувь тус бүрийн эхний хуудсанд өөрийн	17 дугаар зүйл.Төрийн нууц тээгчид тавигдах тэмдэглэгээ 17.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг зохих баримт бичиг, бусад нууц тээгчид дараах тэмдэглэгээ тавьж бэхжүүлэх замаар хэрэгжүүлнэ: 17.1.1.нууцын зэрэглэл; 17.1.2.бүртгэлийн дугаар; 17.1.3.мэдээллийг нууцалсан огноо, нууцлах хугацаа; 17.1.4.мэдээллийг нууцалсан албан тушаалтны албан тушаал, эцэг /эх/-ийн нэр, нэр, гарын үсэг. 17.2.Нууцын зэрэглэлийн дардсыг баримт бичигт хуудас бүрийн баруун дээд өнцөгт дарж тэмдэглэх ба хуудас бүр дугаарлагдсан байна. Хэрэв баримт бичиг хэд хэдэн хувиас бүрдсэн бол хувь тус бүрийн эхний хуудсанд өөрийн

дугаарыг баримт бичгийн нийт хуудасны тооны хамт заасан байна. 18.3.Энэ хуулийн 17.1-д заасан өөр өөр нууцын зэрэглэлтэй мэдээллийг агуулсан баримт бичиг, бусад зүйлд хамгийн өндөр нууцын зэрэглэлээр нийтэд нь тэмдэглэгээ хийнэ. 18.4.Төрийн болон албаны нууц тээгчид нууцын зэрэглэлийн дардсыг тавих боломжгүй тохиолдолд түүний дагалдах баримт бичигт, биет зүйлд түүний гадна талд нууцын зэрэглэлийн дардссыг тавьж бэхжүүлнэ. 18.5.Нууцын зэрэглэлийн дардсыг төрийн болон албаны нууцад хамаарахгүй мэдээлэл тээгчид хэрэглэхийг хориглоно.	дугаарыг баримт бичгийн нийт хуудасны тооны хамт заасан байна. 17.3.Энэ хуулийн 15.1-д заасан өөр өөр нууцын зэрэглэлтэй мэдээллийг агуулсан баримт бичиг, бусад зүйлд хамгийн өндөр нууцын зэрэглэлээр нийтэд нь тэмдэглэгээ хийнэ. 17.4.Төрийн нууц тээгчид нууцын зэрэглэлийн дардсыг тавих боломжгүй тохиолдолд түүний дагалдах баримт бичигт, биет зүйлд түүний гадна талд нууцын зэрэглэлийн дардссыг тавьж бэхжүүлнэ. 17.5.Нууцын зэрэглэлийн дардсыг төрийн нууцад хамаарахгүй мэдээлэл тээгчид хэрэглэхийг хориглоно.
19 дүгээр зүйл.Төрийн болон албаны нууцыг ил болгох үндэслэл, журам 19.1.Төрийн болон албаны нууцыг дараахь үндэслэлээр ил болгоно: 19.1.1.нууцлах хугацаа дуусгавар болсон; 19.1.2.нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон; <u>19.1.3.тухайн мэдээллийг төрийн болон албаны нууцад хамаарахгүй болгосон хууль батлагдаж хүчин төгөлдөр болсон;</u> <u>19.1.4.мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон.</u> <u>19.2.Төрийн болон албаны нууцыг энэ зүйлийн 19.6-д заасан журмын дагуу ил болгоно.</u> 19.3.Төрийн болон албаны нууцад хамаарах мэдээллийг энэ зүйлийн 19.1.2-т заасан үндэслэлээр нууцлах хугацаа дуусахаас өмнө ил болгох эсэхийг тагнуулын байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ. <u>19.4.Энэ хуульд заасны дагуу мэдээллийг нууцлах хугацааг сунгаагүй бол тогтоосон хугацаа дуусмагц мэдээллийг нууцалсан, эсхүл хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан зохих журмын дагуу ил болгоно.</u> <u>19.5.Энэ хуульд заасны дагуу ил болсон түүх, эрдэм шинжилгээ, судалгаа, практикийн болон лавлагааны ач холбогдолгүй мэдээлэл тээгчийг зохих журмын дагуу устгана.</u> <u>19.6.Төрийн болон албаны нууцыг ил болгох журмыг Засгийн газар батална.</u>	18 дугаар зүйл.Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам 18.1.Төрийн нууцыг дараах үндэслэлээр ил болгоно: 18.1.1.төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон; 18.1.2.нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон; 18.1.3.нууцлах хугацаа дуусгавар болсон; 18.2. Энэ зүйлийн 18.1.2-т заасан үндэслэлээр тагнуулын байгууллага төрийн нууцад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа тухайн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ. 18.3.Энэ зүйлийн 18.1.2-т заасан тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тухайн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ. 18.4.Энэ хуулийн 18.1.3-т заасан үндэслэлээр төрийн байгууллага, албан тушаалтан, мөн хуулийн 16.5-д зааснаас бусад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах эсэхийг дараах журмын дагуу зохион байгуулна: 18.4.1.тухайн мэдээллийг нууцлах хугацаа дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө ажлын хэсэг байгуулан шинжилгээ хийлгэж, үндэслэл бүхий дүгнэлт гаргуулан тагнуулын байгууллагын саналыг авна; 18.4.2.мэдээллийг ил болгох талаар тагнуулын байгууллагын саналыг авсны дараа ажлын хэсэг төрийн нууцыг ил болгосон тухай нотолгоо

	бичиг, тухайн байгууллагын даргаар батлуулснаар төрийн хамгаалалтаас гарсанд тооцно; 18.4.3.төрийн хамгаалалтаас гарсан нууц баримт бичиг, бусад тээгчид “ил болсон” гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ. Тухайн баримт бичгийг цаашид шилжүүлэх, хадгалах, нийтэд ашиглуулах асуудлыг албан хэрэг хөтлөлт болон архивын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ; 18.4.4.нууц баримт бичиг, бусад тээгчийг нууцлах хугацааг сунгасан тохиолдолд “хугацааг сунгав” гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ. 18.5.Төрийн архивын хаалттай сан хөмрөгт хадгалагдаж байгаа нууц баримт бичиг, бусад нууц тээгчийг боловсруулсан буюу бүтээсэн байгууллагын эрх олгосноор, тухайн байгууллага, түүний эрх залгамжлагч байхгүй тохиолдолд төрийн архивын байгууллага өөрөө нууцыг ил болгох, хугацааг сунгах асуудлыг энэ хуулийн 18.4-т заасны дагуу шийдвэрлэнэ.
--	---

Дээрх хүснэгтээс харвал, Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд мэдээллийг нууцлах болон ил болгох тухай зохицуулалтад дараах зарчмын шинжтэй өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа *удирдлагадаа танилцуулдаг* байсан бол шинэчилсэн найруулгаар *тагнуулын байгууллагад нэн даруй хүргүүлнэ*;
- Дээрх заалттай холбогдуулан төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналыг хүлээн авсан албан тушаалтанд холбогдох заалтыг хассан;
- “Нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийн тодорхойлолт өөрчлөгдсөн;
- Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон гэх үндэслэлээр төрийн нууцыг ил болгох тухай зохицуулалт нэмсэн;
- Төрийн нууц мэдээлэл нь төрийн нууцад хамаарахгүй болгосон хууль хүчин төгөлдөр болсон, эсвэл мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан нь тогтоогдсон тохиолдолд төрийн нууцыг ил болгох үндэслэл болдог байсныг хассан;
- Нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд Төрийн болон албаны нууцыг ил болгох тухай Засгийн газрын баталсан журмын дагуу ил болгодог байсан бол одоо Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ;

Иймд дээрх шинээр нэмэгдсэн зохицуулалтын зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийг авч үзье.

- **Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд саналаа тагнуулын байгууллагад хүргүүлэх зохицуулалтын тухайд**

14.4. Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2-т заасан жагсаалтад ороогүй боловч энэ хуулийн 15 дугаар зүйл заасан шалгуурт нийцэж байгаа тохиолдолд төрийн нууцад хамруулах саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ.

Одоо хэрэгжиж буй ТБАНТХ-ийн 15 дугаар зүйлийн 15.4-т зааснаар байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь Засгийн газрын тогтоолоор баталсан төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа нэн даруй удирдлагадаа танилцуулж шийдвэрлүүлэх боломжтой. Тус саналыг хүлээн авсан албан тушаалтан тухайн мэдээлэлд шинжилгээ хийж, жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл нууцлахаас татгалзах эсэхийг Засгийн газрын баталсан журмын дагуу шийдвэрлэх зохицуулалттай байсан.

Шинэчилсэн найруулгын төсөлд дээрх зохицуулалтыг хасаж, байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлэх зохицуулалттай болгон өөрчилсөн байна.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны үр дүнд нууцлах шаардлагатай гэж үзсэн мэдээллийг жагсаалтад оруулах саналыг хүлээн авсан удирдлага ямар шалгуур, үндэслэлийг харгалзаж шийдвэрлэх нь тодорхой тусгагдаагүй, үүнээс үүдэн Засгийн газраас баталсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт" нь давхцал ихтэйгээс гадна, логик уялдаагүй, төрийн нууцын тухай ойлголт тодорхой бус болсон, дэлхийн улс орнуудын жишгийг үзвэл, төрийн нууцын тухай хуулиараа төрийн нууцтай холбогдох санал, дүгнэлт гаргах чиг үүргийг тагнуулын байгууллагад олгох тохиолдол цөөнгүй байна¹⁴ гэжээ.

Тагнуулын байгууллага нь төрийн нууцад холбогдох мэдээллийг хадгалах, хамгаалах, хяналт хэрэгжүүлэх, санал, зөвлөмж өгөх, нууцлах шаардлагатай мэдээллийг шалгуурын дагуу хянаж жагсаалтад оруулах зэргээр хяналтыг бүрэн хэрэгжүүлэх, төрийн нууцын мэдээллийг хамгаалах, байгууллага, албан тушаалтны хууль бус үйл ажиллагааг илрүүлэхэд ач холбогдолтой байгууллага юм. Иймд байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь төрийн нууцад хамаарах мэдээллийн

¹⁴ Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, ХЗҮХ, 2023.

жагсаалтад ороогүй боловч нууцлах шаардлагатай тохиолдолд тухайн байгууллага, албан тушаалтан нууцлах арга хэмжээ авч, нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад оруулах саналаа тагнуулын байгууллагад хүргүүлэх зохицуулалт нь мэдээллийг хуульд заасан үндэслэлийн дагуу төрийн нууцад хамруулах, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчим, хуулийн зорилгод нийцэж байна.

- **Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон гэх үндэслэлээр төрийн нууцыг ил болгох, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд Улсын Их Хурал шийдвэрлэх зохицуулалтын тухайд**

18 дугаар зүйл. Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам

18.1. Төрийн нууцыг дараах үндэслэлээр ил болгоно:

18.1.1. төрийн нууцын жагсаалт батлах тухай хуульд өөрчлөлт орсон;

18.2. Энэ зүйлийн 18.1.2-т заасан үндэслэлээр тагнуулын байгууллага төрийн нууцад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа тухайн мэдээлэлд хийсэн дүн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.

18.3. Энэ зүйлийн 18.1.2-т заасан тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тухайн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.

ТБАНТХ-д төрийн нууц мэдээллийг зөвхөн нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас цаашид нууцлах шаардлагагүй болсон, эсхүл нууцлах хугацаа дуусгавар болсон тохиолдолд ил болгох зохицуулалттай байсан. Шинэчилсэн найруулгын төслөөр “Төрийн нууцын жагсаалт батлах” тухай хуульд өөрчлөлт орсноор төрийн нууцыг ил болгох үндэслэл болох зохицуулалт шинээр нэмэгдсэн. Үүнээс харвал, төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын баталсан журмаар зохицуулах системийг халж хуулиар зохицуулах хандлагыг баримтлах төлөвтэй байна.

Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Монгол улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д 9 жилийн хугацаанд (2017-2025) дараах байдлаар 8 удаа нэмэлт, өөрчлөлт орсон байна. Үүнд:

1. Засгийн газрын 2024.10.02-ны 113 дугаар тогтоолоор 2 заалт нэмсэн.
2. Засгийн газрын 2024.06.06-ны 262 дугаар тогтоолоор 2 заалт нэмсэн.
3. Засгийн газрын 2023.03.07-ны 87 дугаар тогтоолоор 1 заалт хассан, 1 заалтыг хүчингүй болгосонд тооцсон, 2 заалтад өөрчлөлт оруулсан.
4. Засгийн газрын 2022.08.10-ны 299 дүгээр тогтоолоор 2 заалт нэмсэн.
5. Засгийн газрын 2021.09.22-ны 294 дүгээр тогтоолоор 1 заалтад өөрчлөлт оруулсан.
6. Засгийн газрын 2020.08.12-ны 48 дугаар тогтоолоор 1 заалт нэмсэн.
7. Засгийн газрын 2020.06.12-ны 220 дугаар тогтоолоор 4 заалт нэмсэн.
8. Засгийн газрын 2019.05.17-ны 196 дугаар тогтоолоор 3 заалт нэмсэн.

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын судалгааны үр дүнд практик дээр, хуульд заагаагүй журмаар гэрээ, хэлэлцээрийг Засгийн газраас нууцлах явдал цөөнгүй байгааг анхаарах нь зүйтэй талаар дурджээ. Засгийн газрын 2017 оны 257 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах

мэдээллийн жагсаалт"-д хуульд заагаагүй, хуульд заасан төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй хэд хэдэн мэдээлэл багтсан бөгөөд үүнийг улсын хэмжээнд нэг мөр тогтоох нь давхардал, хийдэл үүсгэхгүй байх ач холбогдолтой гэсний үндсэнд төрийн нууцын жагсаалтыг журмаар бус, хуулиар зохицуулах, ил болгох эсэхийг Улсын Их Хурал шийдвэрлэдэг болох хэрэгцээ, шаардлага үүссэн байна.

Түүнчлэн төрийн нууцыг ил болгох асуудлын хүрээнд цаг үеэ олсон байх зарчмыг үндэслэж, нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас төрийн болон албаны нууцад хамааруулсан тодорхой мэдээллийг цаашид нууцлах шаардлагагүй болсон тохиолдолд уг мэдээллийг ил болгох боломжтой. Практикт энэ заалт төдийлэн хангалттай хэрэгжихгүй байгааг ТБАНтХ-ийн хэрэгжилтийн үр дагаврын судалгаанд дурджээ. Тухайлбал, 2017 оны 247 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д 2019-2024 оны хооронд 14 мэдээллийг нэмж, 3 мэдээлэлд өөрчлөлт оруулж, 1 мэдээлэл хасаж, 1 заалтыг хүчингүй болгосонд тооцсон.

Төрийн нууцад хамаарах мэдээллийг жагсаалтыг хуулиар зохицуулж, тус хуульд өөрчлөлт орсноор буюу нууцлах шаардлагагүй болсон мэдээллийг Улсын Их Хурлын шийдвэрийн дагуу нийтэд ил болгосноор цаг үеэ олсон байх зарчмыг хангах тул тус зохицуулалт нь практикт хэрэгжих боломжтой бөгөөд зорилгод нийцсэн байна.

Хүснэгт 11. ТБАНТХ болон хуулийн төсөлд заасан хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт

ТБАНТХ	Төрийн нууцын тухай хуулийн төсөл
39 дүгээр зүйл. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 39.1. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ. 39.2. Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараахь хариуцлага хүлээлгүүлэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ: 39.2.1. энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 39.2.2. энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, мөн 38.4-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах. 39.3. Харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан нь холбогдох албан тушаалтандаа энэ хуулийн 39.2-т заасан хариуцлага хүлээлгэж, энэ талаар 14 хоногийн дотор тагнуулын байгууллагад хариу мэдэгдэнэ. 39.4. Энэ хуулийн 39.2-т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг тагнуулын байгууллагаас түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ. 39.5. Тагнуулын байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шаардлага, шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, иргэн түүний дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй. 39.6. Энэ хуулийн 39.5-д заасныг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 39.7. Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.	38 дугаар зүйл. Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага 38.1. Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу эрүүгийн, зөрчлийн болон сахилгын хариуцлага хүлээлгэнэ. 38.2. Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчсөн албан тушаалтны үйлдэлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол тагнуулын байгууллагаас дараахь хариуцлага хүлээлгүүлэхээр харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтанд санал тавьж шийдвэрлүүлнэ: 38.2.1. энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах; 38.2.2. энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах. 38.3. Харьяалах дээд шатны байгууллага, албан тушаалтан нь холбогдох албан тушаалтандаа энэ хуулийн 38.2-т заасан хариуцлага хүлээлгэж, энэ талаар 14 хоногийн дотор тагнуулын байгууллагад хариу мэдэгдэнэ. 38.4. Энэ хуулийн 38.2-т заасныг биелүүлээгүй, эсхүл биелүүлэхээс үндэслэлгүйгээр татгалзсан бол тухайн албан тушаалтанд хариуцлага хүлээлгэх саналыг тагнуулын байгууллагаас түүнийг томилох, чөлөөлөх эрх бүхий байгууллага, албан тушаалтанд тавьж шийдвэрлүүлнэ. 38.5. Тагнуулын байгууллагаас энэ хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд гаргасан шаардлага, шийдвэрийг хүлээн авсан байгууллага, албан тушаалтан, иргэн түүний дагуу холбогдох арга хэмжээг авч, хариу мэдэгдэх үүрэгтэй. 38.6. Энэ хуулийн 38.5-д заасныг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ. 38.7. Төрийн нууцын тухай хууль зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

Дээрх хүснэгтээс үзвэл, ТБАНТХ-ийн 39 дүгээр зүйлд заасан хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын зохицуулалт нь Төрийн нууцын тухай хуулийн төсөлд ижил байдлаар хуульчлагдсан байна. Ийнхүү тус зохицуулалт ижил байдлаар хуульчлагдсан нь тухайн зохицуулалт одоо практикт хэрхэн хэрэгжиж байгаа тэр хэвээр хэрэгжих боломжтой мэт харагдаж байгаа боловч дараах асуудал хөндөгдөж байна. Үүнд: ТБАНТХ-д төрийн нууцад хамаарал мэдээлэл:

- Онц чухал нууц;
- Маш нууц;
- Нууц гэсэн зэрэглэлтэй байхаар хуульчилсан.

Тус хуульд заасны дагуу “нууц”-ын зэрэглэлд хамаарах мэдээлэлд “албаны нууц” хамаардаг байсан. Харин Төрийн нууцын тухай хуулийн төсөлд төрийн нууцад хамаарах мэдээллийг мөн л гурван зэрэглэлтэй байхаар хуульчилсан бөгөөд “онц чухал нууц”, “маш нууц”-ын зэрэглэлд хамаарах мэдээллийг ТБАНТХ-д заасан ижил байдлаар, харин “нууц”-ын зэрэглэлд “Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл энэ хуулийн 15.3, 15.4-т заасан мэдээллийг задруулах нөхцөл бий болгох” мэдээллийг хамааруулан тусгажээ.

Хүснэгт 12. ТБАНТХ болон Төрийн нууцын тухай хуулийн төслийн нууцын зэрэглэлтэй холбоотой зохицуулалт

ТБАНТХ	Төрийн нууцын тухай хуулийн төсөл
16.1. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхол, байгууллага, иргэнд учруулах аюул, занал, хохирлын хэмжээнээс хамаарч төрийн <u>болон албаны</u> нууцад хамаарах мэдээлэл дараахь зэрэглэлтэй байна: 16.1.1. онц чухал нууц; 16.1.2. маш нууц; 16.1.3. нууц.	15.1. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, ашиг сонирхол, байгууллага, иргэнд учруулах аюул, занал, хохирлын хэмжээнээс хамаарч төрийн нууцад хамаарах мэдээлэл дараах зэрэглэлтэй байна: 15.1.1. онц чухал нууц; 15.1.2. маш нууц; 15.1.3. нууц.
16.2. Төрийн нууцад хамаарах мэдээлэл "онц чухал нууц", "маш нууц", албаны нууцад хамаарах мэдээлэл "нууц" зэрэглэлтэй байна.	-
16.3. Төрийн <u>болон албаны</u> нууцад хамаарах мэдээлэлд энэ хуульд зааснаас өөр нууцын зэрэглэл хэрэглэхийг хориглоно.	15.2. Төрийн нууцад хамаарах мэдээлэлд энэ хуульд зааснаас өөр нууцын зэрэглэл хэрэглэхийг хориглоно.
16.4. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээллийг "онц чухал нууц" зэрэглэлд хамааруулна.	15.3. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээллийг "онц чухал нууц" зэрэглэлд хамааруулна.
16.5. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах хүчин	15.4. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах

чадлыг сулруулах мэдээллийг "маш нууц" зэрэглэлд хамааруулна.	чадавхыг сулруулах мэдээллийг "маш нууц" зэрэглэлд хамааруулна.
16.6. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд <u>салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол</u> , үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл <u>төрийн нууцад хамаарах</u> мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг "нууц" зэрэглэлд хамааруулна.	15.5. Задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл энэ хуулийн 15.3, 15.4-т заасан мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг "нууц" зэрэгт хамааруулна.

ТБАНТХ-аар 1/ төрийн нууц, 2/ албаны нууцтай холбоотой харилцааг зохицуулсан бөгөөд тус хуульд зааснаар "нууц" зэрэглэлд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд салбарын болон төрийн байгууллага бусад хуулийн этгээдийн ашиг сонирхол, үйл ажиллагаанд хохирол учруулах, эсхүл төрийн нууцад хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээлэл хамаардаг.

Харин Төрийн нууцын тухай хуулийн төслөөр "албаны нууц" гэх ойлголтыг хасаж, Төрийн нууцтай холбоотой харилцааг тус хуулийн төслөөр зохицуулахаар боловсруулсан байна. Гэтэл тус хуулийн төслийн 38 дугаар зүйлд заасан "Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага"-ын талаарх зохицуулалт нь төрийн болон албаны нууцын харилцааг зохицуулж байгаа хуультай ижил байгаа нь төрийн нууц, албаны нууцыг ижил түвшинд авч үзэж байгаа мэт харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, Төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага нь 1-д төрийн нууц, 2-т албан нууцтай холбоотой хуульд заасан зохицуулалтыг зөрчсөн бол хариуцлага хүлээлгэх асуудал хөндөгдөнө. Харин Төрийн нууцын тухай хуулийн төсөлд зөвхөн төрийн нууцтай холбоотой харилцааг зохицуулсан учир түүнд оногдуулах хариуцлагыг хууль тогтоомжид "албаны нууц"-аас ялгаж, хүлээлгэх хариуцлагыг тусгах нь зүйтэй.

Хүснэгт 13. ТБАНТХ болон Төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан сахилгын хариуцлагатай холбоотой зохицуулалт

ТБАНТХ	Төрийн нууцын тухай хуулийн төсөл
39.2.1. энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;	38.2.1.энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтны албан тушаалын цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах;
6.2.Төрийн болон албаны нууцтай танилцсан Монгол Улсын төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад хуулийн этгээд /цаашид "төрийн байгууллага, бусад хуулийн этгээд" гэх/, улс төрийн нам, хөдөлгөөн, төрийн бус байгууллага, албан тушаалтан, албан хаагч, Монгол Улсын иргэн, гадаад улсын иргэн,	6.2.Төрийн нууцтай танилцсан Монгол Улсын төрийн байгууллага, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн удирдлага, бусад хуулийн этгээд /цаашид "төрийн байгууллага, бусад хуулийн этгээд" гэх/, улс төрийн нам, хөдөлгөөн, төрийн бус байгууллага, албан тушаалтан, албан хаагч, Монгол Улсын иргэн, гадаад улсын

харьяалалгүй хүн тэдгээрийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.	иргэн, харьяалалгүй хүн тэдгээрийг задруулахгүй байх үүрэг хүлээнэ.
6.3.Төрийн байгууллага нь төрийн <u>болон албаны</u> нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаархи мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ.	6.3.Төрийн байгууллага нь төрийн нууцын хадгалалт, хамгаалалтын чиглэлээр хэрэгжүүлсэн ажлын талаарх мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сард багтаан тагнуулын байгууллагад ирүүлнэ.
15.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн <u>болон албаны</u> нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ.	14.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ.
27 дугаар зүйл. Албан тушаалтан, иргэний үүрэг 27.1.Төрийн <u>болон албаны</u> нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, иргэн дараахь нийтлэг үүрэг хүлээнэ: 27.1.1.төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах хууль тогтоомжийг сахин биелүүлэх; 27.1.2.танилцсан болон ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх; 27.1.3.төрийн <u>болон албаны</u> нууцыг задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 27.1.4.нууц задрах, үрэгдэх нөхцөл байдал бий болсон, эсхүл үрэгдсэн, задарсан, нууц хамгаалах журам зөрчигдсөн бол нууц хамгаалах ажилтанд нэн даруй мэдэгдэх; 27.1.5.албаны болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон, өөр ажил, албан тушаалд шилжих тохиолдолд өөрт нь итгэмжлэн хариуцуулсан төрийн болон албаны нууц тээгчийг зохих ёсоор хүлээлгэн өгөх, албан үүргийн хувьд танилцсан төрийн <u>болон албаны нууцыг</u> задруулахгүй байх баталгааг бичгээр гаргах; 27.1.6.хуульд өөрөөр заагаагүй бол хувийн хэргээр гадаад улсад зорчих тохиолдолд байгууллагадаа урьдчилан бичгээр мэдээлэх.	26 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэний үүрэг 26.1.Төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтан, иргэн дараах нийтлэг үүрэг хүлээнэ: 26.1.1.төрийн нууцыг хамгаалах хууль тогтоомжийг сахин биелүүлэх; 26.1.2.танилцсан болон ажил үүргээ гүйцэтгэх явцад мэдсэн төрийн нууцыг хамгаалах, ажиллах хугацаанд, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөний дараа ил болгох хүртэл хугацаанд задруулахгүй байх; 26.1.3.төрийн нууцыг задруулах, үрэгдүүлэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах; 26.1.4.нууц задрах, үрэгдэх нөхцөл байдал бий болсон, эсхүл үрэгдсэн, задарсан, нууц хамгаалах журам зөрчигдсөн бол нууц хамгаалах ажилтанд нэн даруй мэдэгдэх; 26.1.5.албаны болон хөдөлмөрийн харилцаа дуусгавар болсон, өөр ажил, албан тушаалд шилжих тохиолдолд өөрт нь итгэмжлэн хариуцуулсан төрийн нууц тээгчийг зохих ёсоор хүлээлгэн өгөх, албан үүргийн хувьд танилцсан төрийн нууцыг задруулахгүй байх баталгааг бичгээр гаргах; 26.1.6.хуульд өөрөөр заагаагүй бол хувийн хэргээр гадаад улсад зорчих тохиолдолд байгууллагадаа урьдчилан бичгээр мэдээлэх.
28 дугаар зүйл. Төрийн болон албаны нууцыг хамгаалах ажилтны үүрэг	27 дугаар зүйл.Төрийн нууцыг хамгаалах ажилтны үүрэг

28.1.Төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах ажилтан нь энэ хуулийн 27 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараахь үүрэг хүлээнэ: 28.1.1.төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх; 28.1.2.албан тушаалтан, албан хаагчид төрийн <u>болон албаны</u> нууцыг ашиглах, хамгаалахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; 28.1.3.салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн <u>болон албаны</u> нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үзлэг, тооллого зохион байгуулах; 28.1.4.төрийн <u>болон албаны</u> нууцтай танилцах эрх олгосон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах; 28.1.5.гадаад улсын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай тагнуулын байгууллагад мэдэгдэх; 28.1.6.төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны шилжилт хөдөлгөөний талаар тагнуулын байгууллагад мэдэгдэх; 28.1.7.төрийн <u>болон албаны</u> нууцыг хамгаалах журам зөрчигдсөн тохиолдолд албаны шалгалт явуулж дүнг байгууллагын удирдлагад, шаардлагатай бол тагнуулын байгууллагад танилцуулах, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх; 28.1.8.төрийн <u>болон албаны</u> нууц задарсан, үрэгдсэн бол нэн даруй байгууллагын удирдлага болон тагнуулын байгууллагад мэдэгдэх.	27.1.Төрийн нууцыг хамгаалах ажилтан нь энэ хуулийн 26 дугаар зүйлд заасан нийтлэг үүргээс гадна дараах үүрэг хүлээнэ: 27.1.1.төрийн нууцыг хамгаалах хууль тогтоомжийн биелэлтийг хангах, нууц албан хэрэг хөтлөлтийг зохион байгуулж хэрэгжүүлэх; 27.1.2.албан тушаалтан, албан хаагчид төрийн нууцыг ашиглах, хамгаалахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх; 27.1.3.салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцын хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үзлэг, тооллого зохион байгуулах; 27.1.4.төрийн нууцтай эрх олгосон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах; 27.1.5.гадаад улсын иргэн, байгууллагатай албан бус харилцаа тогтоосон бол энэ тухай тагнуулын байгууллагад мэдэгдэх; 27.1.6.төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтны шилжилт хөдөлгөөний талаар тагнуулын байгууллагад мэдэгдэх; 27.1.7.төрийн нууцыг хамгаалах журам зөрчигдсөн тохиолдолд албаны шалгалт явуулж дүнг байгууллагын удирдлагад, шаардлагатай бол тагнуулын байгууллагад танилцуулах, зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээг даруй авч хэрэгжүүлэх; 27.1.8.төрийн нууц задарсан, үрэгдсэн бол нэн даруй байгууллагын удирдлага болон тагнуулын байгууллагад мэдэгдэх.
39.2.2.энэ хуулийн 6.2, 6.3, 15.1 дэх хэсэг, 27, 28 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, мөн 38.4-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах	38.2.2.энэ хуулийн 6.2, 6.3, 14.1 дэх хэсэг, 26, 27 дугаар зүйлд заасан үүргээ удаа дараа биелүүлээгүй, мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй албан тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах
38.4.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.	37.4.Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална. 37.2.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.

Дээрх хүснэгтээс харвал, ТБАНтХ болон Төрийн нууцын тухай хуульд зааснаар цалингийн хэмжээг гурван сар хүртэл хугацаагаар 20 хүртэл хувиар бууруулах болон албан

тушаалтныг албан тушаал бууруулах, албан тушаалаас нь огцруулах, төрийн албанаас халах үндэслэлийг судлан үзэхэд тухайн хариуцлагыг оногдуулах үндэслэл нь ижил байна. Өөрөөр хэлбэл, хуулийн төсөлд заасан сахилгын хариуцлага нь хүчин төгөлдөр үйлчилж буй ТБАНтХ-д заасан сахилгын хариуцлага болон оногдуулах үндэслэл нь бүгд адилхан байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 38.2.2-т *“...мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй...”* гэж заасан боловч тус төслийн 37.4-т *“Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална.”* гэж ямар нэгэн үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг тусгаагүй байсан бөгөөд харин хуулийн төслийн 37.2-т *“Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.”* гэж заажээ. Иймд хуулийн төслийн 38.2.2-т заасан *“...мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй...”* гэснийг *“...мөн 37.2-т заасан үүргээ биелүүлээгүй...”* гэж өөрчлөх нь зүйтэй.

Харин Эрүүгийн хууль болон Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагын асуудлыг судлан үзвэл:

Одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд Төрийн нууцыг хууль бусаар олж авах, 19.12 дугаар зүйлд Төрийн нууцыг задруулах, 19.13 дугаар зүйлд Төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэргийг хуульчилсан бол Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлд Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих зөрчлийг тус тус хуульчилж хариуцлага хүлээлгэхээр заасан.

Эрүүгийн хуулийн 19.11 дүгээр зүйлд заасан “Төрийн нууцыг хууль бусаар олж авах” гэмт хэрэгт *“Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт, эд зүйлсийг хулгайлсан, цуглуулсан, хадгалсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ”* гэж заасан бөгөөд тус хуулийн 19.12 дугаар зүйлд Төрийн нууцыг задруулах, 19.13 дугаар зүйлд Төрийн нууцыг үрэгдүүлэх гэмт хэргийг хувьд төрийн маш нууц болон төрийн онц чухал нууцтай холбоотой асуудал хөндөгддөг.

Хуулийн төсөлд заасан сахилгын хариуцлага нь хүчин төгөлдөр үйлчилж буй ТБАНтХ-д заасан сахилгын хариуцлага болон оногдуулах үндэслэл нь бүгд адилхан байна.

Дээрхээс дүгнэвэл, Төрийн нууцын тухай хуулийн төсөл батлагдсан тус хуульд заасан төрийн нууцын гурван зэрэглэлээс нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэлтэй холбоотой асуудлын хүрээнд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд тус хуулийн 19.11 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэх боломжтой.

Харин Эрүүгийн хуулийн 19.12, 19.13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу “нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийн хүрээнд төрийн нууцыг задруулах, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд төрийн “нууц”-ын зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай эсэхийг судлан үзэж, Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй.

Одоогийн байгаа зохицуулалтын хүрээнд Төрийн болон албаны нууцын тухай хуульд зааснаар албаны нууцад хамаарах мэдээлэл нь “нууц” зэрэглэлтэй учир үүнийг Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт тооцох үндэслэлгүй гэж үзэж хууль тогтоогч хуульчлаагүй байна.

Гэтэл тус хуулийг шинэчлэн найруулж “Төрийн нууцын тухай хууль”-ийн төслийг боловсруулж, тус хуулийн төсөлд төрийн нууцад хамаарах мэдээллийг “онц чухал нууц”, “маш нууц”, “нууц” гэж өөрчлөн ангилж байна. Энэ хүрээнд ТБАНТХ-д зааснаар төрийн нууцад хамаарах мэдээллийн 2 ангилдаг байсныг 3 болгон өөрчилсөн учраас үүнтэй уялдуулан Төрийн нууцын тухай хуулийн төслийг боловсруулахдаа Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалт нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төслийг боловсруулах шаардлагатай байсан боловч боловсруулаагүй орхигдуулсан байна.

Хэрэв тус хуулийн төсөл энэ хэвээр батлагдсан тохиолдолд төрийн нууцах хамаарах “нууц” зэрэглэлийн мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Харин Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлагатай холбоотойгоор тус хуулийн төслийн дагалдуулан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл байх бөгөөд тус төсөлд *“Зөрчлийн тухай хуулийн 15.14 дүгээр зүйлийн гарчиг, мөн зүйлийн 1.1-1.4 дэх заалт, 2 дахь хэсгийн “болон албаны” гэснийг, 15.34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Албаны нууцаас бусад” гэснийг тус тус хассугай.”* гэж заажээ.

Энэхүү зохицуулалтаас үзвэл, одоогийн Зөрчлийн тухай хуульд заасан “Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих” зөрчлийн зохицуулалтаас зөвхөн “болон албаны” гэх үгийг хасаж “Төрийн нууцын тухай хууль зөрчих” зөрчил болгон өөрчилж, оногдуулах шийтгэлийг өөрчлөлгүй хэвээр үлдээсэн гэж үзэж болох юм.

Дээрхээс дүгнэвэл, хүчин төгөлдөр үйлчилж буй ТБАНТХ болон Төрийн нууцын тухай хуулийн төсөлд тусгасан хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалт ижил байдлаар тусгагдсан байна. Эндээс ТБАНТХ-аас “болон албаны” гэх үгийг хасаж Төрийн нууцын тухай хууль болгосон боловч тус хуулийг зөрчсөн зөрчигчид хүлээлгэх хариуцлага нь төрийн нууц болон албаны нууцыг зөрчсөн тохиолдолд хүлээлгэж байсан хуулийн зохицуулалттай ижил байгаа нь анхаарал татаж байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтыг энэ хэвээр нь үлдээх эсэхийг нягтлан шалгах нь зүйтэй.

Нөгөөтээгүүр, энэхүү зохицуулалт нь одоо ч практикт хэрэгжиж байгаа учир цаашид хэрэгжих боломжтой гэж үзэж болох боловч дээр дурдсанчлан Эрүүгийн хуулиар төрийн нууцын “нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэж байна. Нөгөөтээгүүр, “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэлд ямар мэдээлэл хамаарах талаар Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд тодорхой байдлаар тусгаагүйгээс харвал төрийн нууцад хамаарах мэдээллийн “нууц” зэрэглэлтэй холбоотой зохицуулалтыг эргэн харж, засаж сайжруулан холбогдох хуулиуд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хөндөх шаардлагатай болох нь харагдаж байна.

Дагалдах хуулийн төслийн талаар:

Хүчин төгөлдөр үйлчилж буй ТБАНТХ-ийг шинэчлэн найруулсан Төрийн нууцын тухай хуулийн төслийн хүрээнд 42 хуульд өөрчлөлт, 1 хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай нийт 43 дагалдах хуулийн төслийг боловсруулсан байна.

Дагалдах хуулийн төслийн нэр:

1. Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
2. Ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
3. Байгууллагын нууцын тухай хууль (3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцох.)
4. Гамшгаас хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
5. Гүйцэтгэх ажлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
6. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
7. Дипломат албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
8. Засгийн газар дахь хяналтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
9. Захиргааны ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай
10. Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
11. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
12. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (15.34 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Албаны нууцаас бусад" гэснийг хасах)
13. Зэвсэгт хүчний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
14. Инновацийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
15. Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
16. Кибер аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
17. Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
18. Монгол Улсын Их Хурлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
19. **Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай**
20. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
21. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
22. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай ("7.6.Хаалттай мэдээлэлд хамаарах төрийн нууцтай холбогдох Төрийн нууцын тухай хуулиар зохицуулснаас бусад харилцааг энэ хуулиар зохицуулна.", Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэг, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.)
23. Орон нутгийн хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
24. Өмгөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
25. Патентын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
26. Тагнуулын байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
27. Төрийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
28. Төрийн аудитын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
29. Төрийн бус байгууллагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
30. Төрийн тусгай хамгаалалтын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
31. Түгээмэл тархацтай ашигт малтмалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
32. Улсын бүртгэлийн ерөнхий хуульд өөрчлөлт оруулах тухай
33. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

34. Үндэсний аюулгүй байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
35. Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
36. Хувиргасан амьд организмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
37. Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
38. Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
39. Цэргийн алба хаагчийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
40. Шүүх шинжилгээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
41. Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
42. Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
43. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (ЭХХШТХ-ийн 34.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай)

Дээрх 43 хуулиас “болон албаны” гэх үгийг хасахаар тусгасан бөгөөд 4 (ЭХХШТХ, НМЭИТБТХ, ЗтХ, БНТХ) хуульд “болон албаны” гэх үгийг хассанаас гадна дээрх өөрчлөлтүүдийг оруулсан байна. Зөвхөн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахаар тусгажээ.

1 дүгээр зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 15.2.3 дахь заалт нэмсүгэй:

“15.2.3. төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийн талаарх тагнуулын байгууллагын мэдээллийг жил бүр.”

2 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 15.1, 15.2-т заасан” гэснийг “Энэ хуулийн 15.1, 15.2.1, 15.2.2-т” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.9 дэх хэсгийн “болон албаны” гэснийг хассугай.

4 дүгээр зүйл. Энэ хуулийн Төрийн нууцын тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Энэ хуулийн төслийн дагуу Улсын Их Хуралд “төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийн талаарх тагнуулын байгууллагын мэдээллийг жил бүр” ирүүлэхээр тусгасан байна.

3.3. “ОЙЛГОМЖТОЙ БАЙДАЛ” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Тус шалгуур үзүүлэлтээр хуулийн төслийн зүйл, заалт нь найруулга, хэл зүйн болон агуулгын хувьд ойлгомжтой байдлаар томъёологдсон болон логик дараалалтай боловсруулагдсан эсэхийг шалгана. Ингэхдээ Хууль тогтоомжийн тухай хуулийн 4 дүгээр бүлэгт заасан болон “Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлал”-ыг баримталсан эсэхийг нарийвчлан давхар шалгана. Энэ шалгуур үзүүлэлтийн хүрээнд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хүснэгт 14. Хуулийн төслийн зохицуулалт ойлгомжтой эсэхэд хийсэн дүн шинжилгээ

№	Ойлгомжгүй байгаа хуулийн төслийн зохицуулалт	Тайлбар	Санал
1.	Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэг	Төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт “...мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэгт хамааруулна.” гэж заажээ. Гэвч хуулийн төслийн 15.1-15.4 дэх хэсэг болон бусад зохицуулалтад “зэрэглэл” гэж заасан байна.	Төслийн 15.5-д заасан “зэрэгт” гэснийг “зэрэглэлд” гэж өөрчлөх.
2.	Төслийн 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэг	Төслийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...дардссыг...” гэж алдаатай байсан байна.	Төслийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...дардссыг...” гэснийг “дардсыг” гэж бичих.

Түүнчлэн, энэхүү шалгах хэрэгслийн дагуу хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан хуулийн төслийн бүтэц, хэлбэр, 29 дүгээр зүйлд заасан хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага, 30 дугаар зүйлд заасан хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэхийг дараах байдлаар шалгасан.

Хүснэгт 15. Хууль тогтоомжийн тухай хуулийн 28, 29, 30 дугаар зүйлд заасан шаардлагад нийцүүлэн боловсруулсан эсэх.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн бүтэц, хэлбэр	
Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
28.1.Хуулийн төсөл дараах бүтэцтэй байна: 28.1.1.хуулийн төслийн гарчиг; 28.1.2.хуулийн төслийн бүтцийн үндсэн нэгж болох зүйл; 28.1.3.зүйлийн доторх хэсэг; 28.1.4.хэсгийн доторх заалт; 28.1.5.заалтын доторх дэд заалт; 28.1.6.шаардлагатай бол бүлэг, дэд бүлэг, хэсэг, дэд хэсэг, анги.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан Хуулийн төслийн эх бичвэрийн агуулгад тавих нийтлэг шаардлага	

Хууль тогтоомжийн тухай хуулийн зохицуулалт	Хуулийн төслийн зохицуулалтад үнэлгээ хийсэн байдал
29.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.2. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.3. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцааны хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх;	Хуулийн төсөл зохицуулах харилцаа, хүрээнээс хальсан зүйл судалгаагаар тогтоогдоогүй.
29.1.4. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд үл хамаарах хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу хүчингүй болсонд тооцох тухай заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.5 Зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх;	Харилцан уялдаа хэсэгт төслийн зарим зүйл, заалт бусад хуулийн төсөл болон хууль хоорондоо зөрчилтэй байгааг судлан үзсэн болно.
29.1.6. Хэм хэмжээ тогтоогоогүй, тунхагласан шинжтэй буюу нэг удаа хэрэгжүүлэх заалт тусгахгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.7. Бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
29.1.8. Тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаа, хуулийн үйлчлэх хүрээ, эрх зүйн харилцаанд оролцогч хүн, хуулийн этгээдийн эрх, үүрэг, зохицуулалтад удирдлага болгох зарчим, харгалзан үзэх нөхцөл байдал, нийтийн эрх зүйн этгээдийн чиг үүрэг, эрх хэмжээ, тэдгээрийг биелүүлэх журмыг тусгасан байх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
Хууль тогтоомжийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан Хуулийн төслийн хэл зүй, найруулгад тавих нийтлэг шаардлага.	
30.1.1. Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуульд хэрэглэсэн нэр томъёог хэрэглэх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.2. Нэг нэр томъёогоор өөр өөр ойлголтыг илэрхийлэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.3. Үг хэллэгийг монгол хэл бичгийн дүрэмд нийцүүлэн хоёрдмол утгагүй товч, тодорхой, ойлгоход хялбараар бичих;	Өмнөх хүснэгтэд төслийн зарим зүйл, заалт нуршуу, тодорхойгүй, найруулга зүйн алдаатай байдлыг судлан үзсэн.
30.1.4. Хүч оруулсан нэр томъёо хэрэглэхгүй байх;	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.
30.1.5. Жинхэнэ нэрийг ганц тоон дээр хэрэглэх.	Судалгаагаар энэ төрлийн зөрчилтэй асуудал тогтоогдоогүй.

3.4. “ХАРИЛЦАН УЯЛДАА” ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТЭЭР ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Энэхүү шалгах хэрэгслийг хэрэглэж хуулийн төслийн үр нөлөөг үнэлснээр хууль тогтоомжийн давхардал, хийдэл, зөрчлийг тогтоож, тэдгээрийг арилгаж, тухайн хуулийн төслийн дотоод болон бусад хуультай уялдах уялдаа холбоог сайжруулна. Энэ хүрээнд хуулийн төсөл болон тус хуулийн төсөлтэй холбогдуулан боловсруулан хуулийн төслүүд, болон хүчин төгөлдөр мөрдөгдөж буй зохицуулалттай харилцан уялдаж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийнэ.

Төрийн нууцын тухай хуулийн төслийг боловсруулсантай холбоотойгоор дагалдах 43 хуулийн төслөөс гадна Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн 247 дугаар тогтоолоор баталсан бөгөөд төрийн нууцын жагсаалтад нийт 33 байгууллагын 574 мэдээлэл байна. Уг жагсаалтад 2019-2024 онд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд мэдээллийн жагсаалтаас хассан 2, өөрчлөлт оруулсан 3, нэмсэн 14 тохиолдол байна. Төрийн нууцын жагсаалтыг Засгийн газрын шийдвэрээр баталснаар УИХ-ын хяналт суларч, төрийн нууцын жагсаалтыг үндэслэлгүй өргөжүүлэх, үүнтэй холбоотойгоор хүн хүч, техник технологи, зохион байгуулалтын хувьд үр ашиггүй байдлыг үүсгэж байна¹⁵ гэжээ.

Хуулийн төсөл нь мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг Монгол Улсын төрийн нууцад хамааруулах, хууль хүчин төгөлдөр болох гэсэн хоёр зүйлтэй. Энэ хүрээнд Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн Тамгын газар, Засгийн газрын хэрэг эрхлэх газар, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, гадаад харилцаа, батлан хамгаалах, хууль зүй, дотоод хэрэг, эдийн засаг, байгаль орчин, аялал жуулчлал, барилга, хот байгуулалт, боловсрол, соёл, шинжлэх ухаан, спорт, уул уурхай, зам тээвэр, хүнс, хөдөө аж ахуй, хөдөлмөр, нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, эрчим хүчний асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Авлигатай тэмцэх газар, төрийн аудит, Сонгуулийн ерөнхий хороо, Үндэсний статистикийн хороо, Цөмийн энергийн комисс, Төрийн албаны зөвлөл, харилцаа холбоо, мэдээллийн технологи, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар, тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын байгууллага, онцгой байдал, стандарт хэмжил зүй, Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурор, аймаг, нийслэлийн Засаг даргын Тамгын газрын хэмжээнд төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтыг гаргаж, нууцын зэрэглэл, нууцлах хугацааг тодорхойлсон¹⁶ байна.

Төрийн болон нууцын жагсаалт батлах тухай төсөлд:

- А. Монгол Улсын Их Хурлын Тамгын газар
- Б. Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар
- В. Засгийн газрын хэрэг эрхлэх газар

¹⁵ Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2026 он, 2-3 дахь тал.

¹⁶ Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн танилцуулга, 2026 он, 2 дахь тал.

Г. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн ажлын алба, стратегийн судалгааны хүрээлэн

- Д. Гадаад харилцааны салбар
- Е. Батлан хамгаалах салбар
- Ё. Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар
- Ж. Банк, санхүүгийн салбар
- З. Байгаль орчин, аялал жуулчлалын салбар
- И. Барилга, хот байгуулалтын салбар
- Й. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын салбар
- К. Уул уурхай, хүнд үйлдвэрийн салбар
- Л. Зам, тээврийн салбар
- М. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбар
- Н. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбар
- О. Эрүүл мэндийн салбар
- Ө. Эрчим хүчний салбар
- П. Авлигатай тэмцэх салбар
- Р. Төрийн аудитын байгууллага
- С. Сонгуулийн ерөнхий хороо
- Т. Санхүүгийн зохицуулах хороо
- У. Үндэсний статистикийн хороо
- Ү. Цөмийн энергийн комисс
- Ф. Төрийн албаны зөвлөл
- Х. Харилцаа, холбоо, мэдээллийн технологийн салбар
- Ц. Мэргэжлийн хяналтын байгууллага
- Ч. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар
- Ш. Үндэсний хөгжлийн газар
- Щ. Тагнуулын байгууллага, төрийн тусгай хамгаалалтын газар
- Ы. Онцгой байдлын салбар
- Э. Стандарт, хэмжил зүйн газар
- Ю. Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага
- Я. Аймаг, нийслэлийн засаг даргын тамгын газар гэж заажээ.

Энэхүү 33 салбарт хамаарах хүснэгтэд дурдсан асуудлыг төрийн нууцад хамаарах мэдээлэлд хамааруулсан байх бөгөөд энэхүү хүснэгтэд мэдээллүүдээс харвал “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл байхгүй байна.

Энэ нь тус хуулийн төслийн төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, “нууц” зэрэглэлийн мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг үр нөлөөг алдагдуулж байна. өөрөөр хэлбэл, “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл байхгүй байхад ийнхүү зэрэглэл үүсгэсэн мэт харагдаж байна. Иймд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн зохицуулалт болон Төрийн нууцын тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, “нууц” зэрэглэлтэй холбоотой зохицуулалтыг сайтар судлан үзэж, хуулийн төслийн зохицуулалтууд болон хуулийн төсөл хоорондын харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой эсэх асуудал нь хууль хоорондын харилцан уялдаатай холбоотойгоор хөндөгдөж байна. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд дурдсанчлан төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан төрийн нууцын гурван зэрэглэлээс нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэлтэй холбоотой асуудлын хүрээнд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд тус хуулийн 19.11 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин Эрүүгийн хуулийн 19.12, 19.13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу "нууц" зэрэглэлд хамаарах мэдээллийн хүрээнд төрийн нууцыг задруулах, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд төрийн "нууц"-ын зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай эсэхийг судлан үзэж, хууль хоорондын харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Түүнчлэн, хуулийн төслийн 38.2.2-т *"...мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй..."* гэж заасан боловч тус төслийн 37.4-т *"Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална."* гэж ямар нэгэн үүрэг хүлээлгэсэн зохицуулалтыг тусгаагүй байсан бөгөөд харин хуулийн төслийн 37.2-т *"Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй."* гэж заажээ. Иймд хуулийн төслийн 38.2.2-т заасан *"...мөн 37.4-т заасан үүргээ биелүүлээгүй..."* гэснийг *"...мөн 37.2-т заасан үүргээ биелүүлээгүй..."* гэж өөрчлөх нь зүйтэй. Энэ нь хуулийн төслийн зохицуулалт хоорондын харилцан уялдааг хангах боломжийг бүрдүүлнэ.

ДӨРӨВ.ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Төрийн нууцын тухай хуулийн төсөл нь одоо хүчин төгөлдөр мөрдөгдөж буй ТБАНтХ-д заасан “албаны нууц” гэх ойлголтыг хасах, албаны нууцтай холбоотой зохицуулалтыг хүчингүй болгох талаар зохицуулалтыг агуулсан бөгөөд тус хуулийн төсөлд дээрх асуудлаас гадна хэд хэдэн зохицуулалтыг шинээр тусгасан байна.

Тус хуулийн төслийн үр нөлөөг үнэлэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан аргачлалд заасан “Зорилгод хүрэх байдал”, “Практикт хэрэгжих боломж”, “Ойлгомжтой байдал”, “Харилцан уялдаа” гэсэн 4 шалгуур үзүүлэлтийн хүрээнд бүхэлд нь үнэлж, дараах дүгнэлт хүрч байна.

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 4 дүгээр зүйлд заасан мэдээллийг төрийн нууцад хамруулах, нууцлах зарчим нь хуульд нийцсэн, үндэслэлтэй, цаг үеэ олсон байх зарчим хэвээрээ байгаа юм. Мэдээллийг нууцлах нь өөрөө зайлшгүй байх, шаардлагатай хэмжээ, хязгаараас хэтрэхгүй байх зэрэг зарчмыг оруулаагүй нь мэдээлэл илүү ил тод байх нөхцөл бүрдэнэ гэж үнэлэхэд хангалтгүй юм.

- Хуулийн төслийн 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсгийг сайжруулах хэрэгцээ, шаардлагатай байна.

- Хуулийн төслийн 20 дугаар зүйлд төрийн нууцтай танилцах эрхийн цар хүрээ, түүнийг хязгаарлах нөхцөлийг дэлгэрүүлэн зохицуулах нь мэдээлэлтэй танилцах, парламентын тусгай хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм. Иймд тус зохицуулалтыг хуулиар илүү дэлгэрэнгүй зохицуулах шаардлагатай гэж үзлээ.

- Хуулийн төслийн 32 дугаар зүйлд дараах асуудлыг анхаарах шаардлагатай гэж үзлээ. Гэрээний үндсэн дээр төрийн нууц мэдээллийн иргэн, хуулийн этгээдэд шижүүлэх зохицуулалтын тухайд аюулгүй байдлын гэрчилгээ олгох, журам батлах, хяналт тавих эрх бүхий субъектээр тагнуулын байгууллага байгаа нь эрх мэдлийн тэнцвэр алдагдахад хүргэхээр байна. ХБНГУ-ын туршлагаас харвал гэрээний үндсэн дээр төрийн нууц мэдээллийг иргэн, хуулийн этгээд шилжүүлэн авахад тодорхой зөвшөөрөл авах шаардлагатай бөгөөд, зөвшөөрөл олгох чиг үүргийг мэргэжлийн байгууллага хэрэгжүүлдэг боловч үндсэн шалгуур, журам нь хууль эсхүл Засгийн газрын захиргааны хэм хэмжээний актаар тогтоосон байна. Иймд аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллага батлах бус, одоо хэрэгжиж буй ТБАНтХ-д заасныг хэвээр үлдээж Засгийн газар батлах шаардлагатай байна. Түүнчлэн гэрчилгээ олгох, олгохоос татгалзах шийдвэрт холбогдох гомдол гаргах, хянан шийдвэрлэх механизмыг нарийвчлан тусгах нь эрх зүйн тодорхой байдал, институцийн тэнцвэр, хүний болон хуулийн этгээдийн эрхийн баталгааг хангах үүднээс илүү оновчтой зохицуулалт болно.

Практик хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төсөлд заасан Төрийн нууцын тухай хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагатай холбоотой зохицуулалтыг судлан үзэхэд хүчин төгөлдөр үйлчилж буй ТБАНТХ-д заасан зохицуулалттай ижил байдлаар тусгагджээ. Ийнхүү ижил байдлаар тусгасан нь тухайн зохицуулалт одоо практикт хэрэгжиж байгаа учир цаашид ч хэрэгжиж болно гэж үзэх үндэслэл мөн боловч Төрийн болон албаны нууцын тухай хуулиас ялгаатай нь шинэчлэн найруулсан хуулийн төслөөр зөвхөн Төрийн нууцтай холбоотой харилцааг зохицуулахаар хуульчилсан.

Өөрөөр хэлбэл, албаны нууц гэх ойлголтыг хассан тус хуулийн төслийн хувьд төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл 2 байсныг 3 болгон өөрчилсөнтэй холбоотойгоор төсөлд тусгасан “нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд Эрүүгийн хуулийн 19.12, 19.13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд төрийн “нууц”-ын зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай эсэхийг судлан үзэж, Эрүүгийн хуулийн дээрх зохицуулалтуудад нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, Төрийн нууцын тухай хуулийн төслийг боловсруулахдаа Эрүүгийн хуулийн холбогдох зохицуулалт нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төслийг боловсруулах шаардлагатай байсан боловч боловсруулаагүй орхигдуулсан гэж үзсэн болно.

Нөгөөтээгүүр, “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэлд ямар мэдээлэл хамаарах талаар Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд тодорхой байдлаар тусгаагүйгээс харвал төрийн нууцад хамаарах мэдээллийн “нууц” зэрэглэлтэй холбоотой зохицуулалтыг эргэн харж, засаж сайжруулан холбогдох хуулиуд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хөндөх шаардлагатай болох нь харагдаж байна.

Харин тус хуулийн төслийн дагалдуулан боловсруулсан Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслөөс үзвэл, одоогийн Зөрчлийн тухай хуульд заасан “Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчих” зөрчлийн зохицуулалтаас зөвхөн “болон албаны” гэх үгийг хасаж “Төрийн нууцын тухай хууль зөрчих” зөрчил болгон өөрчилж, оногдуулах шийтгэлийг өөрчлөлгүй хэвээр үлдээсэн байна.

Ойлгомжтой байдал шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

- Хуулийн төслийн 15 дугаар зүйлийн 15.5 дахь хэсэгт “...мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэгт хамааруулна.” гэж заажээ. Гэвч хуулийн төслийн 15.1-15.4 дэх хэсэгт болон бусад зохицуулалтад “зэрэглэл” гэж заасан байна. Иймд төслийн 15.5-д заасан “зэрэгт” гэснийг “зэрэглэлд” гэж өөрчлөх.

- Төслийн 17 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “...дардссыг...” гэснийг “дардсыг” гэж бичих нь зүйтэй.

Харилцан уялдаа шалгуур үзүүлэлтийн хүрээнд:

Төрийн нууцын тухай хуулийн төсөлтэй холбоотойгоор Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг боловсруулсан байх бөгөөд тус хуулийн төсөлд тусгасан 33

салбарт хамаарах хүснэгтэд төрийн нууцад хамаарах мэдээлэл болон зэрэглэл, хугацааг тусгасан байна.

Гэвч тус хүснэгтэн дэх төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэлээс харвал “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл байхгүй байна. Энэ нь Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, “нууц” зэрэглэлийн мэдээлэлтэй холбоотой зохицуулалтыг үр нөлөөг алдагдуулж байна. Өөрөөр хэлбэл, “нууц” зэрэглэлд хамаарах мэдээлэл байхгүй байхад ийнхүү зэрэглэл үүсгэсэн мэт харагдаж байна. Иймд Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн зохицуулалт болон Төрийн нууцын тухай хуульд заасан төрийн нууцад хамаарах мэдээллийн зэрэглэл, “нууц” зэрэглэлтэй холбоотой зохицуулалтыг сайтар судлан үзэж, хуулийн төслийн зохицуулалтууд болон хуулийн төсөл хоорондын харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байна.

Мөн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжтой эсэх асуудал нь хууль хоорондын харилцан уялдаатай холбоотойгоор хөндөгдөж байна. Практикт хэрэгжих боломж шалгуур үзүүлэлтийн хүрээнд дурдсанчлан төрийн нууцын тухай хуулийн төсөлд заасан төрийн нууцын гурван зэрэглэлээс нууцын зэрэглэлд хамаарах мэдээлэлтэй холбоотой асуудлын хүрээнд Эрүүгийн хуульд заасан гэмт хэргийн шинжийг хангасан тохиолдолд тус хуулийн 19.11 дүгээр зүйлд заасны дагуу хариуцлага хүлээлгэх боломжтой. Харин Эрүүгийн хуулийн 19.12, 19.13 дугаар зүйлд заасан зохицуулалтын дагуу “нууц” зэрэглэлд хамаарах мэдээллийн хүрээнд төрийн нууцыг задруулах, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх боломжгүй нөхцөл байдал үүсэхээр байна.

Иймд төрийн “нууц”-ын зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд эрүүгийн хариуцлага хүлээлгэх шаардлагатай эсэхийг судлан үзэж, хууль хоорондын харилцан уялдааг сайжруулах шаардлагатай байна.


АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

Хууль тогтоомж, эрх зүйн акт

- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1992), №1;
- Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2022), №6;
- Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №11;
- Төрийн нууцын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (1995), №7;
- Эрүүгийн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2016), №7;
- Зөрчлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэл (2017), №24;
- “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого;
- Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал;
- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр.

Ном, сурах бичиг, судалгааны тайлан, эмхэтгэл

- Directorate General for Internal Policies. Parliamentary oversight of security and intelligence agencies in the European Union. Policy Department C: Citizens' Rights and Constitutional Affairs, European Parliament.
- David Banisar, Comments on the Moldovan Draft Law on State and Official Secrets, 2005, <https://www.osce.org/files/f/documents/3/7/16548.pdf>
- Б.Баясгалан, Монгол Улсын Төрийн болон албаны нууцыг хамгаалах эрх зүйн тогтолцоонд тулгамдаж буй асуудал, ХДЭС, (УБ, 2020), Цуврал 77;
- Глоб интернэшнл, Азийн сангийн Монгол дахь төлөөлөгчийн газар, “Олон улсын хэм хэмжээнд нийцсэн хуулиар дамжуулах олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг дэмжих нь” төсөл, Мэдээлэлтэй байх эрхийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн дүн шинжилгээ, 2019 он;
- Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн үзэл баримтлал, 2025 он;
- ХЗҮХ, Төрийн болон албаны нууцын тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээ, 2023 он;
- ХЗҮХ, Төрийн болон албаны нууцын эрх зүйн зохицуулалт (Олон улсын чиг хандлага, зарим улсын туршлага), 2023 он;
- Ч.Өнөрбаяр, Б.Тэмүүлэн, Ж.Баярцэцэг нар, Төрийн нууцын тухай өнөөгийн хандлагыг өөрчлөх замаар иргэдийн мэдэх эрхийг хангах нь, ННФ, 2010 он.



ХУУЛЬ ЗҮЙН
ҮНДЭСНИЙ ХҮРЭЭЛЭН

СУДАЛГААНЫ ТАЙЛАН

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ
/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
ХУУЛИЙН ТӨСЛИЙГ
ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ
ХОЛБОГДОН ГАРАХ
ЗАРДЛЫН ТООЦОО



2026 он

Судалгааг хянасан:

Н.Жамъянхүү

Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн
Захирал

Судалгааг удирдсан:

М.Түвшинжаргал

Эрдэмтэн нарийн бичгийн дарга, Хууль
зүйн доктор

Судалгааны багийн гишүүд:

О.Энххүслэн

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ахлах ажилтан (LL.M.)

Г.Болор-Эрдэнэ

Хувийн эрх зүйн секторын Эрдэм
шинжилгээний ажилтан

АГУУЛГА

I. УДИРТГАЛ	4
II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО	6
2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох	10
2.2. Хүний нөөцийг тодорхойлох	13
2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох	17
2.4. Үр дүнг тооцох	18
2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.	19
IV. ДҮГНЭЛТ, САНАЛ	21
V. АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ	22

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДОН ГАРАХ ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН

I. УДИРТГАЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 17-д "төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаалуулах" гэж заасан.

Улсын Их Хурлын 2010 оны 48 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал"-ын 3.9.3.2-т "Төрийн мэдээллийн ангилал, нууцын зэрэглэлийг оновчтой болгож, нууц хамгаалалтыг шинэ түвшинд гаргах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтыг боловсронгуй болгоно" гэж, "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын 5.4-т "иргэндээ үйлчилдэг, мэргэшсэн, чадварлаг, ил тод үр нөлөөтэй, ухаалаг төрийн албыг төлөвшүүлнэ", 7.5-д "төр, иргэн, хувийн хэвшлийн мэдээллийн бүрэн бүтэн, нууцлагдсан, хүртээмжтэй байдлыг баталгаажуулж, өрсөлдөх чадварыг бий болгоно" гэсэн зорилтыг тусгасан ба тус бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны 5.6.3-т "Төрийн байгууллагын үйл ажиллагааны ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно" гэж, 5.6.8-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод, хариуцлагатай байдлыг хангах, хяналт тавих зохицуулалтыг боловсронгуй болгоно" гэж, 5.6.8-д "Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж авлига үүсэх эрсдэлийг бууруулна" гэж тус тус заасан.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр"-ийн 4.1.4.1-д "Төрийн үйл ажиллагаанд иргэндийн хяналт тавих тогтолцоог технологийн шийдлээр сайжруулж, шилэн ажиллагааг үргэлжлүүлж, төрийн нууцад хамаарахаас бусад бүх шийдвэр, тогтоол, гэрээ, хэлцэл, мэдээллийн санг олон нийтэд нээлттэй, ил тод болгоно" гэж заасан.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны 59 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр (2023-2030 он)"-ийн 10.1.1-д "Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагын харьяа төрийн өмчит хуулийн этгээдийн төсөв, санхүү, худалдан авах ажиллагаа болон хуулиар төрийн нууцад хамааруулснаас бусад мэдээллийг ил тод болгож, түүнд тавих хяналт, хариуцлагын тогтолцоог бүрдүүлнэ" гэж заасан.

Дээрх бодлогын баримт бичигт дэвшүүлсэн зорилтын хүрээнд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх нь Төрийн нууцын тухай хуулийг шинэчлэх хууль зүйн үндэслэл, шаардлага болсон.

Энэхүү судалгаагаар Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төрийн байгууллага болон иргэн, хуулийн этгээдийн тодорхой үйл ажиллагаа эрхлэхтэй холбогдох зардлыг тооцох, үйл ажиллагааны ачааллыг багасгаж, ногдох зардлыг бууруулах боломжит хувилбарыг боловсруулахыг зорилоо.

Тус хуульд иргэн болон хувийн эрх зүйн хуулийн этгээд үүрэг хүлээлгэх зохицуулалт тусгагдаагүй тул энэхүү зардлын тооцооны судалгааг дараах үндсэн бүтцийн дагуу гүйцэтгэлээ. Үүнд:

1. Төрийн байгууллагын зардлын тооцоо

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын дагуу тооцоолов.

II. ТӨРИЙН БАЙГУУЛЛАГЫН ЗАРДЛЫН ТООЦОО

Төрийн байгууллагын зардал буюу улсын төсөвт үүсэх ачааллыг тооцохын тулд тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлж, түүнд шаардагдах зардлыг тооцох бөгөөд уг ажлыг дараах үе шаттайгаар зохион байгуулна:

- Байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг тодорхойлох;
- Тухайн чиг үүргийг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийг тодорхойлох;
- Холбогдон гарах зардлыг урьдчилан тооцох;
- Зардлыг нэгтгэн тооцох;
- Хувилбарыг нягталж, үр дүнг нэгтгэх.

Хүснэгт 1. Зардалд нөлөөлөх зүйл заалт

Хуулийн төслийн төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүрэгтэй холбогдох зохицуулалт	Чиг үүргийг хэрэгжүүлэхэд нөлөөлөх зүйл заалт
8.1.3.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох.	8.1.Улсын Их Хурал төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ. 8.1.1.төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, хууль тогтоомжийг батлах, тэдгээрийн биелэлтэд хяналт тавих; 8.1.2.төрийн нууцыг хамгаалахад чиглэсэн хөтөлбөр, төсөл, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд зарцуулах хөрөнгийг улсын төсөвт тусгаж батлах;
10.1.5.төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах; 10.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг Улсын Их Хуралд оруулах.	10.1.Засгийн газар улсын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах үйл ажиллагааг уялдуулан зохицуулж дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 10.1.1.төрийн нууцын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулах, энэ талаар холбогдох байгууллага, албан тушаалтанд үүрэг, чиглэл өгөх; 10.1.2.төрийн нууцыг хамгаалах төрийн бодлого, төсөл, хөтөлбөр, эрх зүйн баримт бичгийг боловсруулж, хэрэгжүүлэх; 10.1.3.төрийн нууцтай холбоотой журам, зааврыг батлах; 10.1.4.төрийн нууцыг харилцан солилцох, хамгаалах тухай Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээр байгуулах;
11.1.1.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл	11.1.Байгууллага, албан тушаалтан төрийн нууцыг хамгаалах талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ: 11.1.2.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд байгаа төрийн

ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг нийтлэг журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх;	нууцын хамгаалалтад хяналт тавих; 11.1.3.төрийн нууцыг хамгаалах арга, хэрэгслийг боловсронгуй болгох, шаардлагатай хөрөнгийг төсөвтөө тусгаж санхүүжүүлэх саналаа эрх бүхий байгууллагад гаргаж шийдвэрлүүлэх; 11.1.4.онцгой нөхцөл байдал үүссэн үед төрийн нууцыг хамгаалах төлөвлөгөө боловсруулж батлах, тухайн үед авах арга хэмжээний бэлэн байдлыг хангах.
14.4.Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2-т заасан жагсаалтад ороогүй боловч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шалгуурт нийцэж байгаа тохиолдолд төрийн нууцад хамааруулах саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ.	14 дүгээр зүйл.Мэдээллийг нууцлах 14.1.Мэдээллийг нууцлах арга хэмжээг тэдгээрийг төрийн нууцад хамааруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн холбогдох байгууллага, албан тушаалтан авч хэрэгжүүлнэ. 14.2.Мэдээллийг энэ хуульд заасан нууцын зэрэглэл болон бусад тэмдэглэгээг тавьж бэхжүүлэх замаар нууцална. 14.3.Объект, тодорхой үйл ажиллагааг нууцлахдаа тэдгээрийг халхлах арга хэмжээг Засгийн газрын баталсан журмын дагуу хэрэгжүүлнэ.
18.2.Энэ хуулийн 18.1.2-т заасан үндэслэлээр тагнуулын байгууллага төрийн нууцад хамаарах нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа тухайн мэдээлэлд хийсэн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.	-
18.3.Энэ хуулийн 18.2-т заасан тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тухайн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.	-
18.4.Энэ хуулийн 18.1.3-т заасан үндэслэлээр төрийн байгууллага, албан тушаалтан мөн хуулийн 16.5-д зааснаас бусад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах эсэхийг дараах журмын дагуу зохион байгуулна:	18.4.1.тухайн мэдээллийг нууцлах хугацаа дуусахаас 3-аас доошгүй сарын өмнө ажлын хэсэг байгуулан шинжилгээ хийлгэж, үндэслэл бүхий дүгнэлт гаргуулан тагнуулын байгууллагын саналыг авна; 18.4.2.мэдээллийг ил болгох талаар тагнуулын байгууллагын саналыг авсны дараа ажлын хэсэг төрийн нууцыг ил болгосон тухай нотолгоо бичиж, тухайн байгууллагын даргаар батлуулснаар төрийн хамгаалалтаас гарсанд тооцно; 18.4.3.төрийн хамгаалалтаас гаргасан нууц баримт бичиг, бусад тээгчид "ил болсон" гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ. Тухайн баримт бичгийг цаашид шилжүүлэх, хадгалах, нийтэд ашиглуулах асуудлыг албан

	хэрэг хөтлөлт болон архивын журам, зааврын дагуу шийдвэрлэнэ; 18.4.4.нууц баримт бичиг, бусад тээгчийн нууцлах хугацааг сунгасан тохиолдолд "хугацааг сунгав" гэсэн тэмдэглэгээг тавьж, бүртгэлд тэмдэглэнэ.
23.2.Төрийн нууцтай танилцах эрх олгохдоо тухайн албан тушаалтан, иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн болон шалгагдаж байгаа гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг харгалзан үзнэ.	23 дугаар зүйл.Албан тушаалтан, иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзах үндэслэл 23.1.Албан тушаалтан, иргэнд дараах үндэслэлээр төрийн нууцтай танилцах эрх олгохоос татгалзана: 23.1.1.төрийн нууцтай танилцах шаардлага, нөхцөлийг хангаагүй; 23.1.2.аюулгүй байдлын шалгалтад хамрагдах, төрийн нууцыг хамгаалах баталгааг бичгээр гаргаж өгөхөөс татгалзсан; 23.1.3.аюулгүй байдлын шалгалтад өөрийн тухай болон холбогдох бусад мэдээллийг танилцуулаагүй, эсхүл худал мэдээлсэн; 23.1.4.төрийн нууцыг хамгаалах журмыг удаа дараа, эсхүл ноцтой зөрчиж байсан; 23.1.5.Монгол Улсын харьяатаас гарах хүсэлтээ гаргасан; 23.1.6.сэтгэцийн өвчин, эмгэгтэй нь тогтоогдсон; 23.1.7.согтуурах, мансуурах донтой болох нь тогтоогдсон.
28.2.Төрийн нууц хамгаалах болон шифр хариуцах ажилтанд Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно.	-
32.5.Энэ хуулийн 32.4-т заасан хуулийн этгээдийг судалж, шалгах, аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална.	32.1.Тагнуулын байгууллагын зөвшөөрлийг үндэслэн төрийн нууцыг хариуцсан байгууллагын удирдлагын шийдвэрээр ажил гүйцэтгүүлэхтэй холбоотойгоор хуулийн этгээд, иргэнд зөвхөн тухайн ажлыг гүйцэтгэхэд шаардлагатай хэмжээ, хязгаарын дотор төрийн нууцыг хамгаалах тухай нийтлэг журамд заасны дагуу шилжүүлж болно. 32.2.Энэ хуулийн 32.1-д заасны дагуу нууцыг шилжүүлэн авах хуулийн этгээд нь энэ хууль, түүнд нийцүүлэн гаргасан бусад хууль тогтоомжид заасан нууцыг хамгаалах нөхцөл, шаардлага хангасан, иргэн нь төрийн нууцтай танилцах эрх авсан байна. 32.3.Ажил гүйцэтгэгч ажлыг гүйцэтгэх үед төрийн нууцыг хамгаалах үүргээ

	биелүүлээгүй, эсхүл хангалтгүй биелүүлсэн бол захиалагч уг зөрчлийг арилгах хүртэл хугацаанд төрийн нууцыг ашиглах үйл ажиллагааг зогсоох, төрийн нууцыг татан авах арга хэмжээ авна.
37.4.Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална.	37.1.Тагнуулын байгууллага улсын хэмжээнд өмчийн хэлбэр, харьяалал харгалзахгүйгээр төрийн байгууллага, бусад хуулийн этгээдийн төрийн нууцын хамгаалалтыг хянан шалгаж, зөрчил, дутагдлыг арилгах хугацаатай үүрэг өгч, биелэлтийг хангуулна.
37.7.Тагнуулын байгууллага төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгий талаарх мэдээллийг жил бүр Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд хүргүүлнэ.	37.2.Тагнуулын байгууллагын хяналт, шалгалтын дүнд гаргасан албан шаардлагыг байгууллага, албан тушаалтан заавал биелүүлж, хариу мэдэгдэх үүрэгтэй.

2.1. Төрийн захиргааны байгууллагын чиг үүргийг тодорхойлох

Байгууллагын чиг үүргийг тодорхойлоход дараах зарчмыг баримтална. Үүнд:

1. Тухайн хууль тогтоомжид хамаарах төрийн байгууллага, тэдгээрийн чиг үүргийг тодорхойлох;
2. Байгууллагыг сонгохдоо тухайн чиг үүрэгт хамааралтай, голлон үүрэг гүйцэтгэх байгууллагыг сонгох;
3. Чиг үүрэгт хэрэгжүүлэх, хэмжих боломжтой агуулгыг хамааруулах.

Чиг үүргийг тодорхойлохдоо гүйцэтгэх үйлдэл буюу стандарт үйл ажиллагааг тодорхойлно. Иймд Засгийн газраас баталсан 59 дүгээр тогтоол дах аргачлалын хүрээнд төрийн байгууллагаас бодлогын шинжтэй зарим ажил, үйлчилгээг зардлын тооцоонд хамааруулан тооцдоггүй бөгөөд стандарт үйл ажиллагааг тодорхойлохдоо ерөнхий байдлаар бүлэглэн тодорхойлов.

Хүснэгт 2. Стандарт үйл ажиллагааг тодорхойлох нь

Гүйцэтгэх байгууллага	Гүйцэтгэх ажил үүрэг	Стандарт үйл ажиллагаа
УИХ	8.1.3.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох.	- Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох тогтоолын төсөл боловсруулах - Тогтоолын төслийг хэлэлцүүлэх - Тогтоолын төслийг батлах
	18.3.Энэ хуулийн 18.2-т заасан тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэн тухайн мэдээллийг ил болгох эсэхийг Засгийн газрын өргөн мэдүүлснээр Улсын Их Хурал шийдвэрлэнэ.	- Мэдээллийг ил болгох талаар тогтоолын төсөл боловсруулах - Тогтоолын төслийг хэлэлцүүлэх - Тогтоолын төслийг батлах
ЗГ	10.1.5.төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах;	- Мэдээллийг ангилж боловсруулах - Мэдээллийг шилжүүлэх талаар хэлэлцүүлэх - Мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах
	10.1.6.мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг Улсын Их Хуралд оруулах.	- мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг боловсруулах - мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг хэлэлцүүлэх - мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг

		сунгах асуудлыг өргөн мэдүүлэх
	37.4.Энэ хуулийн 37.1-д заасан хяналт шалгалт явуулах журмыг Засгийн газар батална.	- Журмын төсөл боловсруулах - Журмын төсөл хэлэлцүүлэх - Журмыг батлах
Байгууллага, албан тушаалтан	11.1.1.эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд төрийн нууцыг хамгаалах тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг нийтлэг журамд нийцүүлэн баталж мөрдүүлэх;	- Журмын төсөл боловсруулах - Журмын төсөл хэлэлцүүлэх - Журмыг батлах
	14.4.Байгууллага, албан тушаалтны боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэл нь энэ хуулийн 13.2-т заасан жагсаалтад ороогүй боловч энэ хуулийн 15 дугаар зүйлд заасан шалгуурт нийцэж байгаа тохиолдолд төрийн нууцад хамааруулах саналаа нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлнэ	- Боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэлд үнэлгээ хийх - 13.2-т заасан жагсаалтад хамаарах эсэхийг шалгах. - 15 дугаар зүйлд заасан шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох - Шалгуур хангасан тохиолдолд төрийн нууцад хамааруулах саналыг нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлэх.
	28.2.Төрийн нууц хамгаалах болон шифр хариуцах ажилтанд Засгийн газраас тогтоосон журмын дагуу цалингийн нэмэгдэл олгоно.	- Шифр хариуцах ажилтанд цалингийн нэмэгдэл олгох
	18.4.Энэ хуулийн 18.1.3-т заасан үндэслэлээр төрийн байгууллага, албан тушаалтан мөн хуулийн 16.5-д зааснаас бусад нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах эсэхийг дараах журмын дагуу зохион байгуулна:	- 18.1.3-д заасан үндэслэлийг тодорхойлох - 16.5-д заасан тохиолдлоос бусад нууц баримт бичиг, бусад тээгчид хамаарлыг шалгах - Нууц баримт ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах асуудлыг журамд заасан дарааллаар зохион байгуулах - Зохицуулалтыг байгууллага, албан тушаалтанд мөрдүүлэх

Тагнуулын байгууллага	18.2.Энэ хуулийн 18.1.2-т заасан үндэслэлээр тагнуулын байгууллага төрийн нууцад хамаарах нууц баримт бичиг, бусад тээгчийг ил болгох саналаа тухайн мэдээлэлд хийсэн шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлтийн хамт Засгийн газарт хүргүүлнэ.	- 18.1.2-т заасан үндэслэлийг тогтоох - Төрийн нууцад хамаарах баримт бичиг, бусад тээгчийг шалгах - Шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлт бэлтгэх - Ил болгох саналыг дүгнэлттэй нь хамт Засгийн газарт хүргүүлэх
	23.2.Төрийн нууцтай танилцах эрх олгохдоо тухайн албан тушаалтан, иргэний эрүүгийн хариуцлага хүлээсэн болон шалгагдаж байгаа гэмт хэргийн сэдэлт, зорилго, гэм буруугийн хэлбэр, учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэр хэмжээ, үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл зэргийг харгалзан үзнэ.	- Төрийн нууцтай танилцах хүсэлтийг хүлээн авах - Албан тушаалтны болон иргэний эрүүгийн хариуцлага, гэмт хэрэгтэй холбогдох нөхцөл байдал, зорилго, гэм буруугийн хэлбэрийг үнэлэх - Учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэмжээ, үйлдэлд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох - Үнэлгээнд үндэслэн төрийн нууцтай танилцах эрх олгох эсэхийг шийдвэрлэх.
	32.5.Энэ хуулийн 32.4-т заасан хуулийн этгээдийг судалж, шалгах, аюулгүй байдлын гэрчилгээ олгох журмыг тагнуулын байгууллагын дарга батална.	- Журмын төсөл боловсруулах - Журмын төсөл хэлэлцүүлэх - Журмыг батлах
	37.7.Тагнуулын байгууллага төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлт, хяналт, шалгалтын нэгдсэн дүнгийг талаарх мэдээллийг жил бүр Засгийн газарт танилцуулж, Улсын Их Хуралд хүргүүлнэ.	- Төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах - Нэгдсэн дүнг гаргах. - Жил бүр мэдээллийг Засгийн газарт танилцуулах - Мэдээллийг Улсын Их Хуралд хүргүүлэх

2.2. Хүний нөөцийг тодорхойлох

Хүний нөөцийг тодорхойлохын тулд тухайн чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулах хугацаа болон жилд хэдэн удаа гүйцэтгэх тоо /цаашид "тохиолдлын тоо" гэх/, шаардагдах нийт ажлын цаг гэсэн 3 үзүүлэлтийг тооцож гаргана.

Зарцуулах хугацааг тодорхойлохдоо текст анализын аргад тулгуурлан статистикт тоон мэдээллийг тооцсон болно.

Хүснэгт 3. Стандарт үйл ажиллагаа холбоотойгоор үүсэх хүний нөөцийн хэрэгцээ

Гүйцэтгэх байгууллага	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/
УИХ	Мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл, хугацааг тогтоох тогтоолын төсөл боловсруулах	2400 ¹	1	1440
	Тогтоолын төслийг хэлэлцүүлэх	1440	1	1440
	Тогтоолын төслийг батлах	960	1	960
	Мэдээллийг ил болгох талаар тогтоолын төсөл боловсруулах	2400	1	2400
	Тогтоолын төслийг хэлэлцүүлэх	1440	1	1440
	Тогтоолын төслийг батлах	960	1	960
ЗГ	Мэдээллийг ангилж боловсруулах	2400	1	2400
	Мэдээллийг шилжүүлэх талаар хэлэлцүүлэх	1440	1	1440
	Мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах	480	1	480
	мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг боловсруулах	1440	1	1440
	мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг	960	1	960

¹ 480 минут буюу ажлын 8 цаг.

	сунгах асуудлыг хэлэлцүүлэх			
	мэдээллийг төрийн нууцад хамааруулах, ил болгох, нууцын зэрэглэл тогтоох, өөрчлөх, нууцын хугацааг сунгах асуудлыг өргөн мэдүүлэх	480	1	480
	Журмын төсөл боловсруулах	2400	1	2400
	Журмын төсөл хэлэлцүүлэх	1440	1	1440
	Журмыг батлах	960	1	960
Байгууллага, албан тушаалтан	Журмын төсөл боловсруулах	2400	1	2400
	Журмын төсөл хэлэлцүүлэх	1440	1	1440
	Журмыг батлах	960	1	960
	Боловсруулсан, эсхүл хүлээн авсан мэдээлэлд үнэлгээ хийх	960	1	960
	13.2-т заасан жагсаалтад хамаарах эсэхийг шалгах.	960	1	960
	15 дугаар зүйлд заасан шалгуурт нийцэж байгаа эсэхийг тогтоох	960	1	960
	Шалгуур хангасан тохиолдолд төрийн нууцад хамааруулах саналыг нэн даруй тагнуулын байгууллагад хүргүүлэх.	480	1	480
	18.1.3-д заасан үндэслэлийг тодорхойлох	960	1	960
	16.5-д заасан тохиолдлоос бусад нууц баримт бичиг, бусад тээгчид хамаарлыг шалгах	960	1	960
	Нууц баримт ил болгох, эсхүл нууцлах хугацааг сунгах асуудлыг журамд заасан дарааллаар зохион байгуулах	480	1	480

	Зохицуулалтыг байгууллага, албан тушаалтанд мөрдүүлэх	480	1	480
	Шифр хариуцсан ажилтанд цалингийн нэмэгдэл олгох	28800	12	345600
Тагнуулын байгууллага	18.1.2-т заасан үндэслэлийг тогтоох	960	1	960
	Төрийн нууцад хамаарах баримт бичиг, бусад тээгчийг шалгах	960	1	960
	Шинжилгээ, үндэслэл бүхий дүгнэлт бэлтгэх	960	1	960
	Ил болгох саналыг дүгнэлттэй нь хамт Засгийн газарт хүргүүлэх	480	1	480
	Төрийн нууцтай танилцах хүсэлтийг хүлээн авах	480	1	480
	Албан тушаалтны болон иргэний эрүүгийн хариуцлага, гэмт хэрэгтэй холбогдох нөхцөл байдал, зорилго, гэм буруугийн хэлбэрийг үнэлэх	960	1	960
	Учирсан хохирол, хор уршгийн шинж чанар, хэмжээ, үйлдэлд нөлөөлсөн шалтгаан, нөхцөлийг тодорхойлох	960	1	960
	Үнэлгээнд үндэслэн төрийн нууцтай танилцах эрх олгох эсэхийг шийдвэрлэх.	960	1	960
	Журмын төсөл боловсруулах	2400	1	2400
	Журмын төсөл хэлэлцүүлэх	1440	1	1440
	Журмын төсөл хэлэлцүүлэх	960	1	960
	Төрийн нууцын хууль тогтоомжийн биелэлтийг хянан шалгах	960	1	960
	Нэгдсэн дүнг гаргах	960	1	960

Жил бүр мэдээллийг Засгийн газарт танилцуулах	1440	1	1440
Мэдээллийг Улсын Их Хуралд хүргүүлэх	960	1	960
Нийт			393120

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200 өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /Хөдөлмөрийн тухай хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу (200 x 8) 1.600 ажлын цаг буюу (1.600 x 60) 96.000 минут ажиллана.

Нийт зарцуулах хугацаагаар хүний нөөцийн хэрэгцээ тодорхойлогдох ба тэрхүү хугацааг жилд ажиллах ажлын минутад хувааснаар шаардлагатай хүний нөөц буюу нэмэгдэх орон тоо гарна.

Хүснэгт 4. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн ачаалал

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ /мин/	Жилд шаардагдах ажлын цаг /мин/	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/
УИХ	8640	96000	0.09
ЗГ	12000	96000	0.125
Байгууллага, албан тушаалтан	354240	96000	3.69
Тагнуулын байгууллага	15840	96000	0.165

Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 0.09, Засгийн газраас 0.125, Байгууллага, албан тушаалтнаас 3.69, Тагнуулын байгууллагаас 0.165-аар хүний нөөцийн ачаалал нэмэгдэж байна.

2.3. Гарах зардлыг урьдчилан тооцох

Хуулийн төслийн улмаас төсөвт үүсэх зардал, төрийн байгууллагын ачааллыг тооцохдоо аргачлалд заасны дагуу хүний нөөцийн зардал-г юун түрүүнд тооцно.

Нэг албан хаагчид зарцуулах, төрөөс даах зардлыг тооцохдоо түүнд олгох үндсэн цалингаас гадна (1) бүх төрлийн даатгал, (2) хоол, унааны нэмэгдэл, (3) ажилласан жилийн нэмэгдэл, (4) зэрэг, дэвийн нэмэгдэл, (5) буцалтгүй тусламж, (6) шагнал, урамшуулал зэрэг нэмэлт зардлыг нэмж тооцох шаардлагатай байдаг.

Улсын Их Хуралд хамаарах төрийн албан хаагчдын цалинг 2,127,000, жилд 25,530,000², Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 3,792,000³, жилд 45,510,000 гэж тооцон, тагнуулын байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 1,682,917⁴, жилд 20,195,004 гэж тооцлоо.

Энэ зардал дээр тооцож гаргасан **хүний нөөцийн хэрэгцээнд** үржүүлж хүний нөөцийн нийт зардал гарна.

Хүснэгт 5. Төрийн байгууллагын нэмэгдэж буй хүний нөөцийн зардал

Нэгж	Нэмэгдэж буй ачаалал /хүний тоо/	Нэг албан хаагчийн 1 жилийн цалингийн зардал	Хүний нөөцийн зардал
УИХ	0.09	25,530,000	2,297,700
ЗГ	0.125	45,510,000	5,688,750
Байгууллага, албан тушаалтан	3.69	24,600,000	90,774,000
Тагнуулын байгууллага	0.165	20,195,004	3,332,175

Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 2,297,700, Засгийн газраас 5,688,750, Байгууллага, албан тушаалтнаас 90,774,000, Тагнуулын байгууллагаас 3,332,175 төгрөгийн зардал хүний нөөцийн зардалд гарахаар байна.

² Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛД АЖЛАА ХАРИУЦАН ТАЙЛАГНАДАГ ЗАРИМ БАЙГУУЛЛАГЫН АЖЛЫН АЛБА БОЛОН АДИЛТГАХ БУСАД БАЙГУУЛЛАГА, ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБАНЫ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342211461&showType=1>

³ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт ТӨРИЙН ЗАХИРГААНЫ ТӨВ БАЙГУУЛЛАГЫН ТӨРИЙН ЗАХИРГААНЫ БОЛОН ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342347221&showType=1>

⁴ Засгийн газар болон төрийн захиргааны төв байгууллагын албан хаагчдын цалинг сард дунджаар 2,050,000 байгаа ба үүнийг "Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын төрийн захиргааны болон үйлчилгээний удирдах, гүйцэтгэх, туслах албан тушаалын цалингийн хэмжээг тогтоох итгэлцүүр"-ийг үндэслэн нэмэгдүүлбэл тухайн дүн гарч байна. <https://legalinfo.mn/mn/detail?lawId=15450>

⁵ Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт ТӨРИЙН ТУСГАЙ АЛБАН ТУШААЛЫН ЦАЛИНГИЙН ХЭМЖЭЭ, <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17355342407681&showType=1>

2.4. Үр дүнг тооцох

Хүний нөөцийн дундаж зардал, материаллаг дундаж зардал, бусад зардлыг нэмснээр нийт зардал гарна.

Материаллаг зардал гэж тухайн ажлын байртай холбогдон гарах нийтлэг зардлыг хэлнэ. Үүнд, ажлын байр, (түрээсэлдэг бол түрээсийн төлбөр, төрийн эзэмшлийн эд хөрөнгө бол элэгдэл хорогдлын зардал), цахилгаан дулаан, бичиг хэргийн зардал, техник, тоног төхөөрөмжийн зардал, урсгал зардал, хөрөнгө оруулалтын зардал гэх мэт орно.

Төрийн байгууллагын нэг ажилтанд ногдох материаллаг зардлыг Засгийн газрын 59 дүгээр тогтоолоор батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоог хийх аргачлал”-ын хавсралтыг үндэслэж, нэмэгдсэн ажлын байранд оногдох тоног төхөөрөмж, бичиг хэргийн зардал зэрэг материаллаг зардлыг ерөнхийлөн тооцлоо.

Хүснэгт 6. Нэг албан хаагчид оногдох материаллаг зардал/

Зардлын төрөл	Зардлын нэр	Зардал /төгрөгөөр/
Урсгал зардал	Бичиг хэргийн зардал	121,285
	Шуудан холбоо	167,881
	Компьютер, тоног төхөөрөмж	3,351,757
	Тавилга, эд хогшил	53,725
Зардал	Түлш, халаалт	199,897
	Гэрэл, цахилгаан	937,251
	Цэвэр, бохир ус	51,947
	Урсгал засвар	53,725
	Газрын төлбөр	1,411
Элэгдэл, хорогдлын зардал	Техник, тоног төхөөрөмж	356,555
	Тавилга, эд хогшил	100,000
Нэг албан хаагчид оногдох		5,395,434

Нийт зардлыг тооцох

Хүснэгт 7. Нийт зардал

Нэгж	Хүний нөөцийн зардал	Материаллаг зардал	Нийт
УИХ	2,297,700	485,589	2,783,289
ЗГ	5,688,750	674,429	6,363,179
Байгууллага, албан тушаалтан	90,774,000	620,474	91,394,474
Тагнуулын байгууллага	3,332,175	890,246	4,222,421
Нийт			104,763,363

Уг хуулийн төсөл хэрэгжих тохиолдолд Улсын Их Хурлаас 2,783,289, Засгийн газраас 3,749,429, Байгууллага, албан тушаалтнаас 91,394,474, Тагнуулын байгууллагаас 4,222,421 төгрөгийн зардал, нийтдээ төрийн байгууллагаас 104,763,363 төгрөгийн зардал үүсэхээр байна.

2.5. Хувилбарыг нягталж, үр дүнг танилцуулах.

Хялбарчлах боломжийг шалгах үе шатанд өмнөх үе шатанд тодорхойлсон үүрэг нэг бүрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг бууруулах буюу дарамт, ачааллыг багасгах боломжтой эсэхийг шалгана. Үүнд:

2.5.1.Тохиолдлын тоог багасгах боломж байгаа эсэх;

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Энэхүү зардлын тооцооны хүрээнд үргэлжилсэн шинжтэй чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн. Энэ нь хамгийн багаар буюу жилд 1 байхаар тогтоосон тохиолдлын тоо учир багасгах боломж байхгүй.

2.5.2.Мэдээлэл хүргүүлэх давтамжийг багасгах боломж байгаа эсэх;

Төрийн нууцад хамааруулах, ил болгох асуудал нь тохиолдол бүрд шийдвэрлэгдэх шинжтэй тул давтамжийг урьдчилан бууруулах боломжгүй. Гэхдээ ижил агуулгатай мэдээллийг багцлан нэг удаагийн тогтоолоор шийдвэрлэх, нууцын хугацааг сунгах асуудлыг нэгтгэн хэлэлцэх, урьдчилсан дүгнэлтийг ажлын хэсгийн түвшинд боловсруулж, эцсийн хэлэлцүүлгийг товчлох замаар минутын ачааллыг бууруулах боломжтой.

2.5.3.Мэдээллийн агуулгыг багасгах боломж байгаа эсэх;

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй. Иймд мэдээллийн агуулгыг багасгах боломжгүй. Харин нэгэнт бүртгэлтэй нууц баримт бичгийн мэдээллийг дахин бүрдүүлэхгүйгээр төвлөрсөн мэдээллийн сангаас лавлагаа авах, нууц баримт бичгийн хамаарал шалгах ажиллагааг цахим бүртгэлтэй уялдуулах, хяналт шалгалтын дүнг нэгтгэн гаргах процессыг автоматжуулах зэргээр ачааллыг багасгах боломжтой.

2.5.4.Мэдээллийг цахимаар хүргүүлэх боломжтой эсэх;

Цахим шийдлийг дараах түвшинд нэвтрүүлбэл ачаалал буурна:

- Нууцад хамааруулах саналыг цахимаар илгээх, хүлээн авах;
- Дүгнэлт боловсруулах стандарт загвар ашиглах;
- Хяналт шалгалтын тайланг цахим системд нэгтгэх;
- Жил бүрийн нэгдсэн дүнг автоматаар гаргах гэх мэт

2.5.5.Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог багасгах боломжтой эсэх;

Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог хамгийн багаар тогтоосон байна. Гэвч мэдээлэл нийлүүлэгч нь тухайн төрлийн мэдээллийг зохих дээд шатны байгууллагад

хүргүүлдэг бол мэдээллийн сангаар дамжуулан дээд шатны байгууллагадаа хүргүүлэх боломжийг бүрдүүлж болох юм. Ингэснээр мэдээлэл нийлүүлэгч нэг мэдээллийг 2 өөр этгээдэд хүргүүлэхээр давхар зардал, цаг хугацаа зарцуулахгүй.

IV. ДҮГНЭЛТ, САНАЛ

Төслийн зардлын тооцоог хийх нь хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх явцад иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагад хэдий хэмжээний зардал, ачаалал үүсгэхийг урьдчилан гаргах зорилготой байдаг. Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд төр, хуулийн этгээдэд учрах зардлыг урьдчилан тооцох зорилгоор энэхүү судалгааг гүйцэтгэлээ.

Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 0.09, Засгийн газраас 0.125, Байгууллага, албан тушаалтнаас 3.69, Тагнуулын байгууллагаас 0.165-аар хүний нөөцийн ачаалал нэмэгдэж байна.

Төрийн нууцын тухай хуулийн төслийг хэрэгжүүлэхэд Улсын Их Хурлаас 2,783,289, Засгийн газраас 3,749,429, Байгууллага, албан тушаалтнаас 91,394,474, Тагнуулын байгууллагаас 4,222,421 төгрөгийн зардал, нийтдээ төрийн байгууллагаас 104,763,363 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Нийт зардлын тухайд Улсын Их Хурлаас 2,783,289, Засгийн газраас 3,749,429, Байгууллага, албан тушаалтнаас 91,394,474, Тагнуулын байгууллагаас 4,222,421 төгрөгийн зардал, нийтдээ төрийн байгууллагаас 104,763,363 төгрөгийн зардал үүсэхээр байна.

Төрийн байгууллагын зардал тооцох хүрээнд, хуулийн төсөлд тусгасан чиг үүргийг тухайн төрийн байгууллага жилд хэдэн удаа гүйцэтгэх тоог “тохиолдлын тоо” гэж авч үздэг. Энэхүү зардлын тооцооны хүрээнд үргэлжилсэн шинжтэй чиг үүргийн тохиолдлын тоог 1 гэж авч үзсэн. Энэ нь хамгийн багаар буюу жилд 1 байхаар тогтоосон тохиолдлын тоо учир багасгах боломж байхгүй.

Төрийн нууцад хамааруулах, ил болгох асуудал нь тохиолдол бүрд шийдвэрлэгдэх шинжтэй тул давтамжийг урьдчилан бууруулах боломжгүй. Гэхдээ ижил агуулгатай мэдээллийг багцлан нэг удаагийн тогтоолоор шийдвэрлэх, нууцын хугацааг сунгах асуудлыг нэгтгэн хэлэлцэх, урьдчилсан дүгнэлтийг ажлын хэсгийн түвшинд боловсруулж, эцсийн хэлэлцүүлгийг товчлох замаар минутын ачааллыг бууруулах боломжтой.

Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс мэдээллийн агуулгыг хязгаарлалгүйгээр мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг хангахад чиглэх нь зүйтэй. Иймд мэдээллийн агуулгыг багасгах боломжгүй. Харин нэгэнт бүртгэлтэй нууц баримт бичгийн мэдээллийг дахин бүрдүүлэхгүйгээр төвлөрсөн мэдээллийн сангаас лавлагаа авах, нууц баримт бичгийн хамаарал шалгах ажиллагааг цахим бүртгэлтэй уялдуулах, хяналт шалгалтын дүнг нэгтгэн гаргах процессыг автоматжуулах зэргээр ачааллыг багасгах боломжтой.

Цахим шийдлийг дараах түвшинд нэвтрүүлбэл ачаалал буурна:

- Нууцад хамааруулах саналыг цахимаар илгээх, хүлээн авах;
- Дүгнэлт боловсруулах стандарт загвар ашиглах;
- Хяналт шалгалтын тайланг цахим системд нэгтгэх;
- Жил бүрийн нэгдсэн дүнг автоматаар гаргах гэх мэт

Мэдээллийг хүргүүлэх байгууллагын тоог хамгийн багаар тогтоосон байна. Гэвч мэдээлэл нийлүүлэгч нь тухайн төрлийн мэдээллийг зохих дээд шатны байгууллагад хүргүүлдэг бол мэдээллийн сангаар дамжуулан дээд шатны байгууллагадаа хүргүүлэх боломжийг бүрдүүлж болох юм. Ингэснээр мэдээлэл нийлүүлэгч нэг мэдээллийг 2 өөр этгээдэд хүргүүлэхээр давхар зардал, цаг хугацаа зарцуулахгүй.

АШИГЛАСАН ЭХ СУРВАЛЖ

- Төрийн нууцын тухай (шинэчилсэн найруулга) хуулийн төсөл, 2026 он;
- Хууль тогтоомжийн тухай хууль, 2015 он;
- Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт;
- Монгол Улсын Засгийн Газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр;
- Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал”;
- “Засгийн газрын 2024 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 238 дугаар тогтоолын 2 дугаар хавсралт”, Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт;
- Засгийн газрын 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдрийн 213 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт.



ЭРХ ЗҮЙН МЭДЭЭЛЛИЙН
НЭГДСЭН СИСТЕМ

Нүүр > Төслийн жагсаалт > Санал өгөх

👤 НҮҮР 📄 ЭРХ ЗҮЙН АКТ 📅 МЭДЭЭ 📁 ХҮҮЛИЙН НЭР ТОМЬЁО 📁 БАЙГУУЛЛАГА 📊 ҮНДСЭН ХУҮЛЬ 📊 ТӨСӨЛД САНАЛ ӨГӨХ

ТӨСЛИЙН ДЭЛГЭРЭНГҮЙ

📌 Хариуцагч байгууллага

Хууль зүйн үндэсний хүрээлэн

📅 Нийтэлсэн огноо

2026-02-10 16:16:44

👁 Төслийн төлөв

Санал авч дууссан

📊 Нийт ирүүлсэн санал

0

📊 Дагасан тоо

0

📊 Үзсэн тоо

414

СОНИРХЛЫН БҮЛЭГ

☒ ИРГЭНИЙ БОЛОН АРИЛЖААНЫ ХАРИЛЦАА

☒ УЛСЫН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, БАТЛАН ХАМГААЛАХ

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

САНАЛ АВЧ ДУУСАХ ХУГАЦАА: 2026-02-25

ТАНИЛЦУУЛГА:

ХУВААЛЦАХ ЖИРГЭХ

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ/ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУҮЛЬ

2026 оны ... дугаар сарын ...-ны өдөр

Улаанбаатар хот

ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах үндэсний тогтолцоо, Хэвлэх

БУСАД ТӨСЛҮҮД

ГАЛТ ЗЭВСГИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

Дагасан: 0 Үзсэн: 199 Санал: 0

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ БАЙГУУЛЛАГЫН ТОГТОЛЦОО, ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

Дагасан: 0 Үзсэн: 259 Санал: 0

ГАЗРЫН ТУХАЙ ХУҮЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ

Дагасан: 8 Үзсэн: 3287 Санал: 24

ИРГЭНИЙ ХЭРЭГ ШҮҮХЭД ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУҮЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ

Дагасан: 0 Үзсэн: 166 Санал: 0

НИЙТИЙН ЗОРИУЛАЛТТАЙ ОРОН СУУЦНЫ БАЙШИГИЙН ДҮНДЭЙН ӨМЧЛӨЛИЙН ЭД ХӨРӨНГИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/

Дагасан: 2 Үзсэн: 933 Санал: 0



**ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН ЯАМ**

БИДНИЙ
ТУХАЙ

ҮЙЛ	ХАРЬАА
АЖИЛЛАГАА	БАЙГУУЛЛАГУУД

ХҮҮЛИЙН
ТӨСӨЛ ✓

ТӨРИЙН
ҮЙЛЧИЛГЭ

ИЛТОД
БАЙДАЛ ✓

ДАНС
ШИЛЭН

CCM 48 OF THE
COLOMBO PLAN ~

ОЛОН УЛСЫН
ХЭРЭГЖИЛТ

ЁС ЗҮЙН ДЭД
ХОРОО

ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХҮҮЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ, ТӨРИЙН НУУЦЫН
ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХҮҮЛИЙН ТӨСЛИЙН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛЛОО

Нийтлэгдсэн огноо: 2026-02-13

Монгол Улсын Ерөнхий сайдын 2026 оны 06 дугаар захирамжаар байгуулагдсан Ажлын хэсгээс Төрийн болон албааны нүүшын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нүүшын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хэлэлцүүлгийг өнөөдөр (2026.02.13) зохион байгууллаа.

Хэлэлцүүлгийг нээж Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд, Ажлын хэсгийн ахлагч Д.Мөнх-Эрдэнэ үг хэлж, төрийн үйл ажиллагааны ил тод байдла, иргэдийн мэдэх эрхийн баталгааг бодитой хангах шаардлагын хүрээнд дээрх хуулийн төслүүдийг Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр бэлтгэл ханган ажиллаж буйг онцлов.



ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСӨЛД ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁГ

2026.03.03

Д/д	Санал ирүүлсэн байгууллага	Ирүүлсэн санал	Саналыг тусгасан байдал
1.	Төрийн албаны зөвлөл 2025.12.16 01/2717	Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжин, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тусгах саналыг хавсралтаар хүргүүлж байна.	Дэмжсэн. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд ирүүлсэн саналыг тусгаагүй. Тухайн мэдээлэл нь Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцын шалгуурыг хангаж байх тул жагсаалтад хэвээр үлдээсэн.
2.	Монгол Улсын Ерөнхий аудитор С.Магнайсүрэн 2025.12.30 3632	Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл: Хуулийн төслийн 10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрхийн 10.1.5-д Төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах эрхийг Засгийн газарт дангаар хариуцуулахаар зохицуулсныг Улсын Их Хурал зөвшөөрснөөр Төрийн нууцыг шилжүүлэх талаар зохицуулалтыг нэмж тусгах. Тодруулбал, хуулийн төслийн 10.1.5-д "төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах" гэснийг "Улсын Их Хурал зөвшөөрснөөр төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах" гэж өөрчлөх;	Саналыг тусгаагүй. Засгийн газар уг шийдвэрийг гаргахдаа тагнуулын байгууллагын санал, дүгнэлтийг үндэслэх бөгөөд төрийн нууцад хамаарах тодорхой мэдээллийг шилжүүлэх талаар Улсын Их Хурал тухай бүр зөвшөөрөл олгох нь хуулийн хэрэгжихэд хүндрэл үүсгэх эрсдэлтэй тул одоогийн хуулийн зохицуулалтыг хэвээр үлдээсэн.
		Хуулийн төслийн 18.7-д "Төрийн нууцыг ил болгох журмыг Засгийн газар батална" гэж тусгасныг холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг харгалзах асуудлыг нэмж тусгахын зэрэгцээ "Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль" -ийн төслийн үзэл баримтлалтай хэрхэн нийцэхийг анхаарч үзэх;	Саналыг тусгаж, уг зохицуулалтыг төслөөс хассан.
		Хуулийн төслийн 25.1-д " ...25.3-т зааснаас бусад..." гэсэн нь тус эш татсан хэсэг хуулийн төсөлд тусгаагүй байх тул дахин нягтлах;	Саналыг тусгасан.
		Хуулийн төслийн 27.1.4-т " ...Төрийн нууцтай эрх олгосон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах..." гэснийг " ...Төрийн нууцтай танилцах эрх олгогдсон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах..." гэж найруулгын өөрчлөлт хийх.	Саналыг тусгасан.
		Дараах зохицуулалтыг нэмэлтээр тусгуулах саналтай байна. Үүнд:	
		Хуулийн төслийн 8.1.4-т " ...Төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргахад Засгийн газарт зөвшөөрөл олгох..." гэж,	Саналыг тусгаагүй. Өмнөх хуулийн зохицуулалтыг хэвээр хадгалах нь зүйтэй гэж үзсэн.

		Хуулийн төслийн 18.8-д “...15.1.1, 15.1.2, 15.1.3...” төрийн нууцад хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ил болгосон тохиолдолд ил тод мэдээлэх үүргийг төрийн нууцад хамааруулсан байгууллага хариуцах зохицуулалтыг нэмж тусгах. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл: Хуулийн төслийн “Ы/Онцгой байдлын салбар”-ын жагсаалтын 2-т “Улсын нөөцийн байршил, бодит хэмжээ, тэдгээрийн тайлан, мэдээ, санхүүжилттэй холбогдсон баримт бичиг” онц чухал нууцад хамаарч байгаа нь Төрийн аудитын байгууллагын орон нутгийн аудиторуудад аудит гүйцэтгэх явцад баримт бичигтэй танилцах эрх хэмжээ хүрэлцэхгүй болох нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна. Бусад асуудлын тухайд: 1.Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль болон Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн дагаж мөрдөх хугацааг уялдуулах нь зүйтэй байна. 2.Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн найруулгыг нягталж, нууцад хамааруулсан мэдээллийг ил болгохтой холбоотойгоор үүсэж болох хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлон, холбогдох зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна. Тусгайлан өгөх саналгүй болно.	Саналыг тусгаагүй. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд тухайн мэдээллийг төрийн нууцын “маш нууц” зэрэглэлд хамаарах байдлаар тусгасан. 1.Саналыг тусгасан. 2.Саналыг тусгасан.
3.	Харилцаа холбооны зохицуулах хороо 2025.12.25 01/2586		-
4.	Авлигатай тэмцэх газар 03/21642	1.Хуулийн төслийн 13.1.1-д болзошгүй эрсдэлийн үнэлгээг нэмэлтээр тусгах саналтай байна. Болзошгүй эрсдэлийн үнэлгээ гэдэгт дипломат төлөөлөгчийн газрын байрлаж байгаа улс оронд дайн үймээн, тахал, террорист халдлагын үед Монгол Улсын иргэдийг нүүлгэн шилжүүлэх, эмзэг, өндөр эрсдэлтэй мэдээлэл агуулж байгаа холбооны хэрэгсэл болон цахим системийн аюулгүй байдлыг хангах” нөхцөлийг тусгах; 2.Хуулийн төслийн 17.4-т “...нууцын зэрэглэлийн” гэсний дараа “дардсыг...” гэж засах;	1.Тухайн мэдээлэл нь Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцын шалгуурыг хангахгүй тул тусгаагүй. 2.Саналыг тусгасан.

		3.Хуулийн төслийн 18.1.2-т “нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас...” гэсэн нь хэт ерөнхий ойлголт байх тул ямар нөхцөл байдал үүссэн болохыг тодорхойлон оруулах; 4.Хуулийн төслийн 20.4-т “...шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их...” гэсний дараа “Хурал хүлээн зөвшөөрснөөр...” гэж өөрчлөх; 5.Хуулийн төслийн 20.5-д “...шүүгч, прокурор...” гэсний дараа “мөрдөгч” гэж өөрчлөх; 6.Хуулийн төслийн 30.2-т “...түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болно” гэснийг “...тусгай шуудан зөөгч биечлэн хүргэж өгөх, хүлээн авна” гэж өөрчлөх. Тусгайлсан саналгүй байна.	3.Саналыг тусгаагүй. 4.Саналыг тусгасан. 5.Саналыг тусгасан. 6.Саналыг тусгаагүй.
5.	Үндсэн хуулийн Цэцийн Тамгын газар 2025.12.22 ТГ-1/790		-
6.	Үндэсний статистикийн хороо 2025.12.30 01/924	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: 1.Хуулийн төслийн ҮҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 1-д “Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)” гэснийг хасах; Үндэслэл: Энэхүү мэдээллийн хүрээнд статистикийн байгууллагад баримт бичиг үүсэж хөтлөгддөггүй тул жагсаалтаас хасах саналтай байна. 2.Хуулийн төслийн ҮҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 2-т “Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүнгийн мэдээлэл” гэснийг “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн төрийн цэргийн байгууллагын бэлтгэл үүрэгтэн болон цэргийн мэргэжлийн ангиллын мэдээлэл” гэж өөрчлөх; Үндэслэл: Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн дагуу Хүн ам, өрхийн мэдээллийн санг хүн амын тооллого хоорондын хүн амын тоог хянах, анхан шатны нэгжээс эхлэн бүх шатанд хүн амын тоо мэдээг үнэн зөв тодорхойлох, хүн ам, өрхийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх.	1.Саналыг тусгаагүй. Тухайн мэдээлэл нь төрийн бодлогын хүрээнд хамаарах бөгөөд Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцын шалгуурыг хангаж байх тул жагсаалтад хэвээр үлдээсэн. 2.Саналыг тусгаагүй. Тухайн мэдээлэл нь төрийн бодлогын хүрээнд хамаарах бөгөөд Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцын шалгуурыг хангаж байх тул жагсаалтад хэвээр үлдээсэн.

	боловсронгүй болгох зорилгоор хөтөлдөг. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулах, хөтлөх ашиглахад баримтлах журмын дагуу баг, хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, өрхийн мэдээллийг тухай бүр хөтөлж, баяжуулж байна. Энэ хүрээнд иргэний цэргийн алба хаасан эсэх, ямар хэлбэрээр хаасан болон цэргийн мэргэжлийн ангиллыг бүртгэдэг. Уг мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.ё дахь хэсэг болон Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан "Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт"-д Батлан хамгаалах салбарын төрийн нууц мэдээлэлд оруулсан. Иймд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах эрсдэлтэй. Үндэсний статистикийн хорооны Хүн ам, өрхийн мэдээллийн санд төрийн цэргийн байгууллагын бэлтгэл үүрэгтэн болон цэргийн мэргэжлийн ангиллын мэдээллийг бүртгэж байгаа тул дээрх томъёоллоор өөрчлөх саналтай байна. 3.Хуулийн төслийн УҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 3-т "Төрийн нууцыг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл" гэсний "Төрийн нууцыг" гэдгийг "Төрийн нууц тээгчийг..." гэж өөрчлөх; Үндэслэл: Хуулийн төсөлд тусгасан бусад бүх салбарын хэмжээний төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтад "Төрийн нууц тээгчийн хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл" гэж туссан байх тул "төрийн нууц тээгч" гэсэн Төрийн нууцын тухай хуулийн төслийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан нэр томъёоны дагуу болгох нь зүйтэй гэсэн саналтай байна. 4.Хуулийн төслийн УҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсэгт "Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилтын тухай мэдээлэл" гэж нэмэх; Үндэслэл: Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.в дэх заалтын хүрээнд Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн сагсны бараа, үйлчилгээний жин, анхан шатны тооцооллыг хийж байна. Хэрэглээний сагсны бараа, үйлчилгээний жин гэдэг нь өрхийн хэрэглээний сагсанд багтаж буй тухайн бараа, үйлчилгээг худалдаж авах зардал нь өрхийн нийт зардлын хэдэн хувийг эзэлж байгааг дунджаар харуулдаг үзүүлэлт юм. Тухайн бүтээгдэхүүний зардал нь өрхийн нийт зардалд их хэмжээг эзлэх тусам хэрэглээний жин их байна. Ингэснээр инфляц буюу	3.Саналыг тусгасан. 4.Саналыг тусгасан.
--	--	---

	хэрэглээний үнийн индексэд жин өндөртэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн нөлөө харьцангуй өндөр байдаг. Монгол Улсын хувьд өрхийн хэрэглээний зардалд хүнсний бүтээгдэхүүн 26.7 хувийг эзэлдэг бөгөөд үүнд мах, гурил, будаа, сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн жин дангаараа 19.6 хувийг эзэлдэг. Эдгээр бүлэгт хамаарагдах мах, сүү, гурил нь стратегийн хүнсний бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх замаар инфляцад нөлөөлөх эрсдэлтэй. Мөн Үндэсний статистикийн хорооноос үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилтыг хийх хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд хөтлөгдөх тул жагсаалтад нэмэх саналтай байна.	хэрэглээний үнийн индексэд жин өндөртэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн нөлөө харьцангуй өндөр байдаг. Монгол Улсын хувьд өрхийн хэрэглээний зардалд хүнсний бүтээгдэхүүн 26.7 хувийг эзэлдэг бөгөөд үүнд мах, гурил, будаа, сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн жин дангаараа 19.6 хувийг эзэлдэг. Эдгээр бүлэгт хамаарагдах мах, сүү, гурил нь стратегийн хүнсний бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх замаар инфляцад нөлөөлөх эрсдэлтэй. Мөн Үндэсний статистикийн хорооноос үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилтыг хийх хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд хөтлөгдөх тул жагсаалтад нэмэх саналтай байна.
7. Хүний эрхийн үндэсний комисс 2025.12.31 01/2436	Танайхаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/3500 дугаартай албан бичгээр ирүүлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалтай танилцлаа. Дээрх хуулийн төсөл, үзэл баримтлалд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах зорилгоор төрийн нууцыг Засгийн газрын шийдвэрээр тогтоож байгаа практикийг өөрчлөн хуулиар тогтоож, “албаны нууц”-тай холбоотой зохицуулалтыг хассан нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээнд заасан зарчимд нийцэх дэвшил болсныг сайшаан тэмдэглэж, дараах саналуудыг хүргүүлж байна. Нэг.Төрийн нууцын тухай хуулийн төсөлд: 1.Мэдээллийг төрийн нууцад авахад баримтлах шалгуур үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагааг журамлан хуульчлах, ингэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын нийтлэг зарчим, хүний эрхийн олон улсын гэрээнд заасан хүний мэдэх эрх, мэдээлэлтэй байх эрхийг хангах, хамгаалах болон хязгаарлахад баримтлах шаардлагуудад нийцүүлэх. Түүнчлэн, төрийн нууцад хамааруулж болохгүй мэдээллийг тусгайлан зааж, мэдээллийг хууль бусаар төрийн нууцад авахыг хориглосон хэм хэмжээг тусгах. Үндэслэл, шаардлага: Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн хорооноос гаргасан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл буюу Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх 34 дүгээр Ерөнхий тайлбар, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын 13 дугаар зүйл, “19 дүгээр зүйл” Олон	1.Саналыг агуулгын хувьд тусгасан. Төрийн нууцад хамаарах мэдээллийг нууцлах арга хэмжээ, мэдээллийн нууцын зэрэглэл, түүний шалгуурыг тодорхойлсон. Тухайлбал, Төрийн нууц нь “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц”-ын зэрэглэлтэй байх бөгөөд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд: -Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдалд аюул, занал учруулах, үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох, хүний амь биед аюул учруулах мэдээлэл-“онц чухал нууц” зэрэглэлд; -Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, батлан хамгаалах чадавхыг сулруулах мэдээлэл-“маш нууц” зэрэглэлд;

улсын хүний эрхийн байгууллагын Мэдэх эрхийг хангах хууль тогтоомжийн 9 үндсэн зарчим, “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” Тшванийн зарчим зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд мэдэх эрхийг хангаж, хэрэгжүүлэхдээ нийтийн эрх ашгийг ямагт чухалчлах, зөвхөн нийтийн эрх ашигт нийцэх үндэслэл буй нөхцөлд иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах, ингэхдээ зайлшгүй шаардлагатай бөгөөд тохирсон хязгаарлалт тавих, харин мэдээллийн нийтийн ашиг сонирхлыг хангах ач тус нь ил болгосноор учрах хор хохирлыг давахуйц байгаа тохиолдолд мэдээллийг нээлттэй болгох зэрэг нийтийн эрх ашгийг шалгуур болгосон үндсэн зарчмуудыг тусгасан байна.

Тухайлбал, төрийн байгууллага, түүний албан тушаалтан нь 1) тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой байх, 2) тухайн мэдээллийг ил болгох, өгөх нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, 3) тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх тохиолдолд мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байж болно. Ингэхдээ эхний гурван хэсэгт заасан үнэлгээгээр мэдээллийг нууцлах, өгөхгүй байх нөхцөл бүрдсэн ч, тэр нь төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах шинжтэй бол мэдээллийг нууцалж болохгүй талаарх шалгууруудыг тогтоожээ.

Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас 2024 онд зарласан Авлигын төсөөллийн индексийн үр дүнгээр Монгол Улс 180 орноос 121 дүгээрт жагсаж, өмнөх орноос 3 байр ухарсан бөгөөд тус-тайланд Монгол Улсын авлигын индексийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс нь “иргэдийн мэдэх эрхийг хангах, төрийн анхан шатны мэдээлэл хангалтгүй байгаа” гэдгийг тодорхойлжээ. Түүнчлэн, “Дэлхийн мэдээллийн эрх чөлөөний рейтинг”-ээр Монгол Улс нийт судалгаанд хамрагдсан 140 улс орнуудын рейтингээр 2022 онд 64-т, 2023, 2024 оны байдлаар нийт 150 орноос 87 орноо авч 67 дугаар байранд эрэмбэлэгджээ. Энэ нь мэдээлэлд хандах эрхийг хангах, мэдээллийн хүртээмжийг баталгаажуулах чиглэлээр хууль тогтоомжоо шинэчлэх шаардлагатай орнуудын нэг болохыг илэрхийлж байна.

2.Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэдээллийн нууцын зэрэглэлийг ялгамжтай байдлаар тогтооход баримтлахаар тусгасан “...онц хүнд үр дагавар бий болгох”, “...хүнд үр дагавар бий болгох”, “...хохирол учруулах” гэсэн нэр томьёо тус бүрийн

-үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаанд хохирол учруулах, маш нууц, онц чухал нууц зэрэглэлд хамаарах мэдээллийг задруулах нөхцөл бий болгох мэдээллийг “нууц” зэрэглэлд тус тус хамааруулахаар заасан.

Төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтыг хуулиар тогтоох бөгөөд уг жагсаалтад ороогүй мэдээлэл нь ил тод, нээлттэй байхаар зохицуулсан.

2.Саналыг тусгаагүй. Хууль хэрэглээ, шүүхийн практикт тогтсон ойлголт бөгөөд нэр томьёоны тодорхойлолтод нэг бүрчлэн зааж оруулах шаардлагагүй гэж үзсэн.

	бусдаасаа ялгагдах зааг, хэмжээ, хүрээ, шалгуурын тайлбар, хэрхэн ойлгож хэрэглэх талаар хуулийн төслийн нэр томъёоны тодорхойлолтод нэмж тусгах; Үндэслэл, шаардлага: Мэдээлэлд нууцын зэрэглэл тогтооход эдгээр нэр томъёо тус бүрд ямар хүрээ, хэмжээ, шалгуурыг баримталж нууцын зэрэглэлийг бусдаас нь ялгамжтай тогтоох, бусад хуультай нийцүүлж хэрэглэх эсэх талаарх хуулийн зохицуулалт, тайлбар байхгүйгээс хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл учрах, мэдээллийг өргөн хүрээнд нууцлах, хамааралгүй мэдээллийг нууцлах зэргээр мэдээллийн нууцлалд “субъектив” хандлага үүсгэх, хүний мэдэх эрх зөрчигдөх нөхцөл гарахад нөлөөлөхөөр байна. 3.Мэдээллийг хууль бусаар төрийн нууцад хамааруулсан, эсхүл мэдээлэл гаргаж өгөхөөс хуулийн үндэслэлгүй татгалзсан тохиолдолд иргэдийн гомдол гаргах, шийдвэрлэх механизмыг болон хараат бус шүүхээр хянагддаг зохицуулалтыг тусгах. Үндэслэл, шаардлага: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийг тайлбарласан Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр Ерөнхий тайлбарын 19-т “Мэдээлэл өгөхөөс татгалзсан шийдвэр, мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөөгүй тохиолдлыг хянан шийдвэрлэх механизм бий болговол зохино” гэж заасан нь төрийн байгууллага, Оролцогч улс хүлээн зөвшөөрч, хүндэтгэн хандвал зохино” гэж зөвлөмж болгосон байна. Мөн 2004 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Нэгдсэн Үндэстний байгууллагын үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх Төлөөлөгч, Америкийн орнуудын байгууллагын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын гаргасан Хамтарсан тунхаглалд “Төрийн нууцыг хамгаалах үүргийг зөвхөн түүнийг хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан хүлээнэ. Сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгч зэрэг бусад этгээдийн хувьд мэдээллийг нийтэлсэн, түгээсний төлөө хууль зүйн хариуцлага хүлээх ёсгүй. Төрийн нууц хариуцсан этгээд түүнийг түгээсний төлөө хариуцлага хүлээх нөхцөлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт тусгах ёстой” гэсэн байна. Хоёр.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд:
	3.Саналыг агуулгын хувьд тусгасан. Мэдээллийг үндэслэлгүйгээр нууцалсан асуудлыг тагнуулын байгууллагын хяналт шалгалтаар тогтоож, хуульд заасны дагуу сахилгын шийтгэл оногдуулах, эсхүл Зөрчлийн тухай хуулиар хариуцлага хүлээлгэхээр зохицуулсан.

	1.Төрийн нууцын жагсаалтад оруулахаар тусгасан мэдээлэлд Төрийн нууцын тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцын хүрээ болон хүний эрхийн олон улсын зарчим, иргэний мэдээлэлтэй байх эрхийг хангах болон хязгаарлах шалгуурыг баримтлан нарийвчлан үнэлгээ хийж, дахин боловсруулах. Үндэслэл, шаардлага: Тус хуулийн төслийн үзэл баримтлалд “...салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад хуульд заасан, төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй мэдээллүүд багтсан. “...нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна” гэсэн боловч Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тусгагдсан бүх мэдээллийг ямар нэгэн шалгуураар үнэлгээ хийлгүй хуулийн төсөлд тусгасан байна. “Нууцалбал зохих мэдээлэл” гэдгийг хэрхэн тогтоох шалгуур, үндэслэл, хүрээг нарийвчлан тодорхойлж, нууцлах, ил болгох ажиллагаа, үйл явцыг журамлан хуульчлаагүйгээс шалтгаалан шаардлагагүй олон төрлийн мэдээллийг төрийн нууцын жагсаалтад орох нөхцөл бүрдэж байна. Тухайлбал, “Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны нууцалбал зохих хэсэг” гэсэн мэдээлэл ил байснаар үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах нөхцөл тогтоогдохгүй байна. Үүнтэй холбоотой мэдээлэл төрийн байгууллага болон хэвлэл мэдээллийн цахим хуудаст нээлттэй байгаа бөгөөд үүнийг төрийн нууцыг задрүүлсан гэж үзэж буй талаарх мэдээлэл гараагүй талаар зарим судалгаанд тэмдэглэсэн байна. Мэдээллийг хэт өргөн хүрээнд нууцлах нь хүний эрхийн үүднээс үндэслэлгүй, үр нөлөөгүй бөгөөд иргэдийн мэдэх эрхэд халдсан явдал болдог. Иймээс хүний эрхийн зарчмын үүднээс бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах зорилгод нийцүүлж, тодорхой үндэслэл, шалгуураар үнэлгээ хийсний үндсэн дээр мэдээллийг нууцлах нь оновчтой.	1.Саналыг хүлээн авч Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг боловсруулсан.
--	---	--

	2.Төрийн нууцад хамаарах мэдээллийг нийтлэг агуулгаар нь нэгтгэн улсын хэмжээнд нэг мөр тогтоох, зөвхөн тухайн байгууллага, салбарт хамаарах тусгайлсан төрийн нууцыг тусад нь ялгах байдлаар мэдээллийн давхцал, хийдлийг арилгаж, боловсруулалтыг сайжруулах. Үндэслэл, шаардлага: Нууцын жагсаалтад 33 байгууллага, салбарын 574 мэдээллийг төрийн нууцад хамаарахаар тусгагдсан бөгөөд эдгээр нь давхцал ихтэй, логик уялдаагүйгээс үүдэн төрийн нууцын тухай ойлголт тодорхой бус болсон байна. Тухайлбал, “Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)” нийт 30 удаа, “Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл” нийт 28 удаа, “Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг” нийт 27 удаа, “Төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг” нийт 21 удаа, “Төрийн нууцад хамаарах асуудлаар олон улсын хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж, илтгэх хуудас, танилцуулга” нийт 11 удаа давтагдсан байна. Үүнээс гадна хоёроос дээш, 10-с доош давтагдсан нийт 24 мэдээлэл байгаа талаар зарим судалгаанд тусгасныг харгалзан үзэх шаардлагатай байна.	2.Саналыг хүлээн авч, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд тусгасан.
	3.Хуулийн төсөлд “2010 оноос өмнө цаазаар авах ял гүйцэтгэсэн тухай баримт бичиг, мэдээлэл”-ийг байнга хадгалах, онц чухал нууцад хамруулсныг нягтлан үзэх шаардлагатай байна. Үндэслэл, шаардлага: Цаазаар авахуулсан хүний талаарх мэдээллийг түүний гэр бүлийн гишүүдээс нууцлах нь хүнлэг бус бөгөөд энэрэнгүй ёсны зарчимд нийцэхгүй юм. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын хоёрдугаар тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан “цаазаар авахуулсан хүмүүсийн гэр бүлд цаазаар авсан тухай мэдээллийг ил болгож өгөх”, “Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууц мэдээллээс гаргах” тухай зөвлөмж өгснийг Монгол Улс хүлээн авсан боловч одоо болтол биелүүлээгүй байгааг анхаарах шаардлагатай байна.	3.Тухайн мэдээлэл нь Төрийн нууцын тухай хуулийн төслийн төрийн нууцын “онц чухал нууц” зэрэглэлийн шалгуурыг хангаж байх тул саналыг тусгаагүй.
	4.Хуулийн төсөлд төрийн нууцыг 3 зэрэглэлтэй байхаар тусгасан боловч нууцын жагсаалтад орсон мэдээллийн нууцын	4.Саналыг тусгасан.

	зэрэглэлийг зөвхөн “онц чухал нууц”, “маш нууц” гэж тогтоож, “нууц” гэсэн зэрэглэлд мэдээлэл хамруулаагүй байгааг анхаарч, тодорхой шалгуур, үндэслэлээр нягтлан үзэж, нууцын зэрэглэлийг дахин тогтоох. Үндэслэл, шаардлага: Энэхүү хуулийн төсөлд төрийн нууцыг 3 зэрэглэлтэй байхаар хуульчилж байгаа тул хор хохирол багатай буюу хуулийн төслийн 15.5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан мэдээлэлд “нууц” зэрэглэл тогтоох нь зүйтэй байна. Түүнчлэн, нууцын зэрэглэлийг бодитой тогтоож өгөөгүйгээс шаардлагагүй мэдээллийг төрийн нууцад авах, илүү зэрэглэл тогтоосноос нууцлах хугацаа урт болж иргэдийн мэдэх эрх зөрчигдөх, улмаар уг мэдээллийг үрэгдүүлсэн, задруулсан тохиолдолд хүнд ял, шийтгэл хүлээх эрсдэл үүсэхээр байгааг анхаарах. Тухайлбал, Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйл (Төрийн нууцыг задруулах), 19.13 дугаар зүйл (Төрийн нууцыг үрэгдүүлэх)-д төрийн “маш нууц”, “онц чухал нууц” мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд “нууц” мэдээллийг задруулснаас илүү хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна. 5.Хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангаж тэдгээрийн санал, зөвлөмжийг тусган боловсруулах нь зүйтэй байна. Үндэслэл, шаардлага: “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” Тшванийн зарчимд зааснаар мэдээлэл авах эрх нь төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих боломжийг олгох төдийгүй төрийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог дэмжиж, ардчилал, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын салшгүй хэсэг болдог. Мөн мэдээллийг ил болгох, нууцлан хадгалах тэнцвэрийг зөв тогтоох, энэхүү үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог хангаж, тэдгээрийн санал, зөвлөмжийг харгалзан үзэх нь ардчилсан нийгмийн амин чухал зүйл гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна. Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын 10 дугаар зүйлд авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж зохих тохиолдолд оролцогч улс бүр төрийн захиргаандаа, үүнд зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явцыг	5.Засгийн газрын Хэрэг эрхлэх газар, Хууль зүй, дотоод хэргийн яам, Тагнуулын ерөнхий газар хамтран Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу хуулийн төслийн олон нийтийн хэлэлцүүлгийг 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдөр зохион байгуулсан бөгөөд уг хэлэлцүүлэгт яамд, Засгийн газрын агентлагийн асуудал хариуцсан нийт 50 гаруй албан хаагчид оролцсон. Түүнчлэн, хуулийн төслийг Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын (cabinet.gov.mn) цахим хуудас болон эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем (legalinfo.mn)-д тус тус байршуулж санал авсан.
--	--	--

	оролцуулан, ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна гэж заасан. Мөн тус конвенцын 13 дугаар зүйлд улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бүлэгт түшиглэсэн байгууллага зэрэг төрийн албанаас гаднах бүлгийн идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих талаар тусгасан ба үүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь “шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог дэмжих, олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах” гэж тусгасан. Хуулийн төслийг боловсруулахад иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн санал, зөвлөмжийг авах нь иргэний мэдэх эрхийг хангах, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын хүний эрхийн зарчимд нийцүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой. Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба нь Зөвлөлийн хуулиар олгогдсон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа мэдээллээр хангах, үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийн нэгдсэн санг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцах чиг үүргийг хэрэгжүүлж байна. Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3-т “Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна”, мөн зүйлийн 4-т “Зөвлөлийн Ажлын алба нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй байна” гэж заасан хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн санг энэ хуулиар төрийн нууцад хамааруулах нь зүйтэй байна. Мөн уг хуулийн төслийн 5.1.2-т “төрийн нууц тээгч” гэж төрийн нууцын бичвэр, тэмдэг, дүрс, дохио, техникийн шийдэл, үйл ажиллагааны хэлбэрээр агуулж байгаа материаллаг зүйлийг” гэж заасны дагуу “төрийн нууц тээгч”-ийг Зөвлөлийн ажлын албаны бие бүрэлдэхүүн албаны чиг үүрэгт байнгын тогтмол ашигладаг болно.	Саналыг тусгасан.
8.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Нарийн бичгийн дарга А.Бямбажаргал 2026.01.22 4/25	

		Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлан чиг үүрэгтэй байгууллагуудаас буюу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас Зөвлөлийн Ажлын албаны бие бүрэлдэхүүний дийлэнх олонх буюу 80 хувь нь Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд томилогдож, албан үүрэг гүйцэтгэдэг болно. Дээр дурдсан болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, шаардлагыг ханган ажиллахад Зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, зохион байгуулалт, төсвийн хүрээний мэдээллийг төрийн нууцад хамааруулах зайлшгүй шаардлага үүсэж байна. Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг боловсруулж, хавсралтаар хүргүүлж байна.
9.	Монгол Улсын Дээд шүүх 2026.01.15 01/169	Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан “Төрийн нууцын тухай” болон “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулийн төслийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу хэлэлцэв. Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хэрэгцээ, шаардлагын талаар хэлэлцээд хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ. Нэг.Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг “11.1.1. эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг баталж мөрдүүлэх” гэж өөрчлөн найруулах. Үндэслэл: Төрийн байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг батлан мөрдүүлэх шаардлага бий. Тухайлбал: Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэх, илгээх, бүртгэх, устгах, бүрэн

Нэг.Саналыг тусгасан.

	бүтэн байдлыг хангах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг энэ хууль болон Засгийн газрын баталсан төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна. Мөн хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах асуудлыг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна” гэж заажээ. Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх шатанд тухайн хэргийг хүргүүлэх, хүлээн авах, бүртгэх, хуваарилах, шаардлагатай тохиолдолд хуулийн төслийн 25 дугаар зүйлд заасны дагуу хэргийн оролцогчийг аюулгүй байдлын шалгалтад оруулах, оролцогчдод хэргийн материал танилцуулах, хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх, шүүхийн шийдвэрийн холбогдох хэсгийг нууцлах, шүүхийн шийдвэрийг оролцогчдод танилцуулах, гардуулах, хүргүүлэх, нийтлэх, хадгалах зэрэг ажиллагааг хуулиар нарийвчлан зохицуулах, эсхүл хуулиар эрх олгосны дагуу байгууллагын баталсан журмаар тусгайлан зохицуулах шаардлага бий. Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1.5-д заасны дагуу холбогдох стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх бүрэн эрхийн хүрээнд “Хэргийн хөдөлгөөний стандарт”-аас гадна 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын шүүхийн төрийн болон албаны нууцыг хамгаалах” журмыг батлан мөрдүүлж буй хэдий ч энэ талаар хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй байна. Иймд Төрийн нууцтай холбоотой хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд баримтлах нарийвчилсан журмыг Төрийн нууцын тухай, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны хуулиудаар тусгайлан зохицуулах, эсхүл хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд холбогдох байгууллага (Засгийн газар, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тамгын газар) өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан Төрийн нууцын тухай хуульд заасан нийтлэг шаардлагад нийцүүлэн баталж мөрдүүлэхийг хуульчлах шаардлагатай. Хоёр.Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан “12.1.4. байгууллага, албан тушаалтан төрийн нууцаа хамгаалах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн
--	--

Хоёр.Тэгнүүлэн байгууллага хуулиар хүлээсэн чиг үүргийнхээ хүрээнд төрийн болон албаны нууцын хамгаалалтад хяналт

	заалтад “... эрх бүхий байгууллага, албан тушаалтан даалгасны дагуу дүгнэлт гаргах” гэсэн заалтыг нэмж тусгах. Үндэслэл: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид ЭХХШТХ гэх) 22.3.4-т “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд төрийн нууцыг хамгаалах зорилгоор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хязгаарлаж болно”, 31.3.1-т “...Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна”, 32.10.9-т Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө”, 36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “...төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө” гэж тус тус заасан. ЭХХШТХ-ийн дээрх заалтыг хэрэгжүүлэхийн тулд мөрдөгч, прокурор, шүүх нь Төрийн нууцын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасны дагуу Тагнуулын байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авахаас гадна тодорхой хэрэгт шүүхийн шийдвэрийн төрийн нууц агуулсан хэсгийг нууцлах асуудлаар дүгнэлт, эсхүл зөвлөмж гаргуулах шаардлага үүсч болно. Хуулийн хэрэгжилтээс үзэхэд, төрийн нууц мэдээлэл агуулсан хэргийг хянан шийдвэрлэсэн зарим шүүх төрийн нууцыг задруулах эрсдэлээс сэргийлж шийдвэрээ бүхэлд нь нууцалж, тухайн шийдвэрийг оролцогчид гардуулж өгөхгүйгээр танилцуулах явдал байсаар байна. Ийнхүү шүүхийн шийдвэрийг бүхэлд нь нууцлах нь тухайн шийдвэрийг оролцогчид гардуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх зэрэг ажиллагаанд тодорхой хүндрэлийг дагуулж байна. Иймд энэ талаар Тагнуулын байгууллагаас бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхээс гадна тухайн байгууллага, албан тушаалтан даалгасан тохиолдолд төрийн нууц мэдээлэл агуулсан шийдвэрийн аль хэсгийг нууцлах шаардлагатай талаар дүгнэлт гаргах заалтыг нэмж тусгах нь хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, төрийн нууцыг хамгаалахад чухал ач холбогдолтой гэж үзэв.	тавьж, мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэн ажилладаг тул уг саналыг хуульд давхардуулан тусгах шаардлагагүй. Түүнчлэн, саналд дурдсан асуудлаар тагнуулын байгууллагаас Шүүх шинжилгээний тухай хуулийн 8.4-т заасны дагуу Хууль зүй, дотоод хэргийн сайдын баталсан журмын хүрээнд “шинжээчийн дүгнэлт” гарган ажиллаж байгаа болно.
--	--	---

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан даалгасны дагуу Тагнуулын байгууллагаас гаргасан дүгнэлт нь заавал дагаж мөрдөх императив шинжийг агуулахгүй, харин холбогдох байгууллага, албан тушаалтанд төрийн нууцаа хамгаалах ажилд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх эрхийг баталгаажуулж буй явдал юм.

Гурав.Шүүхээр хянан шийдвэрлэсэн төрийн нууц мэдээлэл агуулсан хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагааг ЭХХШТХ болон Гүйцэтгэх ажлын тухай хуульд заасан журмыг зөрчиж явуулснаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн эрх ашиг ноцтой зөрчигдсөн болох нь тогтоогдвол шүүх төрийн нууцад хамааруулсан холбогдох мэдээллийг шүүхийн шийдвэрээр олон нийтэд ил болгох асуудлыг Төрийн нууцын тухай хуулийн төслийн 18 дугаар зүйл (Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам)-д тусгайлан заах саналтай байна.

Дөрөв.Төслийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч зөвхөн шалгаж шийдвэрлэх тодорхой хэрэг, маргаанд хамаарах төрийн нууцтай хуулиар тогтоосон журмын дагуу танилцана” гэсэн заалтад шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн нууцын ажилтан зэрэг шүүхийн захиргааны ажилтнуудаас гадна шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу томилогдон оролцох иргэдийн төлөөлөгчийг нэмж тусгах.

Үндэслэл: Төрийн нууц мэдээлэл агуулсан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчээс гадна шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, нууцын ажилтан зэрэг шүүхийн захиргааны ажилтнуудаас гадна иргэдийн төлөөлөгч зайлшгүй оролцдог тул тэдгээр нь хуулиар тогтоосон журмын дагуу танилцах эрхтэй байх шаардлагатай.

Гурав.Төрийн нууцыг ил болгох, нууцлах асуудал нь Улсын Их Хурлын онцгой бүрэн эрхэд хамаарахаар төсөлд тусгасан.

Мөрдөн шалгах нууц ажиллагааны явцад хүний эрх зөрчигдсөн эсэхэд хяналт тавьж, хариуцлага тооцох чиг үүрэг нь хуулиараа (ЭХХШТХ 26.9) зөвхөн прокурорт хадгалагддаг. Шүүх мэдээллийг ил болгосноор тухайн хүний эрхийг сэргээж болох ч, нөгөө талдаа үндэсний аюулгүй байдал болон улсын язгуур ашиг сонирхолд хохирол учруулах аюултай.

Шүүх заавал нууцыг “ил болгохгүйгээр” тухайн баримтыг хууль ёсны дагуу цугларсан эсэхийг хянах бүрэн боломжтой. Хэрэв хууль бус бол “нотлох баримтаар тооцохгүй байх” замаар хүний эрхийг хамгаалж болно.

Хуульд заасан “нууц байна” гэдэг ойлголт нь хэргийн оролцогчид (шүүх, өмгөөлөгч, шүүгдэгч) мэдээлэлтэй танилцахаас сэргийлсэн хэрэг биш, харин хөндлөнгийн этгээдээс нууцлах агуулгатай юм.

Дөрөв.Шүүгчийн туслах, нарийн бичгийн дарга нар нь хэрэг хянан шийдвэрлэх эрх бүхий субъект биш, зөвхөн ажил үүргийн хүрээнд нууцтай танилцдаг бөгөөд хуулийн төслийн 20.5-д заасан “тусгай субъект”-д (шүүгч, прокурор г.м) нэмэх шаардлагагүй.

Харин 19 дүгээр зүйлд заасан ерөнхий журмын дагуу (тагнуулын байгууллагын шалгалт, албан тушаалтны жагсаалтад үндэслэн) эрх олгох бүрэн боломжтой.

Иргэдийн төлөөлөгчийн эрх зүйн байдал, нууц хадгалах үүрэг нь Үндсэн хууль болон Шүүхийн тухай хуулиар хэдийн тодорхойлогдсон байдаг. Хэрэв иргэдийн төлөөлөгч төрийн нууцтай танилцах шаардлага тулгарвал хуулийн төслийн 21 дүгээр зүйлд заасан “иргэнд төрийн нууцтай танилцах эрх олгох” шаардлагыг хангуулах замаар шийдвэрлэх боломжтой.

	Тав.Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж, 13.1.5.ё дахь заалтад “төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт “эрүүгийн хэрэгт хамтран ажиллах этгээдээр тогтоогдсон хүн” гэж тус тус нэмэлт оруулах эсэхийг хууль санаачлагч анхаарах нь зүйтэй. Үндэслэл: ЭХХШТХ-ийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Прокурор, мөрдөгч нь мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах шийдвэр, түүний үр дүнг хавтаст хэрэгт хавсаргахад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтална”, 36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “...төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө” гэж тус тус заасан. Иймд, Эрүүгийн хэрэгт прокурорын зөвшөөрлөөр хийгдэх мөрдөн шалгах нууц ажиллагаа, мөн эрүүгийн хэрэгт хамтран ажиллах этгээдээр тогтоогдсон хүнтэй холбоотой мэдээлэл, мөн прокурор болон шүүхийн шийдвэрийн төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг Төрийн нууцын тухай хууль болон Төрийн нууцын жагсаалтад тусгах, эсхүл эдгээр нь Төрийн нууцын тухай хуулийн 13.1.4.д, 13.1.5.ё, 16.4 дүгээр зүйлд заасан ойлголтод хамаарах эсэх талаар хуулийн төслийг эцэслэн боловсруулахдаа анхаарахыг зөвлөж, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох саналаа үүгээр уламжилж байна.	Тав.Хуулийн төслийн 13.1.5.ё заалт нь хэрэг хянан шийдвэрлэх явцад үүссэн төрийн нууцад хамаарах бүх баримт бичгийг (шүүхийн шийдвэр, прокурор, мөрдөгчийн шийдвэр г.м) багтаасан. ЭХХШТХ-д “хэргийн оролцогчид нотлох баримтыг гардуулахдаа нууцад хамаарах хэсгийг уншигдахгүйгээр нууцалж өгөх” талаарх зохицуулалтыг оруулахаар төсөл боловсруулсан. Одоо мөрдөгдөж байгаа ЭХХШТХ-ийн 36.13-т шүүхийн шийдвэрийн нууцад хамаарах хэсгийг нууцалж гардуулах зохицуулалт байгаа тул шинээр нэмэх шаардлагагүй. Хуулийн төслийн 13.1.5.ё заалтын дагуу төрийн нууцтай холбоотой хэрэгт оролцож буй “хамтран ажиллах этгээд”-ийн мэдээлэл нь өөрөө төрийн нууцад шууд хамаарна. ЭХХШТХ-ийн 13.6-д хамтран ажиллах этгээдийн мэдээллийг хавтаст хэргээс тусад нь битүүмжлэн хадгалахаар тодорхой заасан.
10. Санхүүгийн зохицуулах хороо 2026.01.08 1/54	Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн байгууллагын албаны нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор боловсруулж буй дээрх хуулийн төслийг тус Хороо зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг хүргүүлж байна. 1.Төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах, түүний нууцлал, аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллага, бусад хуулийн этгээд төрийн нууц мэдээллийг тус санд бүртгүүлэхтэй холбоотой харилцааг хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, зохицуулж өгөх; 2.Хуулийн төслийн 18.4 дэх хэсгийн “ил болгох,” гэсний дараа “нууцын зэрэглэл өөрчлөх,” гэж нэмэх;	1.Мэдээллийн нэгдсэн сангийн үйл ажиллагаа, аюулгүй байдлыг хангахтай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Засгийн газраас баталсан журмаар зохицуулахаар тусгасан. 2.Саналыг тусгасан.

		Төрийн нууцын тухай хуулийн төслийн 18.4 дэх хэсгээр төрийн нууцыг ил болгох, хугацааг сунгах харилцааг зохицуулсан байх бөгөөд нууцын зэрэглэл өөрчлөх асуудлыг орхигдуулсан байх тул үүнийг нэмэх; 3.Хуулийн төслийн 20.6 дахь хэсгийн “Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын” гэснийг “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын” гэж өөрчлөх; 4.Хуулийн төслийн 25.1 дэх хэсэгт заасан “25.3” гэсэн заалт байхгүйг анхаарах.	3.Саналыг тусгасан. 4.Саналыг тусгаж, зассан.
11.	Монголбанк 2026.01.13 А-1/14	Төрийн байгууллагын “албаны нууц”-ыг дээрх хуулийн төслөөр хүчингүй болгосноор төрийн нууцад хамаарахгүй боловч задруулах, үрэгдүүлэх тохиолдолд банк, санхүүгийн салбарын нийтлэг ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, Монголбанкны эмзэг мэдээлэл (мөнгөний бодлогын шинжилгээний загварын код, гадаад валютын албан нөөцийн бүтэц зэрэг)-ийн аюулгүй байдлыг Байгууллагын нууцын тухай хуулиар хангах боломжгүй хууль зүйн эрсдэл үүсэж байна. Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд банк, санхүүгийн салбарт хамаарах төрийн нууц мэдээлэлд тагнуулын болон гүйцэтгэх ажил эрхлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагааг халхавчлах мэдээлэл зэрэг салбарт шууд хамааралгүй мэдээлэл туссан байгааг тус хуулийн холбогдох бусад хэсэгт шилжүүлэх саналтай байна. Иймд хуулийн зохицуулалтыг цогцоор нь бүрдүүлэх зорилгоор хуулийн төсөл санаачлагчийн зүгээс хуулийн төслийн хэлэлцүүлгийг эрх ашиг хөндөгдөж буй байгууллагатай зохион байгуулж, үүсэж болох асуудлыг шийдвэрлэх саналыг гүйцэд боловсруулсны дараа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх саналыг үүгээр уламжилж байна.	Саналыг тусгаагүй. Төрийн нууцын тухай хуулийн төрийн нууцын шалгуурыг хангахгүй. Санал тусгасан.
12.	Улсын ерөнхий прокурорын газар 2026.01.06 Ц-02/73	Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан, Зөрчлийн тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасан “шаардлагатай тохиолдолд бусад хуульд болон хүчингүй болсонд хууль оруулах нэмэлт, өөрчлөлт тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна” гэсний дагуу шинээр боловсруулах; Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд нэг агуулгатай заалтыг харьяалах байгууллага бүрт давхардуулан	Саналыг тусгаж, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслүүдийг боловсруулсан. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн хувьд Улсын Их Хурлаас 1995, 2004 онуудад баталсан Төрийн нууцын тухай хуулийн бүтцийг жишиг болгон боловсруулсан.

		тусгасан, хэсгийн тэмдэглэгээг а-я хүртэл хийсэн байх тул төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан “Хуулийн төслийн бүтэц, хэлбэр”-ийн шаардлагад нийцүүлэх нь зүйтэй.	
		Холбогдох хуулийн төсөлд тусгуулах саналыг хавсралтаар хүргүүлэв.	
		Хавсралт 5 хуудас.	

ЖИЧ: Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирсэн саналыг тус хуулийн төсөлд тусгасан эсэх үндэслэл, тайлбар, хийгдсэн ажиллагаатай холбоотой мэдээллийг хэлэлцүүлгийн шатанд тагнуулын байгууллагаас өгнө.

---o0o---



**МОНГОЛ УЛСЫН
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ**

Засгийн газрын XI байр, Самбуугийн гудамж 11,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15141
Утас: 26 42 16, Факс: (976-51) 26 44 60,
Цахим шуудан: info@csc.gov.mn,
Цахим хуудас: www.csc.gov.mn

「ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ」
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА
Д.МӨНХ-ЭРДЭНЭ ТАНАА

2025.12.16 № 01/2717
танай _____-ны № _____-т

「 Санал хүргүүлэх тухай 」

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийг зарчмын хувьд дэмжин, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд Төрийн албаны зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тусгах саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Судлан үзэж, хуулийн төсөлд тусгаж өгнө үү.

Хавсралт  хуудастай.

ДАРГА  Д.ЦЭДЭВСҮРЭН

1525076012

Төрийн албаны зөвлөлийн 2025
оны 12 дугаар сарын 16 -ны өдрийн
01/271-дугаар албан бичгийн хавсралт

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд Төрийн албаны
зөвлөлийн чиг үүрэгтэй холбоотой тусгах санал

Ф/ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

№	Төрийн нууцад хамаарах мэдээлэл	Нууцын зэрэглэл			Нууцлах хугацаа (жилээр)	Санал, тайлбар, мэдээлэл
		Онц чухал нууц	Маш нууц	Нууц		
1	Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)		+		20	Хэвээр үлдээх саналтай байна. Төрийн албаны зөвлөлөөс байгууллагын бүтэц, орон тоог тогтоосон эрх бүхий байгууллагын шийдвэрийг үндэслэн Төрийн албаны тухай хуулийн 23.6-д заасны албан тушаалын тодорхойлолтыг хянаж, зөвшөөрөл олгох, батлагдсан албан тушаалын тодорхойлолтын дагуу 33.3-т заасан сонгон шалгаруулалтыг зохион байгуулдаг. Хуулиар төрийн нууцад хамааруулсан байгууллагын бүтэц, орон тоог Улсын Их Хурал, Засгийн газрын шийдвэрээр тогтоох тул холбогдох мэдээллийг үндэслэн шийдвэр гаргадаг. Иймд Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан уг мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хариуцан хамгаалдаг болно.
2	Төрийн нууцад хамаарах асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, тэдгээрийн төсөл, хэрэгжилтийн		+		20	Хасах саналтай байна. Төрийн албаны зөвлөл нь төрийн албаны чадавхыг бэхжүүлэх чиглэлээр Олон улсын гэрээний тухай хууль, Байгууллага хоорондын гэрээ байгуулах журмын дагуу

	талаарх дэлгэрэнгүй мэдээлэл					Гадаад харилцааны ямаар удирдамж, гэрээний төслийг хянуулсны үндсэн дээр ижил түвшний олон улсын болон гадаад улсын байгууллагатай харилцан ажиллаж байна.
3	Төрийн нууцад хамааруулсан асуудлаар олон улсын хурал зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж		+		Хуульд өөрөөр заагаагүй бол хурал, чуулган дуустал	Төрийн нууцад хамаарах асуудлаар гадаад улсын Засгийн газар, байгууллагатай байгуулсан олон улсын гэрээ, хэлэлцээр, протокол, удирдамж байхгүй болно.
4	Төрийн албан хаагчийн бүрэлдэхүүн хөдөлгөөний тайлан дахь үндэсний аюулгүй байдлыг хангах тусгай чиг үүрэгтэй байгууллагуудын бүтэц, зохион байгуулалт, орон тооны тухай мэдээлэл		+		20	Дараах байдлаар өөрчлөн найруулах саналтай байна: Төрийн цэргийн байгууллагад хамаарах, гүйцэтгэх ажиллагаа явуулах эрх бүхий байгууллагын болон хуулиар бүтэц, орон тоо нь нууцад хамруулсан бусад байгууллагын төрийн албан хаагчийн тоо бүртгэлийн тайлан. Энэ мэдээлэл энэхүү жагсаалтын 1-д заасан тайлбар, мэдээллийн хүрээнд гарах бөгөөд уг мэдээлэл задрах нь улсыг батлан хамгаалах хүчний тоо мэдээлэл задрах эрсдэлтэй тул төрийн нууцад хамааруулсан уг мэдээллийг Төрийн албаны зөвлөлд хариуцан хамгаалдаг болно.
5	Төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, бусад нууц тээгч		+		20	Хуулиар төрийн нууцад хамааруулсан байгууллагын бүтэц, орон тоо, албан тушаалын тодорхойлолтыг хянаж, зөвшөөрөл олгох, холбогдох албан тушаалтныг сонгон шалгаруулж, нэр дэвшүүлэх ажиллагааг хаалттай хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэдэг болно.
6	Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг		+		20	Хуулиар төрийн нууцад хамаарах асуудлаар бусад байгууллага, албан тушаалтны боловсруулсан, ирүүлсэн мэдээлэл, албан бичгийг

					нууцлах, хамгаалах арга хэмжээ авч байна.
7	Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл		+	20	Төрийн албаны зөвлөл нь Төрийн албаны тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1-д заасны дагуу төрийн жинхэнэ албан хаагчийг сонгон шалгаруулж томилох үйл ажиллагаанд хяналт, шалгалт хийх чиг үүрэгтэй. Чиг үүргийн хүрэнд хуулиар төрийн нууцад хамааруулсан байгууллагын бүтэц, орон тоо, томилох үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх тул төрийн нууцад хамаарах мэдээлэл, нууц тээгчийг хүлээлцэх, шилжүүлэх, нууц тээгчийг шалгах шаардлага үүсдэг. Бүтэц орон тоог нь төрийн нууцад хамааруулсан байгууллагын төрийн жинхэнэ албан хаагчийн хууль зөрчин халсан, сахилгын шийтгэл оногдуулсан тухай гомдлын дагуу түүнийг ажилд томилогдсон, чөлөөлсөн, шилжүүлсэн бүх шийдвэр, сахилгын шийтгэл оногдуулах үндэслэл болсон үйлдэлтэй холбоотой материал, албан тушаалын тодорхойлолтод үндэслэн шийдвэр гаргах тул энэ бүх мэдээллийг эх хувиар нь татаж шалгана. Шаардлагатай бол шийдвэр гаргасан хүний томилогдсон ажилласан талаарх мэдээллийг татаж шалгадаг. Тухайлбал: Тагнуулын байгууллагад ажиллаж байгаад цэргийн тэтгэвэрт гарсан иргэнээс "хууль бусаар тэтгэвэрт гаргасан, 36 сарын тэтгэмж олгох ёстой боловч 18 сарын тэтгэмж олгосон шааргуулах" талаар гомдол ирж байсан. Уг гомдлыг шалгахад холбогдох мэдээлэл нь нууцад хамаарах байсан тул Төрийн болон албаны нууцын тухай хууль холбогдох журмын дагуу мэдээлэл татах шаардлага үүсэж байсан.



**МОНГОЛ УЛСЫН
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ
КОМИСС**

Засгийн газрын 12 дугаар байр, Барилгачдын талбай-2,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
Утас: (+976) 7000 0222, (+976-51) 26 29 31
Цахим шуудан : info@nhrcm.gov.mn
Цахим хуудас : www.nhrcm.gov.mn

МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН
ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН
ДАРГА С.БЯМБАЦОГТ
ТАНАА

2025.12.31 № 01/2436
танай _____-ны № _____-т

Санал хүргүүлэх тухай

Танайхаас 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/3500 дугаартай албан бичгээр ирүүлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл, үзэл баримтлалтай танилцлаа.

Дээрх хуулийн төсөл, үзэл баримтлалд төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах зорилгоор төрийн нууцыг Засгийн газрын шийдвэрээр тогтоож байгаа практикийг өөрчлөн хуулиар тогтоож, “албаны нууц”-тай холбоотой зохицуулалтыг хассан нь Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын гэрээнд заасан зарчимд нийцэх дэвшил болсныг сайшаан тэмдэглэж, дараах саналуудыг хүргүүлж байна.

Нэг. Төрийн нууцын тухай хуулийн төсөлд:

1. Мэдээллийг төрийн нууцад авахад баримтлах шалгуур үндэслэлийг нарийвчлан тодорхойлж, хэрэгжүүлэх арга хэмжээ, ажиллагааг журамлан хуульчлах, ингэхдээ Монгол Улсын Үндсэн хууль, хүний эрхийн олон улсын нийтлэг зарчим, хүний эрхийн олон улсын гэрээнд заасан хүний мэдэх эрх, мэдээлэлтэй байх эрхийг хангах, хамгаалах болон хязгаарлахад баримтлах шаардлагуудад нийцүүлэх. Түүнчлэн, төрийн нууцад хамааруулж болохгүй мэдээллийг тусгайлан зааж, мэдээллийг хууль бусаар төрийн нууцад авахыг хориглосон хэм хэмжээг тусгах.

Үндэслэл, шаардлага: Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хорооноос гаргасан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйл буюу Үзэл бодолтой байх, үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний талаарх 34 дүгээр Ерөнхий тайлбар, Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын 13 дугаар зүйл, “19 дүгээр зүйл” Олон улсын хүний эрхийн байгууллагын Мэдэх эрхийг хангах хууль тогтоомжийн 9 үндсэн зарчим, “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” Тшванийн зарчим зэрэг олон улсын эрх зүйн баримт бичгүүдэд мэдэх эрхийг хангаж, хэрэгжүүлэхдээ нийтийн эрх ашгийг ямагт чухалчлах, зөвхөн нийтийн эрх ашигт нийцэх үндэслэл буй нөхцөлд иргэдийн мэдээлэлтэй байх эрхийг гагцхүү хуулиар хязгаарлах, ингэхдээ зайлшгүй шаардлагатай бөгөөд тохирсон хязгаарлалт тавих, харин мэдээллийн нийтийн ашиг

1508203144

сонирхлыг хангах ач тус нь ил болгосноор учрах хор хохирлыг давахуйц байгаа тохиолдолд мэдээллийг нээлттэй болгох зэрэг нийтийн эрх ашгийг шалгуур болгосон үндсэн зарчмуудыг тусгасан байна.

Тухайлбал, төрийн байгууллага, түүний албан тушаалтан нь 1) тухайн мэдээлэл нь хуульд заасан хууль ёсны ашиг сонирхолтой холбоотой байх, 2) тухайн мэдээллийг ил болгох, өгөх нь хуулиар хамгаалсан ашиг сонирхолд ноцтой хохирол учрахыг хохирлын үнэлгээгээр заавал тогтоосон байх, 3) тэрхүү учрах ноцтой хохирол нь олон нийтийн мэдээлэлтэй байх ашиг сонирхлоос илүү чухал байх тохиолдолд мэдээллийг нууцлах, мэдээлэл өгөхгүй байж болно. Ингэхдээ эхний гурван хэсэгт заасан үнэлгээгээр мэдээллийг нууцлах, өгөхгүй байх нөхцөл бүрдсэн ч, тэр нь төрийн байгууллага, албан тушаалтны алдаа, дутагдлыг нуух, хаацайлах шинжтэй бол мэдээллийг нууцалж болохгүй талаарх шалгууруудыг тогтоожээ.

Транспаренси Интернэшнл олон улсын байгууллагаас 2024 онд зарласан Авлигын төсөөллийн индексийн үр дүнгээр Монгол Улс 180 орноос 121 дүгээрт жагсаж, өмнөх оноос 3 байр ухарсан бөгөөд тус тайланд Монгол Улсын авлигын индексийн үзүүлэлтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлс нь “иргэдийн мэдэх эрхийг хангах, төрийн анхан шатны мэдээлэл хангалтгүй байгаа” гэдгийг тодорхойлжээ. Түүнчлэн, “Дэлхийн мэдээллийн эрх чөлөөний рейтинг”-ээр Монгол Улс нийт судалгаанд хамрагдсан 140 улс орнуудын рейтингээр 2022 онд 64-т, 2023, 2024 оны байдлаар нийт 150 онооноос 87 оноо авч 67 дугаар байранд эрэмбэлэгджээ. Энэ нь мэдээлэлд хандах эрхийг хангах, мэдээллийн хүртээмжийг баталгаажуулах чиглэлээр хууль тогтоомжоо шинэчлэх шаардлагатай орнуудын нэг болохыг илэрхийлж байна.

2.Хуулийн төслийн 15 дугаар зүйлд мэдээллийн нууцын зэрэглэлийг ялгамжтай байдлаар тогтооход баримтлахаар тусгасан “...онц хүнд үр дагавар бий болгох”, “...хүнд үр дагавар бий болгох”, “...хохирол учруулах” гэсэн нэр томьёо тус бүрийн бусдаасаа ялгагдах зааг, хэмжээ, хүрээ, шалгуурын тайлбар, хэрхэн ойлгож хэрэглэх талаар хуулийн төслийн нэр томьёоны тодорхойлолтод нэмж тусгах;

Үндэслэл, шаардлага: Мэдээлэлд нууцын зэрэглэл тогтооход эдгээр нэр томьёо тус бүрд ямар хүрээ, хэмжээ, шалгуурыг баримталж нууцын зэрэглэлийг бусдаас нь ялгамжтай тогтоох, бусад хуультай нийцүүлж хэрэглэх эсэх талаарх хуулийн зохицуулалт, тайлбар байхгүйгээс хуулийг нэг мөр хэрэглэхэд хүндрэл учрах, мэдээллийг өргөн хүрээнд нууцлах, хамааралгүй мэдээллийг нууцлах зэргээр мэдээллийн нууцлалд “субъектив” хандлага үүсгэх, хүний мэдэх эрх зөрчигдөх нөхцөл гарахад нөлөөлөхөөр байна.

3.Мэдээллийг хууль бусаар төрийн нууцад хамааруулсан, эсхүл мэдээлэл гаргаж өгөхөөс хуулийн үндэслэлгүй татгалзсан тохиолдолд иргэдийн гомдол гаргах, шийдвэрлэх механизмыг болон хараат бус шүүхээр хянагддаг зохицуулалтыг тусгах.

Үндэслэл, шаардлага: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийг тайлбарласан Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр Ерөнхий тайлбарын 19-т “Мэдээлэл өгөхөөс татгалзсан шийдвэр, мэдээлэл авах хүсэлтэд хариу өгөөгүй тохиолдлыг хянан шийдвэрлэх механизм бий болговол зохино” гэж заасан нь төрийн байгууллага,

албан тушаалтны дур зоргын үйлдлийг хязгаарлах, хяналт тавих хүрээнд иргэний гомдол гаргах эрхийг баталгаажуулахыг зөвлөмж болгосон байна.

Комисст 2020-2024 оны хооронд мэдээлэл хайх, хүлээн авах, түгээх эрхтэй холбоотой 29 гомдол, мэдээлэл бүртгэгдсэнээс 17 нь төрийн байгууллага, албан тушаалтнаас нийтэд ил тод мэдээллийг авахаар хандсан ч хариу өгөхгүй байгаатай холбоотой гаргасан гомдол, мэдээлэл бүртгэгджээ.

Нууцад авсан мэдээлэл нь хуульд заасан үндэслэл, журмаар авагдсан эсэх, үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөө, нийгмийн дэг журам гэсэн чухал ашиг сонирхлыг хамгаалахад зайлшгүй, тохирсон зэргийг хараат бус шүүхээр хянуулах нь хүний үндсэн эрхийг хязгаарласан аливаа шийдвэр хууль ёсны эсэхийг тогтоох, хүний мэдэх эрхийн зарчмыг хангах баталгаа болно.

4.Хуулийн төслийн төрийн нууцтай танилцах тусгай нөхцөл гэсэн 20 дугаар зүйлийн 20.5-д заасан төрийн нууцтай танилцах эрх бүхий албан тушаалтанд “Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн” гэж, мөн хэсгийн “хэрэг,” гэсний дараа “гомдол” гэж тус тус нэмэх.

Үндэслэл, шаардлага: Комиссын гишүүн нь гомдол, мэдээлэл шалгах чиг үүргийн хүрээнд “хуульд заасан журмын дагуу төрийн болон албаны нууц, байгууллагын нууц, хүний эмзэг мэдээлэлтэй саадгүй, даруй танилцах” бүрэн эрхтэй гэж Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний комиссын тухай хуулийн 25.1.7-д заасантай нийцүүлж, баталгааг хангах нь зүйтэй байна.

Комисст 2025 онд 1344 гомдол ирсний 453 нь шударгаар шүүлгэх, 284 нь хөдөлмөрлөх, 160 нь халдашгүй чөлөөтэй байх, 73 нь төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл гомдол гаргах эрхтэй холбоотой гомдлууд байна. Мөн Комиссоос 2024 онд 119, 2025 онд 201 хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна. Энэхүү хяналт шалгалтын хүрээнд үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, хууль сахиулах зэрэг тусгай чиг үүргийн болон бусад төрийн байгууллагад хадгалагдаж байгаа төрийн нууцтай танилцаж, гомдол, мэдээллийг хянан шалгах ажиллагаа хийгддэг.

5.Хуулийн төсөлд төрийн нууцыг итгэмжлэн хариуцах үүрэг хүлээгээгүй, танилцах хууль ёсны эрхгүй боловч ажил үүрэг, мэргэжлийн хүрээнд төрийн нууцыг олж авах, танилцах магадлалтай сэтгүүлч, шүгэл үлээгч зэрэг этгээдүүдийн эрх зүйн байдал, тэдгээрийн төрийн нууц хамгаалах, хадгалахтай холбоотой эрх, үүргийн талаарх эрх зүйн зохицуулалтыг тусгах шаардлагатай байна.

Үндэслэл, шаардлага: Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын пактын 19 дүгээр зүйлийг тайлбарласан Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн хорооны 2011 оны 34 дүгээр Ерөнхий тайлбарын 30-д “үндэсний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг, төрийн болон албаны нууцын тухай, үндэсний эв нэгдлийг бусниулахын эсрэг зэрэг үндэсний аюулгүй байдлын талаарх хуулиудад үндэсний аюулгүй байдалд хохирол учруулахгүй, нийтийн ашиг сонирхолд хууль ёсоор хамаарах мэдээллийг түгээсэн сэтгүүлч, судлаач, байгаль орчны активист, хүний эрхийг хамгаалагч болон бусад хүнийг мөрдөн шалгах зорилгоор шалгах, яллах нөхцөл болохгүй”, 45-д “Эх сурвалжаа нууцлах нь сэтгүүлчийн хязгаартай эдлэх бүрэн эрх бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний бүрдэл хэсэг болохыг

Оролцогч улс хүлээн зөвшөөрч, хүндэтгэн хандвал зохино” гэж зөвлөмж болгосон байна.

Мөн 2004 оны 12 дугаар сарын 06-ны өдөр Нэгдсэн Үндэстний байгууллагын үзэл бодолтой байх, түүнийгээ илэрхийлэх эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч, Европын аюулгүй байдал, хамтын ажиллагааны байгууллагын Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний асуудлаарх Төлөөлөгч, Америкийн орнуудын байгууллагын үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний Тусгай илтгэгч нарын гаргасан Хамтарсан тунхаглалд “Төрийн нууцыг хамгаалах үүргийг зөвхөн түүнийг хариуцсан төрийн байгууллага, албан тушаалтан хүлээнэ. Сэтгүүлч, иргэний нийгмийн төлөөлөгч зэрэг бусад этгээдийн хувьд мэдээллийг нийтэлсэн, түгээсний төлөө хууль зүйн хариуцлага хүлээх ёсгүй. Төрийн нууц хариуцсан этгээд түүнийг түгээсний төлөө хариуцлага хүлээх нөхцөлийг Эрүүгийн хуулийн зүйл, хэсэгт тусгах ёстой” гэсэн байна.

Хоёр.Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд:

1.Төрийн нууцын жагсаалтад оруулахаар тусгасан мэдээлэлд Төрийн нууцын тухай хуулийн төслийн 13 дугаар зүйлд заасан төрийн нууцын хүрээ болон хүний эрхийн олон улсын зарчим, иргэний мэдээлэлтэй байх эрхийг хангах болон хязгаарлах шалгуурыг баримтлан нарийвчлан үнэлгээ хийж, дахин боловсруулах.

Үндэслэл, шаардлага:Тус хуулийн төслийн үзэл баримтлалд “...салбар, байгууллагын хэмжээнд төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалтад хуульд заасан, төрийн нууц мэдээллийн хүрээнд хамаарахгүй мэдээллүүд багтсан. ...нууцлах нь ач холбогдлоо алдсан мэдээллийг ил болгох асуудлыг орхигдуулж байна” гэсэн боловч Засгийн газрын 2017 оны 246 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д тусгагдсан бүх мэдээллийг ямар нэгэн шалгуураар үнэлгээ хийлгүй хуулийн төсөлд тусгасан байна.

“Нууцалбал зохих мэдээлэл” гэдгийг хэрхэн тогтоох шалгуур, үндэслэл, хүрээг нарийвчлан тодорхойлж, нууцлах, ил болгох ажиллагаа, үйл явцыг журамлан хуульчлаагүйгээс шалтгаалан шаардлагагүй олон төрлийн мэдээллийг төрийн нууцын жагсаалтад орох нөхцөл бүрдэж байна.

Тухайлбал, “Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой үндэсний хэмжээний томоохон бүтээн байгуулалт, дэд бүтцийн төслийн ажил, түүнд оролцуулах зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүн, техник хэрэгслийн тоо хэмжээ болон ус хангамжийн эх үүсвэр, худалдан авах үйл ажиллагааны нууцалбал зохих хэсэг” гэсэн мэдээлэл ил байснаар үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах нөхцөл тогтоогдохгүй байна. Үүнтэй холбоотой мэдээлэл төрийн байгууллага болон хэвлэл мэдээллийн цахим хуудаст нээлттэй байгаа бөгөөд үүнийг төрийн нууцыг задруулсан гэж үзэж буй талаарх мэдээлэл гараагүй талаар зарим судалгаанд тэмдэглэсэн байна.

Мэдээллийг хэт өргөн хүрээнд нууцлах нь хүний эрхийн үүднээс үндэслэлгүй, үр нөлөөгүй бөгөөд иргэдийн мэдэх эрхэд халдсан явдал болдог. Иймээс хүний эрхийн зарчмын үүднээс бусдын эрх, нэр төрийг хүндэтгэх, үндэсний аюулгүй байдал, нийгмийн дэг журам, хүн амын эрүүл мэнд, ёс суртахууныг хамгаалах

зорилгод нийцүүлж, тодорхой үндэслэл, шалгуураар үнэлгээ хийсний үндсэн дээр мэдээллийг нууцлах нь оновчтой.

2.Төрийн нууцад хамаарах мэдээллийг нийтлэг агуулгаар нь нэгтгэн улсын хэмжээнд нэг мөр тогтоох, зөвхөн тухайн байгууллага, салбарт хамаарах тусгайлсан төрийн нууцыг тусад нь ялгах байдлаар мэдээллийн давхцал, хийдлийг арилгаж, боловсруулалтыг сайжруулах.

Үндэслэл, шаардлага: Нууцын жагсаалтад 33 байгууллага, салбарын 574 мэдээллийг төрийн нууцад хамаарахаар тусгагдсан бөгөөд эдгээр нь давхцал ихтэй, логик уялдаагүйгээс үүдэн төрийн нууцын тухай ойлголт тодорхой бус болсон байна. Тухайлбал, “Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)” нийт 30 удаа, “Төрийн нууц тээгчийг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл” нийт 28 удаа, “Төрийн нууцад хамаарах асуудлаар төрийн байгууллага, бусад хуулийн этгээдтэй харилцсан албан бичиг” нийт 27 удаа, “Төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг” нийт 21 удаа, “Төрийн нууцад хамаарах асуудлаар олон улсын хурал, зөвлөгөөн, чуулганд оролцох төлөөлөгчдийн ажлын чиглэл, удирдамж, илтгэх хуудас, танилцуулга” нийт 11 удаа давтагдсан байна. Үүнээс гадна хоёроос дээш, 10-с доош давтагдсан нийт 24 мэдээлэл байгаа талаар зарим судалгаанд тусгасныг харгалзан үзэх шаардлагатай байна.

3.Хуулийн төсөлд “2010 оноос өмнө цаазаар авах ял гүйцэтгэсэн тухай баримт бичиг, мэдээлэл”-ийг байнга хадгалах, онц чухал нууцад хамруулсныг нягтлан үзэх шаардлагатай байна.

Үндэслэл, шаардлага: Цаазаар авхуулсан хүний талаарх мэдээллийг түүний гэр бүлийн гишүүдээс нууцлах нь хүнлэг бус бөгөөд энэрэнгүй ёсны зарчимд нийцэхгүй юм.

Нэгдсэн Үндэстний байгууллагын Хүний эрхийн зөвлөлөөс Монгол Улсын Хүний эрхийн төлөв байдлын хоёрдугаар тайланг хэлэлцсэнтэй холбогдуулан “цаазаар авхуулсан хүмүүсийн гэр бүлд цаазаар авсан тухай мэдээллийг ил болгож өгөх”, “Цаазаар авах ялын гүйцэтгэлийг улсын нууц мэдээллээс гаргах” тухай зөвлөмж өгснийг Монгол Улс хүлээн авсан боловч одоо болтол биелүүлээгүй байгааг анхаарах шаардлагатай байна.

4.Хуулийн төсөлд төрийн нууцыг 3 зэрэглэлтэй байхаар тусгасан боловч нууцын жагсаалтад орсон мэдээллийн нууцын зэрэглэлийг зөвхөн “онц чухал нууц”, “маш нууц” гэж тогтоож, “нууц” гэсэн зэрэглэлд мэдээлэл хамруулаагүй байгааг анхаарч, тодорхой шалгуур, үндэслэлээр нягтлан үзэж, нууцын зэрэглэлийг дахин тогтоох.

Үндэслэл, шаардлага: Энэхүү хуулийн төсөлд төрийн нууцыг 3 зэрэглэлтэй байхаар хуульчилж байгаа тул хор хохирол багатай буюу хуулийн төслийн 15.5 дугаар зүйлд заасан шалгуурыг хангасан мэдээлэлд “нууц” зэрэглэл тогтоох нь зүйтэй байна.

Түүнчлэн, нууцын зэрэглэлийг бодитой тогтоож өгөөгүйгээс шаардлагагүй мэдээллийг төрийн нууцад авах, илүү зэрэглэл тогтоосноос нууцлах хугацаа урт

болж иргэдийн мэдэх эрх зөрчигдөх, улмаар уг мэдээллийг үрэгдүүлсэн, задруулсан тохиолдолд хүнд ял, шийтгэл хүлээх эрсдэл үүсэхээр байгааг анхаарах.

Тухайлбал, Эрүүгийн хуулийн 19.12 дугаар зүйл (Төрийн нууцыг задруулах), 19.13 дугаар зүйл (Төрийн нууцыг үрэгдүүлэх)-д төрийн “маш нууц”, “онц чухал нууц” мэдээллийг задруулсан, үрэгдүүлсэн тохиолдолд “нууц” мэдээллийг задруулснаас илүү хүнд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр хуульчилсан байна.

5.Хуулийн төслийг боловсруулах үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагын оролцоог хангаж тэдгээрийн санал, зөвлөмжийг тусган боловсруулах нь зүйтэй байна.

Үндэслэл, шаардлага: “Үндэсний аюулгүй байдал ба мэдээлэл авах эрхийн тухай” Тшванийн зарчимд зааснаар мэдээлэл авах эрх нь төрийн үйл ажиллагаанд олон нийтийн хяналт тавих боломжийг олгох төдийгүй төрийн бодлого боловсруулахад олон нийтийн оролцоог дэмжиж, ардчилал, үндэсний аюулгүй байдлыг хангах зорилгын салшгүй хэсэг болдог. Мөн мэдээллийг ил болгох, нууцлан хадгалах тэнцвэрийг зөв тогтоох, энэхүү үйл ажиллагаанд иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоог хангаж, тэдгээрийн санал, зөвлөмжийг харгалзан үзэх нь ардчилсан нийгмийн амин чухал зүйл гэдгийг хүлээн зөвшөөрсөн байна.

Авлигын эсрэг Нэгдсэн Үндэстний байгууллагын конвенцын 10 дугаар зүйлд авлигатай тэмцэх хэрэгцээг харгалзан үзэж зохих тохиолдолд оролцогч улс бүр төрийн захиргаандаа, үүнд зохион байгуулалт, чиг үүргээ хэрэгжүүлэх болон шийдвэр гаргах явцыг оролцуулан, ил тод байдлыг сайжруулахад шаардлагатай байж болох арга хэмжээг дотоодын хууль тогтоомжийнхоо тулгуур зарчимд нийцүүлэн авна гэж заасан. Мөн тус конвенцын 13 дугаар зүйлд улс бүр авлигаас урьдчилан сэргийлж, тэмцэхэд хувь хүн болон иргэний нийгэм, төрийн бус байгууллага, бүлэгт түшиглэсэн байгууллага зэрэг төрийн албанаас гаднах бүлгийн идэвхтэй оролцоог хөхиүлэн дэмжих талаар тусгасан ба үүнийг хэрэгжүүлэх арга хэмжээний нэг нь “шийдвэр гаргах ажиллагааны ил тод байдлыг сайжруулах, түүнд олон нийтийн оролцоог дэмжих, олон нийт мэдээлэл авах боломжтой байх явдлыг хангах” гэж тусгасан.

Хуулийн төслийг боловсруулахад иргэд, иргэний нийгмийн болон хэвлэл мэдээллийн байгууллагын төлөөллийг оролцуулах, тэдгээрийн санал, зөвлөмжийг авах нь иргэний мэдэх эрхийг хангах, олон нийтийн хяналтын тогтолцоог бүрдүүлэх, олон улсын хүний эрхийн зарчимд нийцүүлэх, төрийн үйл ажиллагааг ил тод, нээлттэй, хүртээмжтэй болгоход чухал ач холбогдолтой.

ДАРГА  Д.СҮНЖИД



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗАРТ

МОНГОЛ УЛС
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗАР

14250 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
Сөүлийн гудамж 41, Утас: 7011-0251, Факс: (976) 7011-0251,
И-мэйл: comcor@iaac.mn, Вэб сайт: http://iaac.mn

2025. 12. 23 № 03/21642.
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөл санал өгөх
тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдийн хэг/3500 дугаартай албан бичгээр ирүүлсэн “Төрийн болон албаны нууцын тухай” хуулийн шинэчилсэн найруулга болох “Төрийн нууцын тухай” хуулийн төсөлтэй танилцан, дараах саналыг хүргүүлж байна.

Үүнд:

1. Хуулийн төслийн 13.1.1ё -д болзошгүй эрсдэлийн үнэлгээг нэмэлтээр тусгах саналтай байна. Болзошгүй эрсдэлийн үнэлгээ гэдэгт дипломат төлөөлөгчийн газрын байрлаж байгаа улс оронд дайн үймээн, тахал, террорист халдлагын үед Монгол улсын иргэдийг нүүлгэн шилжүүлэх, эмзэг, өндөр эрсдэлтэй мэдээлэл агуулж байгаа холбооны хэрэгсэл болон цахим системийн аюулгүй байдлыг хангах” нөхцөлийг тусгах;

2. Хуулийн төслийн 17.4-т “... нууцын зэрэглэлийн” гэсний дараа “дардсыг...” гэж засах;

3. Хуулийн төслийн 18.1.2-т “... нөхцөл байдал өөрчлөгдсөний улмаас...” гэсэн нь хэт ерөнхий ойлголт байх тул ямар нөхцөл байдал үүссэн болохыг тодорхойлон оруулах;

4. Хуулийн төслийн 20.4-т “... шалгаж байгаа асуудлын хүрээнд Улсын Их ... гэсний дараа “хурал хүлээн зөвшөөрснөөр...” гэж өөрчлөх;

5. Хуулийн төслийн 20.5-д “... шүүгч, прокурор...” гэсний дараа “мөрдөгч” гэж өөрчлөх;

6. Хуулийн төслийн 30.2-т “... түүнийг биечлэн хүргэх тусгай шуудан зөөгч ашиглаж болно” гэснийг “... “тусгай шуудан зөөгч биечлэн хүргэж өгөх, хүлээн авна” гэж өөрчлөх.

ТАМГЫН ХЭЛТСИЙН ДАРГА,
ЭРХЭЛСЭН КОМИССАР

З.БААСАННЯМ



142503023181



МОНГОЛ УЛСЫН
ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН
ТАМГЫН ГАЗАР

17023 Улаанбаатар хот,
Хан-Уул дүүрэг, 11 дүгээр хороо, Зайсангийн гудамж 11,
Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн байр,
Утас: 26 71 40, 26 01 09, Факс: (976-51) 26 71 74,
И-мэйл: info@conscourt.gov.mn

2025.12.22 № ТГ-1/790
танай 2025.12.12 -ны № ХЭГ/3500 -т

Хариу өгөх тухай

Танай байгууллагаас ирүүлсэн 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн
“Хуулийн төсөлд санал авах тухай” ХЭГ/3500 дугаар албан бичигтэй танилцаад
тусгайлан саналгүй байна.

Хүндэтгэсэн,

ДАРГА



Д.БАЯНБИЛЭГ

1702313289

25/11/58 Төрдаг



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО

Засгийн газрын III байр, Бага тойруу 44,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, 14200
Утас/Факс: (976-11) 32 14 33,
Цахим шуудан: international@nso.mn,
Цахим хуудас: www.nso.mn

2025.12.30. № 01/924

танай _____-ны № _____-т


「 ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ
ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД ДАРГА
Ш.РАДНААСЭД ТАНАА

Танай байгууллагаас ирүүлсэн Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлтэй танилцаж, зарчмын хувьд хуулийн төслүүдийг дэмжиж байна.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

ДАРГА



Б.БАТДАВАА

1425090854

1725100836

[illegible]

၁၈၈၆/ ၁၈၈၇ ခုနှစ်၊ ဧပြီလ၊ ၁၈ ရက်၊
 နံနက် ၈ နာရီ၊ ဝမ်းဗိုက်၊ နံနက် ၈ နာရီ

୨୩/୫
 ୨୩/୫
 ୨୩/୫

နိဂုံး ၏ နိဂုံး ၏ 3 မြောက် မြောက် + မြောက် မြောက် 44 :




 משרד החינוך וההשכלה / משרד החינוך וההשכלה / משרד החינוך וההשכלה

ХУУЛИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлж байна. Үүнд:

1. Хуулийн төслийн у/ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 1-д “Улсын Их Хурал, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцсэн хуулиар төрийн нууцад хамааруулсан мэдээлэл (тогтоол, зөвлөмж, хуралдааны тэмдэглэл)” гэснийг хасах;

Үндэслэл: Энэхүү мэдээллийн хүрээнд статистикийн байгууллагад баримт бичиг үүсэж хөтлөгддөггүй тул жагсаалтаас хасах саналтай байна.

2. Хуулийн төслийн у/ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 2-т “Төрийн цэргийн байгууллагын бие бүрэлдэхүүний тоо бүртгэл, бэлтгэл үүрэгтэн, цэрэгт татах болон цэргээс халагдах хүмүүсийн нэгдсэн мэдээлэл, цэргийн мэргэжлийн ангилал, оногдуулан данслагдсан хүн, техникийн нэгдсэн дүнгийн мэдээлэл” гэснийг “Хүн ам, өрхийн мэдээллийн сангийн төрийн цэргийн байгууллагын бэлтгэл үүрэгтэн болон цэргийн мэргэжлийн ангиллын мэдээлэл” гэж өөрчлөх;

Үндэслэл: Статистикийн тухай хууль, Хүн ам, орон сууцны тооллогын тухай хуулийн дагуу Хүн ам, өрхийн мэдээллийн санг хүн амын тооллого хоорондын хүн амын тоог хянах, анхан шатны нэгжээс эхлэн бүх шатанд хүн амын тоо мэдээг үнэн зөв тодорхойлох, хүн ам, өрхийн талаарх мэдээллийн санг бүрдүүлэх, боловсронгуй болгох зорилгоор хөтөлдөг. Хүн ам, өрхийн мэдээллийн санг баяжуулах, хөтлөх ашиглахад баримтлах журмын дагуу баг, хорооны Засаг дарга нь тухайн нутаг дэвсгэрийн хүн ам, өрхийн мэдээллийг тухай бүр хөтөлж, баяжуулж байна. Энэ хүрээнд иргэний цэргийн алба хаасан эсэх, ямар хэлбэрээр хаасан болон цэргийн мэргэжлийн ангиллыг бүртгэдэг. Уг мэдээллийг Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.ё дахь хэсэг болон Засгийн газрын 2017 оны 247 дугаар тогтоолоор батлагдсан “Монгол Улсын төрийн нууцад хамаарах мэдээллийн жагсаалт”-д Батлан хамгаалах салбарын төрийн нууц мэдээлэлд оруулсан. Иймд задруулах, үрэгдүүлэх тохиолдолд үндэсний аюулгүй байдал, үндэсний ашиг сонирхолд аюул, занал, хохирол учруулах эрсдэлтэй. Үндэсний статистикийн хорооны Хүн ам, өрхийн мэдээллийн санд төрийн цэргийн байгууллагын бэлтгэл үүрэгтэн болон цэргийн мэргэжлийн ангиллын мэдээллийг бүртгэж байгаа тул дээрх томъёоллоор өөрчлөх саналтай байна.

3. Хуулийн төслийн у/ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсгийн 3-т “Төрийн нууцыг хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл” гэсний “Төрийн нууцыг” гэдгийг “Төрийн нууц тээгчийг...” гэж өөрчлөх;

Үндэслэл: Хуулийн төсөлд тусгасан бусад бүх салбарын хэмжээний төрийн нууцад хамааруулах мэдээллийн жагсаалтад “Төрийн нууц тээгчийн хүлээлцсэн, шилжүүлсэн, шалгасан тухай мэдээлэл” гэж туссан байх тул “төрийн нууц тээгч” гэсэн Төрийн нууцын тухай хуулийн төслийн

5 дугаар зүйлийн 5.1.2-т заасан нэр томъёоны дагуу болгох нь зүйтэй гэсэн саналтай байна.

4. Хуулийн төслийн у/ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРОО хэсэгт “Үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилтын тухай мэдээлэл” гэж нэмэх;

Үндэслэл: Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 13.1.в дэх заалтын хүрээнд Үндэсний статистикийн хороо нь хэрэглээний үнийн сагсны бараа, үйлчилгээний жин, анхан шатны тооцооллыг хийж байна. Хэрэглээний сагсны бараа, үйлчилгээний жин гэдэг нь өрхийн хэрэглээний сагсанд багтаж буй тухайн бараа, үйлчилгээг худалдаж авах зардал нь өрхийн нийт зардлын хэдэн хувийг эзэлж байгааг дунджаар харуулдаг үзүүлэлт юм. Тухайн бүтээгдэхүүний зардал нь өрхийн нийт зардалд их хэмжээг эзлэх тусам хэрэглээний жин их байна. Ингэснээр инфляц буюу хэрэглээний үнийн индексэд жин өндөртэй бараа, үйлчилгээний үнийн өөрчлөлтийн нөлөө харьцангуй өндөр байдаг. Монгол Улсын хувьд өрхийн хэрэглээний зардалд хүнсний бүтээгдэхүүн 26.7 хувийг эзэлдэг бөгөөд үүнд мах, гурил, будаа, сүү, сүүн бүтээгдэхүүний дэд бүлгийн жин дангаараа 19.6 хувийг эзэлдэг. Эдгээр бүлэгт хамаарагдах мах, сүү, гурил нь стратегийн хүнсний бүтээгдэхүүн бөгөөд эдгээр бүтээгдэхүүний үнэд нөлөөлөх замаар инфляцад нөлөөлөх эрсдэлтэй. Мөн Үндэсний статистикийн хорооноос үндэсний аюулгүй байдлыг хангахад ач холбогдолтой эрдэм шинжилгээ, судалгааны ажил, судалгааны туршилтыг хийх хэрэгцээ шаардлага гарсан тохиолдолд хөтлөгдөх тул жагсаалтад нэмэх саналтай байна.

_____оОо_____



МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХ

Ц.Жигжиджавын гудамж 7/1, Бага тойруу, 1 дүгээр хороо,

Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160

Утас: (976-51) 26 15 44,

Цахим шуудан: info@supremecourt.mn

2026. 01.15 № 01/169

танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

Танай 2025 оны ХЭГ/3500 дугаартай албан бичгээр санал авахаар ирүүлсэн “Төрийн нууцын тухай хууль” /шинэчилсэн найруулга/ болон “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль”-ийн төслийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн хуралдаанаар хэлэлцэж, гарсан саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 3 хуудастай.


ЕРӨНХИЙ ШҮҮГЧ



Д.ГАНЗОРИГ

151602000594

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн
хуралдааны 2026 оны 01 дүгээр сарын 09-ний
өдрийн 01 дүгээр тогтоолын хавсралт



**ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛЬ /ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГА/
БОЛОН ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛД ХҮРГҮҮЛЭХ САНАЛ**

Монгол Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2026 оны 01 дүгээр сарын 09-ний өдрийн хуралдаанаар Монгол Улсын Засгийн газраас санаачлан боловсруулсан “Төрийн нууцын тухай” болон “Төрийн нууцын жагсаалт батлах тухай” хуулийн төслийг Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.8.3-т заасны дагуу хэлэлцэв.

Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга, хэрэгцээ, шаардлагын талаар хэлэлцээд хуулийн төсөлд дараах саналыг хүргүүлэх нь зүйтэй гэж үзлээ.

Нэг. Төслийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтыг “11.1.1. эрхэлсэн салбар, харьяа байгууллагын хэмжээнд хууль тогтоомжийн хэрэгжилтийг зохион байгуулж хангах, байгууллагын чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг баталж мөрдүүлэх” гэж өөрчлөн найруулах.

Үндэслэл: Төрийн байгууллагууд өөрсдийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан төрийн нууцыг хамгаалах талаар нарийвчилсан зохицуулалт бүхий журмыг батлан мөрдүүлэх шаардлага бий.

Тухайлбал: Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийн төслийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт “Төрийн нууц, түүний тээгчийг бүтээх, боловсруулах, хадгалах, ашиглах, дамжуулах, шилжүүлэх, тээвэрлэх, илгээх, бүртгэх, устгах, бүрэн бүтэн байдлыг хангах болон тэдгээртэй холбоотой бусад үйл ажиллагааг энэ хууль болон Засгийн газрын баталсан төрийн нууцыг хамгаалах нийтлэг журамд заасны дагуу хэрэгжүүлнэ” гэж заасан байна.

Мөн хуулийн төслийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт “Иргэн, эрүү, захиргааны хэрэг, маргааныг хянан шийдвэрлэхэд төрийн нууцыг хамгаалах асуудлыг энэ хууль, холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу зохицуулна” гэж заажээ.

Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан хэргийг шүүхээр хянан шийдвэрлэх шатанд тухайн хэргийг хүргүүлэх, хүлээн авах, бүртгэх, хуваарилах, шаардлагатай тохиолдолд хуулийн төслийн 25 дугаар зүйлд заасны дагуу хэргийн оролцогчийг аюулгүй байдлын шалгалтад оруулах, оролцогчдод хэргийн материал танилцуулах, хэргийг шүүх хуралдаанаар хянан хэлэлцэх, шүүхийн шийдвэрийн холбогдох хэсгийг нууцлах, шүүхийн шийдвэрийг оролцогчдод танилцуулах, гардуулах, хүргүүлэх, нийтлэх, хадгалах зэрэг ажиллагааг хуулиар нарийвчлан зохицуулах, эсхүл хуулиар эрх олгосны дагуу байгууллагын баталсан журмаар тусгайлан зохицуулах шаардлага бий.

Шүүхийн ерөнхий зөвлөлийн хувьд Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1.5-д заасны дагуу холбогдох стандарт, дүрэм, журам батлан мөрдүүлэх бүрэн эрхийн хүрээнд “Хэргийн хөдөлгөөний стандарт”-аас гадна 2019 оны 05 дугаар сарын 21-ний өдрийн 56 дугаар тогтоолоор “Монгол Улсын шүүхийн

төрийн болон албаны нууцыг хамгаалах” журмыг батлан мөрдүүлж буй хэдий ч энэ талаар хуулийн тусгайлсан зохицуулалт байхгүй байна.

Иймд Төрийн нууцтай холбоотой хэргийг шүүхээр хянан шийдвэрлэхэд баримтлах нарийвчилсан журмыг Төрийн нууцын тухай, эсхүл хэрэг хянан шийдвэрлэх процесс ажиллагааны хуулиудаар тусгайлан зохицуулах, эсхүл хуулиар олгогдсон бүрэн эрхийн хүрээнд холбогдох байгууллага (Засгийн газар, Улсын дээд шүүх, Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн тамгын газар) өөрийн чиг үүрэг, үйл ажиллагааны онцлогийг харгалзан Төрийн нууцын тухай хуульд заасан нийтлэг шаардлагад нийцүүлэн баталж мөрдүүлэхийг хуульчлах шаардлагатай.

Хоёр. Төслийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасан “12.1.4. байгууллага, албан тушаалтан төрийн нууцаа хамгаалах ажлыг зохион байгуулахад мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх” гэсэн заалтад “... эрх бүхий байгууллага, албан тушаалтан даалгасны дагуу дүгнэлт гаргах” гэсэн заалтыг нэмж тусгах.

Үндэслэл: Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн (цаашид ЭХХШТХ гэх) 22.3.4-т “Мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах тухай прокурорын зөвшөөрөлд төрийн нууцыг хамгаалах зорилгоор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан мэдээллийг хязгаарлаж болно”, 31.3.1-т “...Төрийн нууцад хамаарах хэргийн яллагдагчаар татах тогтоолыг яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид гардуулахгүйгээр танилцуулна”, 32.10.9-т Төрийн нууцад хамаарах мэдээлэл агуулсан яллах дүгнэлтийг яллагдагчид бүрэн танилцуулан, төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө”, 36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “...төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө” гэж тус тус заасан.

ЭХХШТХ-ийн дээрх заалтыг хэрэгжүүлэхийн тулд мөрдөгч, прокурор, шүүх нь Төрийн нууцын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4-т заасны дагуу Тагнуулын байгууллагаас мэргэжил, арга зүйн туслалцаа авахаас гадна тодорхой хэрэгт шүүхийн шийдвэрийн төрийн нууц агуулсан хэсгийг нууцлах асуудлаар дүгнэлт, эсхүл зөвлөмж гаргуулах шаардлага үүсч болно.

Хуулийн хэрэгжилтээс үзэхэд, төрийн нууц мэдээлэл агуулсан хэргийг хянан шийдвэрлэсэн зарим шүүх төрийн нууцыг задруулах эрсдэлээс сэргийлж шийдвэрээ бүхэлд нь нууцалж, тухайн шийдвэрийг оролцогчид гардуулж өгөхгүйгээр танилцуулах явдал байсаар байна. Ийнхүү шүүхийн шийдвэрийг бүхэлд нь нууцлах нь тухайн шийдвэрийг оролцогчид гардуулах, холбогдох байгууллагад хүргүүлэх, олон нийтэд мэдээлэх зэрэг ажиллагаанд тодорхой хүндрэлийг дагуулж байна.

Иймд энэ талаар Тагнуулын байгууллагаас бусад эрх бүхий байгууллага, албан тушаалтанд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэхээс гадна тухайн байгууллага, албан тушаалтан даалгасан тохиолдолд төрийн нууц мэдээлэл агуулсан шийдвэрийн аль хэсгийг нууцлах шаардлагатай талаар дүгнэлт гаргах заалтыг нэмж тусгах нь хуулийг нэг мөр ойлгож зөв хэрэглэх, төрийн нууцыг хамгаалахад чухал ач холбогдолтой гэж үзэв.

Эрх бүхий байгууллага, албан тушаалтан даалгасны дагуу Тагнуулын байгууллагаас гаргасан дүгнэлт нь заавал дагаж мөрдөх императив шинжийг агуулахгүй, харин холбогдох байгууллага, албан тушаалтанд төрийн нууцаа хамгаалах ажилд нь мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлэх эрхийг баталгаажуулж буй явдал юм.

Гурав. Шүүхээр хянан шийдвэрлэсэн төрийн нууц мэдээлэл агуулсан хэрэгт мөрдөн шалгах нууц ажиллагааг ЭХХШТХ болон Гүйцэтгэх ажлын тухай хуульд

заасан журмыг зөрчиж явуулснаас хүний эрх, хууль ёсны ашиг сонирхол, эсхүл нийтийн эрх ашиг ноцтой зөрчигдсөн болох нь тогтоогдвол шүүх төрийн нууцад хамааруулсан холбогдох мэдээллийг шүүхийн шийдвэрээр олон нийтэд ил болгох асуудлыг Төрийн нууцын тухай хуулийн төслийн 18 дугаар зүйл (Төрийн нууцыг ил болгох үндэслэл, журам)-д тусгайлан заах саналтай байна.

Дөрөв. Төслийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэгт заасан “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч зөвхөн шалгаж шийдвэрлэх тодорхой хэрэг, маргаанд хамаарах төрийн нууцтай хуулиар тогтоосон журмын дагуу танилцана” гэсэн заалтад шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, шүүхийн нууцын ажилтан зэрэг шүүхийн захиргааны ажилтнуудаас гадна шүүх хуралдаанд хуульд заасан журмын дагуу томилогдон оролцох иргэдийн төлөөлөгчийг нэмж тусгах.

Үндэслэл: Төрийн нууц мэдээлэл агуулсан хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд шүүгчээс гадна шүүгчийн туслах, шүүх хуралдааны нарийн бичгийн дарга, нууцын ажилтан зэрэг шүүхийн захиргааны ажилтнуудаас гадна иргэдийн төлөөлөгч зайлшгүй оролцдог тул тэдгээр нь хуулиар тогтоосон журмын дагуу танилцах эрхтэй байх шаардлагатай.

Тав. Төслийн 13 дугаар зүйлийн 13.1.4 дэх заалтад “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж, 13.1.5.ё дахь заалтад “төрийн нууц мэдээлэл агуулсан шүүхийн шийдвэрийн холбогдох хэсэг” гэж, 16 дугаар зүйлийн 16.4 дэх хэсэгт “эрүүгийн хэрэгт хамтран ажиллах этгээдээр тогтоогдсон хүн” гэж тус тус нэмэлт оруулах эсэхийг хууль санаачлагч анхаарах нь зүйтэй.

Үндэслэл: ЭХХШТХ-ийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Прокурор, мөрдөгч нь мөрдөн шалгах нууц ажиллагаа явуулах шийдвэр, түүний үр дүнг хавтаст хэрэгт хавсаргахад энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасныг баримтална”, 36.13 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт “...төрийн нууцад хамаарах хэсгийг уншигдах боломжгүй байдлаар нууцалж, гардуулан өгнө” гэж тус тус заасан.

Иймд, Эрүүгийн хэрэгт прокурорын зөвшөөрлөөр хийгдэх мөрдөн шалгах нууц ажиллагаа, мөн эрүүгийн хэрэгт хамтран ажиллах этгээдээр тогтоогдсон хүнтэй холбоотой мэдээлэл, мөн прокурор болон шүүхийн шийдвэрийн төрийн нууц мэдээлэл агуулсан хэсгийг Төрийн нууцын тухай хууль болон Төрийн нууцын жагсаалтад тусгах, эсхүл эдгээр нь Төрийн нууцын тухай хуулийн 13.1.4.д, 13.1.5.ё, 16.4 дүгээр зүйлд заасан ойлголтод хамаарах эсэх талаар хуулийн төслийг эцэслэн боловсруулахдаа анхаарахыг зөвлөж, хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох саналаа үүгээр уламжилж байна.

МОНГОЛ УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН
НИЙТ ШҮҮГЧИЙН ХУРАЛДААН



МОНГОЛ УЛСЫН
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ЗӨВЛӨЛ

14201 Улаанбаатар хот, Төрийн ордон
Сүхбаатарын талбай 6, Утас: 51-263882, Факс: 329883,
И-мэйл: info@nsc.gov.mn

2026.01.22 № 4/25
танай 2025.12.12 -ны № хэрг/3500 -т

МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА
С.БЯМБАЦОГТ ТАНАА

Санал хүргүүлэх тухай

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн Ажлын алба нь Зөвлөлийн хуулиар олгогдсон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх, үндэсний аюулгүй байдлын талаарх судалгаа мэдээллээр хангах, үндэсний аюулгүй байдлыг хангах төрийн бодлогыг уялдуулан зохицуулах, хэрэгжүүлэхэд шаардагдах мэдээллийн нэгдсэн санг холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хариуцах чиг үүргийг хэрэгжүүлж байна.

Түүнчлэн, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 3-т “Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна.”, мөн зүйлийн 4-т “Зөвлөлийн Ажлын алба нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй байна.” гэж заасан хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн санг энэ хуулиар төрийн нууцад хамааруулах нь зүйтэй байна.

Мөн уг хуулийн төслийн 5.1.2-т “төрийн нууц тээгч” гэж төрийн нууцын бичвэр, тэмдэг, дүрс, дохио, техникийн шийдэл, үйл ажиллагааны хэлбэрээр агуулж байгаа материаллаг зүйлийг” гэж заасны дагуу “төрийн нууц тээгч”-ийг Зөвлөлийн ажлын албаны бие бүрэлдэхүүн албаны чиг үүрэгт байнгын тогтмол ашигладаг болно.

Дээрх чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд, Үндэсний аюулгүй байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэгтэй байгууллагуудаас буюу төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас Зөвлөлийн Ажлын албаны бие бүрэлдэхүүний дийлэнх олонх буюу 80 хувь нь Төрийн албаны тухай болон холбогдох бусад хууль тогтоомжийн хүрээнд томилогдож, албан үүрэг гүйцэтгэдэг болно.

Дээр дурдсан болон бусад холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, шаардлагыг ханган ажиллахад Зөвлөлийн Ажлын албаны бүтэц, орон тоо, зохион байгуулалт, төсвийн хүрээний мэдээллийг төрийн нууцад хамааруулах зайлшгүй шаардлага үүсэж байна.

000042018

Иймд Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд тусгах саналыг боловсруулж, хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: 2 хуудастай.

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА



А.БЯМБАЖАРГАЛ

Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн
нарийн бичгийн даргын 2026 оны 01
дүгээр сарын 22-ны өдрийн 4/25
дугаар албан бичгийн хавсралт

Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын
төсөлд тусгах санал:

Д/д	Нэмэлт, өөрчлөлт оруулах санал	Үндэслэл, хэрэгцээ, шаардлага
1.	Хуулийн төслийн 13.1.5.к-т “энэ хуулиар төрийн нууцад хамааруулсан асуудал хэлэлцсэн хаалттай хуралдааны тэмдэглэл, баримт бичиг” гэсний дараа 13.1.5.л. “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сан болон Зөвлөлийн ажлын албаны зохион байгуулалтын бүтэц, орон тоо, төсвийн тухай мэдээлэл” гэж нэмж тусгах.	Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн 10 дугаар зүйлийн 3-т “Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн сангийн бүтэц, зохион байгуулалт, бүрдүүлэлт, ашиглалтын журмыг Ерөнхийлөгчийн зарлигаар тогтооно. Зөвлөлийн дэргэдэх мэдээллийн сан нь төрийн нууцад хамаарах бөгөөд тусгай хамгаалалтад байна.”, мөн зүйлийн 4-т “Зөвлөлийн ажлын алба нь мэдээллийн нэгдсэн санг бүрдүүлэх, үйлчилгээ үзүүлэх бүтэцтэй байна.” гэж заасан хуулийн хэрэгжилтийн хангах хүрээнд Зөвлөлийн мэдээллийн нэгдсэн санг энэ хуулиар төрийн нууцад хамааруулах, Түүнчлэн Зөвлөлийн Ажлын албаны хүний нөөц, бие бүрэлдэхүүний дийлэнх буюу 80 орчим хувь нь төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагаас томилогдож албан үүрэг гүйцэтгэдэг бөгөөд хуулийн төслийн 5.1.2-т “төрийн нууц тээгч” гэж төрийн нууцын бичвэр, тэмдэг, дүрс, дохио, техникийн шийдэл, үйл ажиллагааны хэлбэрээр агуулж байгаа материаллаг зүйлийг” гэж заасны дагуу “төрийн нууц тээгч”-ийг албаны чиг үүрэгт байнгын тогтмол ашигладаг. Иймд Зөвлөлийн ажлын албанд албан үүрэг гүйцэтгэж буй алба хаагч нарын мэдээллийг Ажлын албанд үүрэг гүйцэтгэж байх хугацаанд нууцлах зайлшгүй шаардлага үүсдэг болно.
2.	Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслийн 33 дахь хэсэг “ҮАБЗ-ийн төсвийн бусдаар гүйцэтгүүлэх ажил, үйлчилгээний зардал” гэснийг “Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн төсвийн Нийтлэг, ажил, үйлчилгээний	Санхүүжилт, төсвийн зохицуулалт, нууц мэдээллийг агуулдаг тул задарч үрэгдсэнээр төсвийн удирдлага алдагдаж, үйл ажиллагаанд саад учирч, төрийн нууц үрэгдэх эрсдэл бий болно.

	хураамжийн судалгаа, хөгжүүлэлтийн зардал” гэж өөрчлөн найруулах.	ҮАБЗ-ийн гүйцэтгүүлж буй зарим ажил, үйлчилгээ нь үндэсний аюулгүй байдлыг хангах үйл ажиллагаатай шууд хамааралтай, бодлого, стратегийн шинж чанартай байдаг тул үндэсний аюулгүй байдалд эрсдэл учруулах нөхцөл бүрдэнэ. Санхүүгийн мэдээлэл задрах нь аль байгууллага, аль төсөлд хэчнээн хөрөнгө зарцуулж байгааг ил болгох бөгөөд төсвийн зарцуулалт, ажил үйлчилгээний хэмжээ, хугацаа, байршил зэрэг мэдээлэл гадаадын тусгай алба, түүний төлөөний этгээд мэдэх, сөргөөр ашиглах боломж бий болно. Үүний үр дүнд ач холбогдол бүхий төслүүдийг чиглэсэн сөрөг арга хэмжээ, саад тотгор бий болох эрсдэлтэй. Зарцуулалтын мэдээлэл задрах нь иргэд, олон нийтийг төөрөгдөлд оруулах, эмх замбараагүй байдал бий болгох, төр, засгийн үйл ажиллагаанд эргэлзээ төрүүлэх магадлалтай. Зарцуулалтын нарийвчилсан мэдээлэл ил болсон тохиолдолд ач холбогдол бүхий төслүүдийн төлөвлөгөө, худалдан авалт, нийлүүлэлтэд саад учирч, төсвийн үр ашиг буурах эрсдэлтэй.
--	---	---

ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН АЖЛЫН АЛБА



МОНГОЛ УЛС
МОНГОЛБАНК

Бага тойруу 3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-11) 31 03 92, Факс: (976-11) 31 14 71,
Цахим хуудас: www.mongolbank.mn

2026. 01. 13 № А-1/14
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/3500 дугаар албан бичгээр ирүүлсэн Төрийн нууцын тухай хууль болон Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төслүүдтэй танилцлаа.


Төрийн байгууллагын “албаны нууц”-ыг дээрх хуулийн төслөөр хүчингүй болгосноор төрийн нууцад хамаарахгүй боловч задруулах, үрэгдүүлэх тохиолдолд банк, санхүүгийн салбарын нийтлэг ашиг сонирхолд сөргөөр нөлөөлөх, Монголбанкны эмзэг мэдээлэл (мөнгөний бодлогын шинжилгээний загварын код, гадаад валютын албан нөөцийн бүтэц зэрэг)-ийн аюулгүй байдлыг Байгууллагын нууцын тухай хуулиар хангах боломжгүй хууль зүйн эрсдэл үүсэж байна.

Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд банк, санхүүгийн салбарт хамаарах төрийн нууц мэдээлэлд тагнуулын болон гүйцэтгэх ажил эрхлэх байгууллагын бүтэц, үйл ажиллагааг халхавчлах мэдээлэл зэрэг салбарт шууд хамааралгүй мэдээлэл туссан байгааг тус хуулийн холбогдох бусад хэсэгт шилжүүлэх саналтай байна.

Иймд хуулийн зохицуулалтыг цогцоор нь бүрдүүлэх зорилгоор хуулийн төсөл санаачлагчийн зүгээс хуулийн төслийн хэлэлцүүлгийг эрх ашиг хөндөгдөж буй байгууллагатай зохион байгуулж, үүсэж болох асуудлыг шийдвэрлэх саналыг гүйцэд боловсруулсны дараа Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх саналыг үүгээр уламжилж байна.

Хүндэтгэсэн

ДЭД ЕРӨНХИЙЛӨГЧ



Г.ЭНХТАЙВАН

1526020041



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРОО

Засгийн газрын 4 дүгээр байр, Бага тойруу-3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: (976-51) 26 44 44, Факс: (976-51) 26 41 24,
Цахим шуудан: info@frc.mn, Цахим хуудас: www.frc.mn

2026.01.08 № 1/54
танай _____-ны № _____-т

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН
ДЭД ДАРГА Ш.РАДНААСЭД ТАНАА

Хариу хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/3500 тоот албан бичгээр ирүүлсэн Төрийн болон албаны нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл, түүний үзэл баримтлалтай танилцлаа.

Төрийн үйл ажиллагааны ил тод, нээлттэй байдал, иргэдийн мэдэх эрхийн баталгааг хангах, авлига, хүнд суртлыг бууруулах, төрийн байгууллагын албаны нууцын хадгалалт, хамгаалалт, хяналтын үр дүнтэй тогтолцоог бүрдүүлэх зорилгоор боловсруулж буй дээрх хуулийн төслийг тус Хороо зарчмын хувьд дэмжиж байгаа бөгөөд дараах саналыг хүргүүлж байна.

1.Төрийн нууцын бүртгэл, мэдээллийн нэгдсэн сан байгуулах, ашиглах, түүний нууцлал, аюулгүй байдлыг хангах, төрийн байгууллага, бусад хуулийн этгээд төрийн нууц мэдээллийг тус санд бүртгүүлэхтэй холбоотой харилцааг хуулийн төсөлд нарийвчлан тусгаж, зохицуулж өгөх;

2.Хуулийн төслийн 18.4 дэх хэсгийн “ил болгох,” гэсний дараа “нууцын зэрэглэл өөрчлөх,” гэж нэмэх;

Төрийн нууцын тухай хуулийн төслийн 18.4 дэх хэсгээр төрийн нууцыг ил болгох, хугацааг сунгах харилцааг зохицуулсан байх бөгөөд нууцын зэрэглэл өөрчлөх асуудлыг орхигдуулсан байх тул үүнийг нэмэх;


3.Хуулийн төслийн 20.6 дахь хэсгийн “Улсын Их Хурлаас байгуулагддаг байгууллагын” гэснийг “Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын” гэж өөрчлөх;

4.Хуулийн төслийн 25.1 дэх хэсэгт заасан “25.3” гэсэн заалт байхгүйг анхаарах.


Хүндэтгэсэн,

ДАРГА

Т.ЖАМБААЖАМЦ



1518000091



ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର

ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର ମହାବଳୀପୁର



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАРТ

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР**

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn


2025.12.30 № 3632
танай _____-ны № _____-т

Хуулийн төсөлд санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн “Хуулийн төсөлд санал авах тухай” ХЭГ/3500 дугаартай албан бичгээр ирүүлсэн хуулийн төсөлтэй тус тус танилцлаа.

Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга), Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөлд өгөх саналыг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт.2...хуудастай.



С.МАГНАЙСҮРЭН

**ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН
НАЙРУУЛГЫН ТӨСӨЛ БОЛОН ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ
БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД ӨГӨХ САНАЛ**

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл:

Хуулийн төслийн 10 дугаар зүйл.Засгийн газрын бүрэн эрхийн 10.1.5-д Төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах эрхийг Засгийн газарт дангаар хариуцуулахаар зохицуулсныг Улсын Их Хурал зөвшөөрснөөр Төрийн нууцыг шилжүүлэх талаар зохицуулалтыг нэмж тусгах.

Тодруулбал, хуулийн төслийн 10.1.5-д “төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах” гэснийг “Улсын Их Хурал зөвшөөрснөөр төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргах” гэж өөрчлөх;

Хуулийн төслийн 18.7-д “Төрийн нууцыг ил болгох журмыг Засгийн газар батална.” гэж туссаныг холбогдох мэргэжлийн байгууллагын саналыг харгазах асуудлыг нэмж тусгахын зэрэгцээ, “Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль” -ийн төслийн үзэл баримтлалтай хэрхэн нийцэхийг анхаарч үзэх;

Хуулийн төслийн 25.1-т “...25.3-т зааснаас бусад...” гэсэн нь тус иш татсан хэсэг хуулийн төсөлд тусаагүй байх тул дахин нягтлах;

Хуулийн төслийн 27 дугаар зүйлийн 27.1.4-т “...Төрийн нууцтай эрх олгосон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах...” гэснийг “...Төрийн нууцтай танилцах эрх олгогдсон албан тушаалтан, иргэнээс нууц хамгаалах баталгаа гаргуулан авах...” гэж найруулгын өөрчлөлт хийх.

Дараах зохицуулалтыг нэмэлтээр тусгуулах саналтай байна. Үүнд:

Хуулийн төслийн 8.1.4-т “...Төрийн нууцад хамаарах мэдээллийг шилжүүлэх шийдвэр гаргахад Засгийн газарт зөвшөөрөл олгох...” гэж;

Хуулийн төслийн 18 дугаар зүйлийн 18.8-д “ ...15.1.1, 15.1.2, 15.1.3...” төрийн нууцад хамаарах мэдээллийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу ил болгосон тохиолдолд ил тод мэдээлэх үүргийг төрийн нууцад хамааруулсан байгууллага хариуцах зохицуулалтыг нэмж тусгах.

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл:

Хуулийн төслийн “Ы/Онцгой байдлын салбар”-ын жагсаалтын 2-т “Улсын нөөцийн байршил, бодит хэмжээ, тэдгээрийн тайлан, мэдээ, санхүүжилттэй холбогдсон баримт бичиг” онц чухал нууцад хамаарч байгаа нь Төрийн аудитын байгууллагын орон нутгийн аудиторуудад аудит гүйцэтгэх явцад баримт бичигтэй танилцах эрх хэмжээ хүрэлцэхгүй болох нөхцөл байдал үүсэх эрсдэлтэй байна.

Бусад асуудлын тухайд:

1. Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хууль болон Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хууль, Хууль хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслүүдийн дагаж мөрдөх хурацааг уялдуулах нь зүйтэй байна.

2. Төрийн нууцын тухай хууль (шинэчилсэн найруулга)-ийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн найруулгыг нягталж, нууцад хамааруулсан мэдээллийг ил болгохтой холбоотойгоор үүсэж болох хүндрэл, бэрхшээлтэй асуудлуудыг тодорхойлон, холбогдох зохицуулалтыг тусгах нь зүйтэй байна.

---o0o---



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН
ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ТЭРГҮҮН ДЭД
ДАРГА Ш.РАДНААСЭД ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР**

Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 4 дүгээр
хороо, Самбуугийн гудамж-18
Утас: 51-260855, Факс: (976-51)263739
Цахим шуудан: gpo@prosecutor.mn
Цахим хуудас: www.prosecutor.mn
2026.01.06 № Ц-02/73

Санал хүргүүлэх тухай

Танай 2025 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн ХЭГ/3500 дугаартай албан бичгээр ирүүлсэн "Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл", "Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөл"-тэй танилцлаа.

Төрийн нууцын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй холбогдуулан, Зөрчлийн тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсэгт заасан "шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулна." гэсний дагуу шинээр боловсруулах;

Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн төсөлд нэг агуулгатай заалтыг харьяалах байгууллага бүрт давхардуулан тусгасан, хэсгийн тэмдэглэгээг а-я хүртэл хийсэн байх тул төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан "Хуулийн төслийн бүтэц, хэлбэр"-ийн шаардлагад нийцүүлэх нь зүйтэй.

Холбогдох хуулийн төсөлд тусгуулах саналыг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 5 хуудас.



МАКСИМ ЧИНБАТ
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ГАЗАР
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОРЫН ОРЛОГЧ, ТӨРИЙН ХУУЛЬ ЦААЗЫН
ШАДАР ЗӨВЛӨХ

ХУУЛИЙН ТӨСӨЛД ГАРГАСАН САНАЛ

№	Төслийн зүйл, хэсэг, заалт	Гаргасан санал			Саналын үндэслэл, хэрэгцээ, шаардлага
		Өөрчлөх	Нэмэх	Хасах	
0	1	2	3	4	5
НЭГ.ТӨРИЙН НУУЦЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ					
1	5 дугаар зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт		“онц хүнд үр дагавар” гэсэн нэр томъёоны тайлбар.		Эрүүгийн хуульд “нууц”, “маш нууц”, “онц чухал нууц” задруулахыг гэмт хэрэгт тооцохоор хуульчилсан. Хуулийн төсөлд “...үндэсний ашиг сонирхолд онц хүнд үр дагавар бий болгох ...мэдээллийг “онц чухал нууц” зэрэглэлд”, “Монгол Улсын үндэсний ашиг сонирхолд хүнд үр дагавар бий болгох, ... мэдээллийг “маш нууц” зэрэглэлд тус тус хамруулна гэжээ. Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулиудад “онц хүнд үр дагавар”, “хүнд үр дагавар”, “Үндэсний аюулгүй байдалд хохирол учруулах” гэснийг тайлбарласан тайлбар байхгүй байгаа нь хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангахад хүндрэл учирна. Иймд хуулийн тайлбар хийх.
2			“хүнд үр дагавар” гэсэн нэр томъёоны тайлбар.		
3	20 дугаар зүйл.Төрийн нууцтай танилцах тусгай нөхцөл 20.5.Үндсэн хуулийн цэцийн гишүүн, шүүгч, прокурор, мөрдөн байцаагч зөвхөн шалгаж	“...мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж.			2015 онд шинэчлэн найруулсан Монгол Улсын Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд “мөрдөн байцаагч” гэснийг “мөрдөгч” гэж томъёолсон тул хуульд нийцүүлэх.

	шийдвэрлэх тодорхой хэрэг, маргаанд хамаарах төрийн нууцтай хуулиар тогтоосон журмын дагуу танилцана.				
4	25.2.Энэ хуулийн 25.1-д заасан аюулгүй байдлын шалгалт явуулах журмыг тагнуулын байгууллагын дарга батална. 12.2. Энэ хуулийн 12.1.7-д заасан мэдээллийн санг байгуулах, ашиглах журмыг Засгийн газар батална. 18.7. Төрийн нууцыг ил болгох журмыг Засгийн газар батална. 37.5. Энэ хуулийн 37.3-т заасан хяналт шалгалтыг зохион байгуулж явуулах журмыг Засгийн газар батална.		“журмыг Засгийн газраас батална.”	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолоор батлагдсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл”-ийн 36-д “...хуулиар журам батлах эрх олгосон зохицуулалтаас татгалзаж хүчингүй болгох, хуулиар зохицуулах шаардлагатай харилцааг дүрэм, журмаар зохицуулахгүй байх холбогдох зохицуулалтыг хуульд тусгах”-аар заасан. Иймээс дээрх заалтуудыг хуулиар зохицуулах.	
ХОЁР.ТӨРИЙН НУУЦЫН ЖАГСААЛТ БАТЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ					
5	1 дүгээр зүйл. ю/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага 6.Эрх бүхий байгууллагын удирдлагаас гүйцэтгэх ажлыг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар гаргасан шийдвэр, заавар, журам, бусад баримт бичиг	“эрх байгууллагын бүхий удирдлагаас гүйцэтгэх ажил” гэсний дараа “мөрдөн шалгах нууц ажиллагааг”.		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 1.10 дугаар зүйлд “мөрдөн шалгах нууц ажиллагаа” гэж прокурорын зөвшөөрлөөр нууцаар явуулах энэ хуульд заасан ажиллагааг;” ойлгохоор заасан тул энэхүү ажиллагааны талаарх шийдвэр, заавар, журам, бусад баримт бичгийг гүйцэтгэх ажлын нэгэн адил нууцад хамааруулах.	

6			“Мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах прокурорын тогтоол, танилцуулга, төлөвлөгөө, тайлбар, үр дүн, нууц ажиллагааны магадлагаа, нууц ажиллагаа явуулахаар бичсэн даалгавар, нууцлал баримт бичиг, мэдээлэл”, “10 жил”.		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 16.8 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хуульд заасан үндэслэл, журмын дагуу явуулсан мөрдөн шалгах нууц ажиллагааны үр дүнг нотлох баримтаар тооцох ба нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлэх ажиллагааны арга, хэрэгсэл, эх сурвалж нууц байна.” гэж заасан тул энэ ажиллагаатай холбоотой харилцааг нэмэх.
7	1 дүгээр зүйл. ю/ Монгол Улсын Үндсэн хуулийн цэц, шүүх, прокурорын байгууллага		“Прокурорын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хүрээнд гаргасан прокурорын эрх зүйн хэлбэр, хийсэн хяналт, шалгалт, судалгааны материал, холбогдох баримт бичиг”, “10 жил”.		Прокурорын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2 дахь хэсэгт заасны дагуу прокурор мөрдөн шалгах нууц ажиллагаа, гүйцэтгэх ажилд хяналт тавихад хамаарах бүрэн эрхийн дагуу гаргасан эрх зүйн хэлбэр, хяналт, шалгалтын материал, илтгэх хуудас, танилцуулга, шаардлага гэх мэт баримт бичгийг нууцад хамааруулах талаар тусгах.
8			“Тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмж, түүний ашиглалт болон бүртгэлийн мэдээлэл”, “10 жил”		Прокурорын байгууллага нь гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагааг хэрэгжүүлж буй эрх бүхий байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах чиг үүргийн хүрээнд ашиглагдаж буй тусгай зориулалтын автомашин, техник хэрэгсэл, програм хангамж, бүртгэлийн сан гэх мэт мэдээлэл, баримтыг төрийн нууцын жагсаалтад оруулах.
9			“Гүйцэтгэх мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналтын		

			үйл ажиллагаанд ашиглах мэдээлэл бүхий бүртгэлийн сан, зориулалтын программ хангамж, нууцлах код, түлхүүр, өгөгдөл, нууц тээгчид байгаа мэдээлэл”, “10 жил”		
			“Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэх хүрээнд Прокурорын байгууллагад батлагдсан төсөв, зардал, төсвийн гүйцэтгэлийн тайлан, тэдгээрийн асуудлаар харилцсан албан бичиг, батлагдсан санхүүгийн үйл ажиллагаанд хийсэн аудитын тайлан, Монгол Улсын үндэсний аюулгүй байдал, төрийн нууцтай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллага, албан тушаалтантай харилцсан мэдээлэл”, “10 жил”		Гүйцэтгэх ажил, мөрдөн шалгах нууц ажиллагаанд тавих прокурорын хяналтын чиг үүргийг хэрэгжүүлэхэд ашиглагдаж буй төсвийн мэдээллийг нууцын жагсаалтад хамруулах.

11	1 дүгээр зүйл. ё/ Хууль зүй, дотоод хэрэг, хууль сахиулах салбар		“Мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах тогтоол, танилцуулга, төлөвлөгөө, тайлбар, үр дүн, нууц ажиллагааны магадлагаа, нууц ажиллагаа явуулахаар бичсэн даалгавар, нууцлал баримт зохих мэдээлэл”, “10 жил”		Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль, Гүйцэтгэх ажлын тухай хуульд Цагдаа, Тагнуул, Авлигатай тэмцэх газрын мөрдөгч нууц ажиллагааны үр дүн болох баримт, мэдээллийн талаар магадлагаа үйлдэж, прокуророор баталгаажуулж, хавтаст хэрэгт тусгана гэж заасан. Хуулийн төсөлд мөрдөн шалгах нууц ажиллагаанд хамаарах төлөвлөгөө, түүний үр дүн буюу магадлагаа, прокурорын зөвшөөрөл, бусад нууцлал зохих баримт, мэдээллийг зөвхөн Тагнуулын байгууллагын хэмжээнд нууцлах төрийн нууцын мэдээллийн жагсаалтад оруулахаар хязгаарласан нь үндэслэлгүй тул нэмж тусгах.
12	1 дүгээр зүйл. п/Авлигатай тэмцэх газар				

АЖЛЫН ХЭСЭГ

Д/д	Нэр	Албан тушаал
1.	Б.Энхбаяр	Хууль зүй, дотоод хэргийн сайд
2.	Д.Мөнх-Эрдэнэ	Хууль зүй, дотоод хэргийн дэд сайд
3.	Ч.Эрдэнэчимэг	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын дарга
4.	Л.Мөнхтүшиг	Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга
5.	Н.Мягмар	Хууль зүй, дотоод хэргийн яамны Төрийн нарийн бичгийн дарга
6.	Д.Ганхуяг	Батлан хамгаалах яамны Төрийн нарийн бичгийн дарга
7.	А.Бат-Эрдэнэ	Тагнуулын ерөнхий газрын Тэргүүн дэд дарга
8.	Б.Төрбат	Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын Хууль, эрх зүйн газрын референт
9.	Б.Батмөнх	Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга
10.	Ч.Хүдэрбаяр	Тагнуулын ерөнхий газрын хэлтсийн дарга

---o0o---